

ХУУЛЬ ТОГТООМЖ, ШҮҮХ ЭРХ МЭДЛИЙН
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, СУРГАЛТ, МЭДЭЭЛЭЛ,
СУРТАЛЧИЛГААНЫ ҮНДЭСНИЙ ТӨВ

ХУУЛЬ ДЭЭДЛЭХ ЁС

№ 3



УЛААНБААТАР ХОТ
2003 ОН

ЭРХЭМ УНШИГЧ ТАНАА

Эрхэм уншигч танд ирж буй Шинэ жилийн мэндчилгээ дэвшүүлж, эрүүл энх, аз жаргал, хамгийн сайн сайхныг хүсэн өрөөж байна.

Хууль тогтоомж, шүүх эрх мэдлийн эрдэм шинжилгээ, сургалт, мэдээлэл, сурталчилгааны үндэсний төв /ХЗҮТ/-ийн хэвлэл хууль зүйн эрдэм шинжилгээ, судалгаа, онол, практикийн сэтгүүлийн гуравдугаар Таны гар дээр очиж байна.

Энэ сэтгүүлээ шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах нийт байгууллагын ажилтан, төрийн ба төрийн бус байгууллага, иргэний нийгмийн болон бизнесийн байгууллагын хууль зүйн зөвлөх, эрдэмтэн судлаач, хууль зүйн их, дээд сургуулийн багш, оюутанд зориулан гаргаж байна.

Манай сэтгүүл дараахь тогтмол булантай. Үүнд:

- Төрийн байгуулалтын хууль тогтоомж;
- Иргэний хууль тогтоомж;
- Шүүх эрх мэдэл;
- Прокурорын хяналт;
- Олон улсын эрх зүй, харьцуулсан эрх зүй;
- Криминологи;
- Эрх зүйн үйлчилгээ.

"Хууль дээдлэх өс" сэтгүүл 2004 онд нийтийн захиалгад үргэлжлэн орсон тул Та сонирхсон сэдвээрээ өгүүлэл, нийтлэл бичиж, манай сэтгүүлийг захиалан уншина гэдэгт итгэлтэй байна.

СОНИН, СЭТГҮҮЛИЙН НЭГДСЭН ЗӨВЛӨЛ

сонин, сэтгүүлийн нэгдсэн зөвлөлийн бүрэлдэхүүн:

Ц.Бат-Орших	Сонин, сэтгүүлийн нэгдсэн зөвлөлийн ерөнхий эрхлэгч
А.Доржготов	Улсын дээд шүүхийн шүүгч
Н.Ганбаяр	Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга
Б.Цэрэнбалтав	Улсын ерөнхий прокурорын орлогч
Ж.Амарсанаа	Хууль зүйн үндэсний төвийн захирал
Ж.Энхнасан	Хууль зүйн үндэсний төвийн Захиргааны хэлтсийн дарга
Т.Мэндсайхан	Хууль зүйн үндэсний төвийн Хууль зүйн сургалтын төвийн эрхлэгч
Б.Балган	Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга
Э.Лхагвасүрэн	Үндсэн хуулийн цэцийн ажилтан
П.Цэцгээ	Улсын дээд шүүхийн Судалгааны төвийн захирал
А.Энхжав	Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төвийн дарга
Ж.Сайнжаргал	Цагдаагийн ерөнхий газрын Тамгын газрын дарга
Б.Пүрэвням	Монголын Өмгөөлөгчдийн холбооны Ерөнхийлөгч
А.Оюунчимэг	Монголын Нотариатчдын танхимын Ерөнхийлөгч
Г.Сумъяа	Сонин, сэтгүүлийн нэгдсэн зөвлөлийн хариуцлагатай нарийн бичгийн дарга

-ooOoo-

ЭНЭ ДУГААРТ:

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН ХУУЛЬ ТОГТООМЖ

- Захиргааны байгууллага, албан тушаалтны хууль зөрчсөн үйл ажиллагааны улмаас иргэн, хуулийн этгээдэд учруулсан гэм хорыг арилгах асуудал

7

*ХЗҮТ-ийн Төрийн байгуулалтын секторын
эрдэм шинжилгээний ажилтан Н.Отгончимэг*

- Бүгд Найрамдах Казахстан Улсын Үндсэн хуулийн зөвлөл хэрхэн ажилладаг вэ?

12

Үндсэн хуулийн цэцгийн ажилтан Э.Лхагвасүрэн

ИРГЭНИЙ ХУУЛЬ ТОГТООМЖ

- 2002 оны Иргэний хууль ба зөрчилдөөний хэм хэмжээ
МУИС-ийн Хууль зүйн сургуулийн дэд профессор,
хууль зүйн доктор Т.Мэндсайхан

16

- Лизингийн гэрээний эрх зүйн зохицуулалтын асуудал
ХЗҮТ-ийн Иргэний хууль тогтоомжийн секторын
эрдэм шинжилгээний ажилтан У.Мөнхбат

26

- Үл хөдлөх эд хөрөнгийн эрх зүйн хамгаалалт
Отгонтэнгэр их сургуулийн магистрант О.Цэвэлмаа

32

- Гэр бүлийн хууль тогтоомжийн түүхэн хөгжил
МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Иргэний эрх зүйн
тэнхимийн багш А.Дугармаа

34

- Арбитрын тухай шинэ хуулийн талаар өгүүлэх нь
Хуульч Б.Дөшдондог

37

ШҮҮХ ЭРХ МЭДЭЛ

- Монгол Улсын шүүх эрх мэдлийн тогтолцоо ба шүүхийн эрх зүйн үзэл баримтлалын зарим асуудал

42

Улсын дээд шүүхийн шүүгч Ц.Амарсайхан

- Ази, номхон далайн зарим орны хорих байгууллага: Өнөөгийн байдал, чиг хандлага

54

*Эмэгтэйчүүдийн хорих ангийн дарга, Монгол Улсын
гавъяат хуульч, хурандаа Р.Оюунбадам*

ПРОКУРОРЫН ХЯНАЛТ

- АНУ-д прокурор ямар үүрэг гүйцэтгэдэг вэ?
Нийслэлийн прокурорын туслах, хэлтсийн дарга
Ж.Эрдэнэбаатар

60

ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙ, ХАРЬЦУУЛСАН ЭРХ ЗҮЙ

- Английн шүүхийн шийдвэрийн эмхтгэл ба эрх зүйн эх сурвалжид тооцогдох бүтээлийн ач холбогдол 66
ХЗҮТ-ийн Олон улсын эрх зүйн секторын эрдэм шинжилгээний ажилтан Б.Гүнбилэг
- Олон улсын нийтийн эрх зүй, олон улсын хувийн эрх зүйн харилцан хамаарал 71
Гадаад харилцааны яамны мэргэжилтэн А.Төмөр
- Олон улсын эрх зүйн хэм хэмжээг хууль зүйн туслалцаа үзүүлэх болон өмгөөллийн үйл ажиллагаанд хэрэглэхэд анхаарах зарим асуудал 76
Хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор С.Жанцан
- Эрх зүйн хэм хэмжээний тайлбарын канон 82
Цагдаагийн Академийн ахлах багш, цагдаагийн дэд хурандаа Н.Гантулга

КРИМИНОЛОГИ

- Эрүүгийн хуульд тусгагдсан нийгмийн үйлчилгээ үзүүлэх ял, түүнийг боловсронгуй болгох асуудал 86
ХЗҮТ-ийн Криминологийн судалгааны секторын эрдэм шинжилгээний ажилтан Б.Билэгсайхан
- Оросын Холбооны Улс дахь авилгалын өнөөгийн төлөв байдал 91
ОХУ-ын ДЯЯ-ны Удирдлагын академийн адъюнкт, цагдаагийн хошууч О.Зоригт

ЭРХ ЗҮЙН ҮЙЛЧИЛГЭЭ

- Хуульчдаас өндөр төвшинд сонгон шалгаруулна 95
ХЗДХЯ-ны мэргэжилтэн, Хууль зүйн магистр Т.Төгсжаргал
- Нотариат аливаа баримтын үнэн зөвийг гэрчилдэг 97
Монголын Нотариатчдын танхимын Хэвлэл мэдээллийн албаны ажилтан П.Уянга
- Мэдүүлэг авах арга /Мөрдөн байцаагчид өгөх сэтгэл зүйн зөвлөмж/ 101
ОХУ-ын Аж үйлдвэр, шинжлэх ухаан, технологийн яамны сэтгэл судлалын шинжээч Игорь Олегович Вагин
- Оюуны өмчийн эрхийн нэр томъёоны дагалга 105
"Евромаркпат-Монгол" ХХК-ийн захирал Ю.Энхтөвшин

Дугаарыг эрхэлсэн: Сэтгүүлийн нэгдсэн зөвлөлийн гишүүн А.Доржготов

**ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТНЫ
ХУУЛЬ ЗӨРЧСӨН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УЛМААС ИРГЭН,
ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД УЧРУУЛСАН ГЭМ ХОРЫГ АРИЛГАХ АСУУДАЛ**

*ХЗҮТ-ийн Төрийн байгуулалтын хууль тогтоомжийн
секторын эрдэм шинжилгээний ажилтан Н.Отгончимэ*

Эрх зүйт төрийн нэг үндсэн зарчим бол эрх зүй буюу хууль дээдлэх зарчим юм. Захиргааны байгууллага, албан тушаалтны хувьд энэ нь тэдний үйл ажиллагаа хуульд нийцэж, түүний дагуу явагдана гэсэн үг бөгөөд хууль зөрчсөн аливаа үйл ажиллагааны улмаас учруулсан хохирлоо захиргааны байгууллага, албан тушаалтан хариуцан арилгах үүргийг бусад этгээдийн нэг адил хүлээх учиртайг илтгэнэ.

Захиргааны байгууллага, албан тушаалтны хууль бус үйл ажиллагааны улмаас учруулсан гэм хорыг иргэн, хуулийн этгээд арилгуулах эрх нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13-г иргэн "...бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх" эрхтэй хэмээн тусгалаа олсон байна.

Захиргааны байгууллага, албан тушаалтан хууль бус хэрэгжүүлснээс гэм хор учирч болох үйл ажиллагааг төрөлжүүлж авч үзвэл:

- Эрх зүйн хэм хэмжээ тогтоосон акт гаргах;
- Эрх олгох үйл ажиллагаа (тодорхой үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгох);
- Тодорхой үйлдлийг заавал хийлгэхээр даалгах (тухайлбал, илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээ авах, аж ахуйн нэгжийг тусгаарлахыг даалгах г.м.);
- Тодорхой үйл ажиллагаа явуулахыг хориглох эсвэл зогсоохыг үүрэг болгох;
- Иргэн, хуулийн этгээдийн тодорхой хүсэлт, шаардлагыг хангах, эс хангах (тухайлбал, эд хөрөнгийн битүүмжлэлийг задлах, аж ахуйн нэгжийг татан буулгах тухай хүсэлт г.м.);
- Захиргааны хариуцлагын арга хэмжээ авах;
- Иргэн, хуулийн этгээдийн өмч, эд хөрөнгийн байдалд нөлөөлөх албадлагын бусад арга хэмжээ авах (тухайлбал, харилцах данснаас татварын өрийг үл маргах журмаар гарган авах, эд хөрөнгөд үзлэг хийх, хураан авах, татварын өрөнд эд хөрөнгө барьцаалах, эд хөрөнгө битүүмжлэх, дансны зарлагын гүйлгээг хаах г.м.);
- Бусад үйл ажиллагаа.

Захиргааны байгууллага албан тушаалтан гэм хор учруулсны улмаас хууль зүйн хариуцлага хүлээх үндэслэл нь *нэгдүгээрт*, хууль зүйн үндэслэл *хоёрдугаарт*, бодит үндэслэлд хуваагдана.

Хууль зүйн үндэслэл гэдэг нь гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйд хариуцлага хүлээлгэхээр заасан эрх зүйн хэм хэмжээ байх явдал юм. Энэ нь юуны өмнө бидний дээр дурдсан Үндсэн хуулийн хэм хэмжээ болох бөгөөд үүнээс гадна Иргэний хууль-ийн "Гэм хорыг арилгах" арван наймдугаар

¹ Энэ хууль 2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр батлагдсан. "Төрийн мэдээлэл" сэтгүүлийн 2002 оны 7 дугаарт нийтлэгдсэн.

бүлэг, "Гэм хор учруулснаас үүсэх үүрэг" тавин хоёрдугаар бүлэг, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль¹-д захиргааны байгууллагын хууль бус үйл ажиллагааны улмаас учруулсан гэм хорыг арилгах үүргийн хууль зүйн үндэслэлийг заасан байна.

Тэгвэл учруулсан гэм хорыг арилгах үүрэг үүсэх бодит үндэслэл нь захиргааны байгууллага, албан тушаалтны хууль бус үйлдэл, эс үйлдэхүй болно. Гэм хорыг арилгах хариуцлага хүлээлгэхэд эдгээр хууль зүйн ба бодит үндэслэлийн аль, аль нь бүрдсэн байх шаардлагатай. Өөрөөр хэлбэл, гэм хорыг арилгах үүрэг үүсэх эрх зүйн хэм хэмжээ, хариуцлага хүлээх хууль бус үйлдэл, эс үйлдэхүй байхыг шаардана.

Эрх зүйн хариуцлага хүлээлгэх шалгуур нь эрх зүйн зөрчлийн бүрэлдэхүүний сургаал байдаг. Захиргааны байгууллага, албан тушаалтны гэм хор учруулсан хууль бус үйл ажиллагаанд хариуцлага хүлээлгэхэд эрх зүйн зөрчлийн бүрэлдэхүүний асуудал нэг адил яригдана.

Гэм хор учруулсны хариуцлага хүлээх захиргааны байгууллага, албан тушаалтны гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүй нь дараахь ерөнхий болон тусгай бүрэлдэхүүнтэй. Үүнд:

1. Гэм хор учруулсан этгээдийн эрх зүй зөрчсөн үйл ажиллагаа;
2. Гэм хорын бодит байдал;
3. Гэм хор учруулсан этгээдийн эрх зүйн эсрэг чиглэсэн үйл ажиллагаа ба учруулсан гэм хорын шалтгаант холбоо;
4. Гэм хор учруулагчийн гэм буруу;
5. Гэм хор учруулагчийн эрх зүйн байдалд холбогдох нөхцөл;
6. Гэм хор учруулагчийн үйл ажиллагаанд холбогдох нөхцөл.

Үйлдэл, эс үйдэхүй, гэм хор буюу хохирол, шалтгаант холбоо, гэм буруу зэрэг нь бүрэлдэхүүний ерөнхий элементүүд болох юм. Харин 5, 6 дахь нь тусгай элемент болно. Ийнхүү тусгай элементийг тодорхойлж байгаа нь захиргааны байгууллага, албан тушаалтны эрх зүйн байдал, үйл ажиллагааны онцлогоос үүдэлтэй.

Бүрэлдэхүүний эдгээр элементийг тус бүрт нь дэлгэрэнгүй авч үзэж, агуулгыг тодорхойлъя.

1. Гэм хор учруулсан этгээдийн эрх зүй зөрчсөн үйл ажиллагаа

Монгол Улсын Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.1., 498.2.-т гэм хорын хариуцлагыг зөвхөн гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйд хүлээлгэхээр заасан. Өөрөөр хэлбэл, захиргааны байгууллага, албан тушаалтны гэм хор учруулсан үйл ажиллагаа нь иргэний ба захиргааны хэргийн шүүх (2004 оны 6 дугаар сарын 1-нээс эхлэн)-ээс хууль бус гэж тооцогдсон байх ёстой юм. Тэгэхдээ тухайн үйл ажиллагаа нь хувийн болон нийтийн эрх зүйн аль, алиныг зөрчсөн шинжтэй байна.

Учир нь захиргааны байгууллага, албан тушаалтан ба иргэн, хуулийн этгээдийн хоорондын харилцааг нийтийн эрх зүйн хэм хэмжээгээр, харин гэм хорыг арилгах асуудлыг иргэний эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулдаг.

¹ Энэ хууль 2002 оны 12 дугаар сарын 26-ны өдөр батлагдсан. "Төрийн мэдээлэл" сэтгүүлийн 2003 оны 3 дугаарт нийтлэгдсэн.

Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.2.-т заасан албан үүргээ зөрчсөн гэм буруутай үйлдэл (эс үйлдэл) нь:

- хууль, эрх зүйн бусад баримт бичгээр хүлээлгээгүй бүрэн эрх хэрэгжүүлсэн;
- хууль, эрх зүйн бусад баримт бичгээр хүлээлгэсэн бүрэн эрхийг хууль бусаар шилжүүлэн хэрэгжүүлсэн;
- хүлээлгэсэн бүрэн эрхээ хэтрүүлсэн зэрэг байдлаар илэрч болно.

2. Гэм хорын бодит байдал

Улсын дээд шүүхийн 1997 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 473 дугаар тогтоол¹-д гэм хорыг "...гэм хор (хохирол)..." гэж тусгасан байна.

Гэм хор учруулснаас үүсэх үүргийн зүйл (объект) нь бусдын амь нас, эрүүл мэндийг бусниулсан, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг доромжилсон, гутаасан, эд хөрөнгийг гэмтээсэн, устгасан зэрэг үйлдлийн өвцст учирсан хохирол байна. Хохирол мөнгөн илэрхийллээр тодорхойлогддог².

Учирсан гэм хорыг арилгах хэмжээний хувьд учруулсан бодит хохирол болон олох ёстой байсан орлогыг хамаарна. Гэм хорын хэмжээг тодорхойлохдоо хохирогчийн ашиг сонирхол, гэм хор учирсан нөхцөл байдал, гэм хор учруулагчийн гэм буруугийн хэр хэмжээг харгалзан үзнэ.

3. Гэм хор учруулсан этгээдийн эрх зүйн эсрэг чиглэсэн үйл ажиллагаа ба учруулсан гэм хорын шалтгаант холбоо

Гэм хор учруулсан хууль бус үйл ажиллагаа ба хохирлын хооронд шалтгаант холбоо байх ёстой. Шалтгаант холбоо гэсэн ойлголт нь уг үндсийн хувьд философийн салбарт хамаарах боловч хууль зүйн шинжлэх ухааны анхаарал татсан, чухал институт болсон байна.

Шалтгаант холбоо бол субъектив гэхээсээ илүүтэй объектив шалгуур байдаг. Аливаа үзэгдэл нь дараа, дараагийн үзэгдлийн шалтгаан, нөхцөл болдог учир шалтгаант холбоо ар, араасаа цуврах гинжин хэлхээ мэт байна.

Яригдаж буй гэм хор тухайн үйл ажиллагаанаас шалтгаалсан гэдгийг шүүгч тогтоохдоо юуны өмнө тэр бүх шалтгаан, нөхцөлүүдээс асуудалд холбогдох хамгийн гол чухал, хууль зүйн ач холбогдолтой хэсгийг салган авч, үнэлэлт өгөх хэрэгтэй юм. Гэм хорын шалтгааны хувьд хэд, хэд байж болох бөгөөд тэдгээрийг тус бүрт нь нягтлан гэм хор учруулахад ямар үүрэг гүйцэтгэсэн гэдгийг тодорхойлно.

Тухайн гэм хор үүсэхэд нөлөөлсөн шалтгаант холбоо нь үйлдэл, эс үйлдэхүйтэйгээ чухал, үндсэн, шууд, зөвлөхгүй, голлох, тогтоортой³ гэсэн шинжээр холбогдсон байх ёстой. Дурдсан шинжтэй холбогдолтой жишээ татъя.

¹ Монгол Улсын дээд шүүхийн тогтоолын эмхтгэл. I дэвтэр. УБ., 1999., 314-318 дахь тал.

² Т.Менсжаргал, Иргэний эрх зүй. Үүргийн тусгай төрөл. УБ., 1998., 144 дэх тал.

³ Рипинский Ю. С. Имущественная ответственность государства за вред причиняемый предпринимателям. Санкт-Петербург, 2002., С. 112, 113.

Татварын алба татвараа төлөөгүй байсан компаниас зарж байсан их хэмжээний согтууруулах ундааг татварын өрийн барьцаанд авч битүүмжилжээ. Битүүмжлэл 3 сар үргэлжилсэн байна. Энэ хугацаанд согтууруулах ундааны хадгалах хугацаа дууссан байна. Энэхүү тохиолдолд компанид учруулсан гэм хорыг татварын алба арилгах үндэслэлтэй юу гэдэг асуулт урган гарна. Гэм хор үүсгэсэн шалтгаан хэд, хэд байна. Үүнд:

- татварын албаны эд хөрөнгө битүүмжилсэн акт;
- татварын өрөнд эд хөрөнгө барьцаалсан гэрээ;
- согтууруулах ундааны хадгалах хугацаа дууссан зэрэг орно.

Эд хөрөнгө битүүмжилсэн акт нь нэгэнт хууль зүйн дагуу хийгдсэн учир энэ нь гэм хор үүсэхэд нөлөөлсөн шууд шалтгаан болж чадахгүй. Барьцааны гэрээг татвар төлөгчийн хүсэл зоригийн дагуу хийх учир үүнд татварын албаны үйлдэл төдийлэн хамааралгүй болох юм. Эндээс дүгнэвэл, гэм хор учрахад татварын албаны зүгээс хууль бусаар нөлөөлсөн зүйлгүй тул тэдэнд гэм хорыг арилгах үүрэг үүсэхгүй болох харагдаж байна.

4. Гэм хор учруулагчийн гэм буруу

"Гэм хор учруулагч өөрийн үйлдлээ (эс үйлдэхүй) хууль бус болохыг, мөн үйлдэл (эс үйлдэхүй)-ийн эцэст сөрөг үр дагавар гарахыг мэдсэн, мэдэх боломжтой байсан атлаа түүнийг зориуд хүсэж, үйлдсэн сэтгэл зүйн хандлагыг гэм буруугийн санаатай хэлбэр гэнэ. Гэм хор учруулагч үйлдэл (эс үйлдэхүй)-ийнхээ хууль бус болохыг мэдсэн боловч гарах үр дагаврыг гаргуулахгүй гэж хөнгөмсгөөр найдсан, эсхүл үйлдлийнхээ хууль бус болохыг, мөн гарах үр дагаврыг урьдчилан мэдээгүй бол гэм буруугийн болгоомжгүй хэлбэр байна".

Гэм хор учруулсан этгээд ийнхүү гэм хор учруулсан нь түүний буруугаас болоогүй гэдгийг нотолбол гэм хор учруулсны хариуцлагаас чөлөөлөгдөнө.¹ Хуулийн энэ заалтаас дүгнэвэл гэм буруугийг нотлох үүрэг хариуцагч талд ногдож байна.

5. Гэм хор учруулагчийн эрх зүйн байдалд холбогдох нөхцөл

Гэм хор арилгах үүргийн субъект нь захиргааны байгууллага, албан тушаалтан байх тохиолдлыг бид авч үзэж байна. Захиргааны байгууллага, албан тушаалтан гэж хэнийг хэлэх вэ?

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д "захиргааны байгууллага" гэж нийтийн ашиг сонирхлыг илэрхийлэн засаглалсан шийдвэр гаргадаг, төрийн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг төв, орон нутгийн бүх байгууллага, түүнчлэн Засгийн газрын байгууллагын зарим үүргийг төлөөлөн гүйцэтгэдэг Засгийн газрын бус байгууллага, хууль болон нийтийн эрх зүйн гэрээний үндсэн дээр бусдыг захирамжилсан шийдвэр гаргаж, нийтлэг үйлчилгээ үзүүлдэг сургууль, эмнэлэг, холбоо, харилцаа, эрчим хүчний зэрэг байгууллагын захиргаа, нутгийн өөрөө удирдах ёсны болон шашны байгууллага, зэрэг нийтийн эрх зүйн субъект болох байгууллагыг; 3.1.2-т "захиргааны албан тушаалтан" гэж энэ хуулийн 3.1.1-д

¹ Т.Мөнхжаргал, Иргэний эрх зүй. Үүргийн тусгай төрөл. УБ., 1998., 149 дэх тал.

² Иргэний хууль. 497.2 дахь хэсэг. Энэ хууль "Төрийн мэдээлэл" сэтгүүлийн 2002 оны 7 дугаарт нийтлэгдсэн.

заасан байгууллагын нийтийн эрх зүйн хүрээнд захирамжлах, зохион байгуулах бүрэн эрхийг бие даан хэрэгжүүлдэг төрийн жинхэнэ албан хаагч, түүнчлэн нийтийн эрх зүйн холбогдолтой асуудлаар бусдыг захирамжилсан шийдвэр гаргадаг төрийн бус албан тушаалтныг ойлгоно хэмээн заасан.

Эдгээр тодорхойлолтод заасан нөхцөл, шалгуурыг хангасан байгууллага, албан тушаалтан нь захиргааны байгууллага, албан тушаалтан болж, гэм хор учруулсан тохиолдолд хариуцагч болох юм.

6. Гэм хор учруулагчийн үйл ажиллагаанд холбогдох нөхцөл

Захиргааны байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаа нь үйлдэл, эс үйлдэхүйн хэлбэртэй байна. Нийтийн эрх зүйн хүрээнд захиргааны байгууллага, албан тушаалтны хэрэгжүүлж буй үйл ажиллагаа нь олон талын шинж агуулах бөгөөд тэдгээрээс зөвхөн гадагш чиглэсэн үйлдэл, эс үйлдэхүй нь маргааны объект болно.

Захиргааны байгууллага, албан тушаалтны үйлдэл, эс үйлдэхүй нь захиргааны актын хэлбэрээр илрэх ба тэр нь тодорхой нэг тохиолдлыг зохицуулахаар амаар буюу бичгээр гаргасан захирамжилсан шийдвэр болон эрх зүйн үр дагавар шууд бий болгодог нэг удаагийн захирамжилсан бусад арга хэмжээ, мөн захиргааны байгууллагын хэм хэмжээ тогтоосон шийдвэр байна.

Захиргааны байгууллага, албан тушаалтны хууль бус үйл ажиллагаанаас учирсан гэм хорыг арилгах үүргийг шүүхээс хүлээлгэсэн тохиолдолд бидний анхаарал татаж буй зүйл бол төсвийн байгууллагад ногдуулсан төлбөрийг ямар эх үүсвэрээс гаргуулах тухай асуудал юм.

Төрийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг бий болгох зорилгоор тухайн жилд төрийн мэдэлд хуримтлуулан хуваарилж, зарцуулах мөнгөн хөрөнгийн орлого, зарлагын тэнцлийг Монгол Улсын нэгдсэн төсөө гэдэг. Харин төсвийн зарлага гэж төрийн чиг үүргийг хэрэгжүүлэхийн тулд батлагдсан төсвөөс төсвийн захирагчийн үйл ажиллагаа, түүний үр дүнг санхүүжүүлэхээр хуваарилж, зарцуулж буй төсвийн хөрөнгийг хэлдэг. Иймд гэм хор учруулсны төлбөр нь төсвийн зарлагын нэг төрөл болж байна.

-00000-

БҮГД НАЙРАМДАХ КАЗАХСТАН УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЗӨВЛӨЛ ХЭРХЭН АЖИЛЛАДАГ ВЭ?

Үндсэн хуулийн цэцийн ажилтан Э.Лхагвасүрэн

Бүгд Найрамдах Казахстан улс нь Үндсэн хуулийн хяналтын дагнасан байгууллага болох Үндсэн хуулийн зөвлөлтэй. Энэхүү зөвлөл нь Бүгд Найрамдах Улс /БНУ/-ын нутаг дэвсгэр дээр Казахстан Улсын Үндсэн хуулийг хамгаалах гол баталгаа юм. Үндсэн хуулийн зөвлөлийн гишүүд нь өөрийн бүрэн эрхийг хэрэгжүүлэхдээ аливаа байгууллага, албан тушаалтан, улс төрийн нам, эвслээс хараат бус байж, гагцхүү Үндсэн хуульд захирагдах ба хэн ч Үндсэн хуулийн зөвлөлийн гишүүдийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох, нөлөөлөхийг хуулиар хатуу хориглодог.

Үндсэн хуулийн зөвлөлийн бүрэлдэхүүн, тэдний бүрэн эрхийн баталгаа. Үндсэн хуулийн зөвлөл нь дарга, зургаан гишүүн, нийт долоо хүний үндсэн бүрэлдэхүүнтэй. Мөн БНУ-ын Ерөнхийлөгч байсан хүн Үндсэн хуулийн зөвлөлийн "насан туршийн гишүүн" буюу "байнгын гишүүн"-ээр сонгогддог. Үндсэн хуулийн зөвлөлийн дарга болон хоёр гишүүнийг албан тушаалд томилох буюу чөлөөлөх асуудлыг БНУ-ын Ерөнхийлөгч, хоёр гишүүнийг парламентын сенатын дарга, мөн хоёр гишүүнийг Мажилис парламентын дарга шийдвэрлэнэ. Үндсэн хуулийн зөвлөлийн гишүүнээр хууль зүйн дээд боловсролтой, БНУ-ын нутаг дэвсгэр дээр оршин суугч, 30-аас дээш насны, БНУ-ын уугуул иргэн байна.

Үндсэн хуулийн зөвлөлийн дарга, гишүүдийн бүрэн эрхийн хугацаа 6 жил байдаг бөгөөд хугацаанаасаа өмнө огцрох болон халагдах тохиолдолд тухайн гишүүнийг огцорсноос хойш 1 сарын дотор анх томилсон эрх бүхий байгууллага, албан тушаалтан нь гишүүнийг нөхөн томилдог юм. Хэрвээ Үндсэн хуулийн зөвлөлийн дарга, гишүүдийн бүрэн эрхийн хугацаа нь аливаа маргаантай асуудлыг тэдний оролцоотойгоор хэлэлцэж байх үед дуусвал, тэдгээрийн бүрэн эрхийг зөвлөлийн шийдвэр гартал хэвээр хадгална. Казахстаны Үндсэн хуулийн зөвлөлийн гишүүд сонгогдсонхоо дараа парламентын чуулганы хуралдаан дээр тангараг өргөдөг журамтай.

Үндсэн хуулийн зөвлөлийн дарга, гишүүн өөрийн үйл ажиллагааг ямар нэг байгууллага албан тушаалтанд тайлагнадаггүй, хэн ч тэднээс өөрсдийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх асуудлаар тайлан шаардах эрхгүй. Мөн Үндсэн хуулийн зөвлөлийн дарга, гишүүд нь хуралдааны шийдвэр гарахаас өмнө Үндсэн хуулийн зөвлөлөөр авч хэлэлцэж байгаа маргааны талаар өөрийн санал бодлыг илэрхийлэх, хэн нэгэнд зөвлөгөө өгөх эрхгүй. Аливаа маргаантай асуудлыг хэлэлцэн шийдвэрлэхэд Үндсэн хуулийн зөвлөлийн дарга, гишүүд тэгш эрх эдэлдэг.

Үндсэн хуулийн зөвлөлийн дарга, гишүүдийг гэмт хэрэг үйлдээгүй байхад нь баривчлах, захиргааны шийтгэл хүлээлгэх, парламентын зөвшөөрөлгүйгээр эрүүгийн хариуцлагад татахыг хориглодог. Үндсэн хуулийн зөвлөлийн дарга, гишүүдийн цалин, орон байр, унаа, эмнэлгийн үйлчилгээ, сувиллын эмчилгээ болон бусад баталгааг Ерөнхийлөгчийн зарлигаар тогтоодог байна.

Үндсэн хуулийн зөвлөлийн дарга, гишүүдийн бүрэн эрхийг түтгэлзүүлэх, дуусгавар болгох. Үндсэн хуулийн зөвлөлийн дарга гишүүдийн бүрэн эрхийг дараахь тохиолдолд түтгэлзүүлнэ.

Үүнд: 1/Зөвлөлийн хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр 3 удаа дараалан оролцоогүй; 2/эрүүл мэндийн байдлаас шалтгаалан өөрийн албан үүргийг удаан хугацаагаар гүйцэтгэх чадваргүй бол; 3/шүүхийн шийдвэрээр сураггүй алга болсонд тооцогдсон.

Үндсэн хуулийн зөвлөлийн гишүүний бүрэн эрхийг түтгэлзүүлэх тухай шийдвэрийг тэдний бүрэн эрхийг зогсоох үндэслэлийг тогтоосноос хойш 1 сараас илүүгүй хугацаанд гаргана. Харин дараахь тохиолдолд тэдний бүрэн эрхийг анх томилсон байгууллага, албан тушаалтан нь дуусгавар болгоно. Үүнд: 1/халагдах тухай өргөдлийн дагуу; 2/ял ногдуулах тухай шүүхийн шийдвэрийн дагуу; 3/хэрэг хүлээх чадваргүй бол; 4/нас нөгчсөн бол; 5/Үндсэн хуулийн шаардлага болон өргөсөн тангарагаасаа няцсан бол; 6/хуулиар тогтоосон бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болсон бол; 7/ 60 нас хүрсэн бол; 8/улс төрийн нам, олон нийтийн бусад байгууллагад элссэн эдгээр болно.

Үндсэн хуулийн зөвлөлийн дарга нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлдэг байна: 1/Үндсэн хуулийн зөвлөлөөр хуралдаанаар авч хэлэлцэх асуудлын бэлтгэл ажиллагааг удирдах зохион байгуулах; 2/Үндсэн хуулийн зөвлөлийн хуралдааныг хуралдааныг даргалгах; 3/гишүүдийн албан үүргийг хуваарилах, ажлын албыг удирдах, зохион байгуулах; 4/хуралдааны бэлтгэл хангах удирдамж өгөх; 5/парламентын чуулганы хуралдаан дээр Үндсэн хуулийн хууль ёсны байдлын талаар Үндсэн хуулийн зөвлөлийн илгээлтийг танилцуулах; 6/БНУ-ын Ерөнхийлөгчийн шаардлагын дагуу Үндсэн хуулийн хууль ёсны байдлын тухай илгээлтийг танилцуулах; 7/Үндсэн хуулийн зөвлөлийн хуралдааны шийдвэр, тэмдэглэлд гарын үзэг зурах; 8/Үндсэн хуулийн зөвлөлийн дотоод дэгд санал оруулах, 9/төсвийнхөө хүрээнд ажлын албаны орон тоо, бүтцийг тогтоох, ажлын албаны дотоод дүрмийг батлах; 10/ажилтныг албан тушаалд томилох буюу чөлөөлөх болон хуульд заасан бусад бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үндсэн хуулийн зөвлөлийн дарга нь эрх хэмжээний асуудлаар тушаал, заавар, захирамж гаргана.

Үндсэн хуулийн зөвлөлийн чиг үүрэг, эрх хэмжээг дурдвал:

1.Үндсэн хуулийн зөвлөл нь БНУ-ын Ерөнхийлөгчийг сонгох, парламентын гишүүнийг сонгох, ард нийтийн санал асуулга явуулах талаар маргаан гарсан тохиолдолд авч хэлэлцэнэ;

2.БНУ-ын Үндсэн хуульд заасны дагуу Ерөнхийлөгчийн гарын үсэгтэй хуулийг парламентад орохоос нь өмнө авч хэлэлцэнэ. Мөн БНУ-ын олон улсын гэрээг Үндсэн хуульд нийцсэн эсэхийг шийдвэрлэнэ;

3.Үндсэн хуулийн хэм хэмжээнд албан ёсны тайлбар гаргах, БНУ-ын Ерөнхийлөгчийг хугацаанаас нь өмнө албан тушаалаас нь чөлөөлөх, огцруулах дүгнэлтийг парламентад гаргах;

4.Үндсэн хуулийн маргаан хянан шийдвэрлэх практик ажиллагааг дүгнэж, энэ талаар парламентад жил бүр илгээлт явуулна.

Үндсэн хуулийн зөвлөлийн маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа нь өргөдөл, хүсэлтийг үндэслэн үүсэх бөгөөд өргөдлийг иргэд; хүсэлтийг Ерөнхийлөгч, парламентын Сенатын дарга, Мажилис парламентын дарга, гишүүд, Ерөнхий сайд, БНУ-ын шүүхийн шүүгчид, Үндсэн хуулийн актыг

шалгагч төрийн байгууллага, албан хаагчид Үндсэн хуулийн зөвлөлд бичгээр гаргах эрхтэй байдаг.

Үндсэн хуулийн зөвлөл өргөдлийг хүлээн авсан өдрөөс эхлэн 1 сарын, хүсэлтийг хүлээн авсан өдрөөс хойш 3 хоногийн дотор шалгаж, маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг явуулна. Харин хуулийн заалттай нийцээгүй, эсвэл хүсэлт гаргах эрх бүхий байгууллага, албан тушаалтан биш, тавьсан шаардлага нь Үндсэн хуулийн зөвлөлийн харьяаллын асуудал биш, өмнө нь хэлэлцэгдсэн, холбогдох эрх зүйн акт нь хүчингүй болсон бол өргөдөл, хүсэлтийг буцаадаг байна.

Үндсэн хуулийн зөвлөлийн хуралдаанаар маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг казак эсвэл орос хэл дээр явагдана. Дарга хуралдаанаар авч хэлэлцэх маргааны талаар товч танилцуулж, хуралдааны бүрэлдэхүүн, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдод тэдний эрх, үүргийг танилцуулах, хуралдаанд нэмэлт тайлбар өгөх эсэхийг маргагч талуудаас тодруулна. Хуралдаанд маргааныг шалгасан илтгэгч гишүүн тухайн маргааны шаардлага, үндэслэл, өргөдөл, хүсэлтийг агуулгын талаар дэлгэрэнгүй илтгэнэ.

Хуралдааны явцад маргагч талууд чөлөөтэй мэтгэлцэх, тэднээс асуулт асуух хариулт авах дарааллыг хянан хэлэлцэж байгаа маргаан тус бүрийн онцлогийг харгалзан хуралдаан даргалагч тогтооно. Хуралдаанаас зөвлөлдөх шатанд шилжихэд, зөвлөлдөх тасалгаанд дарга, гишүүдээс өөр хүн байхыг хориглоно.

Маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчид нь тус, тусын бүрэн эрхийн хүрээнд адил тэгш эрх эдэлдэг. Оролцогчид нь хянаж байгаа маргааны талаархи материалтай танилцах; холбогдох бичиг баримтыг хуулбарлан авах; тэмдэглэл хийх; нотлох баримтын гаргаж өгөх; хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гарсан бүх асуудлаар өөрийн санал, дүгнэлтийг гаргах; маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны явцад чөлөөтэй мэтгэлцэх; амаар болон бичгээр тайлбар гаргах; маргаж буй асуудлын талаархи өөрийн шаардлага, хүсэлтийн үндэслэлийг өөрчлөх, бүхэлд нь буюу зарим хэсгээс нь татгалзах эрхтэй.

Маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчид нь БНУ-ын Үндсэн хууль болон Үндсэн хуулийн зөвлөлийн тухай хуулийг баримтлах; Үндсэн хуулийн зөвлөлийн гишүүдтэй хүндэтгэлтэй харьцах, тэдний шаардлагыг биелүүлэх; хуралдааны дэгийг чанд сахих, хуралдаан даргалагчид захирагдах үүрэг хүлээдэг байна.

Үндсэн хуулийн зөвлөлөөс гаргах шийдвэр нь:

-Дүгнэлт;

-Тогтоол;

-Илгээлт гэсэн хэлбэртэй байх ба шийдвэр нь хамтын зарчмаар буюу нийт гишүүний олонхийн саналаар гаргадаг. Шийдвэрийг батлахад санал тэнцүү тоогоор хуваагдсан тохиолдолд Үндсэн хуулийн зөвлөлийн даргын саналаар шийдвэрлэнэ. Дарга түр эзгүй, түүнийг орлож байгаа гишүүний тухайд энэ заалт үйлчлэхгүй. Харин энэ тохиолдолд эхний санал хураалтад оролцоогүй дарга, гишүүний оролцоотойгоор санал хураалтыг дахин явуулна. Хуралдаанд оролцсон гишүүдийн хэн нь ч санал хураалтад оролцохгүй байх,

эсвэл татгалзах эрхгүй. Үндсэн хуулийн зөвлөлийн шийдвэрт гишүүд, дараа нь дарга гарын үсэг зурж, баталгаажуулна.

Үндсэн хуулийн зөвлөлийн шийдвэрийг дахин хянах ажиллагаа нь Үндсэн хуулийн хэм хэмжээ өөрчлөгдсөн байвал, шийдвэр батлах мөчид шинэ нөхцөл байдал үүссэн бол Үндсэн хуулийн зөвлөлийн шийдвэрийг дахин хянах тухай тогтоол гаргах ба энэ нь угтаа шийдвэрийг хүчингүй болгох тухай тогтоол юм. Энэ тохиолдолд Үндсэн хуулийн зөвлөлийн дарга шийдвэрийг дахин хянах хуралдаанд бэлтгэх гишүүнийг томилох, мөн хуралдаан болох товыг тогтооно.

Үндсэн хуулийн зөвлөлийн шийдвэр нь БНУ-ын нутаг дэвсгэр дээр нийтээр дагаж мөрдөх, эцсийн бөгөөд давж заалдаж үл болох шийдвэр юм. Үндсэн хуулийн зөвлөлийн шийдвэрээр хууль тогтоомж, олон улсын гэрээ, тэдгээрийн холбогдох заалтууд Үндсэн хуульд нийцээгүй болох нь тогтоогдвол тэдгээрийг парламентаас баталж болохгүй.

Үндсэн хуулийн зөвлөлийн шийдвэрээр хүчингүй болсон хууль тогтоомж, холбогдох заалтыг үндэслэж гаргасан албан тушаалтан болон шүүхийн шийдвэр ч хэрэгжих ёсгүй.

БНУ-ын Ерөнхийлөгчийн, Сенатын болон Мажилис парламентын гишүүдийн сонгууль Үндсэн хууль болон орон нутаг, засаг захиргааны нэгж, сонгуулийн тойрогт явуулсан Сонгуулийн төв комиссын шийдвэрт нийцээгүй болох нь Үндсэн хуулийн зөвлөлийн шийдвэрээр батлагдвал тухайн сонгуулийг хүчингүйд тооцно. Ард нийтийн санал асуулга ч мөн адил үүнд хамаарагдаж болох юм.

Үндсэн хуулийн зөвлөлийн шийдвэрийг:

1/Үндсэн хуулиар тогтоосны дагуу өргөдөл, хүсэлт гаргагч эсвэл түүний төлөөлөгчид, мөн аль ч тохиолдолд Ерөнхийлөгч, парламент, Дээд шүүх, Ерөнхий прокурор, Хууль зүйн сайдад түүнийг баталснаас хойш 2 хоногт багтаан илгээж, БНУ-ын албан ёсны хэвлэлд казах, орос хэл дээр нийтэлнэ;

2/Зайлшгүй тохиолдолд бусад шийдвэрийг Үндсэн хуулийн зөвлөлийн дэгээр тогтоосон үед зохих албан байгууллага, албан тушаалтан, албан хаагчдад илгээх буюу хэвлэн нийтэлнэ.

2002 ОНЫ ИРГЭНИЙ ХУУЛЬ БА ЗӨРЧИЛДӨӨНИЙ ХЭМ ХЭМЖЭЭ

*МУИС-ийн Хууль зүйн сургуулийн дэд профессор,
хууль зүйн доктор Т.Мэндсайхан*

Иргэний хуулийн хэм хэмжээнүүд хоорондоо нягт холбоотой бөгөөд тэдгээрийн аль нэгийг бусад хэм хэмжээтэй нь холбон авч үзэхгүйгээр зөв ойлгож тайлбарлах боломжгүй юм¹. Иргэний хуульд тусгагдсан зөрчилдөөний хэм хэмжээнүүдийн хувьд харилцан уялдаа холбооны асуудал нэгэн ижил хөндөгдөнө.

2002 оны 9 дүгээр сарын 1-нээс мөрдөгдөж буй Иргэний шинэ хууль 6 хэсгээс бүрдэнэ. Сүүлийн VI хэсэг "Олон улсын иргэний эрх зүй" гэж нэрлэгдэх бөгөөд 539-аас 552 хүртэл бүгд 14 зүйлийг багтаасан байна. Эдгээр 14 зүйлд олон улсын шинжтэй иргэний эрх зүйн харилцаанд хэрэглэгдвэл зохистой эрх зүйн эх сурвалж, тэр дундаа олон улсын гэрээ, гадаад улсын хуулийг сонгох арга журмыг голлон тодорхойлно. Ийм журам агуулсан хэм хэмжээг "зөрчилдөөний" хэмээн нэрлэдэг. Зөрчилдөөний хэм хэмжээг зөв хэрэглэхийн тулд энэхүү хэм хэмжээний бүтэц, тогтолцоо, хууль тогтоомжийн техник, зөрчилдөөний эрх зүйн онол, сургаалын категори ухагдахуун, баримтагдаг зарчим, бэрхшээлтэй асуудлыг бүрэн судалж мэдэх шаардлага зүй ёсоор тавигдана.

Иргэний шинэ хууль Монгол Улсын олон улсын хувийн (иргэний) эрх зүйд ямар өөрчлөлт, шинэчлэлт оруулав, үнэхээр шинэ хууль болж чадав уу гэдэг асуултад эхлээд хариулж, дараа нь хуулийн тодорхой зүйл, заалтууд, түүнд агуулагдсан зөрчилдөөний хэм хэмжээ, түүний төрөл, ангилалтыг болон хуулийг сонгох арга, шилжүүлэг, шилжүүлэг буцах, квалификаци зэрэг үндсэн асуудлууд хуульд хэрхэн тусгагдсаныг судлан үзэх нь зүйтэй болов уу.

Нэг. Өмнө нь мөрдөгдөж байсан 1994 оны Иргэний хуулийг эргэн судлах, түүнтэй харьцуулах үндсэн дээр 2002 оны Иргэний шинэ хуулийн шинэчлэгдсэн өөрчлөгдсөн зүйлсийг тодруулъя.

Монгол Улсын 1994 оны Иргэний хуулийн "Олон улсын иргэний эрх зүй" гэсэн VII хэсэг ЗСБНХУ ба Бүгд найрамдах улсуудын 1991 онд батлагдсан "Иргэний хууль тогтоомжийн үндсүүд"-д тусгасан зүйл заалтыг үндсэнд нь хуулбарласан байдаг. 1994 оны Иргэний хуулийн дээрх хэсэг 14 зүйлтэй байсан юм. 1963 оны Иргэний хуультай харьцуулбал 1994 оных их дэвшилтэй болж, түүнд өмч, гэм хор, итгэмжлэл болон хуулийн этгээдийн талаарх тусгайлсан зохицуулалт шинээр, мөн гадаад эдийн засгийн гэрээнд хэрэглэгдэх эрхийг тодорхойлох журам нарийвчлагдан нэмэгдсэн билээ. Энэхүү хуулийн VII хэсгийг "Олон улсын иргэний эрх зүй" гэж нэрлэсэн боловч уг эрх зүйн тодорхойлолт, зохицуулах зүйлийн хүрээ, онцлогийг хуульд зааж өгөөгүй. Гадаад улсын хууль болон олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн заншлын хэм хэмжээг иргэний эрх зүйн харилцаанд хэрэглэж болно гэж энэ хуулийн 424 дүгээр зүйлд заасан юм. Гэхдээ адгээр хэм хэмжээ хэрэглэгдэх ерөнхий тохиолдлыг хуулиар тодорхойлоогүй. Түүнчлэн гадаад улсын хууль хэрэглэнэ гэж шилжүүлэг хийхдээ түүнийхээ хүрээг нарийвчлан зааглаагүй.

¹ Фогельсон Ю.Б. Избранные вопросы общей теории обязательств. Юрист, 2001., С. 9.

² Т.Мэндсайхан, Олон улсын хувийн эрх зүй. УБ., 2002., 7 дахь тал.

Иймээс гадаад улсын эрх зүй рүү бүхэлд нь шилжүүлэг хийж байгаа юм уу, эсвэл зөвхөн материаллаг хэм хэмжээ рүү нь шилжүүлэг хийж байна уу гэдгийг ялгахад бэрхшээлтэй. Иргэний эрх зүйн харилцааны тодорхой төрлийн хувьд "нэр", "эд хөрөнгийг үндэслэлгүйгээр олж авах буюу эзэмших" болон "даалгаваргүйгээр бусдын үүрэг биелүүлэх" үүргийн зохицуулалт орхигдсон байв.

Иргэний хууль өөрчлөгдөх нь түүнтэй салшгүй холбоотой олон улсын иргэний эрх зүйн (ОУИЭЗ) зохицуулалтыг мөн өөрчлөхөд хүргэжээ. Нөгөө талаар Монгол Улсын гадаад харилцаа өргөжиж, монгол иргэд гадаадын иргэдтэй гэр бүл болох, гадаад улсад аялах, сурах, хөдөлмөрлөх, түүнчлэн гадаадын иргэд Монгол Улсад зочлон ирэх, амьдран суух, аж ахуй эрхэлж, хөрөнгө оруулах явдал нэмэгдсээр байгаа нь ОУИЭЗ-н зохицуулалтыг улам боловсронгуй болгох нөхцөл шаардлагыг бүрдүүлсэн юм. 2002 оны Иргэний хуулийн "Олон улсын иргэний эрх зүй" гэсэн VI хэсэгт 1994 оны Иргэний хуультай харьцуулахад дараахь нэмэлт, өөрчлөлт орсон байна:

а) Шинэ хуулиар хасагдсан 1994 оны хуулийн зүйл заалт:

430 дугаар зүйлд (Иргэний эрх зүйн чадамжийг хариу хязгаарлах) тусгагдсан "харилцан адил байх" зарчмыг шинэ хуульд уламжлан аваагүй. Гэхдээ энэ зарчмыг үгүйсгэсэн гэж шууд ойлгож болохгүй юм. Учир нь Монгол Улсын Үндсэн хуулийн 18 дугаар зүйлд энэхүү зарчмыг тусгасан байдаг.

б) Шинэ хуульд өөрчлөгдөн орсон 1994 оны хуулийн зүйл заалт:

-424 дүгээр зүйл (Гадаад улсын хуулийг хэрэглэх үндэслэл) агуулгын хувьд өргөжиж, шинэ хуулийн "гадаад улсын эрх зүйн хэм хэмжээг хэрэглэх" нэртэй 540 дүгээр зүйл болсон;

-426 дугаар зүйл (Гадаад улсын хууль хэрэглэхийг хязгаарлах) хасагдсан боловч агуулга нь шинэ хуулийн 540.1-д тусгалаа олсон;

-431 дүгээр зүйлийн (Эд хөрөнгийн бус амины эрхийг хамгаалах) заалт шинэ хуулийн 547.1.7-д шилжин орсон. Харин холбоос нь нэлээд өөрчлөгдсөн байна;

-1994 оны Иргэний хуулийн VII хэсгийн бусад ихэнх зүйл, заалт агуулгын хувьд үндсэн өөрчлөлтгүйгээр 2002 оны Иргэний хуульд шилжин оржээ.

в) 2002 оны Иргэний хуульд шинээр нэмэгдсэн зүйл:

-545 дугаар зүйл (ОУИЭЗ-н харилцаанд төр оролцогч болох нь);

-546 дугаар зүйл (Иргэнийг сураггүй алга болсонд тооцох, нас барсан гэж зарлах); Энэ зүйл нь 1994 оны Иргэний хуулийн 428 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн заалтыг авсан шинэ хуулийн 543.7-той зохицуулалтын хувьд давхцсан байна.

-550 дугаар зүйлд шаардах эрх шилжих асуудлын зөрчилдөөний журмыг тусгасан нь үнэхээр шинэ юм.

г) 2002 оны Иргэний хуульд шинээр нэмэгдсэн хэсэг, заалт:

-540.2 дахь хэсэгт гадаад улсын хуулиас Монгол Улсын хууль руу буцааж шилжүүлэг (ишлэл) хийх тухай тусгасан;

-540.3 дахь хэсэг нь зөрчилдөөний хэм хэмжээг хэрэглэх тохиолдол, түүний төрөл (гипотез)-ийг тодорхойлох арга журмыг агуулсан;

-543.4 дэх хэсэг нь дүрвэгсдийн эрх зүйн байдлыг зохицуулсан;

-548.1, 548.2, 548.3, 548.6 дахь хэсэг нь хэлцлийн хэлбэр, хэлцэл хүчин төгөлдөр эсэхийг тодорхойлоход зориулагдсан;

-549.3 дахь хэсэг нь хууль сонгох тухай талуудын хүсэл зоригийг хамгаалахад чиглэсэн.

2002 оны Иргэний хуулийн VI хэсэг өмнөх хуультай харьцуулбал тооны хувьд нэлээд өөрчлөгдсөн боловч агуулгын хувьд үндсэндээ бага хөндөгджээ. Өөрөөр хэлбэл, шинэ хуульд ОХУ-ын хуулийн жишиг хэвээр үлдсэн байна. Харин хуулийн зарим зүйл, заалтаас (жишээ нь, 540.2, 540.3, 548, 549.1, 550 дугаар зүйл) үзэхэд зөрчилдөөний эрх зүйн шинэлэг зохицуулалтыг бүрдүүлэх оролдлого огт хийгдээгүй биш юм. Ялангуяа хуулийн 540.2 ба 540.3 дахь хэсэгт шилжүүлгийн хүрээ болон тодорхойлох аргыг бага боловч тодруулан тусгасан нь манай улсын ОУХЭЗ-н ерөнхий ангийн хувьд дэвшилттэй явдал болжээ.

Харин "нэр", "эд хөрөнгийг үндэслэлгүйгээр олж авах буюу эзэмших" болон "даалгаваргүйгээр бусдын үүрэг биелүүлэх" үүргийн талаархи дутуу зохицуулалтыг шинэ хуульд нэмж тусгаагүй байна. Ер нь 1994, 2002 оны хуульд олон улсын хувийн эрх зүйн тусгай ангийн хувьд үндсэндээ бүрэн болсон боловч түүнд ерөнхий ангийн зохицуулалт ихэд хангагдгүй, ойлгомжгүй тусгагджээ. Иймээс тусгай ангид цоорхой гарсан, тодорхой зөрчилдөөний хэм хэмжээг хэрэглэхэд бэрхшээлтэй үед түүнийг нөхөх ерөнхий заалт дутагддаг юм. Ерөнхий ангийн энэхүү дутуу, ойлгомжгүй байдлыг онол, сургаал, эрдэмтэн судлаачдын бүтээлд дэвшүүлсэн санал, үзэл баримтлалаар нөхөх нь зохистой.

Ерөнхий анги нь бие махбодиор зүйрлэвэл судас, шөрмөс, эд эрхтэнийг холбогч хэрэгсэл нь болно. Хэрэв аль нэг эд эрхтэн нь ажиллах боломжгүй үед түүнийг нөхөх, орлуулах боломжийг хангах арга хэрэгслийг бүрдүүлэх үүрэгтэй. Энэхүү холбогч, удирдагч хэсэг болох учиртай ерөнхий ойлголт, зарчим, хэм хэмжээг хэрэглэх нийтлэг асуудлын зохицуулалт манай улсын хууль тогтоомжид үгүйлэгдэж байна. Цаашид энэ чиглэлээр хууль тогтоомжийг боловсронгуй болгох шаардлага зүй ёсоор тавигдана.

Одроо Иргэний хуудийн зөрчилдөөний буюу хэрэглэгдвэл зохистой хуулийг сонгох арга, журмыг агуулсан хэм хэмжээг төрөл, арга, техникийн хувьд нь шинжлэн үзье. Зөрчилдөөний хэм хэмжээг түүний зарим шинж онцлогор төрөлжүүлэн ангилах нь хуулийг боловсронгуй болгох, хуулийг зөв тайлбарлан хэрэглэхэд практик ач холбогдолтой байдаг юм.

Зөвхөн үндэсний төдийгүй гадаад улсын хуулийг хэрэглэх боломжийг агуулсан **олон талын** гэж нэрлэгддэг зөрчилдөөний хэм хэмжээг олон улс орнууд ОУХЭЗ-н талаарх хуульдаа оруулдаг юм. Эдгээр улсын тоонд манай улс мөн багтана. Иргэний шинэ хуулийн 548.1 дэх хэсэгт олон талын хэм хэмжээг буюу хэлцэл хийсэн аль ч улс орны (үндэсний болон гадаад) хуулийг хэрэглэх боломж агуулна. Иргэний хуулийн 543, 544, 546-552 дугаар зүйлүүдийн ихэнхи заалтууд ийм төрлийн хэм хэмжээг агуулдаг буюу манай улс үндсэндээ олон талт зөрчилдөөний хэм хэмжээний тогтолцоотой гэж хэлж болно.

Монгол Улсын Иргэний хуульд олон талын төдийгүй нэг талын зөрчилдөөний хэм хэмжээ багагүй байдаг. Монгол Улсын 2002 оны Иргэний хуулийн 543.5, 543.6, 543.7, 548.6, 548.7, 551.2, 552.4-д нэг талын хэм

¹ Т.Мэндсайхан, Олон улсын хувийн эрх зүй. УБ., 2002., 103, 142 дахь тал.

хэмжээг хэрэглэсэн буюу зөвхөн Монгол Улсын хуулийг хэрэглэх боломжийг заасан байдаг. Тухайлбал, гадаад улсад байгаа үл хөдлөх хөрөнгийн талаар монгол иргэд Монгол Улсад байхдаа хоорондоо худалдааны гэрээ хийжээ. Энэ тохиолдолд аль улсын хуулийг хэрэглэж хэлцэл буюу гэрээний хэлбэрт тааигдах шаардлагыг тогтоох вэ гэдэг асуулт үүснэ. Энд юуны өмнө Монгол Улсын хуульд дээрх асуудлыг тодруулан зохицуулсан олон талт зөрчилдөөний хэм хэмжээ байхгүй, зөвхөн монголд байгаа үл хөдлөх хөрөнгөд хамаарах нэг талын хэм хэмжээ байгааг анхаарах хэрэгтэй.

Нэг талт зөрчилдөөний хэм хэмжээнээс олон талт зөрчилдөөний хэм хэмжээ үүсгэх аргыг ОУХЭЗ-н эрдэмтэд, зарим орны шүүхийн практик хүлээн зөвшөөрсөн байдаг¹. Жишээ нь, Иргэний хуулийн 548.5-д байгаа нэг талын ЗХХ-г "аль нэг улсын нутаг (Монгол Улсын) дэвсгэр дээр байгаа үл хөдлөх хөрөнгийн талаарх хэлцлийн хэлбэрийг тухайн улсын (Монгол Улсын) хуулиар тодорхойлно." хэмээн өөрчлөн өргөжүүлэх боломжтой.

ОУХЭЗ-д зөрчилдөөний хэм хэмжээг бие даасан ба бие даагаагүй хэмээн ангилдаг. Монгол Улсын Иргэний шинэ хуулийн 543.2-д "Гадаад улсын иргэний эрхийн чадамжийг түүний харьяалагдаж байгаа улсын хуулиар тодорхойлно." гэсэн нь шууд буюу биеэ даасан ЗХХ юм. Харин Иргэний шинэ хуулийн 548.7-д "Хэлцэл хийсэн газрыг тогтоох асуудлыг Монгол Улсын хуулиар тодорхойлно." гэсэн нь шууд бус зөрчилдөөний хэм хэмжээ болно. Энэ хэм хэмжээ Иргэний хуулийн 548.2-д заасан хэм хэмжээнд туслах маягаар хэрэглэгдэнэ. ОУХЭЗ-н тодорхойлох (квалификаци хийх), хязгаарлалт, тохируулга хийх журмууд бичигдээгүй шууд бус хэм хэмжээ болдог учир Монгол Улсын Иргэний хуулийн 540, 541 дүгээр зүйлд тусгагдсан заалтууд ийм төрлийн хэм хэмжээнд хамаарна. Тухайлбал, дээрх хуулийн 540.2-д шилжүүлэг, түүнийг хамрах хүрээний тухай, 540.3-д тодорхойлох асуудлыг тусгасан нь чухал ач холбогдолтой болсон юм.

ОУХЭЗ-д зөрчилдөөний хэм хэмжээний холболтын зүйлийг тайлбарлах биш харин тодорхойлох (квалификаци хийх) ёстой гэж үздэг². Энэхүү тодорхойлох асуудал 1878 онд мэдэгдэгдсэн *genvoi*-н асуудлаас хожуу хүлээн зөвшөөрөгдсөн юм. Францын хуульч Этинне Бартин (1860-1948), германы эрдэмтэн Франц Каан (1861-1904) нар энэ ойлголтыг 1891 онд анх удаа шинжлэх ухааны эргэлтэд оруулжээ. ЗХХ нь холболтын зүйлд хэрэглэдэг ойлголт, нэр томъёогоор үндэсний эрх зүйн төдийгүй олон улсын түвшинд ялгаатай байдаг. Иймд зөрчилдөөний хэм хэмжээний дагуу зөв зүйлчлэх³ зорилгоор уг хэм хэмжээний холболтын зүйлийг тодорхойлох шаардлага үүсдэг байна.

Энэ тухай Монгол Улсын 2002 оны шинэ Иргэний хууль зохицуулахыг оролдсон байна. Тус хуулийн 540.3-д "Монгол Улсын эрх зүйн хэм хэмжээнд ямарваа нэгэн эрх зүйн харилцааг тодорхойлоогүй, эсхүл түүнийг өөр нэрийн дор ялгаатай агуулгаар тодорхойлсон бөгөөд Монгол Улсын эрх зүйн хэмжээг тайлбарлах аргаар тодорхойлж болохооргүй бол түүний эрх зүйн ангиллыг тогтооход тухайн эрх зүйн харилцаа зохицуулсан гадаад улсын эрх зүйн хэм хэмжээг харгалзаж болно" гэж заасан нь Монгол Улсын

¹ Firsching/Hoffmann. Internationales Privatrecht, 5. Aufl. 1997., S.158.

² Ангил хэлээр classification эсвэл characterization, герман хэлээр qualifikation, орос хэлээр квалификация гэж тус тус нэрлэнэ.

³ Д.Наранчимэг, Иргэний эрх зүйн үндсэн асуудал. 1999., 105-109 дэх тал.

зөрчилдөөний эрх зүйд чухал ач холбогдолтой заалт болжээ. Тодорхойлох (квалификаци хийх) асуудал үүсэх нь зөрчилдөөний болон материаллаг эрх зүйн ялгаатай байдал, мөн үндэсний болон гадаад улсын материаллаг эрх зүйн хоорондох ялгаатай байдлаар нөхцөлдөнө.

Зөрчилдөөний хэм хэмжээг императив, диспозитив шинжтэй гэж ангилж болно. Монгол Улсын шүүх үндэсний ЗХХ-г эхэлж хэрэглэх үүрэгтэй боловч гадаад улсын императив шинжтэй ЗХХ-г харгалзан үзэх учиртай. Үүний нэгэн адил гадаад улсын шүүх манай улсын ийм шинжтэй ЗХХ-г тэргүүн ээлжинд хэрэглэх нь зүйтэй. Иргэний хуулийн 552.4 дэх хэсэгт зөвхөн Монгол Улсын шүүх төдийгүй гадаад улсын шүүх ч харгалзан үзэх ёстой захирамжлах шинжтэй хэм хэмжээг тогтоосон юм.

Зөрчилдөөний хэм хэмжээг зөв сонгон хэрэглэхийн тулд үндсэн ба туслах эсхүл туслахын туслах г.м. хэм хэмжээ, түүний холбоосыг харгалзан шаардлагатай болдог. Энэхүү ангилал нь тухайн хэрэгтэй илүү ойр дотно байх эрх зүйг тогтоох аргачлал технологийг буюу зөрчилдөөний хэм хэмжээг хэрэглэх техникийг зөв ойлгоход тусална. Монгол Улсын хуульд үндсэн болон туслах хэм хэмжээг барагүй ашигласан нь арга, техникийн хувьд боловсронгуй болсны шинж.

Одоо Монгол Улсын зөрчилдөөний хэм хэмжээнд хэрэглэсэн түүний бүтэц, бүрэлдэхүүн хэсгүүдийн хоорондын харилцааг тодруулъя. ЗХХ-ий бүтэц буюу холболтын зүйл болон холболтыг тодруулах зорилгоор Монгол Улсын Иргэний хуульд байдаг нэгэн зөрчилдөөний хэм хэмжээний бүтцийг жишээ болгон үзье. 2002 оны Иргэний хуулийн 547.1.1-д эд хөрөнгийн өмчлөх эрхийг тухайн эд хөрөнгө байгаа улсын хуулиар тодорхойлно заажээ. Эхний хэсэг "эд хөрөнгийн өмчлөх эрх" нь холболтын зүйл, хоёр дахь хэсэг "тухайн эд хөрөнгө байгаа улс" нь холболт болно. Дээрхи тохиолдолд холболт нь "тухайн эд хөрөнгө байгаа улсын" гэсэн нэг л холбоосыг хэрэглэжээ. Бусад ЗХХ-д дараах холбоос буюу дүрмийг хэрэглэсэн байна. Үүнд: хувь этгээдийн хувийн хууль (543, 544, 546, 552 дугаар зүйл), хэлцэл хийсэн газрын хууль (548.2 дахь хэсэг), талууд хэрэглэгдэх хуулийг сонгох боломж (549.1 ба 549.2 дахь хэсэг), гэрээний агуулгад шийдвэрлэх ач холбогдол бүхий үүргийг гүйцэтгэж байгаа талын хууль (549.4, ба 549.8 дахь хэсэг), гэрээний үр дагавар бий болж байгаа, үүргийн гүйцэтгэлийг хүлээн авч байгаа улсын хууль (549.5, ба 549.9 дэх хэсэг), гэм хор учруулсан үйл баримт буй болсон улсын хууль (551.1 дэх хэсэг).

Монгол Улсын зөрчилдөөний хэм хэмжээнүүд дан ийм хялбар бүтэцтэй бус бөгөөд тэдгээрийн холболтын хэсэг нь холбоосоос гадна этгээд болон цаг хугацааны мөчийг тодруулсан нэмэлт зүйлсээс бүрдэнэ. Тухайлбал, өв залгамжлалын харилцаанд хэрэглэгдэх хуулийг тодорхойлсон Иргэний хуулийн 552.1-д "өвлүүлэгчийн хамгийн сүүлд байнга амьдарч байсан" гэдэг холбоосын тодотгол хэрэглэжээ. Тэгэхээр өвлүүлэгч нь холбоосыг тодотгосон субъект болно. Хэрэв холболтын зүйл цаг хугацааны урсгалаас үүдэн шинж чанарын хувьд өөрчлөгдөх үр дагаврын боломжтой учир өмнөх жишээнд "хамгийн сүүлчийн" гэдэг үг хэрэглэсэн байна. Учир нь өвлүүлэгч олон улс оронд сэлгэн амьдарч байсан байх боломж бий. Иймээс зөрчилдөөний хэм хэмжээнд холбоосыг тодорхой цаг хугацааны мөчтэй холбож өгөөгүй бол холболтын нөхцөл өөрчлөгдөх бүрд хэрэглэгдэх хууль өөрчлөгдөхөд хүргэнэ. Иргэний хуулийн 552.2-д "гэрээслэлийг хийх ба өөрчлөх үед" гэсэн холболтын хугацааны тодотгол хэрэглэсэн нь гэрээслэл хийсэн эсвэл өөрчилсний дараа

гэрээслэл бичигч хаана байх, хаана хамгийн сүүлд амьдран байх зэргээс хамааран гэрээслэлийн эрх зүйн байдал үл өөрчлөгдөх боломж олгоно.

Өөр нэг сонирхол татсан зүйл бол Монгол Улсын зөрчилдөөний хэм хэмжээнд зөвхөн ганц төдийгүй олон тооны холбоосыг зэрэг буюу холбоосын комбинаци хэрэглэсэн тохиолдол элбэг байдаг. 2002 оны Иргэний хуулийн 548.2-ын "хэлцлийн хэлбэрийг түүнийг хийсэн буюу тухайн хэлцлийн зүйлээс хамаарч холбогдох улсын хуулиар тодорхойлно." гэсэн хэм хэмжээнд "хэлцэл хийсэн улс" буюу "тухайн хэлцлийн зүйлээс хамаарч холбогдох улс" гэдэг хоёр дүрмийг зэрэг хэрэглэсэн байна. Ийнхүү олон холбоос хослон хэрэглэсэн кумулятив, альтернатив болон бусад төрлийн холболт бүхий хэм хэмжээнүүдийг дурдвал:

Монгол Улсын ОУХЭЗ-д хоёр холбоосыг зэрэгцээ буюу кумулятив холболт хэрэглэгдээгүй ба гадаад орнуудын ОУХЭЗ-д тохиолддог. Харин хоёрдогч холбоосыг ашигласан хэм хэмжээ бий. Энэ хоёрдогч холбоос нь ихэвчлэн өөр нэг хэм хэмжээнд тусгагдах учир туслах хэм хэмжээтэй адилтган андуурч болох талтай. Жишээ нь Монгол Улсын Иргэний хуулийн 548.2-т "хэлцлийн хэлбэрийг түүнийг хийсэн ... улсын хуулиар тодорхойлно", 548.4-т "Монгол Улсын хуулийн шаардлагыг хангасан бөгөөд ... хүчин төгөлдөр бус гэж тооцож болохгүй" гэж заасан нь нэг дэх хэсгийн үндсэн холбоосын үйлчлэлийг хязгаарлаж, хэлцлийг хэлбэрийн хувьд хүчин төгөлдөр болгохыг дэмжиж өгнө.

Иргэний хуулийн 548.8-ийн 2 дахь өгүүлбэр дээрхийн ижил кумулятив холболтын шинжийг агуулна. Зэрэгцээ холболтыг үндсэндээ хамгаалах, хязгаарлах чиг үүрэгтэйгээр хэрэглэнэ. Мөн Иргэний хуулийн 543.2 ба 543.4 дахь хэсгийн зохицуулалт эрх зүйн гүйлгээг хамгаалахад чиглэснийг анхаарах хэрэгтэй (шинэ хуулийн 548.2 болон 548.3, 548.4, 548.6, 548.8, 543.2 болон 543.5 зэргийг харьцуулан үз). Бодгаль болон хуулийн этгээдийн эрх зүйн чадвар, чадамжыг тусад нь хувийн хуулиар нь тодорхойлсон (Иргэний хуулийн 543 ба 544 дүгээр зүйл) нь нэг талаар хуваарилах шинжтэй. Харин олон этгээд оролцсон харилцаанд хуваарилах холболтыг жинхэнэ утгаар нь хэрэглэсэн байдаг. Жишээ нь гэр бүл бологсдод тавих урьдчилсан шаардлагыг тэдгээрийн харьяалсан улсын эрх зүйгээр (хуваарилах холбоос) тодорхойлно.

Монгол Улсын Иргэний хуульд альтернатив холболт хэрэглэсэн тохиолдол багагүй байна. *Хууль хэрэглэгч (шүүх) сонгож болох холболтыг* Иргэний хуулийн 551.1-д хэрэглэсэн гэж үзэж болно. Учир нь гэм хор учрах нөхцөл байдал үүссэн газар болон гэм хор учирсан газар өөр байх үед (дистанц бүхий деликт гэж нэрлэнэ) аль нэг улсын хуулийг шүүгч хохирогч талд ашигтайгаар шийдэх боломжтой байдаг. Мөн нэхэмжлэгчийн сонгох *факультатив холболт* Иргэний хуулийн 547.1.6 (хуучин хуулийн 431 дүгээр зүйлд ийм холболт хэрэглэгдсэн)-д бий. Дүрмийн ба дүрмийн бус тохиолдлыг зөвшөөрсөн *сөрвөлцсөн холболтыг* Иргэний хуулийн 551.1 ба 551.2-т хэрэглэжээ.

Үндсэн холбоос буюу эрх зүйг сонгох. Эрх зүйг сонгох боломж агуулсан журам ихэвчлэн гэрээний харилцаанд хэрэглэгдэнэ. Сонгох утгатай холбоос нь нэмэлт болон хязгаарлалт бүхий байдаг. Үүнийг тодруулбал:

- (1) Хэрэв талууд хэрэглэх эрх зүйгээ сонгоогүй тохиолдолд энэхүү холбоос нь өөр туслах объектив холбоосоор нөхөгдөнө. Ийм туслах холбоос

тухайлбал, Монгол Улсын 1994 оны Иргэний хуулийн 434 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг ("...талууд хэрэглэх хуулийг сонгоогүй бол...") болон шинэ хуулийн 549.4-д агуулагдана.

- (2) Талууд эрх зүйгээ сонгохдоо зөрчилдөөний эрх зүйг бус зөвхөн материаллаг эрх зүйг сонгож болохыг зөвшөөрдөг. Манай улсын хуульд энэ байдал тодорхой тусгагдаагүй.
- (3) Түүнчлэн тодорхой зорилгоор хязгаарлагдмал хүрээнд (альтернатив буюу хоёр үндсэн холбоосын аль нэгийг сонгох) эрх зүйг сонгохыг зөвшөөрнө. Жишээ нь үүрэг шаардах тал эсвэл "сулхан" тал (хэрэглэгч, ажилтан г.м.)-ын эрх ашгийг хамгаалах зорилгоор зөвхөн эдгээр талууд өөрт ашигтай хуулийг сонгох боломж олгодог. Жишээ нь, Монгол улсын Иргэний хуулийн 431 дүгээр зүйл болон 432 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт ийм зохицуулалт бий.
- (4) Тухайн улсын захирангуй хэм хэмжээгээр сонгох эрхийг хязгаарлана. Жишээ нь үл хөдлөх хөрөнгөтэй холбогдолтой гэрээнд ийм төрлийн хязгаарлалт ихэвчлэн байж болно.

Эрх зүйг сонгох холбоосыг туслах байдлаар хэрэглэх онцгой тохиолдол. Тодорхой төрлийн харилцаанд хэрэглэгдэх үндсэн холбоосын зэрэгцээ зарим нөхцөл бүрдсэн үед тодорхой тооны эрхээс аль нэгийг сонгож, туслах маягаар хэрэглэх тохиолдол байж болно. Жишээ нь ХБНГУ-д нэр, гэр бүл, өв залгамжлалд ийм холбоос хэрэглэсэн. Манай улсын хуульд ийм төрлийн холбоос хэрэглээгүй.

Түүнчлэн холболтын бусад төрлийг хуульд хэрэглэсэн тохиолдол байна. Нийтлэг зүйлийн холболт Иргэний хуулийн 551.2-т орсон. Үүний дагуу гэм хор учруулсан тохиолдолд гэм хор учруулагч болон хохирогч нар нь нэг ижил иргэний харьяалал эсвэл байнга оршин суудаг нийтлэг улстай бол тэр улсын хуулийг хэрэглэж болно. Мөн Иргэний хуулийн хуулийн 547.1.4-т "...хэлцлийн зүйл болж байгаа эд хөрөнгийг өмчлөх асуудал нь уг хэлцэлд хэрэглэгдэх хуулиар тодорхойлогдон" гэсэн нь шалтгаант (акцессор) холболтын буюу *lex causae*-н нэг жишээ юм. Энэ аргыг мөн 548.2-ийн хоёр дахь хувилбарт ашиглажээ.

Монгол Улсын Иргэний хууль зөрчилдөөний хэм хэмжээний холболтын шатлал буюу ЗХХ-ний үндсэн (дүрмийн) холбоос хэрэглэхэд боломжгүй үед субсидари буюу туслах холбоос хэрэглэсэн байна. Өөр үгээр хэлбэл, үндсэн холбоос нь иргэний харьяалал байх, хэрэв үүнийг тодорхойлох боломжгүй бол туслах холбоосоор оршин байгаа газрыг ашиглаж болно. Мөн Иргэний хуулийн 549 дүгээр зүйлийн "хууль сонгох" нь гадаад эдийн засгийн хэлцэл, гэрээнд үндсэн холбоос болно. Хэрэв хуулиа сонгоогүй бол өөр туслах холбоос хэрэгтэй болно. 549 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт гэрээний үүрэгт гол үүрэг гүйцэтгэгч (худалдагчийн) талын хуулийг туслах байдлаар хэрэглэхээр заасан. Монгол Улсын Иргэний хуулийн 549.1 ба 549.2-д гадаад эдийн засгийн хэлцэлд оролцогч талууд хэрэглэгдэх хуулиа сонгож болохыг зөвшөөрсөн байдаг. Хуулиа сонгох өөр тохиолдлыг Монгол Улсын хуульд тусгаагүй.¹

ОУХЭЗ-н шилжүүлэг нь шууд эсвэл нөхцөлт байх ба нөхцөлт шилжүүлгийн үед *renvoi*-н асуудал үүсэх боломжтой гэж үзсэн билээ. Монгол улсын зөрчилдөөний хэм хэмжээнээс үзэхэд чухам аль шилжүүлгийг

¹ Монгол Улсын Иргэний хууль /2002 он/-ийн 547.1.6-д хязгаарлагдмал сонгох эрх тусгагдсан.

зөвшөөрсөн нь тодорхой бус байна. Шүүх арбитрын практикт ч ийм асуудал хөндөгдөөгүй болно. Монгол Улсын 2002 оны шинэ Иргэний хуулийн 540.2-д "Гадаад улсын хуульд Монгол Улсын хуулийг баримтлахаар заасан бол Монгол Улсын хууль тогтоомжийг хэрэглэнэ" гэж заасныг гадаад улсын ЗХХ дотоодын эрх зүй рүү шууд шилжүүлэг хийнэ гэсэн утгыг агуулна гэж үзэх нь зүйтэй. Энд гадаадын улсын ЗХХ дотоодын эрх зүй рүү шилжүүлэг хийх тухай тусад нь дурдаад, харин дотоодын ЗХХ-ний үндсэн дээр гадаадын улсын эрх зүй рүү хийх шилжүүлэг ямар шинжтэй байхыг хууль тогтоогч нар хөндөөгүй байна.

Дотоод руу хандсан шилжүүлэг шууд байх юм бол гадаадад хандсан нь мөн шууд байна гэсэн хялбар бодомжийг мөрдвөл Монгол Улс зөвхөн шууд шилжүүлгийг хүлээн зөвшөөрнө гэж дүгнэж болно. Гэхдээ манай улстай өргөн харилцаатай нэлээд улс орнууд нөхцөлт шилжүүлгийг хүлээн зөвшөөрч байгааг бид харгалзахгүй байх боломжгүй. Иймд цаашид шилжүүлэг буюу *renvoi*-н асуудлыг илүү ойлгомжтой зохицуулах нь ОУХЭЗ-н талаарх Монгол Улсын хууль тогтоомжийг боловсронгуй болгох нэгэн чухал чиглэл юм.

Гадаад эдийн засгийн гэрээний үед манай улс (Иргэний хуулийн 549.1) эрх зүйгээ сонгохыг зөвшөөрсөн ба энэ нь зөвхөн материаллаг хэм хэмжээнд хамаарах нь зохистой. Харин сонгож болох эрх зүйн тоог хязгаарласан үед үүнийг талууд дураараа өргөжүүлэх нь хуулийн зорилгод үл тохирно. Мөн Монгол Улсын ОУХЭЗ-д гэрээний үүргийн талаарх ЗХХ нь чухам ямар шилжүүлэг хэрэглэсэн болохыг тогтоохдоо олон улсын нийтлэг жишгийг харгалзах нь зүйтэй. Олон улсын жишгээр гэрээний үүргийн хувьд зөвхөн шууд шилжүүлэг үүснэ гэж үздэг.

2002 оны Иргэний хуулийн төслийг боловсруулсан ажлын хэсгийн гишүүдийн тайлбар танилцуулгаас¹ үзэхэд ОУХЭЗ болон олон улсын иргэний процессын чиглэлээр төрөлжсөн хууль шинээр гаргах зүйтэй гэж үзсэн нь дэмжүүштэй юм. Төрөлжсөн хуульд дараахь зохицуулалтыг тусгавал зохистой санагдана. Үүнд:

А) ОУХЭЗ-ийн нийтлэг үндэслэлийн зарим зүйл, заалтыг (540 ба 541 дүгээр зүйл) дараахь байдлаар өөрчлөн найруулах, түүнд нэмэлт оруулах:

• **Хэрэглэгдэх хуулийг тодорхойлох**

1. Олон улсын шинжтэй /гадаад улсын эрх зүйн холбогдол бүхий/ иргэний эрх зүйн харилцаанд хэрэглэгдэх хуулийг энэхүү хуулийн (олон улсын иргэний эрх зүйн) үндсэн дээр тодорхойлно.

2. Хэрэв энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу хэрэглэгдэх хуулийг тодорхойлох боломжгүй бол тухайн иргэний эрх зүйн харилцаатай илүү нягт холбоотой улсын хуулийг хэрэглэнэ.

3. Энэ хуульд ямарваа нэгэн эрх зүйн харилцааг тодорхойлоогүй, эсхүл түүнийг өөр нэрийн дор эсвэл ялгаатай агуулгаар тодорхойлсон бол Монгол Улсын эрх зүйн дагуу тайлбарлах аргаар тодорхойлно. Хэрэв энэ арга боломжгүй бол тухайн харилцааны эрх зүйн ангиллыг тогтооход холбогдох гадаад улсын эрх зүйг харгалзаж болно.

¹ - ХБНГУ-ын профессор Р.Книппер, Шилжилтийн улс орнууд дахь иргэний эрх зүйн өөрчлөлт. "Эрх зүйн шинэтгэл" сонин, Тусгай дугаар, 2001 оны 11 дүгээр сар.

- Д.Наранчимэг, Иргэний хуулийн төсөл дэх шинэ болон шинэлэг зохицуулалтын онол практикийн асуудал. Мөн тэнд.

• **Гадаад улсын хууль хэрэглэхээр шилжүүлэг хийх**

1. Гадаад улсын хууль хэрэглэхээр шилжүүлэг хийх нь холбогдох /тухайн/ улсын зөвхөн материаллаг эрх зүйд хамаарна.

2. Гадаад улсын хууль Монгол Улсын хууль руу буцааж шилжүүлэг хийж байвал гэрээний үүргээс бусад тохиолдолд түүнийг хүлээн авч, Монгол Улсын материаллаг эрх зүйн хэм хэмжээг хэрэглэнэ.

3. Иргэний эрх зүйн харилцаанд оролцогч талууд тохиролцон аль нэг улсын хуулийг сонгосон бол зөвхөн холбогдох /тухайн/ улсын материаллаг эрх зүйн хэм хэмжээг баримтална.

• **Гадаад улсын хуулийн агуулгыг тогтоох**

(хэвээр үлдэх)

• **Гадаад улсын хууль хэрэглэхийг хязгаарлах**

1. Гадаад улсын хуулийг хэрэглэх нь Монгол Улсын эрх зүйн гол үндсэн зарчмууд болон Монгол Улсын Үндсэн хуультай харшлахаар бол түүнийг үл хэрэглэнэ (*ordre public*). Энэ тохиолдолд Монгол Улсын хуулийг хэрэглэнэ.

2. Монгол Улсын эрх зүйн хэм хэмжээ нь зохицуулалтын зүйл болон зориулалтын онцлогоос шалтгаалан заавал хэрэглэгдэхээр (захирангуй хэм хэмжээ) байвал гадаад улсын хууль үл хэрэглэгдэнэ. Аливаа гадаад улсын хуулийг хэрэглэх үед түүний захирангуй хэм хэмжээг нэгэн адил харгалзан үзэж болно.

Б) Тусгай анги буюу зөрчилдөөний хэм хэмжээнүүдийг хувьд:

I. Зарим зөрчилдөөний хэм хэмжээг (одоогийн хуулийн 544, 545 дугаар зүйлүүд) дараахь байдлаар шинэчлэн найруулах:

• **Гадаад улсын хуулийн этгээдийн иргэний эрх зүйн чадвар**

1. Гадаад улсын хуулийн этгээдийн иргэний эрх зүйн чадварыг түүний үүсгэн байгуулагдсан улсын хуулиар тодорхойлсныг тус улсад хүлээн зөвшөөрнө.

2. Гадаад улсын хуулийн этгээд Монгол Улсын нутаг дэвсгэр дээр хэлцэл хийхдээ өөрийн удирдах байгууллага, төлөөлөгчийн бүрэн эрхийн талаар Монгол Улсын хуульд байхгүй хязгаарлалтыг үндэслэж болохгүй.

• **Төр олон улсын иргэний эрх зүйн харилцаанд оролцогч болох нь**

Монгол Улсын төр олон улсын иргэний эрх зүйн харилцаанд нэг тал болон оролцож байвал дор дурдсанаас бусад тохиолдолд зөвхөн Монгол Улсын хуулийг хэрэглэнэ:

1. Монгол Улсын төр гадаад улсын хууль хэрэглэхийг зөвшөөрснөө шууд илэрхийлсэн;

2. Гадаад улсын нутаг дэвсгэр дээр байгаа үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой эрх зүйн харилцаа;

3. Гадаад улсын сонирхол бүхий аж ахуйн байгууллагад хувь оролцох талаарх эрх зүйн харилцаа.

II. Итгэмжлэл, нэр, үндэслэлгүйгээр баяжих болон бусдын үүргийг даалгаваргүйгээр гүйцэтгэх талаар зарим зөрчилдөөний хэм хэмжээг шинээр нэмэх:

"Гэрээний бус үүргийн харилцаанд үүрэг үүсэх үндэслэл болсон үйл баримт бий болсон улсын эсхүл үүрэг гүйцэтгэгчийн оршин байгаа улсын хуулийг хэрэглэнэ" гэсэн зохицуулалт хэрэглэх хувилбар бий.

В) Зөрчилдөөний хэм хэмжээний бүтэц, хэрэглэх асуудал:

Зөрчилдөөний хэм хэмжээнд олон холбоосыг¹ зэрэг хэрэглэх тохиолдол байдаг. Эдгээр холбоосыг хамтад нь эсвэл альтернатив эсвэл хуваарилах байдлаар үр дагаврын хувьд ялгавартай зөв хэрэглэхийн тулд хуульд үүнийг тодорхой заах хэрэгтэй. Одоогийн хуульд "болон", "буюу", "эсхүл" гэсэн үгээр дээрх холбоосыг хооронд нь холбосон байна. Үүнээс "буюу" гэсэн үг олон дахин хэрэглэгдсэн ба "эсхүл", "болон" гэдэг үгээс ямар ялгаатай болохыг зөв тогтоох чухал юм. Зарим үед "буюу" гэдэг үгийн оронд "эсхүл" гэдэг үгийг хэрэглэх нь илүү ойлгомжтой болохоор байна. Мөн субсидар буюу туслах шинжтэй олон шат дараалсан хэм хэмжээг ОУИЗЗ-д өргөн хэрэглэдэг. Өөрөөр хэлбэл, үндсэн хэм хэмжээг хэрэглэх боломжгүй үед туслах хэм хэмжээг шат дараалан хэрэглэнэ. Үүнийг шүүх, арбитрын практикт анхаарах нь зүйтэй.

Г) Нар томьёо: ОУИЗЗ-н олон ойлголт, хэллэг, нар томьёо гадаад хэлнээс орж ирсэн учир энэ чиглэлийн судлаачид, мэргэжилтнүүд зөвшин хэлэлцсэний үндсэн дээр монгол хэлнээ нэгдмэл нэг янзаар нэрлэж, бичиж хэвших шаардлагатай байна. Тухайлбал, олон улсын иргэний эсхүл олон улсын хувийн эрх зүй гэж нэрлэх үү, зөрчилдөөний хэм хэмжээ, гадаад улсын хууль руу шилжүүлэг хийх, материаллаг хэм хэмжээ, холболт холбоос гэсэн ойлголт нар томьёог хэрэглэх үү г.м. Хуульд орсон нар томьёо цаашид хэвшмэл шинжтэй болох илүү бололцоотойг харгалзан үзэх нь зүйтэй.

Гадаад орнуудын иргэний ба худалдааны хууль тогтоомжийг харьцуулан судлахад хамгийн тогтвортой, удаан настай, хууль тогтоогчдоос өөрчлөх хөдөлгөхдөө хамгийн хойрго байдаг хууль бол иргэний хууль байдаг. Учир нь уг хуулиар зохицуулагддаг харилцааны төрөл олон янз, цар хүрээ маш өргөн, орон зай хязгаартгүй, цаг хугацаа тасралтгүй билээ. Иймд хуучин, шинэ хуулийн агуулгын төдийгүй үйлчлэх хугацааны ялгаа, зөрөө нь багагүй хэмжээний бэрхшээл, зөрчилдөөн, хууль ёсны тонуул² бий болох нөхцөлийг бүрдүүлнэ.

Орчин үеийн иргэний эрх зүйчдийн түгээмэл үзэл баримтлалаас үзэхэд иргэний хууль удаан хугацаанд тогтвортой болон зохистой зохицуулж үйлчлэхийн тулд хэтэрхий нарийвчилсан зохицуулалтаас зайлсхийх, ерөнхий нийтлэг заалтыг өргөжүүлэх, талуудын эрх чөлөөг бага хязгаарлах, шүүхийн практикт илүү ач холбогдол өгөх шаардлагатай ажээ.

-ooOoo-

¹ ОУХЗЗ-д зөрчилдөөний хэм хэмжээний бүтцийг тодруулахдаа холболт /диспозици/-ын тодорхой нэг дүрмийг холбоос гэж нэрлэдэг. Жишээ нь хэлцлийн хэлбэрийг хэлцэл хийсэн улсын хуулиар тодорхойлно гэсэн хэм хэмжээний "хэлцэл хийсэн улсын" гэдэг нь уг хэм хэмжээнд хэрэглэгдсэн холбоос юм.

² Ф.Бастия, Хууль. УБ., 2002., 20 дахь тал

ЛИЗИНГИЙН ГЭРЭЭНИЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН АСУУДАЛ

*ХЗҮТ-ийн Иргэний хууль тогтоомжийн секторын
эрдэм шинжилгээний ажилтан У.Мөнхбат*

Оршил

Улс орнуудын эдийн засгийн харилцаа, шинжлэх ухаан, техник, технологи хурдацтай хөгжих тусам олон улсын харилцаанд худалдаа, хөрөнгө оруулалт, санхүүгийн үйлчилгээний төрөл болох факторинг, франчайзинг, лизинг, форфейтингийн хэрэглэгдэх хүрээ орон зайгаа тэлж байгаатай уялдаад улс орнууд дотоодын хууль тогтоомжоо өөрчлөх, боловсронгуй болгох хэрэгцээ бий болж байна. Энд би 2002 оны Иргэний хуульд орсон лизингийн гэрээний нэг төрөл болох санхүүгийн түрээсийн гэрээний талаар товч авч үзэв. Энэ ойлголт нь манай орны хувьд шинэ зүйл боловч хөгжлийн урт удаан хугацааны түүхтэй үзэгдэл юм.

Анхны лизингийн операцийг ойролцоогоор МЭӨ 2000 жилийн тэртээ Вавилонд явуулж байсан гэж түүхэнд тэмдэглэсэн байна. Улмаар XI зуунаас Венец /Итали/-д, XIX зууны үеэс АНУ-д, дэлхийн хоёрдугаар дайны дараа буюу 1950-1970 онуудад Япон болон баруун Европын орнуудад, 1970 оноос хойш хөгжиж байгаа орнуудад санхүүгийн түрээсийн операци нь нэлээд хурдацтай хөгжих болжээ.

1. Санхүүгийн түрээс буюу лизингийн тухай ойлголт, тодорхойлолт

Санхүүгийн түрээс гэж санхүүгийн аль ч төрөл хэлбэрүүдийн өвөрмөц шинжүүдийг агуулсан түрээсийн онцгой хэлбэр юм. Энэ нь шинээр үүсч буй аж ахуйн нэгж, байгууллага болон үйл ажиллагаагаа цаашид явуулах санхүүгийн болон техник, технологийн хүндрэл, бэрхшээлтэй жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд банкны зээлийг орлож чадах, хөрөнгө оруулалтын "боломж"-ийн таатай хэлбэр болж өгдөг.

Санхүүгийн түрээсийн операцийг зохих журмын дагуу буюу боловсронгуй, нарийвчлан зохицуулсан хууль тогтоомжийн дагуу явуулбал тухайн харилцаанд оролцогчдын аль, алинд нь ашигтай байдаг байна. Санхүүгийн түрээс буюу лизинг нь энэ утгаараа эдийн засгийн агуулгатай ойлголт болох бөгөөд ийм тодорхойлолтуудыг ном зохиолоос харж болох юм. Тухайлбал, "лизинг нь санхүүгийн хөрөнгө оруулалтын нэг хэлбэр"; "лизинг нь түрээслэгчид тодорхой хугацаанд, төлбөртэйгээр хувь хүн, хуулийн этгээдээс лизингийн гэрээнд заасны дагуу авсан эд хөрөнгөө шилжүүлэх хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа юм" /ОХУ-ын Лизингийн тухай хууль /1998 он/-ийн 2 дугаар зүйл/.

Харин лизинг нь хууль зүйн шинж чанараараа иргэний эрх зүйн харилцааг үүсгэх, өөрчлөгдөх, дуусгавар болгоход чиглэгдсэн хэлцэл гэж ойлгогддог байна.

¹ Лизинговые отношения в России /Законодательные и нормативные акты, образцы договоров лизинга, комментарий специалистов/. 2000г., №4, С. 3.

Энэ утгаараа:

-Лизингийн хэлцэл гэдэг нь түрээслүүлэгч, түрээслэгч, лизингийн зүйлийг худалдагч /үйлдвэрлэгч, нийлүүлэгч/ худалдан авагчийн хооронд лизингийн гэрээ үйлдэхэд зайлшгүй шаардлагатай гэрээүүдийн цогц юм;

-Санхүүгийн түрээсийн гэрээ гэдэг нь түрээслүүлэгч, түрээслэгчийн заасан эд хөрөнгийг худалдагчаас өмчлөлдөө авах, мөн түрээслэгчид энэхүү эд хөрөнгийг үйлдвэрлэл /аж ахуй/ эрхлэхэд нь тодорхой хугацаагаар төлбөртэйгээр эзэмшил, ашиглалтад нь шилжүүлэх үүрэг бүхий иргэний эрх зүйн гэрээ юм;¹

-Лизингийн гэрээ гэдэг нь лизингийн зүйлтэй холбоотойгоор иргэний эрх, үүргийг тогтоох, өөрчлөх дуусгавар болгоход чиглэгдсэн лизинг өгөгч болон лизинг авагчийн хооронд бичгийн хэлбэрээр байгуулсан тохиролцоо.²

Дээрхээс дүгнэн дараахь үндсэн хоёр тодорхойлолтыг өгч болох юм.

Санхүүгийн түрээсийн үйл ажиллагаа гэдэг нь түрээслэгч нь лизингийн объектыг өөрийн үзэмжээр сонгож, түрээслэгчийн хөрөнгөөр авч эзэмших, ашиглах, уг эд хөрөнгийг өмчлөх эрх нь хадгалагдаж буй түрээслэгчээс санхүүгийн гэрээний үндсэн дээр тодорхой хугацаанд, тодорхой нөхцөлтэйгөөр ашиглахтай холбогдсон хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны төрлийг хэлнэ.

Харин санхүүгийн түрээсийн гэрээ гэдэг нь түрээслүүлэгч, түрээслэгчийн сонгож, тодорхойлсон эд хөрөнгийг өөрийн нэр дээр худалдан авч, түүнд эзэмшүүлж, ашиглуулах эсвэл өмчлүүлэх, түрээслэгч нь түрээслүүлэгчид эд хөрөнгийн элэгдэл хорогдлын үнийн нийт болон дийлэнх хэсгийг тодорхой хугацаатайгаар төлөх эрх, үүрэг бүхий нэгээс дээш жилийн хугацаатайгаар байгуулсан хэлцэл юм. Агуулгын хувьд санхүүгийн түрээсийн үйл ажиллагаа болон гэрээ нь лизингийн цогц үйл ажиллагааны нэг төрөл болдог.

2. Лизинг /санхүүгийн түрээс/-ийн гэрээний үндсэн шинж

Эрдэмтэд, судлаачдын дунд лизингийн гэрээний онцлогийг тодорхойлох талаар янз бүрийн үзэл баримтлалтай байдаг. Тэдний нэг хэсэг нь эд хөрөнгө хөлслөх гэрээний нэг төрөл гэж үздэг³ бол нөгөө хэсэг нь зээлийн гэрээний болон худалдах худалдан авах гэрээний төрөл, харин гурав дахь хэсэг эрдэмтэд нь түрээсийн гэрээ, зээлийн гэрээ мөн бусад гэрээний шинжийг агуулсан гэрээний онцгой төрөл гэж үздэг байна. /Гражданское и торговое право в капиталистических странах. Москва, 1986 г./

Энэхүү гэрээг түүнтэй адил төстэй хөлслөх гэрээ, түрээсийн гэрээ, зээлийн гэрээ, зээлээр худалдах-худалдан авах гэрээ, зуучлалын гэрээ зэргээс дараахь шинжүүдээр ялгаж болно.

¹ К.Шмиттофф, Экспорт: Право и практика международной торговли. М., 1993, С. 237.

² Лизинговые отношения в России /Законодательные и нормативные акты, образцы договоров лизинга, комментарий специалистов/. 2000г., №4, С. 59.

³ А.С.Скряидов, "Международное частное право" Санкт-Петербург., 1998, С. 154.

1. Субъектээрээ ялгаатай. Дээр дурдсан гэрээнүүдэд 2 тал оролцдог бол санхүүгийн түрээсийн гэрээнд 3 тал оролцдог бөгөөд үүнд нийлүүлэгч буюу үйлдвэрлэгч, түрээслэгч буюу лизинг авагч, түрээслүүлэгч буюу лизинг өгөгч гэсэн субъектууд байна. Улс орнуудын практикаас харахад түрээслүүлэгч нь ихэвчлэн банк болон лизингийн үйлчилгээгээр төрөлжсөн тусгай байгууллагууд байдаг байна. Мөн төр нь санхүүгийн түрээсийн гэрээний оролцогч байж болдог практик нэгэнт тогтжээ.

2. Санхүүгийн түрээсийн гэрээний зүйл нь аж ахуй, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эрхлэхэд зориулсан хөдлөх буюу үл хөдлөх эд хөрөнгө байдаг. Гэхдээ санхүүгийн түрээсийн гэрээний зүйлд эдэлбэр газар болон бусад байгалийн объектууд ордоггүй. Харин аж ахуй, үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа ямар ч /хүнсний ба өргөн хэрэглээний бус/ эд юмс байж болно.

Практикт ихэвчлэн гэрээний дараахь зүйлүүд байдаг. Хөдлөх хөрөнгөд нь тээврийн хэрэгсэл /ачааны болон суудлын/, барилгын техник, суурь машин, тооцоолон бодох техникийн болон мэдээлэл боловсруулах хэрэгслүүд, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, механизм, багаж хэрэгсэл, лиценз, ноу-хау, компьютерийн программ гэх мэт объектууд, харин үл хөдлөх хөрөнгөд нь үйлдвэр, барилга байгууламж ордог байна.

3. Санхүүгийн түрээсийн гэрээ байгуулах үйл ажиллагаа нь бусад гэрээг бодвол нарийн процесст явагддаг. Нэгдүгээрт: түрээслэгч нийлүүлэгчийг сонгож, лизингийн зүйлийг тодорхойлох бөгөөд тоног төхөөрөмж худалдан авах гэрээний нөхцөлийг нийлүүлэгчтэй тохиролцоно. Хоёрдугаарт: түрээслүүлэгч түрээслэгчээс түүний нийлүүлэгчтэй хийсэн тохиролцоотой холбоотой баримт бичгийг шилжүүлж авна. Гуравдугаарт: эцсийн тохиролцоонд хүрсэн тохиолдолд түрээслүүлэгч нь түрээслэгчийн даалгавраар нийлүүлэгчтэй бараа, тоног төхөөрөмж худалдах-худалдан авах гэрээг байгуулж, өөрийн өмчлөлдөө авна. Дөрөвдүгээрт: түрээслүүлэгч нь түрээслэгчид худалдан авсан тоног төхөөрөмжөө гэрээний үндсэн дээр түрээслүүлнэ.

4. Санхүүгийн түрээсийн гэрээ нь хатуу тогтоосон журмын дагуу хэрэгждэг. Түүнд түрээсийн төлбөр төлөх график, хатуу тогтоосон хугацаа, гэрээний зүйлийн элэгдэл, хорогдлыг тооцох журам, даатгал болон эрсдэлийг хуваарилах асуудал зэргийг тусгаж өгдөг.

5. Түрээслүүлэгч нь худалдах-худалдан авах гэрээндээ тухайн гэрээний зүйлийг өөр этгээдэд санхүүгийн лизингийн гэрээгээр шилжүүлнэ гэдгээ дурдсан байх ёстой.

6. Санхүүгийн түрээсийн гэрээний бусад гэрээнээс ялгарах нэг онцлог нь санхүүжилтын зорилготой гэж хэлж болно. Өөрөөр хэлбэл түрээслэгчийн үндсэн хөрөнгөд нь хамаарах эд хөрөнгийг өөрөө худалдан авахад эргэлтийн хөрөнгөгүй болчихгүйн тулд энэ гэрээний төрөл ашигтай байдаг.

7. Санхүүгийн түрээсийн гэрээний хугацаа дуусвал гэрээний зүйлийг түрээслэгчид худалдаж болдгоороо бусад гэрээнээс ялгагдана.

8. Лизингийн үйл ажиллагааны санаачилгыг талуудын хэн нь ч гаргаж болох бөгөөд үүнээс шалтгаалахгүйгээр түрээслэгчийн сонголт чухал байдаг.

Санхүүгийн түрээсийн гэрээний сонгодог ойлголтоор түрээслүүлэгч түрээслэгчийн сонголтод нөлөөлөх ёсгүй юм.

3. Лизингийн төрөл, хэлбэр

Практикт болон судлаачдын онол, үзэл баримтлалаар санхүүгийн түрээс, гүйлгээний буюу ашиглалтын лизинг, буцах лизинг гэсэн лизингийн нэлээд хэрэглэгддэг төрөл байна.¹

Үүнээс гадна лизингийг түрээслэгч болон түрээслүүлэгчийн хооронд зохион байгуулагдах харилцааны онцлогоос шалтгаалан шууд ба шууд бус лизинг; оролцогчид болон лизингийн зүйлийн аль улсад харьяалагдаж байгаагаар нь үндэсний ба олон улсын; үйлчлэх хугацаагаар нь урт хугацааны, дундаж, богино хугацааны; гэрээний зүйлээс нь шалтгаалаад хөдлөх, үл хөдлөх эд хөрөнгийн лизинг; санхүүжүүлж буй хэлбэрээр нь нэг удаагийн болон дахин лизинг гэж судлаачид ангилж үздэг байна. Дээрх ангилалтууд лизингийн гэрээ нь янз бүрээр хэрэглэгдсэний үр дүн бөгөөд лизингийн шинжүүдийг бусад гэрээний элементүүдтэй холимог маягаар ашиглах нь их болсон.

Мөн лизингийг дараахь байдлаар ангилжээ². Үүнд:

1. Стандарт лизинг-лизингийн энэхүү хэлбэрийн үед нийлүүлэгч нь төхөөрөмжийг лизингийн компанид худалдана. Лизингийн компани нь лизинг авагчид энэ тоног төхөөрөмжийг түрээсэлнэ. Нийлүүлэгч, лизинг авагч хоёрын хооронд лизингийн гэрээний талаар эрх зүйн харилцаа үүсэхгүй. Гэвч техникийн үйлчилгээг нийлүүлэгч нь хариуцах бөгөөд лизингийн компани нь техникийн үйлчилгээний асуудалд оролцохгүй.

2. Буцах лизинг-түрээслэгч нь эргэлтийн хөрөнгөгүй болсон тохиолдолд лизингийн объектыг түрээслэгчид худалдаад дараа нь түүнийгээ санхүүгийн түрээсийн гэрээний үндсэн дээр авч ашигладаг байна.

3. "Уян" лизинг-лизингийн энэхүү төрлийн онцлог нь лизинг өгөгч нь лизинг авагчид нэгэнт үйлчилгээ үзүүлэхээр байгуулагддаг. Энэ нь лизингийн гэрээ нь өртөг өндөртэй. Учир нь лизинг өгөгч нь тоног төхөөрөмжид шаардагдах засвар, даатгал, заримдаа үйлдвэрлэлийг явуулахад оролцдог. Мөн шатахуун түлш нийлүүлэх ажлыг гүйцэтгэдэг. Ихэвчлэн энэхүү лизингийг өндөр хүчин чадалтай, шинэ тоног төхөөрөмж жишээлбэл компьютер, онгоц, бусад нарийн машин, механизмуудыг ашиглахад хэрэглэдэг.

4. Цэвэр лизинг-энэ тохиолдолд тоног төхөөрөмжийг ашиглахтай холбоотой үндсэн үүрэг нь лизинг авагчид байдаг. Тэр татвар, хураамж төлөх, тоног төхөөрөмж ашиглахтай холбоотой даатгал болон бусад бүх зардлыг хариуцдаг.

¹ Юридическая энциклопедия. М., 1999., С. 877-879.

² Международное валютно-кредитные и финансовые отношения. /Финансы и статистика/. М., 2000., С. 237.

5.Тоног төхөөрөмжийн үндсэн үнийн лизинг-ашиглалтад байсан тоног төхөөрөмжийг энэхүү харилцаанд хэрэглэдэг. Дилерүүд /худалдааны агентууд/ өргөн ашигладаг.

6.Нийлүүлэгчийн лизинг-түрээсийн энэ хэлбэр нь буцах лизингийн хэлбэртэй төстэй. Тоног төхөөрөмжийг нийлүүлэгч нь хоёр талын үүрэгтэй байдаг.

7.Үргэлжлүүлэх /дахин/ лизинг-энэ хэлбэрийн лизингийн үйл ажиллагаагаар урд нь түрээслүүлсэн тоног төхөөрөмжийг илүү боловсронгуй болгон, тодорхой үе шаттайгаар өөрчлөхөд оршино. Жишээ нь компьютерын үйлчилгээ.

8. Бүрэн үйлчилгээтэй лизинг-“уян” лизингтэй төстэй. Гэвч төрөл бүрийн үйлчилгээ /тусламж/ үзүүлэхээр гэрээнд заасан байдаг. Жишээ нь лизинг өгөгч нь түрээслэгч тоног төхөөрөмжийг авахаас өмнө судалгаа хийх, тухайн тоног төхөөрөмжийг ашиглахад шаардлагатай түүхий, эд материалыг нийлүүлэх, өндөр мэргэжилтэй хүн олж өгөх гэх мэт.

Эдгээрээс гадна хуучин Тусгаар улсуудын хамтын нийгэмлэгийн улсууд оролцсон “Улс хоорондын лизингийн тухай” 1998 оны конвенцын 3 дугаар зүйлд улс хоорондын лизингийн дараахь төрлүүдийг тусгасан байна. Үүнд: Санхүүгийн лизинг, гүйлгээний /шуурхай/ лизинг, буцах лизинг, бартерын лизинг байхаас гадна лизингийн бусад төрөл байж болохыг тус конвенц үгүйсгээгүй. Зарим улс орнуудын практикт гэрээний хэлбэрийн хувьд заавал бичгээр хийх хууль зүйн шаардлага байхгүй бөгөөд бүр интернетээр, утсаар, факсаар, шуудангаар гэх мэт бусад хэлбэрээр байгуулж болохоор байна. Харин Монгол Улсын Иргэний хуульд зааснаар бол заавал бичгээр хийх ба энэ шаардлагыг хангахгүй буюу бичгээр хийгээгүй бол хүчин төгөлдөр бусад тооцогдоно.

4. Санхүүгийн түрээсийн гэрээ ба Монгол Улсын болон олон улсын практик

Монгол Улсын практикт лизингийн үйл ажиллагаа 1990 оноос эхлэн явагдсан гэх боловч 1998 оноос зарим хуульд энэхүү харилцааг зохицуулж өгсөн байна. Тухайлбал, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 3-т “санхүүгийн лизинг” гэж; Банкны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1-ийн 10-т “санхүүгийн түрээсийн үйл ажиллагаа” гэж; Гадаад хөрөнгө оруулалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6-д “санхүүгийн лизинг болон франчайзингийн хэлбэрээр хөрөнгө оруулах”, мөн тус хуулийн 3 дугаар зүйлийн 4-т “гадаадын хөрөнгө оруулалтын гэрээ гэдэг нь заавал хуулийн этгээд байгуулахгүйгээр тодорхой төслийг хэрэгжүүлэхийн тулд гадаадын хөрөнгө оруулагчдаас оруулж байгаа санхүүгийн лизингийн болон франчайзингийн, менежмент, маркетинг, бүтээгдэхүүний хувь оруулахтай холбогдсон аливаа хөрөнгө оруулалтын гэрээ эсвэл хэлцэлийг хэлнэ” гэж; Иргэний хуулийн “Санхүүгийн түрээс /лизинг/” гэсэн 26 дугаар бүлэгт буюу 312 дугаар зүйлийн 1-д “Санхүүгийн түрээсийн гэрээгээр түрээслүүлэгч нь гэрээнд заасан хугацаагаар түрээслэгчийн ашиглалтад эд хөрөнгө шилжүүлэх, түрээслэгч нь тогтмол хугацаанд түрээсийн төлбөр төлөх үүргийг тус тус хүлээнэ” гэж; Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай Монгол

Улсын хуулийн 7 дугаар зүйлийн 1.3-т "санхүүгийн түрээсийн үйл ажиллагаа (үйлчилгээ)" гэсэн зохицуулалтыг оруулж өгчээ.

Эндээс харахад хууль тогтоомжид тус ойлголтыг ялгаатай нэр томъёогоор тодорхойлсон байна. Энэ нь цаашид үүнтэй холбогдсон аливаа харилцаанд хэлбэрийн ялгаатай байдлаас агуулгын зөрчилд хүргэж болох сөрөг талтай юм. Тиймээс нэр томъёоны ялгаатай байдлыг арилгаж, нэг мөр ойлгох үүднээс түүнийг жигдрүүлэх хэрэгтэй байна.

Шинэ Иргэний хууль батлагдаагүй байхад манай практикт лизингийн гэрээний зарим элементийг агуулсан гэрээнүүд /жишээ нь, эзэлээр худалдах-худалдан авах гэрээ, такси түрээсээр эзэмшүүлэх гэрээ, такси түрээсээр худалдах, лизингийн гэрээ гэх мэт/-ийг байгуулж байжээ. Эдгээр гэрээг байгуулах гол үндэслэл нь 1994 оны Иргэний хуулийн 169 дүгээр зүйл болж байсан хэдий ч зарим тийм төрлийн гэрээ нь тус хуулийн худалдах-худалдан авах гэрээний хэм хэмжээнд үндэслэсэн байсан нь шүүхэд тухайн харилцаатай холбоотой маргааныг шийдвэрлэхэд нэлээд бэрхшээлтэй тулгарч байв. Өөрөөр хэлбэл, түрээсийн гэрээ, худалдах-худалдан авах гэрээ, нэрлэгдээгүй гэрээний зохицуулалтын алиныг нь үндэслэж шийдвэрлэх вэ гэсэн асуудал үүсдэг юм. Харин 2002 оны Иргэний хуульд санхүүгийн түрээсийн гэрээний тусгайлсан зохицуулалт оруулснаар энэ асуудлыг нэг мөр болгосон.

Одоо практикт байгуулагдаж буй санхүүгийн түрээсийн /лизинг/ гэрээнээс харахад ихэнхи нь түрээслүүлэгчийн эрх нь илүү давамгайлсан байдалтай байх бөгөөд түрээслэгч нь тухайн гэрээний нөхцөлүүдийг зөвшөөрөх эсэх нь тэдэнд чухал биш гэсэн хандлага ажиглагдаж байна. Түрээслэгч лизингийн гэрээнд санал оруулах буюу боловсруулахад оролцох эрх нь хязгаарлагдмал байх нь элбэг. Энэ байдал нь тухайн санхүүгийн түрээсийн үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуй нэгж, хуулийн этгээдийн нэг талаас эрсдэл багатайгаар ашиг олох гэсэн зорилготой, нөгөө талаас санхүүгийн түрээсийн үйл ажиллагааны мөн чанар /давуу тал/-ыг ойлгоогүйтэй холбоотой юм.

Монгол Улсын Иргэний хуулийн 312 дугаар зүйлд лизингийн гэрээ /санхүүгийн түрээсийн биш 3 төрлийг тодорхойлж өгчээ. Нэгд, санхүүгийн түрээсийн гэрээ; хоёрт, шууд лизинг /энэ нь үйлдвэрлэгч өөрөө түрээслэгчид лизингийн гэрээний дагуу хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгийг шилжүүлдэг/; гуравт, үргэлжлүүлэн хийх лизингийн гэрээ болно.

Эндээс би Иргэний хуульд ойлголтын ялгаа байгааг харуулах гэсэн юм. Олон улсын практикт дээрх 3 төрлийн гэрээ нь өөр өөрийн өвөрмөц онцлог шинж, давуу болон сул талаараа, тухайн харилцааны ямар хэсэгт хэрэгтэй зэргээрээ хэрэглэгдээд тогтчихсон. Мэдээж энэ тохиолдолд гадаадын бизнес эрхлэгчид Иргэний хуулийн зохицуулалтыг ойлгоход хүндрэлтэй болно. Мөн саяхан шүүгчдийн дунд явуулсан судалгааны явцад "Иргэний хуульд орсон ойлгомжгүй нэр томъёо байна уу?" гэсэн асуулагд "санхүүгийн түрээс /лизинг/", "үзүфрукт", "факторинг" гэх зэргээр хариулж байсан. Тэгэхээр Улсын дээд шүүхээс гадаад зарим нэр томъёог агуулгын болон утгын аль аль талаас нь тайлбар хэрэгтэй болжээ.

ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГИЙН ЭРХ ЗҮЙН ХАМГААЛАЛТ

(Монгол, Японы үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн харьцуулалт)

Отгонтэнгээр их сургуулийн магистрант О. Цэвэлмаа

Япон улсын хувьд үл хөдлөх хөрөнгийн бүртгэл нь олон жилийн түүхтэй бөгөөд газар болон барилга, байгууламжийг тус тусад нь бүртгэдэг байна. Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн зорилго нь субъектын эрхийг хуулиар хамгаалахаас гадна үл хөдлөх эд хөрөнгийн гүйлгээ, гэрээ зэргийн эрсдэлгүй байдлыг хангаж баталгаажуулах гэсэн нийгмийн чухал үүргийг гүйцэтгэж байна.

Япон улсад үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийг төрийн байгууллага хариуцан ажилладаг. Японы Иргэний хуулийн 176 дугаар зүйлд зааснаар үл хөдлөх эд хөрөнгөтэй холбогдсон эрх нь субъектын хүсэл зоригийн илэрхийллээр өөрчлөлт, хөдөлгөөнд орно. Жишээлбэл: Х байшингийн эзэмшигч А тухайн байшинг В-д худалдах тохиолдолд Х-ийн байшин нь зөвхөн А, В-ын хоорондын тохиролцоогоор л В-ын эзэмшилд шилжинэ. Японд гэрээг нотариатаар баталгаажуулах шаардлага байхгүй. Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэл нь тус улсын Иргэний хуулийн 177 дугаар зүйлд зааснаар гуравдагч эдгээдээс хууль ёсны эзэмшигчийг хамгаалах үүрэгтэй. Өөрөөр хэлбэл В нь Х байшинг А-аас худалдан авч, бүртгэлийг өөрийн нэр дээр шилжүүлсний дараагаар С гарч ирэн Х байшинг өөрийн өмч хэмээн маргаан үүсгэсэн тохиолдолд В нь бүртгэлийн үйлчлэлээр эзэмших эрх хамгаалагдах болно.

Монголд үл хөдлөх эд хөрөнгөтэй холбоотой гэрээг нотариатаар батлуулж байж хүчин төгөлдөр болдог ба Японд үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийг сонирхогч этгээдийн мэдүүлгийг үндэслэж төрийн байгууллага болох Хууль зүйн харьяаны Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн газар гүйцэтгэдэг бөгөөд холбогдох бүх журам нь үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн хуулиар зохицуулагдсан байна.

Японд үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэл нь үл хөдлөх эд хөрөнгийн тухай хууль болон хууль зүйн яамнаас батлан гаргасан журмын дагуу явагддаг. Тус улсад газар ба байшин, барилгыг тус тусад нь бүртгэдэг тул нэг мужид 10-аас дээш тооны үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн газар байдаг. Японы үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн газар нь аливаа үл хөдлөх хөрөнгө тус бүрт бүртгэл хөтөлдөг.

Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийг гаргахдаа эрхийг шилжүүлэн өгч буй этгээд болон эрхийг шилжүүлэн авч буй этгээд хамтарч гаргана. Жишээ нь, байшин худалдсан хүн ба худалдан авсан хүн хамтарч зохих мэдүүлгийг бүрдүүлж, шаардлагатай баримт бичгийг хавсарган харьяаллынхаа үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн газарт өгөх ёстой. Ийнхүү бүртгүүлэх үед үл хөдлөх эд хөрөнгийн зөвшөөрлийн татвар /хураамж/ хэмээх улсын татварыг төлөх хэрэгтэй болдог.

Мэдүүлгийг хүлээн авсан бүртгэгч юуны өмнө мэдүүлгийн хүлээн авсан дугаарыг олгож, дараа нь мэдүүлгийн агуулга ба бүртгэлийн дэвтрийг

харьцуулан алдаа мадаг байвал мэдүүлгийг буцааж, хэрэв тийм бус бол бүртгэлийг гүйцээх ёстой.

Бүртгэл дууссан тохиолдолд мэдүүлэгт хавсаргасан бичиг баримтанд бүртгэгдсэн тухай тамга дарж, мэдүүлэг гаргагчид буцааж өгнө. Мэдүүлэг нь бүртгэлийн дэвтрээс тусдаа хадгалагддаг. Тэдгээр нь тус тусын хувийн дугаарын дэс дарааллын дагуу хадгалагдаж байдаг тул хайж олоход маш хялбар байна.

Японд зөвхөн үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлээр зогсохгүй ер нь ямар ч гэрээг нотариатаар батлуулах шаардлагагүй. Японд үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийг даалгаврын гэрээгээр бусдаар төлөөлүүлэн хийлгэж болох боловч түүнийг зөвхөн мэргэжлийн хүн л хийх эрхтэй байдаг. Японд үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн бараг бүгдийг нь шихо-шоши нар төлөөлөн гүйцэтгэдэг /шихо-шоши буюу бичиг хэргийн хууль/. Шихо-шоши нь хуулийн зүйн сайдын явуулдаг шалгалтанд тэнцсэн хүн юмуу хууль зүйн сайдын тусгай зөвшөөрөл авсан хүн засаг захиргааны нэгж бүрд байдаг шихо-шошид элсч, үйл ажиллагаагаа явуулах эрхтэй байдаг. Шихо-шошигийн орон нутгийн холбоонуудыг нэгтгэсэн Японы шихо-шошигийн нэгдэл гэж байдаг.

Японы үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэл нь нэг талаар хууль ёсны эзэмшигчийг эрх зүйн үүднээс баталгаажуулан хамгаалах зорилготой боловч нөгөө талаар тухайн үл хөдлөх эд хөрөнгийн эрх зүйн байдлыг сонирхсон хүнд мэдээллээр хангахыг зорилго болгож, үл хөдлөх эд хөрөнгийн гүйлгээний эрх зүйн баталгаатай, эрсдэлгүй орчин нөхцөлийг хангадаг. Японы иргэний хуулинд 4 төрлийн барьцааны эрх байдаг. Үүнээс хамгийн өргөн хэрэглэгддэг нь /энгийн/ барьцаа юм. Барьцааны эрх нь барьцааны объект болон үл хөдлөх эд хөрөнгийн эзэмшигч болон зээлдүүлэгч, зээлдэгч хоёрын хоорондын гэрээгээр үүснэ. Жишээ нь гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд барьцаалагдсан үл хөдлөх эд хөрөнгийг шүүхээс дуудлага худалдаанд оруулж, мөнгийг нь зээлдүүлэгч буюу барьцаалагчид олгодог. Японд барьцааны эрх нь урт түүхтэй учир хууль зүйн орчин нь ч нэлээд боловсронгуй болсон байна. Мөн ихэнх иргэд орон сууц, газар зэргийг худалдан авахдаа барьцааны эрхийг ашигладаг юм. Ер нь ганц Японоор зогсохгүй барьцаа гэдэг нь аливаа эдийн засгийн үйл ажилагаатай нягт холбогдож үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн хамтаар хөгжиж иржээ.

-ooOoo-

ГЭР БҮЛИЙН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТҮҮХЭН ХӨГЖИЛ

*МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Иргэний
эрх зүйн тэнхимийн багш А.Дугармаа*

Гэр бүлийн эрх зүй нь бие даасан салбар эрх зүй мөн эсэх асуудал 1960-аад оны эцэс хүртэл судлаач эрдэмтдийн анхаарлыг татаж, хууль зүйн шинжлэх ухаанд судлагдаж байсан маргаантай асуудлын нэг байсан юм. Гэр бүлийн болоод иргэний эрх зүйн зохицуулах зүйл, зохицуулалтын аргын хооронд ихээхэн зөрүү байхгүй учраас иргэний эрх зүйн системийн бүрэлдэхүүн хэсэг гэсэн үзэл баримтлал эрдэмтдийн дунд зонхилж байсан юм.

Энэ нь гэр бүлийн харилцааг төрөлжүүлэн зохицуулсан хууль байхгүй, гэр бүлийн гишүүдийн хоорондын эд хөрөнгийн бус амины болон эд хөрөнгийн харилцааг иргэний эрх зүйн харилцаатай адилтган үзэж байсантай холбоотой юм. Гадаадын улс орнуудад тухайлбал Франц, Швейцарь, Герман зэрэг улсад гэр бүлийн эрх зүйн харилцааг Иргэний хуулиар зохицуулж байсан төдийгүй манай улсад ч энэ үед төрөлжсөн Гэр бүлийн тухай хууль батлагдаагүй байсан.

Эрдэмтэн судлаачид гэр бүлийн эрх зүйн зохицуулах нийгмийн харилцааны өвөрмөц, онцлог шинжүүд, тухайн харилцааг хэрхэн яаж зохицуулж байгаа арга хэлбэрийг тодорхой болгосны үндсэн дээр маргааныг эцэслэж, гэр бүлийн эрх зүй нь бие даасан салбар эрх зүй мөн гэсэн нэгдсэн дүгнэлтэд хүрсэн юм. Ингэснээр гэр бүлийн эрх зүй нь гэрлэлтийн үр дүнд бий болсон гэр бүлийн гишүүдийн эд хөрөнгийн бус амины ба эд хөрөнгийн харилцааг зохицуулахад гадна хүүхэд үрчлэх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоохтой холбогдсон тус тусдаа бие даасан боловч нэг нь нөгөөгөөсөө урган гарсан харилцан бие биеэ нөхцөлдүүлж байдаг нийгмийн нэг төрөл чиглэлийн харилцаа хэмээн үзэх болжээ.

Гэр бүлийн харилцааг зохицуулахын тулд төрөөс олон хууль тогтоомжийг батлан гаргаж мөрдүүлсэн бөгөөд тухайн үеийн улс орны нийгэм, эдийн засгийн онцлог байдал, зан заншлын зарчимд тулгуурлан тэдгээр нь улам боловсронгуй болж, шинэчлэгдэж ирсэн юм.

Монгол Улсад хувьсгал ялснаас хойш гэр бүлийн харилцааг зохицуулсан анхны хууль бол 1926 оны Иргэний хууль юм. Уг хуулийн гуравдугаар бүлэг "Гэр бүлийн эрх, үүргийн тухай" хэмээн нэрлэгдэж тухайн цаг үеийн нөхцөлд тохирсон гэр бүлийн харилцааг зохицуулж байсан. Тухайлбал, 18 насанд хүрсэн хүмүүс эр, эм /гэр бүл/ бололцож болох бөгөөд гэрлэх эрэгтэй, эмэгтэй харилцан санал нийлэлцсэн байх, ялгаварлан гадуурхахгүй байх, эцэг, эх, төрсөн үр хүүхэд, нэгэн эцэг, эхийн ах, эгч, дүү хоорондоо гэрлэж болохгүй зэргээр хуулиар тодорхой шаардлага тавьсан байдаг. Иргэний гэр бүлийн бүртгэлтэй холбогдуулан орон нутгийн захиргааны газрууд өрхийн дансанд төрсөн, үрчилсэн, нас барсан, гэр бүл болсон, салсныг тодорхой тэмдэглэж, бүртгэх, Засгийн газрын дэргэдэх Хэрэг эрхлэх газраас ерөнхийлөн хянах журмыг нарийвчлан тогтоосон нь эрх зүйн анхны зохицуулалт байлаа.

Үүнээс хойш 1950 онд Иргэний гэр бүлийг бүртгэх байгууллагын тухай, 1956 онд БНМАУ-ын гэрлэх ба гэр бүл асрамж, тэтгэмжийн тухай хуулиудыг баталснаар нь гэр бүлийн харилцааны асуудлыг төрөлжүүлэн зохицуулах анхны эхлэл тавигдсан гэж үзэж болох юм. Эдгээр хууль нь гэрлэхэд баримтлах зарчим, гэр бүлийн харилцаанд гишүүдийн тэгш эрхийг хангах, үр хүүхдийг өв, тэгш зөв боловсон өсгөж хүмүүжүүлэх үүрэг, гэр бүлийн нийгэмд гүйцэтгэх үүрэг, ёс суртахууны хүмүүжлийг дээшлүүлэх, төрөл садангийн эрх, үүрэг, хүүхдийн эрх ашиг сонирхлыг хамгаалахтай холбогдсон харилцааг нэлээд нарийвчилсан байдлаар зохицуулсан байв.

1973 онд БНМАУ-ын АИХТ-ийн 159 дүгээр зарлигаар БНМАУ-ын Гэр бүлийн хууль батлагдаж, социалист нийгэмд гэр бүлийг бэхжүүлэх, коммунист ёс суртахуунд нийцсэн хэвийн харилцааг хөгжүүлэх, эцэг, эх, үр хүүхэд болон гэр бүлийн бусад гишүүдийн эрх, ашгийг хамгаалах, тэдний нийгэмд гүйцэтгэх үүрэг, хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор гэрлэх, гэрлэснээ цуцлах, гэр бүлийн гишүүний хоорондын амины болон эд хөрөнгөний харилцаа, хүүхэд үрчлэх, асран хамгаалах, харгалзан дэмжихтэй холбогдсон буюу иргэний гэр бүлийн байдал бүртгэхээс үүсэх нийгмийн харилцааг зохицуулж байв.

Энэ хууль нь 5 хэсэг, 13 бүлэг, 113 зүйлтэй байлаа. Гэр бүлийн хуульд хуулийн зорилго, зохицуулах харилцаа, гэр бүлийн үндэс, эх, хүүхдийн эрх ашиг сонирхлыг хамгаалах арга, гэрлэх үндэс, гэрлэсний эрх, үүрэг, гэрлэснийг хүчингүйд тооцох буюу гэрлэлт цуцлах журам, гэр бүлийн гишүүдийн эд хөрөнгийн эрх, үүрэг, улсаас асран хамгаалах, харгалзан дэмжих тухай, хүүхэд үрчлэх, иргэний гэр бүлийн байдал бүртгэх журмыг тухайн нийгмийн онцлог байдалтай уялдуулан зохицуулж байлаа.

Монгол Улсын 1992 оны шинэ Үндсэн хуулийн арван зургадугаар дугаар зүйлд гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй байх, гэрлэлт нь хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёр тэгш эрх, сайн дурын харилцаанд үндэслэнэ гэж зааснаар иргэний эрх, эх чөлөөг баталгаатай хангах, гэр бүлийн харилцааны зохицуулалтад төрөөс оролцох оролцоог аль болохоор багасгах, гэр бүлийн эрх зүйн харилцааг зохицуулах хэм хэмжээг улам боловсронгуй болгох үүднээс УИХ-аас 1999 онд Гэр бүлийн тухай хуулийг шинэчлэн батлан гаргасан юм. Энэ хууль нь 8 бүлэг, 76 зүйлтэй бөгөөд өмнө үйлчилж байсан хуультай харьцуулахад дараахь онцлогийг агуулжээ.

Нэг. Гэр бүлийн хуулиар зохицуулагдах харилцаа өргөжсөн байна.

Гэр бүлийн тухай хуулийн 6 дугаар бүлэгт тэжээн тэтгэх, тэтгүүлэхтэй холбогдсон харилцаанд тэжээн тэтгэх гэрээний зохицуулалт, 7 дугаар бүлэгт Монгол Улсын харьяат хүүхдийг гадаадын иргэнд үрчлүүлэх болон хүүхэд үрчлэхэд мөрдөх журам, 8 дугаар бүлэгт хараа хяналтгүй хүүхдийн эрх ашгийг хамгаалахад сум, дүүргийн Засаг дарга, хүүхдийн эрх ашгийг хамгаалах байгууллагын гүйцэтгэх үүрэг, хүүхдийг гэр бүлдээ асарч хүмүүжүүлэхийг хүссэн иргэнд хүүхдийг шилжүүлэхтэй холбогдсон гэрээний асуудлыг тус тус шинээр зохицуулж байна.

Хоёр. Өмнөх хуулиудад байгаагүй хэм хэмжээг шинээр тусгажээ.

1. Гэр бүлийн тухай хуулийн 3 дугаар зүйлд энэ хуультай холбогдох нэр томъёог тайлбарласан.

2. Гэрлэлт сайн дурынх байх, гэр бүлийн харилцаанд тэгш эрхтэй оролцох, гэр бүл, эх няхсын эрх ашгийг төр хамгаалах, гэр бүлийн дотоод хэрэгт хөндлөнгөөс үл оролцох зэрэг гэр бүлийн эрх зүйн гол гол зарчмыг хуульд тусгаж өгсөн.

3. Хуульд гэр бүлийн эрхийг хамгаалахад шүүх, захиргааны байгууллагын гүйцэтгэх үүргийг нарийвчлан зааглаж тогтоосон.

4. Гэрлэхэд харшлах шалтгааныг шинэчилсэн байдлаар зохицуулснаас гадна гэрлэхийг хүсэгчид эрүүл мэндийн шинжилгээнд хамрагдаж байх, түүнээс гарах үр дагаврыг гэрлэгчдэд тайлбарлан өгч байх зохицуулалтыг хуульчилсан байна.

5. Хараа хяналтгүй, хүнд нөхцөлд байгаа, бүтэн өнчин хүүхдийн нэгдсэн бүртгэлийг сум, дүүргийн Засаг дарга хөтөлж, тэднийг халамжийн байгууллагад шилжүүлэх, бусдад үрчлүүлэх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг томилж байх, үүнтэй холбогдон гарах зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг заажээ.

6. Нийгмийн амьдралд олдмол, хаягдсан хүүхдийн эрх ашгийг хамгаалах зайлшгүй шаардлага гарсантай уялдан тэдэнд нэр өгөх, хүүхдийн эцэг, эхийг тогтоох, эцэг, эх байх эрхийг хязгаарлах шинэ зохицуулалт хуульд тусгалаа олсон байна.

7. Шүүхийн журмаар гэрлэлт цуцлахад хүүхдийн асрамжийн асуудлыг шүүх шийдвэрлэх, хүүхдийг бусдад үрчлүүлэх, асрамжид шилжүүлэхэд 7 нас хүрсэн буюу түүнээс дээш насны хүүхдээс саналыг нь авсны үндсэн дээр асуудлыг хянан хэлэлцэж байхаар тогтоож өгөв.

8. Эцэг, эх нь насанд хүрээгүй буюу насанд хүрсэн боловч хөдөлмөрийн чадваргүй хүүхдээ, хүүхэд хөдөлмөрийн чадваргүй болсон эцэг, эх, гэрлэгчид болон төрөл садангийн хүмүүс бие биеэ тэжээн тэтгэх нөхцөл, журмыг тогтоож, тэжээгч тэтгүүлэгч нар харилцан тохиролцож тэжээн тэтгэх гэрээний үндсэн дээр бие биеэ тэтгэх журмыг шинээр хуульчилж өгөв.

9. Түүнчлэн сар бүр хүүхэд тус бүрт тогтоох тэтгэлгийн хэмжээг шинэчлэн хүүхдийн оршин байгаа бүс нутагт Засгийн газраас тогтоосон амьжиргааны баталгаажих доод түвшингийн хэмжээ, хүүхдийн насны байдлыг харгалзан тогтоож байх болов.

10. Иргэний хуульд гэр бүлийн гишүүдийн эд хөрөнгийн харилцааны нэгээхэн хэсэг болох гэр бүлийн гишүүдийн хуваарьт өмч, хамтран өмчлөх дундын өмч, түүнийг захиран зарцуулах, хуваарилахтай холбогдсон харилцааг эд хөрөнгийн эрхтэй холбогдсон гэрээ байгуулсны үндсэн дээр зохицуулж болох цоо шинэ зохицуулалтыг тусгасан байна.

Гэр бүлийн тухай хуулиар тухайн харилцааг журамлан зохицуулсан хэм хэмжээг нарийвчлан системчилсэнд хуулийн бас нэг онцлог оршиж байна. 1999 оны Гэр бүлийн тухай хуульд тусгагдсан дээр дурьдсан шинэ хэм хэмжээнүүд нь гэр бүлийн харилцааг нийгэм эдийн засгийн өөрчлөлттэй уялдуулан оновчтой зохицуулахад үр дүнгээ өгөх нь зайлшгүй юм.

АРБИТРЫН ТУХАЙ ШИНЭ ХУУЛИЙН ТАЛААР ӨГҮҮЛЭХ НЬ

Хуульч Д. Дашдондог

Арбитрын тухай шинэ хуулиар Монголын худалдаа, аж үйлдвэрийн танхим МХАЙТ-ын дэргэдэх Гадаад худалдааны арбитрыг өөрчлөн гадаад, дотоод худалдаа, эдийн засаг, аж ахуйн бусад харилцааны явцад гэрээт талуудын хооронд үүссэн маргааныг хянан шийдвэрлэх хосолмол ажиллагаатай арбитраудыг зарим тохиолдолд шүүхийн харьяалах хэргийг хянан шийдвэрлэх эрхтэйгээр төв, орон нутаг дах холбогдох төрийн бус байгууллагуудын дэргэд байгуулахаар шийдвэрлэсэн нь содон бөгөөд сонирхолтой шийдэл болов уу гэж үзэж байна. ✓

Энэ хууль Монголын арбитрын үйл ажиллагааны цаашдын хөгжил, нэр хүндэд хэрхэн нөлөөлөхийг амьдрал харуулах биз ээ. Хууль нийгмийн тухайн харилцааг зөв залж, зохицуулахуйц бөгөөд амьдралд нийцсэн байх шаардлагын үүднээс үзвэл нэлээд учир дутагдалтай болжээ. Тухайлбал, нэгд хуулийн дагуу зохион байгуулагдах Монголын арбитрын системийн гол тулгуур болох МХАЙТ-ын дэргэдэх болон бусад байнгын арбитраудад холбогдох харилцааг зохицуулахаасаа *ad hoc* арбитрад хамаарагдах харилцааг зохицуулахад түлхүү чиглэгджээ. Хоёрт хуулийн заалт нэг бүрийн агуулга, уялдаа холбоо байрлал цэгцгүй, ялангуяа тэрлэж буй үгийнхээ утгын учгийг мэдрэх талаар нэлээд бүдүүвч муйхардуу ханджээ гэж хэлмээр байна. Энэ хуульд үйл ажиллагааны шинж байдлаар "түр арбитр" гэж нэрлэсэн *ad hoc* арбитрыг монголд хот, хөдөөгүй ажиллуулах байтугай түүний тухай бидний мэдлэг ердөө л нэрлэх төдий хэмжээнд байгаа билээ. Ийм нөхцөлд түүнийг манай оронд ийнхүү, гэр тусмаа байнгын арбитрай нэг түвшинд хольж хуульчлах нь зөв эсэхийг мэдэхгүй байна.

Ad hoc арбитр бол маргагч талуудын тохиролцооны аясаар зохион байгуулагдаж, тухайн нэг маргааныг хянан шийдвэрлээд үйл ажиллагаа, эрх хэмжээ нь дуусгавар болдог түр зуурын ажиллагаатай арбитр билээ. Байнгын арбитр бэхжиж, нэр хүнд нь өсөхийн хирээр *ad hoc* арбитрийг ашиглах явдал олон улсын практикт багасаж байна гэж үздэг.

Дээрхтэй холбогдуулан хуулийн зарим зүйлийг авч үзье:

1. Хуулийн зорилгыг тодорхойлсон 1.1 дэх хэсэгт "эдийн болон эдийн бус баялагтай холбоотой маргаан" гэсэн нь чухам ямар эрхийн харилцаанаас үүссэн байх нь тодорхой бус байна. Энд "Иргэний эрхийн харилцааны" маргаан байхыг тодотгох шаардлага дараах байдлаас урган гарч байна. Тухайлбал, хуулийн 11.1-д "...аль нэг эрх зүйн харилцаатай холбогдон үүссэн...бүх төрлийн...маргааныг..." гэж эрх зүйн ямар ч харилцаанаас үүдэлтэй асуудал багтаж болохоор маш өргөн хүрээгээр томьёолжээ. Нэгэнт хуулийн заалт учраас "Хууль бол хууль" гэдэг зарчмаар үг үсэгчлэн хандах ахул арбитраар шийдвэрлүүлэхгүй хэрэг, маргаан үгүй болох нь ээ. Тэгэхлээр маргагч талууд болон хөдөлмөрчин олон хулгайчийн талаар ч юм уу, магадгүй гэрлэлтээ цуцлуулах, эсвэл хөдөлмөрийн маргаанаа шийдвэрлүүлэхээр арбитрын хаалга татаж будлих энүүхэнд болголт. Эцсийн эцэст энэ 11.1 дэх сүржин заалт арбитрын ажиллагааны мөн чанар, тэнхлэгийг гуйвуулсан, үнэндээ амьдралгүй хоосон заалт болсон ажээ.

2. Хуулийн 3.3 дахь хэсэгт "Монголын арбитр"-ын гэхийн оронд "Монгол Улсын" гэсэн нь хууль зүйн утгаараа бас л алдаа гэж хэлж болох байх. Арбитр нь төрийн бус байгууллагын дэргэд ажиллахыг энэ хууль 5.2 дэх заалтаар тунхагласныг ч бодсон тэр.

3. Арбитрын харьяалах маргааны тухай бие даасан 6 дугаар зүйл байсаар атал байнгын арбитр ямар маргаан шийдвэрлэх бэ? гэдгийг арбитр байгуулах тухай хэсэгт /5.6 дахь хэсэг/ хольчихжээ. Энэ заалт ийнхүү байрлалаасаа төөрөөд зогсохгүй бусад зүйл ангиа ч амьдралгүй болгож мэдэх нь нээ. Тодруулбал, нэгэнт 5.6 дахь хэсэгт байнгын арбитрын эрхлэх үйл ажиллагаа гэж нэрлээд түүндээ арбитрын харьяаллын маргааны тухай 6 дугаар зүйлийг бүхэлд нь багтаагдсан болохоор 6 дугаар зүйл нь 5.6 дахь хэсэгт залгиулаад хорвоогоос халихын хамт 5.1-ын дагуу мэндлэх түр арбитр нь шийдвэрлэх маргаан ч үгүй хоцрох бололтой. Энэ бол 5.6 дахь хэсгийг буруу байрлуулалтаар зогсохгүй түүнд 6 дугаар зүйлийг утгагүй хавчуулж, "дагнан" гэсэн зааглан хамаатгасан үг нэмсний балаг юм.

4. "Байнгын болон түр арбитрын маргаан шийдвэрлэх ажиллагааг адил зарчмаар явагдана" гэсэн дэгийн чанартай зүйлийг арбитр байгуулах гэсэн зохион байгуулалтад холбогдох хэсэгт 5.8 дахь хэсэг болгож хүчээр шингээжээ.

5. Хуулийн 4 дүгээр зүйлд заасан нэр томъёоны тодорхойлолтод 8.2-т дурдсан "өөр этгээд" гэснийг тайлбарлаагүй учраас тэр нь хэн бэ? гэсэн асуулт гарах бололтой. Ер нь 8.2 дахь хэсгийн гол цөм нь дүрмийн тухай асуудал атал, түүнийг "...шүүхийн тогтолцоо" гэсэн хэсэгт оруулжээ. Уг нь арбитр томилох журмын тухай хэсэгт 15.9 дэх заалт болгож болох мэт. Дээрх "өөр этгээд" гэдэгт 1961 оны Европын зэрэг олон улсын конвенц, практикийн дагуу бол байнгын арбитрын дарга, *ad hoc* арбитрт бол эрх бүхий худалдааны танхимийн дарга байхаар ойлгож болох юм.

6. Баримт бичиг хүргүүлэх тухай 9.1-д "шуудангаар хүргүүлэхдээ... хаягаар явуулна. Ийнхүү хүргэсэн өдрийг уг баримт бичгийг хүлээн авсан өдөрт тооцно" гэсэн гүжирмэгдүү заалт байх юм. "Ийнхүү хүргэсэн" гэдгээ яаж тогтоох юм бэ? "хаягаар явуулна" гэдэг бол хүргэсэн гэсэн үг биш, огноо ч биш. Цаг үеийг тодорхойлох ийм асуудалд огноо шийдвэрлэх ач холбогдолтой. Огноо бол тухайн үйл явдлын эхлэл, төгсгөлийн хугацааг илэрхийлсэн, хууль зүйн үр дагавар бүхий он сар өдөр юм. Дээрх 9.1-д дурьдснаар шийдэх юм бол зөрчил гаргаагүй талыг шударга тогтоох боломжгүй бөгөөд, явуулсан, хүлээж авсан тухайн нөхцөл байдлаас шалтгаалан, нэг талд нь ашигтай, нөгөөд нь хохиролтой үр дагавар үүсгэхээр байна. Нэгэнт үг асуудлыг энэ хуулиар хөндөж байгаа бол ийм бүдүүвч байдлаар зааж болохгүй болов уу.

7. Хуулийн 12.1-д "Талууд... шүүхэд эхлээд нэхэмжлэл гаргасан боловч..." гэсэн нь талууд бүгдээрээ нэхэмжлэл гаргасан ч юм шиг, нэг л ойлгомж муутай аж. Жам ёсоор нэг тал нь нэхэмжилж байж шүүх, арбитрт хэрэг үүсдэг. Тэгэхээр энэ заалтын агуулга нь "Талууд маргаанаа шүүхээр шийдвэрлүүлэхээр анх тохиролцсоны дагуу нэхэмжлэгч шүүхэд нэхэмжлэл гаргасан боловч арбитраар шийдвэрлүүлэхээр хүсэлт гаргавал" гэсэн санаа болов уу? Цаашилбал нэхэмжлэгч нэхэмжлэлдээ бүх учир шалтгаанаа дурдаж, нотлох баримтуудыг хавсаргадаг учраас ихэнх тохиолдолд,

тайлбарыг хариуцагч гаргадаг. Иймд 12.1-д дурдсан тайлбарын тухай хэсгийг дахин хянаж үзмээр.

8. Маргагч талууд ямар арбитр /байнгын, түр/-аар маргаанаа шийдвэрлүүлэх, хэрэв байнгын арбитрт бол хаанахын арбитрт хандах, түр арбитр сонгох бол хаана, хэрхэн /хэдэн арбитрч/ байгуулахаа тохиролцож, гэрээ байгуулах үедээ буюу жич хэлэлцээрт тусгах ёстой. Харин арбитрчдын тооны талаар дахин хэлэлцээр байгуулах ёстой мэтээр 14.2-т заасан нь техникийн ажил нэмэх илүү заалт байна. Түүнчлэн 14.1 дах хэсэгт хэд хэдэн арбитрчаас бүрдэж болно гэсэн нь уламжлал болсон 3 арбитрчаас ч илүү тооны байж болно гэсэн үг үү.

9. Хуулийн 15.1 дэх заалтад хэнийг ч арбитрчаар томилж болно гэсэн нь утгын хувьд хуулийн 5.4 дэх заалттай зөрчилдөж байна. Түр арбитрын хувьд ч нэг их зохицохгүй болов уу? Жишээ нь НҮБ-ын Ази, Номхон далайн орнуудын Эдийн засгийн Комиссын дэргэдэх Олон улсын худалдааны арбитрын журамд уг арбитрын төвд бэлтгэсэн жагсаалтаас арбитрч сонгож байхыг зөвлөсөн байдаг юм билээ. Ер нь *ad hoc*-ын арбитрчаар асар их мэдлэг, туршлагатай, өндөр нэр хүнд бүхий хүм сонгогдох бөгөөд тэд нь заавал нэг улсын бус, хоёроос гурван ч улсын иргэд байж болох юм.

10. Хуулийн 5.4-т байнгын арбитрын дүрмийг батлах тухай заасан атал, түүний удирдлага, зохион байгуулалтыг уг дүрмээр тогтооно гэж бие даасан зүйл, анги /5.5/ хуульчлан оруулсан нь хуулийн заалт нарийсч байгаа хэрэг үү? Уг нь тийм заалттай, заалтгүй удирдлага, зохион байгуулалтын асуудал дүрмийн гол зүйлийн нэг болж, дүрэмд тусгагдахаар барахгүй шаардлагатай бусад асуудал, тухайлбал, арбитрчийг хэрхэн томилохыг ч 15.10 дах хэсгийн дагуу зохицуулсан байх ёстой болов уу? Байнгын арбитрын аливаа үйл ажиллагааны журмыг талууд харилцан тогтоох учиргүй тул 15.3-ын "Арбитрч томилох журмыг талууд харилцан тохиролцох..." гэсэн заалтыг зөвхөн түр арбитрт хамаарагдана гэж ойлгох нь зүйтэй биз ээ.

11. Татгалзах үндэслэл гэсний 16.4 дэх заалтад "Талууд өөрийн томилсон буюу томилоход нь оролцсон арбитрчийг зөвхөн томилогдсоных нь дараа татгалзан гаргана" гэсэн нь 1-д үндэслэл бус, татгалзах тухай журам аж, 2-т талууд өөрсдөө томилчихоод хөндлөнгөөс хэн нэгэн томилсон мэт "Томилогдсоных нь дараа" гэсний болон мөн арбитрчийг сөрөг тал нь татгалзах магадлал ихтэй атал томилогч өөрөө татгалзахын учир, үндэслэл эндээс харагдахгүй байна.

12. Хуулийн 17.1 дахь заалтад арбитрчыг татгалзан гаргах журмыг талууд тохиролцохоор тусгажээ. Арбитрч байхаас өөрөө татгалзаж, түүнийг талууд зөвшөөрөхөөс бусад тохиолдолд арбитрчийг татгалзан гаргах эсэхийг арбитрчдын бүрэлдэхүүн шийдвэрлэх тухай 17.3 дахь хэсэг болон 17.2-ын арбитрчийг талууд өөрсдөө шууд татгалзан гаргах эрхтэй байх мэт энэ хоёр заалтыг өөр хооронд нь сайтар уялдуулан зохицуулах хэрэгтэй бололтой. Ер нь 17 дугаар зүйл бүхэлдээ нугачаа ихтэй, ойлгоход хялбар бусын гадна заалтууд давхардсанаас нэг нь нөгөөдөө уусч байх шиг.

13. Хуулийн 18.1 дэх хэсэгт арбитрч үүргээ биелүүлэхэд нөлөөлсөн шалтгаан нь адил атал "биелүүлээгүй", "биелүүлэх боломжгүй" гэж ангилахын учир юу вэ? "Биелүүлээгүй" гэдэг нь ямар нэг хэлбэрээр санаатай үйлдэл дагуулж байгаа бол түүнийг нь тодруулмаар.

14. Хуулийн зохицуулалтын зорилго байнгын ба түр арбитрын аль алинд нь хамаарах нь 1 ба 5 дугаар зүйлээс ойлгогдож байгаа боловч ихэнх зүйл нь зөвхөн түр арбитраг зориулсан агуулгатай байх тул хоёр өөр арбитраг механик байдлаар хамааруулах нь бодит амьдралд нийцэхгүй бизээ. Жишээ нь хуулийн 23, 24 гэх мэт зүйлүүд тэр чигээрээ түр арбитраг хамаарагдах шаардлагаас бүрджээ. Хуульд үүнтэй уялдуулан тодотгосон өөр заалт байхгүй учраас арга буюу байнгын арбитраг холбож ойлгоход хүргэж байна. Тэгэхлээр байнгын арбитраг ажиллагаагаа өөрийн дүрмээр бус тухай бүр маргагч талуудын тохиролцоогоор явуулахад хүрэх болно.

15. Арбитрын ажиллагаа эхлэх тухай 25.1 дэх хэсэгт "Талууд өөрөөр тохиролцоогүй бол нэхэмжлэгчийн нэхэмжлэлийг хариуцагч тал хүлээн авсан өдрөөс арбитрын ажиллагаа эхэлнэ" гэжээ. Энэ заалт ялангуяа, байнгын арбитрын хувьд огт тохирохгүй. Энэ асуудлаар олон улсын конвенцын заалтыг бус, өөрийн орны суурь хууль, тухайлбал, иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, түүний 64, 66 дугаар зүйлийг баримтлах ёстой. Харин түр арбитрын хувьд маргааныг арбитраар шийдвэрлүүлэх тухай нэхэмжлэгчийн мэдэгдлийг хариуцагч хүлээж авсан өдрөөс эхлэн тооцох журам олон улсын конвенцод тусгагдсан байдаг юм билээ.

16. Арбитрын ажиллагаа явуулах хэлний тухай 26 дугаар зүйлийн 26.3-т "Арбитрын ажиллагаа явуулах хэлний талаар талууд тусгайлан өөрөөр тохиролцоогүй бол тухайн хэлээр арбитрын ажиллагааг дагнан явуулна" гэжээ. "Тухайн хэл" гэж ямар хэл байдгийг хууль тогтоогчдоос асуухаас яах вэ?

17. Шинжээч томилох тухай 30.1 дэх хэсэгт "Талууд өөрөөр тохиролцоогүй бол...арбитрын бүрэлдэхүүн...шинжээч томилж болно" гэсэн нь тухайн байдлаас шинжээч томилох зайлшгүй шаардлага гарсан ч талууд "Шинжээч томилохгүй" гэж тохиролцсон бол арбитрагчдын ам үдэгдэж, шийдвэр гаргахад хүндрэл учрах бус уу. Түүнчлэн, шинжээч хуралд тайлбар хийх асуудал ч 30.3 дахь хэсгийн ёсоор мөн мухардмал байдалд орох бололтой.

18. Хуулийн 34 дүгээр зүйлийг "Маргаан шийдвэрлэх эрх зүйн хэм хэмжээ" гэж нэрлээд 34.1-д "Маргаан шийдвэрлэхэд хэрэглэх эрх зүйн хэм хэмжээг талууд харилцан тохиролцоо бөгөөд арбитрын бүрэлдэхүүн тэдгээрийн тохиролцсон хэм хэмжээг хэрэглэж маргааныг шийдвэрлэнэ" гэсэн нь даанч харамсалтай. Ингэснээр маргаан шийдвэрлэхэд хэрэглэх хуулийг бус, түүний тодорхой хэм хэмжээ, өөрөөр хэлбэл, зүйл, анги /норм/-ийг талууд нь зааж, арбитрагчид түүнд нь дөрлүүлэн хөтлөгдөж байх юм байна.

Маргаан шийдвэрлэхэд хэрэглэх хуулийн хэм хэмжээг талууд өөрсдөө тохиролцон зааж байх юм бол өөрөөсөө арбитраг гэж байхын хэрэг байгаа юм уу. Маргаан шийдвэрлэхэд хэрэглэх эрхийн хэм хэмжээг хэргийн байдалд тохируулан сонгох эрх мэдэлгүй тийм цаасан бараар яах юм. Уг нь маргаан үүссэн тохиолдолд хаанахын /ямар/ хууль, эрх зүйг хэрэглэхийг талууд тохиролцож, түүний ямар хэм хэмжээг үндэслэн тухайн маргааныг шийдвэрлэхэд арбитрагчид нь сонгож хэрэглэх эрхтэй байдагсан.

19. Ийм заалттай хууль гарч байгааг үзвэл манай хууль тогтоогчид дэндүү чамлалттай, туйлын хайнга байгааг харуулж байх шиг санагдана. Хуулийн 34.2-т "Арбитрын бүрэлдэхүүн талуудын тохиролцсон эрх зүйн хэм

хэмжээг хэрэглэхдээ уг тохиролцоонд тусгайлан заагаагүй бол түүнийг тухайн улсын материаллаг эрх зүйн хэм хэмжээ гэж ойлгож хэрэглэнэ" гэжээ. Энэ хуульд тухайлбал, 34 дүгээр зүйлд зааснаар талууд үнэндээ нэг л хэм хэмжээ /норм/-г тохиролцсон байх учраас энд материаллаг эрх зүй энэ тэр гээд байх хэрэг байна уу. Яагаад гэвэл, материаллаг эрх зүй гэдэгт хуулийн ганц нэг хэм хэмжээ бус, хууль /эрх зүй/ бүхэлдээ ойлгогдох ёстой.

20. Хуулийн 35.1 дэх хэсэгт "Арбитрын бүрэлдэхүүнээс гаргасан шийдвэрийг тухайн арбитрын шийдвэр гэж үзэх ба талууд өөрөөр тохиролцоогүй бол арбитрын бүрэлдэхүүн шийдвэрийг олонхийн саналаар гаргана" гэсний 2 дахь хэсгийн тухайд гэвэл аль нэг тал нь өөрийн давуу байдлаа ашиглаад, эсвэл, шахалтад орж цөөнхийн саналыг хүчинтэй тооцохоор тохирчихвол арбитрч түүнийг зөвшөөрөх ёстой юу? Ингэж хуульчлахын учир, үндэслэл юу вэ?

21. Хуулийн 40.2.2-т "арбитрч томилох тухай... арбитрын бүрэлдэхүүн талуудад зохих ёсоор мэдэгдээгүй..." гэснийг ойлгосонгүй. Хэрэв арбитрын бүрэлдэхүүн талуудаар сонгогдож /томилогдож/ буй болдог хэвээр бол өөрөө бүрдээгүй байж арбитрч томилох тухай яаж юун мэдээ өгөх юм бэ?

22. Давж заалдах шатны шүүх хүчингүй болгож болох шийдвэрт хамааруулан 40.2.6 дах заалтад "Тухайн арбитрын шийдвэр Монгол Улсын нийтлэг ашиг сонирхол, үндэсний аюулгүй байдалд харшлагаар бол" гэсэн нь бодит байдал ямар ч байсан улсын эрх ашгийг харгалз гэсэн чиглэл өгч, арбитрын төвийг сахисан болон хараат бус байдлад нөлөөлж байна гэдэг ойлголт өгөх талгүй юу?

23. Хуулийн 41 дүгээр зүйлийн 41.3.6-аас бусад заалт *ad hoc* арбитрт хамаарагдах юм байна. Харин 41.1-ийн дагуу шаардлагатай зардлыг төлөвлөхдөө юу үндэслэх нь тодорхойгүй санагдана. Түүнчилэн, 45.1-д заасан тохиолдол байнгын арбитрт ч гардаг тул төлөвлөсөн зардлаас бодит зардал бага гарвал зөрүүг бүрэлдэхүүн буцааж олгоно гэсэн нь арбитруудын аль алинд хамаарагдана гэж үзвэл, ялангуяа, байнгын арбитрын арбитрч ч мөнгөний нярав болж хувирах бололтой.

Дүгнэж үзэхэд, хуулийн боловсруулалт ерөнхийдөө *ad hoc* арбитр холбогдох зүйлд түлхүү тулгуурласан байдалтай байгаагаас байнгын арбитрын үйл ажиллагааны журам, уламжлалт шинж чанар зарим талаар зөрчигдөж, хэрэг хянан шийдвэрлэх дэг журмын хувьд маргагч талуудын эрх ихээхэн нээгдсэн бололтой байна.

Эцэст нь, арбитрын хуульд тайлбар /комментарий/ бичиж байгаа биш болохоор түүний заалт нэг бүрийг авч үзээгүйг тэмдэглэхийн ялдамд хуулийн 10 дугаар зүйлийг 3 дугаар бүлэгт оруулах гэх мэтээр, ялангуяа, 12, 13, 27, 37 дугаар зүйлийн утга агуулгын уялдаа, байрлалын талаас дахин анхаарал хандуулахыг уламжлахын хамт, МХАҮТ-аас бусад, төрийн бус байгууллагын дэргэдэх байнгын арбитрууд зөвхөн түшиглэсэн байгууллагынхаа гишүүдийн хооронд үүссэн маргааныг хянан шийдвэрлэж байхаар харьяалал тогтоох нь зүйтэй болов уу гэж үзэж байгаагаа мөн сонордуулмаар байна.

МОНГОЛ УЛСЫН ШҮҮХ ЭРХ МЭДЛИЙН ТОГТОЛЦОО БА ШҮҮХИЙН ЭРХ ЗҮЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫН ЗАРИМ АСУУДАЛ

Улсын дээд шүүхийн шүүгч Ц.Амарсайхан

1. Оршил

Монгол Улсын түүхэнд анх удаа 1992 оны Үндсэн хууль шүүх эрх мэдлийг жинхэнэ утгаар нь тодорхойлон тусгаж, шүүхийн зохион байгуулалт, үйл ажиллагааны ардчилсан үндэс, зарчмуудыг баталгаажуулж өгсөн билээ. Засаг хуваарилах зарчмын дагуу манай улс төрийн байгуулалдаа хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийг зааглаж, тэдгээрийг хэрэгжүүлэх арга, хэлбэр, механизм, эрх хэмжээ, нийтлэг ба онцлог зорилго, хоорондын харилцаанд баримтлах зарчим, чиглэл зэргийг Үндсэн хуулиар тодорхойлж өгсөн юм.

Засгийн нэг тулгуур өндөрлөг, эрх зүйт төрийг төлөвшүүлэн тогтоох үйл явцын амин чухал хэсэг нь шүүх эрх мэдэл билээ. Манай нийгмийн амьдралд шүүх эрх мэдлийг хэр бодит зүйл болгож чадсанаас эрх зүйн шинэтгэл, өөрчлөлтөд шийдвэрлэх алхам хийгдэх юм. Эрх зүйн үндэс сууриа Үндсэн хуулиар баталгаажуулж авснаас хойш 10 гаруй жил өнгөрөхөд шүүх эрх мэдлийн байгууллагуудын тогтолцоо, үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчинд ямар өөрчлөлт орж, өнөөгийн байдал ямар байна вэ.

Шүүх эрх мэдэл жинхэнэ агуулгаараа хэрэгжих бүх нөхцөл бүрдэх нь олон жил үргэлжлэх урт хугацааны процесс юм гэдгийг хүн бүр хүлээн зөвшөөрнө. Энэ хугацаанд туршлага хуримтлагдах, алдаж онох, засаж залруулах, өөрчилж шинэчлэх олон үйл явдал болдог. Шүүхийн тухай хуульд 7 удаа нэмэлт өөрчлөлт орж, 2002 онд Шүүхийн тухай шинэ хууль батлагдсан. Прокурорын байгууллагын тухай хуульд 2 удаа өөрчлөлт орж мөн онд шинэ хууль батлагдлаа. Өмгөөллийн тухай хууль ч 2002 онд шинээр батлагдлаа. Үндсэн хуульд болон Шүүхийн тухай хуульд шүүн таслах ажлын төрлөөр дагнасан шүүх байгуулж болно гэсний дагуу Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль батлагдаж, Монгол Улсад захиргааны шүүх байгуулагдахаар болж, одоо бэлтгэл ажил хийгдэж байна.

2. Шүүх эрх мэдлийн байгууллага

Монгол Улсын Үндсэн хуулийн "Шүүх эрх мэдэл" бүлэгт Монгол Улсын шүүхийн үндсэн тогтолцоо, зохион байгуулалт, үйл ажиллагааны үндсэн зарчим, шүүгчийн бүрэн эрхийн болон үйл ажиллагааны эрх зүйн үндэслэлүүдийг зааж өгснөөс гадна шүүгдэгчийн өөрийгөө өмгөөлөх болон мэргэжлийн өмгөөлөгчөөр өмгөөлүүлэх эрхийг, төрийн нэрийн өмнөөс шүүх хуралдаанд оролцох прокурорын эрхийг, прокурорын байгууллагын тогтолцоо, зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг хуулиар тогтоохоор заасан байдаг. Мөн энэ бүлэгт шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах зорилго бүхий байгууллага болох Шүүхийн ерөнхий зөвлөлийн эрх зүйн байдлыг тодорхойлсон билээ.

Ингэснээр шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгууллага нь Монгол Улсын шүүхийн тогтолцоонд багтах шүүх хэдий ч энэхүү эрх мэдлийг хэрэгжүүлэх

үйл ажиллагаа нь Шүүхийн ерөнхий зөвлөл, прокурор, өмгөөллийн байгууллагын оролцоотой салшгүй холбоотой тул шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгууллагууд гэсэн нэр томъёо бидний амьдралд орж ирсэн юм. Эдгээр байгууллагын зохион байгуулалт, үйл ажиллагааны үндсэн нь тус бүрдээ хуулиар зохицуулагддаг хэдий ч шүүх эрх мэдэл гэсэн төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн үндсэн нэг зорилготой гэж хэлж болно. Эдгээр болон бусад байгууллагын үйл ажиллагааны онцлог болон хоорондын харилцааны талаар товч дурдъя.

а) Шүүх ба Үндсэн хуулийн цэц

Үндсэн хуулийг хамгаалах гэдэг нь өргөн утгаараа Үндсэн хуулийн биелэлтэд хяналт тавих талаарх төрөл бүрийн арга хэмжээний нийлбэр цогц юм. Ийм ч утгаараа Үндсэн хуулийг хамгаалах буюу түүний биелэлтэд хяналт тавих ажиллагааг хэрэгжүүлэх нь Үндсэн хуулийн заалтыг амьдралд хэрэгжүүлэхийг эрмэлздэг бүх байгууллага, иргэдийн эрхэм зорилго гэж хэлж болно. Гэвч Үндсэн хуулийн биелэлтэд хяналт тавих үйл ажиллагааг юуны өмнө энэ үүргийг гүйцэтгэх эрх бүхий байгууллага хуульд заасан үндэслэлээр хэрэгжүүлнэ.

"Монгол Улсын Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн" гэж Монгол Улсын Үндсэн хуульд заасан байдаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуулийн шүүх мөн гэдэгт эргэлзэх хүн байхгүй л болов уу. Харин шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгууллага мөн үү гэдэг асуултыг дэлгэрүүлж үзье.

Үндсэн хуулийн дөчин долдугаар зүйлд *"Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ. Ямар ч нөхцөлд хуулиас гадуур шүүх байгуулах, шүүх эрх мэдлийг өөр байгууллага эрхлэн хэрэгжүүлэхийг хориолоно"* гэж, дөчин наймдугаар зүйлд *"Шүүхийн үндсэн тогтолцоо Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэх бөгөөд эрүү, иргэн, захиргааны зэрэг шүүн таслах ажлын төрлөөр шүүхийг дагнан байгуулж болно. Дагнасан шүүхийн үйл ажиллагаа, шийдвэр нь Улсын дээд шүүхийн хяналтаас гадуур байж үл болно"* гэж заажээ. Тэгвэл Үндсэн хуулийн цэц буюу Үндсэн хуулийн шүүх маань шүүхийнхээ тогтолцоонд ордоггүй, шийдвэр нь Улсын дээд шүүхийн хяналтад байдаггүй л юм бол шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч биш гэж үзэх үү?

Ихэнх ардчилсан улсад төрийн эрх мэдэл хэрэгжүүлэх Үндсэн хуулийн үндэс нь засгийн эрх мэдэл хуваарилах зарчим байдаг. Ардчилсан улсад засгийн бүх эрх мэдэл ард түмний мэдэлд байх ба тэр нь төрийн засаглалын байгууллагуудаар дамжин хэрэгждэг. Төрийн аль нэг байгууллага өөрийн гарт засгийн бүх эрх мэдлийг хяналтгүйгээр төвлөрүүлэх боломжийг хязгаарлахын тулд засгийн нэгдмэл эрх гурван салаа мөчирт (хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх) хуваагддаг билээ. Засгийн эрх мэдэл хуваарилах нь төрийн байгууллагууд үйл ажиллагааныхаа төрлөөр төрөлжих, тэдгээрт зохих эрх хэмжээ олгох, бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ бие даасан, хараат бус байх, өөр хоорондоо харилцан хамаарах, хяналт тавих боломжтой байхыг илэрхийлдэг.

Энэхүү засаг хуваарилах зарчмыг хэрэгжихэд "харилцан хязгаарлалтын тогтолцоо" бий болгох нь чухал байдаг. Тэгвэл Үндсэн хуулийн цэц нь хууль, зарлиг, Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн бусад шийдвэр, Монгол Улсын олон улсын гэрээ Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх; Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдыг огцруулах, Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татах үндэслэл байгаа эсэх зэргийн асуудлаар дүгнэлт гаргах бүрэн эрхтэйн хувьд засаг хуваарилах онолын "харилцан хязгаарлалтын тогтолцооны" шүүх засаглалын мэдлийг хэрэгжүүлэгч болж байна. Монгол Улсын шүүхийн тогтолцоо нь Улсын дээд шүүх болон бусад шүүхүүдээс бүрддэг, шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлдэг бол Үндсэн хуулийн цэц нь шүүхийн тогтолцоогүй шүүх засаглалын байгууллага уу, эсвэл Улсын дээд шүүх нь шүүхийн тогтолцооныхоо хамт засгийн эрхгүй шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч үү гэдэг асуудал өөрийн эрхгүй тавигдаж байна.

2002 онд батлагдсан Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд захиргааны шүүхийн шийдвэрлэх маргааны хүрээнд Улсын Их Хурлын, Ерөнхийлөгчөөс гаргасан актууд хамаарахгүйгээр тусгасан байна (хуулийн 4 дүгээр зүйл). Шүүхийн тогтолцоонд багтаж буй захиргааны шүүх нь мөн л "харилцан хязгаарлалтын тогтолцоог" бүрэн утгаар нь хэрэгжүүлэгч болж чадахгүй хэвээр үлдлээ.

Монгол Улсын бүх шатны шүүх нь Шүүхийн тухай хуулийн 12 дугаар зүйлд зааснаар хэрэг маргааныг хянан шийдвэрлэхдээ Үндсэн хууль, түүнд нийцүүлэн гаргасан бусад хуулийг хэрэглэнэ, Үндсэн хуульд нийцээгүй хуулийг хэрэглэхгүй байхаар заажээ. Мөн хууль нь Үндсэн хуульд нийцэхгүй байна гэж үзвэл шүүх тухайн хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлж, саналаа Улсын дээд шүүхэд оруулж, Улсын дээд шүүх нь саналыг хэлэлцэж, Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргана гэжээ. Тэгвэл Улсын Их Хурлын тогтоолыг Үндсэн хууль зөрчсөн гэдэг утгаар нь биш өөрийн нь эсвэл бусдын эрхийг хохироосон, хуульд харш гэж үзсэн иргэний гомдлыг захиргааны шүүх хүлээн авч шийдвэрлэх боломжгүй тул яах вэ? Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль Үндсэн хууль зөрчсөн, шударга шүүхээр эрхээ хамгаалуулах иргэний эрхийг нь зөрчсөн гэж үзэх үү? Эсвэл хууль тогтоох байгууллагын гаргасан эрхийн актыг шүүх хянах эрхгүй буюу шүүхэд "харилцан хязгаарлалтын тогтолцоо" хамаагүй, шүүх эрх мэдлийг шүүхийн тогтолцоонд орж буй эрүү, иргэн, захиргааны шүүхэд хамруулж ойлгохгүй гэж үзэх үү?

Энэ мэтийн олон асуулт гарч болзошгүй ба тэдгээрт үндэслэл бүхий хариулт өгснөөр шүүх эрх мэдлийн тогтолцоо төрийн тогтолцоонд ямар байр суурь эзлэхийг зөв тодорхойлоход ач холбогдолтой ба Үндсэн хуулийн хэрэгжилтэд хяналт тавих үүрэг бүхий, манай улсын ардчиллын нэгэн томоохон ололт болох Үндсэн хуулийн шүүхийн байр суурийг зөв тодорхойлоход ач холбогдолтой гэж үзэж байна. Төрийн гурван өндөрлөг гэсэн ойлголтод шүүх эрх мэдлийн өндөрлөг багтдаг юмаа гэдгийг манай улсын иргэд тэр болгон мэдэхгүй байж магадгүй ч, үгүйсгэгдээгүй байхад энэ ойлголт албан ёсны баримт бичгүүдэд ч өөрөөр хэрэглэгдсээр ирлээ.

Эрх зүйт төрийн элементүүдэд тухайн улсын Үндсэн хуулийн зохицуулалт, Үндсэн хуулиар бэхжүүлсэн тухайн нийгмийн чөлөөт ардчилсан хэв журмыг хамгаалахтай холбоотой хүчин зүйлүүд багтдаг. Энэ нь улс орон болгонд өвөрмөц ялгаатай байдаг бөгөөд Үндсэн хуулийг хамгаалдаг Үндсэн хуулийн шүүхүүд, Үндсэн хуулийн онол дээр тулгуурласан практик дээрээ

түшиглэн уг элементүүдийг тогтоолцох нь зүйтэй юм. Эрх зүйт төрийн онолын үндэслэл улс орон болгонд адил төсөөтэй боловч эрх зүйт төр ямар элементтэй байх, элемент болгон нь хэрэгжлээ олох ямар хэлбэртэй байх нь төр болгонд өөр байж болдог. Гагцхүү эдгээр нь онолынхоо үндэслэлд нийцэж байх ёстой ба зөвхөн энэ тохиолдолд тухайн төр эрх зүйт төр болно гэж ойлгогддог.

б) Шүүх ба Шүүхийн ерөнхий зөвлөл

Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах зорилгоор Шүүхийн ерөнхий зөвлөл ажиллана гэж Монгол Улсын Үндсэн хуульд заасан ба Шүүхийн ерөнхий зөвлөлийн зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг Шүүхийн тухай хуулиар тогтоодог юм. Шүүхийн ерөнхий зөвлөл нь шүүх, шүүгчийн шүүн таслах ажиллагаанд оролцохгүйгээр, гагцхүү хуульчдаас шүүгчийг шилж олох, эрх ашгийг нь хамгаалах зэрэг шүүхийг бие даан ажиллах нөхцөлөөр хангахтай холбогдсон үүргийг биелүүлдэг.

Эрх мэдэл хуваарилах онолыг сонгодог байдлаар нэлээд цэгцтэй боловсруулсан сэтгэгч гэж Ш.Монтескьег зүй ёсоор үздэг. Тэрээр "Хуулийн амин сүнс" бүтээлдээ "Хууль тогтоох хийгээд, гүйцэтгэх эрх мэдлийг нэг гарт төвлөрүүлбэл эрх чөлөөний тухай ярих ч аргагүй. ...Нэгэнт эрх чөлөөгүй нөхцөлд хараат бус, шударга шүүх мөн оршихгүй. Шүүх эрх мэдлийг хууль тогтоох эрх мэдэлд нагтгавал иргэдийн амьдрал, эрх чөлөө дур зоргын золиос болно. Хэрэв гүйцэтгэх эрх мэдэлд шүүхийг нэгтгэвэл шүүх дарангуйлагч болох бололцоотой" гэж бичжээ. Суут ухаантны энэхүү үгийг ахин дахин эргэж уншиж нэгийг ухаарч байх нь одоогийн үеийн улс төрч, төрийн эрх баригч нарт тун илүүдэхгүй энэ дашрамд тэмдэглээ.

Шүүхийн ерөнхий зөвлөл нь Үндсэн хуульд заагдсан, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч шүүхийн үйл ажиллагаатай салшгүй холбоотой, хамтын удирдлагын байгууллага юм. Тэрээр шүүн таслах ажилд хөндлөнгөөс оролцох эрхгүй хэдий ч шүүн таслах ажиллагаа хэвийн явагдах нөхцөлийг бүрдүүлэгчийн хувьд шүүх эрх мэдлийн хэрэгжилтийн идэвхтэй оролцогч билээ. Шүүхийн ерөнхий зөвлөлийг хэн толгойлох вэ гэсэн асуулт өнгөрсөн хугацаанд багагүй маргаан дэгдээж, энэ талаар байж болох хувилбар бүрийг сонгож үзсэн гэж болно.

Шүүхийн тухай анхны хуулиар Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргыг гишүүд дотроосоо олонхийн саналаар томилохоор тогтоосон бөгөөд уг зөвлөлийн анхны хуралдаан Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийг даргаараа томилсон. Шүүхийн тухай хуульд 1996 онд оруулсан өөрчлөлтөөр Шүүхийн ерөнхий зөвлөлийг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн толгойлох болсон. Шүүхийн тухай 2002 оны хууль батлагдах үед Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж гарч, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга нь улс төрийн албан тушаалтан байж болохгүй гэж дүгнэсний дагуу Шүүхийн тухай хуульд Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга нь Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч байхаар хуульчилсан.

Шүүхийн ерөнхий зөвлөлийг хэн толгойлсноос тус зөвлөлийн эрх зүйн байдал, үйл ажиллагааны чиг үүрэг, зарчим өөрчлөгдөхгүй нь мэдээж хэдий ч энэхүү өөрчлөлтүүд нь өөрийн ололттой, дутагдалтай талуудтай билээ. Шүүхийн ерөнхий зөвлөлийг Засгийн газрын гишүүн толгойлоход шүүхийн төсвийн хүндрэлтэй асуудлыг түргэн, шуурхай шийдвэрлэх боломжтой байх

ач холбогдолтой байлаа. Гэтэл шүүхийн төсвийн хүндрэл зөвхөн Шүүхийн ерөнхий зөвлөлийг хэн толгойлдогос шалтгаалдаг гэвэл хилс болно. Шүүхийн төсвийг төр бүрдүүлэхдээ шүүн таслах ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг хангахуйц хэмжээгээр л шийдвэрлэх үүрэгтэй. Хөрөнгө санхүүгийн бэрхшээл нь улс орны эдийн засгийн хөгжилтэй шууд холбоотой тул түүнийг зүй тогтлын биш цаг зуурын гэж ойлгох нь зөв байх. Харин шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах байгууллагыг улс төрийн албан тушаалтан, Засгийн газрын гишүүн, одоогийн нөхцөлд хууль тогтоох байгууллага болох Улсын Их Хурлын гишүүн толгойлох нь дээрх суут ухаантны хэлсэн үг, засаглал хуваарилах онолд хэр нийцэж байгаа нь илүү анхаарал татах байх. Зарчмын утгаараа энэ нь шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдалд эсрэг байдлаар нөлөөлөх боломжийг бүрдүүлж болох юм.

Шүүхийн ерөнхий зөвлөлийг Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч тэргүүлэх нь шүүхийн захиргааны байгууллага салбарынхаа хэмжээнд нэгдмэл бүтэц, тогтолцоотой, нийтлэг дэг журамтай байх, шүүхийн удирдлага, зохион байгуулалтыг улс төрөөс ангид байлгах, шүүх эрх мэдлийн бие даасан байдлыг хангах зорилтын үүднээс зөв гэж тайлбарлах боломжтой хувилбар юм.

Гэтэл шүүгчийн шүүн таслах ажилдаа хараат бус байх нь мөн шүүн таслах ажил, захиргааны ажлаас ангид байлгаснаас хамааралтай билээ. Шүүгчийг ажилд авах, шилжүүлэх, чөлөөлөх, огцруулах, цалин хөлсийг нь олгох асуудлыг мэддэг этгээд шийдсэн хэргийг нь мөн хянадаг бол шүүгч жинхэнэ утгаараа хараат бус байж чадах эсэх нь эргэлзээтэй. Шүүхийн төсөв санхүүгийн бэрхшээлийг даван туулах гэж Засгийн газар, Улсын Их Хурлаас мөнгө гуйж буй этгээд Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч байх хэр зохимжтой вэ. Ийнхүү шүүхийн Ерөнхий шүүгч гэсэн ойлголтоос эргэж шүүн таслах ажил эрхэлдгүй, аж ахуйн ажил хөөцөлддөг шүүхийн дарга гэсэн ойлголтонд эргэн орно гэсэн үг үү?

Тийм гэсэн хариулт ирэхгүй байх, учир нь Шүүхийн ерөнхий зөвлөлийг хэн толгойлсноос үл хамааран уг байгууллагын үндсэн чиг үүрэг хэвээр. Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын алба Улсын дээд шүүхтэй нэг байранд орсноор Дээд шүүхийн бүтцэнд орохгүй, шүүн таслах ажиллагаанд оролцохгүй, өөрийн төсөв, санхүүтэй, өөрийн бие даасан үйл ажиллагаагаа явуулна.

Гэхдээ Шүүхийн ерөнхий зөвлөл удирдлага зохион байгуулалтын хувьд өөрөө бие даасан, дарга нь засаглалын салаа мөчрийн аль нэгт хамаарадггүй, эрх мэдэл бүхий албан тушаалтан байх нь илүү зохимжтой санагддаг. Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын ажлыг аливаа өөр албан тушаалтай хавсарч хийснээр энэхүү ажилд байнга, өдөр дутам анхаарлаа хандуулж чадахгүй байх дутагдалтайгаас гадна хүссэн хүсээгүй Ерөнхий зөвлөлийн даргын ажил түүний үндсэн ажилтай хутгалдаж, холилдох явдал гардаг.

Жишээлбэл, Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргад иргэний хэрэг шийдвэрлэгдэхгүй удаж байна, шүүгч муу ажиллаж байна гэсэн гомдол ирэхэд Ерөнхий зөвлөлийн дарга-Хууль зүй, дотоод хэргийн сайд шүүхэд үүрэг өгөх, шүүн таслах ажиллагаанд оролцох шаардлага гарна. Яг энэ өргөдөл Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга-Улсын дээд шүүхийн Ерөнхий

шүүгчид ирлээ гэж үзье. Ерөнхий шүүгч шүүгчийн хувьд тухайн хэргийг хянах тохиолдолд хэргийн оролцогч талаас гарсан гомдол түүний субъектив хандлагад нөлөөлөхгүй гэх баталгаа бага юм. Ер нь Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн, Хууль зүйн сайдын аль алины ажил чамлахааргүй их, онцгой хариуцлагатай гэдэгтэй хүн бүр санал нийлэх байх.

Шүүхийн Ерөнхий зөвлөлийн даргын ажил эдгээрээс дутахааргүй л хүнд ажил юм. Гэтэл энэ нүсэр их ажилтай албан тушаалуудыг заавал хавсарч хийгээд байдаг нь нэг талаас хавсарч буй ажлын аль нэг нь хаягдаж, цалгардахад хүрэх, нөгөө талаар шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байх Үндсэн хуулиар баталгаажсан зарчмыг өөрийн эрхгүй хөндөхөд хүргэж болзошгүй юм. Дэлхийн улс орнууд энэхүү асуудлыг өөрсдийн онцлог байдалд тохируулан өөр өөрөөр шийдсэн байдаг.

Шүүхийн бие даасан байдлыг хангах үүрэг бүхий шүүхийн захиргааны байгууллага нь шүүхээсээ тусдаа Засгийн газраа түшиглэн үйл ажиллагаа явуулдаг тогтолцоо Герман, Нидерланд, Тайланд зэрэг улсад байдаг бол АНУ, Япон, Солонгос зэрэг улсад шүүхийн захиргааны удирдлага, зохион байгуулалтын асуудлыг шүүгчдийн өөрсдийнх нь шууд оролцоотойгоор хэрэгжүүлдэг аж. Бид өөрийн орны онцлог, түүхэн хөгжлийн үе шат зэргийг харгалзан энэхүү асуудалд шүүмжлэлтэй, нухацтай хандсанаар шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг боловсронгуй болгох, уг эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгууллагуудын тогтолцоог зөв тодорхойлоход ач холбогдолтой гэж үзнэ.

в) Шүүх ба прокурорын байгууллага

Монгол Улсын Үндсэн хуулийн шүүх эрх мэдэл бүлэгт прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно гэж заасан байдаг. 2002 онд батлагдсан Прокурорын байгууллагын тухай хуулийн 2 дугаар зүйлд *"Прокурорын байгууллага нь Монгол Улсын нутаг дэвсгэрт эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэг мөр хангуулах үндсэн чиг үүрэг бүхий, үйл ажиллагаагаа төрийн нэрийн өмнөөс явуулдаг, бие даасан, хараат бус, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцогч байгууллага мөн* гэж тодорхойлжээ.

Мөн хуулийн 15, 16 дугаар зүйлд *прокурор эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс улсын яллагчаар оролцоно, төрийн байгууллагын хүсэлтээр иргэний хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд зохиогчийн төлөөлөгчөөр оролцож, өмгөөлөгчийн бүрэн эрх эдэлнэ* гэж тус тус заагджээ.

Шүүх эрх мэдэл нь эрүү, иргэн, захиргааны шүүн таслах ажиллагаагаар хэрэгжлээ олдог тул энэхүү ажиллагааны оролцогч прокурорын байгууллагыг шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцогч байгууллага гэж нэрлэх нь зүйн хэрэг юм. Харин прокурорын байгууллагын тодорхойлолтод "эрүүгийн хуулийн хэрэгжилтийг нэг мөр хангуулах үндсэн чиг үүрэг бүхий" гэж заасан нь прокурор иргэний шүүн таслах ажиллагаанд оролцох эрх, үүргийг үгүйсгэсэн мэт харагдаж байна. Мөн иргэний шүүн таслах ажиллагаанд оролцож буй прокурор нь өмгөөлөгчийн бүрэн эрх эдэлнэ гэж Прокурорын байгууллагын тухай хуульд туссан байсан нь Өмгөөллийн тухай хуулийн 16.3. буюу *"прокурор ажлаасаа өөрчлөгдсөнөөс хойш 3 жилийн хугацаанд өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэхийг хориглосон* заалттай харшилж

байсан. Учир нь прокурорын ажлыг хийхээ больсноос хойш 3 жилийн хугацаанд өмгөөлөгчийн бүрэн эрхийг эдэлж болохгүй хүн прокуророор ажиллаж байхдаа өмгөөлөгчийн бүрэн эрхийг эдлэх нь утга муутай зүйл гэдэг нь ойлгомжтой билээ.

Энэ санааг Монгол Улсын дээд шүүх 2003 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн 2 дугаар тогтоолдоо тусгаж, хуулийн тайлбар гаргахдаа иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож буй прокурор Өмгөөллийн тухай хуульд заасан өмгөөлөгчийн бүрэн эрхийг биш харин Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан иргэний процесст оролцож буй өмгөөлөгчийн эдлэх эрхийг хэлж байгаа гэж тайлбарласан юм. Энэхүү тайлбарын үндэслэлийг Үндсэн хуулийн Цэц дүгнэлтэндээ тусгаж, Прокурорын байгууллагын тухай хуулийн дээрх заалтыг хүчингүй болгожээ. Прокурорын байгууллагын тухай хуулийн нэг заалтын талаар хийгдсэн дээрх ажиллагааг харахад шүүх эрх мэдлийн байгууллагууд нь хуулийг тайлбарлах, улмаар үйл ажиллагааныхаа үндсэн зарчмыг тодорхой болгоход өөр өөрсдийн эрх мэдлийн хүрээнд хамтарч ажиллах бололцоотойг илэрхийлж байна.

Улсын дээд шүүхийн тайлбар нь хүчин төгөлдөр хуулийг бусад хуультай уялдуулах зорилгоор аргагүй хийгдсэн гэж ойлгогдож байгаа ба ер нь шүүгч, прокурор нь ажлаасаа чөлөөлөгдсөн тохиолдолд 3 жилийн хугацаанд өмгөөллийн үйл ажиллагаа явуулах эрхгүй байх тухай Өмгөөллийн тухай хуулийн заалт нь өөрөө шүүгч, прокуророор ажиллаж байгаа хүмүүсийг эзэмшсэн мэргэжил, эрхэлж байсан албан тушаалаар нь ялгаварлан гадуурхах, эзэмшсэн мэргэжлийн дагуу чөлөөтэй ажил хөдөлмөр эрхлэх эрхийг нь хязгаарласан заалт гэж ойлгогддог.

Прокурорын байгууллага, шүүх хоёр ямагт зэрэгцэн үйл ажиллагаа явуулж ирсэн бөгөөд "шүүхийн прокурор" гэсэн ойлголт байсныг ч бид мартаагүй билээ. Шүүн таслах ажиллагаанд оролцох прокурорын байр суурийг яв цав, зөв тодорхойлсноор шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны арга, хэлбэрийг боловсронгуй болгох, эдгээр байгууллагуудын ажлын уялдаа холбоог нарийн зааглаж, бэхжүүлэх, эцсийн дүндээ шүүх эрх мэдлийг шударга үнэн, хууль зүйн үндэслэлтэй явуулах нөхцөлийг бүрдүүлэхэд тус дөхөм үзүүлэх юм.

г) Шүүх ба өмгөөллийн байгууллага

Өмгөөллийн тухай хуульд зааснаар Монголын өмгөөлөгчдийн холбоо нь өмгөөлөгчдийг эгнээндээ нэгтгэсэн, тэдний эрх ашгийг хамгаалах зорилго бүхий төрийн бус, мэргэжлийн байгууллага гэжээ. Төрийн бус байгууллага нь шүүх эрх мэдэл гэгч төрийн эрх мэдлийн хэрэгжилтэд ямар хамаатай байх вэ гэсэн асуулт тавигдана.

Монголын өмгөөлөгчдийн холбоо нь өөрөө шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд шууд хамааралгүй юм. Энэ байгууллагын үйл ажиллагаа, зорилго, чиглэл нь ч өөр. Гэхдээ гишүүдийн нь үйл ажиллагаа, ер нь өмгөөлөх үйл ажиллагааны зорилго нь шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны зорилготой нягт холбоотой юм. Хүний эрх, эрх чөлөө, шударга ёсыг хангах, хууль дээдлэх нь өмгөөллийн үйл ажиллагааны гол үндсэн зарчмуудын нэг билээ.

Монгол Улсын Үндсэн хуульд "Шүүгдэгч өөрийгөө өмгөөлөх эрхтэй, шүүгдэгчид энэ эрхээ эдлэхэд хүсэлтээр нь буюу хуульд зааснаар хууль зүйн туслалцаа үзүүлнэ" гэж заажээ. Өмгөөлөгчдийн холбоо төрийн бус байгууллага хэдий ч өмгөөлөгч өөрийн үйл ажиллагаагаараа төрийн эрх мэдэл болох шүүн таслах ажиллагаанд чухал үүрэг гүйцэтгэдэг. Хүний эрхийг чанд хамгаалах үйл ажиллагаа нь төрөөс хараат бус байж, өмгөөлөгч "хувийн секторын" хүн болсон нь манай хууль зүйн тогтолцоонд мөн л дөнгөж 10 жилийн нүүр үзэх гэж байгаа шинэ ойлголт юм. Гэхдээ өмгөөлөгчдийг бэлтгэх, өмгөөллийн эрх олгох, эрхийг хасах, түдгэлзүүлэх гэх мэт ажиллагаа нь төрийн хараа хяналтад байдаг ба энэ нь шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд мэдлэг хомс, ёс зүйн хувьд дутагдалтай, өмгөөлөгчийн эрхэм үүргийг гүйцэтгэх чадваргүй хүмүүсийг оруулахгүй, байлгахгүй байх зорилгыг тодорхой хэмжээгээр агуулж байна гэж ойлгогддог.

Эрүүгийн байцаан шийтгэх, иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгчийн эдлэх эрх, хүлээх үүргийг холбогдох хуулиудад нь нарийвчлан зааж өгсөн байдаг ба өмгөөлүүлэх эрхээр нь хангаж өгөх үүрэг шүүхэд ноогддог тул шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг өмгөөллийн үйл ажиллагаагүйгээр төсөөлөх аргагүй юм. Харин цаашид шүүн таслах ажиллагаанд өмгөөлөгчийн оролцоог шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч субъектуудын нэг гэсэн утгаар нь судалж, үндэс нэгтэй үйл ажиллагааг нэгдсэн зарчим, шалгуураар дүгнэвэл шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа, түүнийг зохицуулж буй хууль тогтоомжийг боловсронгуй болгоход чухал ач холбогдолтой юм.

3. Шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төрөл ба шүүх эрх мэдлийн байгууллага оролцох нь

Шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь эрүүгийн болон иргэний шүүн таслах ажиллагааны хэлбэрээр явагдаж билээ. Удахгүй захиргааны шүүн таслах үйл ажиллагаа явагдаж эхэлнэ. Энэхүү ажиллагааны журам, ажиллагаанд оролцогчдын эрх, үүргийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай, Эрүүгийн байцаан шийтгэх тухай, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиудаар зохицуулна. Шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгууллагуудын шүүн таслах ажиллагаанд оролцох оролцоо, эрх, үүрэг, эрх зүйн байдал өөр хэдий ч энэхүү үйл ажиллагаанд өөрийн байр суурьтайгаар оролцооны үр дүнд шүүх эрх мэдэл хэрэгжлээ олдог билээ.

2002 оны 9 дүгээр сарын 1-нээс эхлэн дагаж мөрдөж буй Эрүүгийн байцаан шийтгэх, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиуд нь шүүн таслах ажиллагаанд шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгууллагуудын оролцоо, үйл ажиллагааны зарчим, эрх, үүргийг нь нарийн тодорхойлсон юм.

Тус тусын оролцооны онцлог ялгаа нь өөрсдийн гүйцэтгэж байгаа үүргийн онцлогоос хамаардаг хэдий ч шүүн таслах ажиллагааны гол зорилгод нэгтгэгддэг тул зорилго, чиглэл нь нэг юм. Процессийн эрх зүй (эрүүгийн ч, иргэний ч) эрх зүйн тогтолцоонд эзлэх байр суурь нь тодорхой бөгөөд харин бусад салбар эрх зүйтэй харьцах харилцааны онцлогт анхаарлаа хандуулъя. Процессийн эрх зүйг материаллаг эрх зүйн илэрхийлэл гэж үзэх үзэл хуульчдын дунд байдаг. Өөрөөр хэлбэл Эрүүгийн эрх зүйн хэм хэмжээ Эрүүгийн байцаан шийтгэх үйл ажиллагаанд хэрэгжлээ олдог, Иргэний эрх зүйн хэм хэмжээ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд

хэрэгжлээ олдог тул процессийн эрх зүй нь материаллаг эрх зүйн илэрхийллийн нэг хэлбэр гэж үзэх тохиолдол цөөнгүй байдаг.

Энгийн нэг жишээн дээр авч үзэхэд эрх зүйн боловсрол олгодог их дээд сургуулиудад эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн хичээл эрүүгийн эрх зүйн тэнхимд, иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй иргэний эрх зүйн тэнхимд харьяалагддаг билээ. Тэгвэл прокурор, шүүгч, өмгөөлөгч гурвыг шүүн таслах ажиллагаанд юу нэгтгэж байна вэ? Эрүүгийн эрх зүйн хэм хэмжээ, иргэний эрх зүйн хэм хэмжээ юу? Тэд энэхүү эрх зүйн хэм хэмжээг хэрхэн яаж хэрэглэх вэ гэсэн асуудлаар мэргэжлийн хүмүүсийн хувьд өөрийн гэсэн тайлбар санал гаргаж байгаа нь ойлгомжтой. Гэхдээ тэдгээрийг нэгтгэж байгаа нэг зүйл бол шүүх эрх мэдлийг хэрэгжүүлж буй процесс өөрөө юм.

Эрүүгийн шүүх эрх мэдэл, иргэний шүүх эрх мэдэл гэж байдалгүйн адил шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгууллагууд эрүү, иргэний ямар хэрэг шийдвэрлэгдэж байгаагаас үл хамааран шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх хэлбэр болох шүүн таслах ажиллагаанд хуулиар өөр өөрт нь оногдсон эрх хэмжээний дагуу оролцож байгаа билээ. Тэгэхлээр процессийн эрх зүй нь материаллаг эрх зүйтэй салшгүй холбоотой байдаг хэдий ч процессийн эрх зүй өөрөө салбар салбараараа хоорондоо илүү их холбоотой ба тэдгээрийн үндсэн зарчим, үндсэн ойлголтуудыг цогцоор нь, харьцуулан судалгаатай хандах нь чухал байна.

Энэ утгаар нь авч үзвэл :

- процессийн эрх зүй ба түүний эрх зүйн системд эзлэх байр суурь;
- процессийн эрх зүй ба материаллаг эрх зүй;
- процессийн хууль тогтоомж;
- иргэний болон эрүүгийн шүүн таслах ажиллагаан дахь шүүх;
- иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллаганы оролцогч талууд;
- эрүүгийн шүүн таслах ажиллагааны оролцогч талууд;
- эрүүгийн байцаан шийтгэх ажиллаган дахь иргэний нэхэмжлэл;
- эрүү болон иргэний шүүн таслах ажиллаганы нотолгоо, нотлох баримт;
- эрүү болон иргэний шүүн таслах ажиллагааны үндсэн зарчмууд гэх мэт сэдвээр харьцуулсан судалгаа явуулж, хоёр процессийн нэгдмэл шинжүүдийг нь, онцлог ялгааг нь нарийвчлан гаргаж болох юм.

Үнэндээ хэлэхэд эрүү, иргэний процессийн ялгааг дөвийлгөж гаргах нь тэдгээрийн адил байдлыг судлахаас илүү байдгийг бид бүхэн мэднэ. Энэхүү судалгааг шинжлэх ухааны үүднээс ч, практик судалгааны ч үүднээс зохих түвшинд хийвэл хууль тогтоомжийг боловсронгуй болгох, шүүх эрх мэдлийн байгууллагуудын шүүн таслах ажиллагаанд эзлэх байр суурь, тэдгээрийн эрх, үүрэг, үйл ажиллагааны үндсийг зөв тодорхойлоход ач холбогдолтой юм.

4.Шүүх эрх мэдлийн байгууллагын эрх зүйн байдал, үйл ажиллагааны журмыг зохицуулж буй эрх зүйн салбар. Шүүхийн эрх зүй

Шүүх эрх мэдлийн байгууллагуудын эрх зүйн байдлыг тодорхойлох харилцааг Үндсэн хуулийн эрх зүй, эрүү, иргэн, захиргааны шүүн таслах ажиллагааны журмыг тодорхойлсон харилцааг эрүү, иргэн, захиргааны процессийн эрх зүй тус тус зохицуулдаг. Нийгмийн харилцааны аль хэсгийг нь эрх зүйн ямар салбар зохицуулах вэ гэдэг шалгуурыг тухайн харилцааг

ямар үйл ажиллагаа, үйл баримт бий болгосноос шалтгаалан тодорхойлох нь зөв байх.

Тэгвэл шүүхийн болон шүүх эрх мэдлийн бусад байгууллагын зохион байгуулалт, харьяалах хэрэг шийдвэрлэх үйл ажиллагааны журам зэргийг тодорхойлж буй эрхийн хэм хэмжээнүүд тулгуур суурь нэгтэй ба тэр нь шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх явцад буюу уялдаа холбоо бүхий бусад ажиллагаанд шууд хамаардаг аргаар цогцолбор шинжийг хадгалдаг. Тухайлбал, шүүхийн байгууламж, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа, иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилго, чиглэлүүд үндсэндээ нэгдмэл юм. Эдгээр нь эрх зүйн тусгай гурван салбарын хувьд өөрсдийн бие даасан байдал, онцлог шинж чанарыг хадгалахын зэрэгцээ шүүх эрх мэдэл хэмээх төрийн үйл ажиллагааны нэгдсэн нэг төрөлд багтдаг. Энэ утгаараа **шүүхийн эрх зүй** гэсэн эрх зүйн нэг салбар эрх зүйн системд байгаа гэдгийг хүлээн зөвшөөрөх цаг болсон.

Шүүхийн эрх зүй гэх эрх зүйн шинэ салбарыг бий болгох шаардлага байна уу, үгүй юу гэсэн асуулт тавигдах биш харин одоогийн эрх зүйн тогтолцоонд шүүхийн болон шүүх эрх мэдлийн байгууллагуудын байгууламжийн, шүүн таслах ажиллагааны төрлүүдийг нэгтгэсэн нийлмэл, цогцолбор эрх зүй байгаа юу? гэдэг асуултыг тавих нь илүү чухал санагдаж байна. Энэ салбарыг шүүхийн эрх зүй гэж нэрлэхгүй өөрөөр нэрлэсэн ч хамаагүй, голчлүү байгаа эсэхэд хариулт өгч, энэ нь хий хоосон, зохиомол, хэнд ч хэрэггүй "байгууламж" биш харин бодит амьдралд байгаа, эрх зүйн нэг салбар мөн юм гэж тодорхойлох нь чухал байна.

Шүүхийн эрх зүйн үзэл баримтлал нь цоо шинэ зүйл биш юм. Оросын нэрт эрдэмтэн, доктор, профессор Н.Н.Полянский (1878-1961) анх шүүхийн эрх зүйн үзэл баримтлалын асуудлыг гарган ирж, сүүлд ЗХУ-ын үед нэрт эрдэмтэн М.С.Строгович, В.М.Савицкий, А.А.Мельников нар түүний үзэл санааг дэмжин үргэлжлүүлж байсан хэдий ч хөрөнгөтний үзэл суртлыг зөвлөлтөйн процессийн эрх зүйд оруулах оролдлого гэж шүүмжлэгдэж байснаар энэ талаар тэд хэдий үзэл бодлоо хамгаалсаар ирсэн ч шүүхийн эрх зүйн үзэл баримтлал газар авч чадаагүй билээ.

Оросын хуульч В.А.Рязановский 1919 онд "Процессийн нэгдмэл байдал" нэртэй бүтээл туурвиж байсан ба түүнийг нь Эрхүүгийн их сургууль 1919 онд хэвлүүлж, 1924 онд Харбинд уг ном дахин хэвлэгдэж байжээ. Гэтэл энэ бүтээлийн талаар ер нь судлаачид дурдахгүй байсаар олон жил болсон ч энэ номын анхны хэвлэлийн нэг хувь азаар хаант Оросын үеийн Эрхүүгийн шүүгчийн хүүд хадгалагдсан байсан нь олон, дөнгөж 1996 онд дахин хэвлэжээ.

Шүүхийн процессийн нэгдмэл байдлын тухай үзэл баримтлалыг В.А. Рязановский маш эртнээс улбаатайгаар гаргаж иржээ. Бауэр (1827), Рудольф Иеринг "Эрхийн төлөө тэмцэл" (орос хэл дээр 1874 онд хэвлэгдсэн), мөн түүний алдарт зохиол болох "Эрх зүй дэх зорилго" (1877) бүтээлүүдэд энэхүү үзэл баримтлал тусгалаа олж байсан байна. Ийнхүү шүүхийн эрх зүйн үзэл баримтлалд хандах судлаачдын анхаарал сулрахгүй байсаар ирсэн. Нэн ялангуяа сүүлийн жилүүдэд энэхүү судалгаа улам бүр сонирхол татаж, шинэ санаа, бодлыг агуулах болжээ.

Шүүхийн байгууламж, эрүү, иргэний шүүх ажиллагааны уялдаа холбоо, ач холбогдлыг төдийлөн ойшоохгүй, тэдгээрийг нэг үндэстэй, төрийн үйл ажиллагааны нэг төрөл болох "шүүх эрх мэдэл"-д хамаарах гол шинжийг анхаарахгүй, харин эрүүгийн процесс ба эрүүгийн эрх зүй, иргэний процесс ба иргэний эрх зүйн хоорондох холбоог илүү чухалчлан үзэх хандлага онол, практикийн хүрээнд одоо ч хүчтэй хэвээр байгаа. Процессийн эрх зүй нь материаллаг эрх зүйн илэрхийлэл гэж үзэх үзэл санаа давамгайлсаар ирлээ.

Тэдгээрийн хоорондын уялдаа холбоог хэрхэвч үгүйсгэхгүйгээр асуудлыг өөр өнцгөөс харснаар шүүхийн эрх зүйн үзэл баримтлалыг хүлээн зөвшөөрөх үндэс суурь гарна гэж бодож байна. Шүүхийн эрх зүйн үзэл санааг бүрэн тайлбарлахын тулд юуны өмнө процессийн эрх зүйн шүүхийн эрх зүйд эзлэх байр суурийг тодорхойлох, дараа нь процессийн болон материаллаг эрх зүйн хоорондын холбоо, харьцааг нарийвчлан зааглах, эцэст нь шүүхийн байгууламжийн асуудлыг эрх зүйн хэмжээнд авч үзэж, шүүхийн эрх зүйд эзлэх байр суурийг тодорхойлох хэрэгтэй юм.

5. Шүүхийн эрх зүйн үзэл баримтлалыг хөгжүүлж, судалсны ач холбогдол

Шүүхийн эрх зүй нь цогцолбор салбарын хувьд шүүхийн эрх зүйн шинжлэх ухааны зүйл нь болдог. Шүүхийн эрх зүйн үзэл баримтлалын шинжлэх ухааны болон практик ач холбогдол нь юунд байна вэ? Шүүх эрх мэдлийн тухай шинжлэх ухааныг хөгжүүлэхэд, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд ямар нэмэртэй вэ гэдэг асуултад төвч хариулахыг оролдъя. Дээр дурдсанчлан, бид шүүхийн эрх зүйг бий болгох тухай биш харин түүнийг танин мэдэх, Үндсэн хууль, бусад хуульд шууд нэрлэгдээгүй ч тусгагдсан байгаа байдлыг нь зөв олж харж, амьдралд хэрэгжүүлэх асуудлыг тавих нь чухал юм.

Шүүхийн байгууламж ба процессийн эрх зүй, процессийн эрх зүйн өөр өөр салбаруудын хоорондын уялдаа холбоог тодруулснаар хэрхэвч тэдгээрийг нэг зүйл юм, нэг хуулиар зохицуулагдах ёстой гэж үзэхгүй. Харин ч тэдгээр харилцааг зохицуулж буй хуулиуд нь бие даасан, тус тусын байхаас гадна цаашид ч улам нарийвчилсан зүйл заалт, зохицуулалтыг агуулж улам бүр боловсронгуй болох ёстой билээ. Шүүхийн байгууламж, процессийн эрх зүй нэгдсэн кодификацийг шаарддаггүй юм бол ер нь шүүхийн эрх зүйн үзэл баримтлалын ач холбогдол юунд оршиж байна вэ?

Шүүхийн эрх зүйн үзэл баримтлалыг хөгжүүлж, судалснаар Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар засаглалын нэгэн оргил болох төрийн үйл ажиллагааны чухал хэсэг, "шүүх эрх мэдлийн" шинжлэх ухааны суурийг гүнзгийрүүлэн судлах, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, энэ олон талт үйл ажиллагааг цогцолбор байдлаар шинжлэх бололцоо бүрдэнэ. Шүүхийн эрх зүйг бүрдүүлэгч салбаруудын судлаачид нийтлэг асуудлаар судалгаа явуулж, үр дүнтэй ажиллах нөхцөл боломж бүрдэнэ. Эрүүгийн процессийг шүүхийн эрх зүйн нэг хэсэг гэж үзсэнээр хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаа бол шүүн таслах ажиллагаанд туслах ач холбогдолтой гэдэг зарчмын ойлголтын шинжлэх ухааны үндсийг баталгаажуулна. Эрүү, иргэний шүүн таслах ажиллагааны нэгдсэн үндэс, зарчмыг нарийвчлан судалснаар энэ хоёр процессийн нийтлэг, нэгдмэл шинж чанар, адил ач холбогдол, зорилт, чиглэлийг тал бүрээс тодорхойлно. Шүүх эрх мэдлийг зохион байгуулах,

хэрэгжүүлэх чиглэлээр одоо үйлчилж байгаа, цаашид гарах хууль тогтоомжийг боловсронгуй болгоход үнэтэй нэмэр оруулна. Шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгууллагуудын тогтолцоо, хоорондын ажлын уялдаа холбоо, харилцан шүтэлцээг улам боловсронгуй болгоход чухал ач холбогдолтой юм.

6. Дүгнэлт

Шүүх эрх мэдэл гэгч төрийн үйл ажиллагааг Үндсэн хуульдаа баталгаажуулан тодорхойлсноос хойш 10 гаруй жил өнгөрлөө. Шүүх эрх мэдэл гэгч ойлголт бидний амьдралд бий болсоор 10 гаруй жил боллоо.

Аливаа асуудлын үндэс суурь, учир шалтгаан, зарчмын ойлголтуудыг тодорхойлоогүйгээс, гүнзгийрүүлэн судлаагүйгээс, гарч болзошгүй бэрхшээл алдааг урьдчилан тооцож үзээгүйгээс ажлын явц, үр дүн удаашрах, амжилтанд хүрэхгүй байх магадлалыг бий болгодог билээ.

Ер нь шүүх эрх мэдлийн тулгамдсан асуудлуудыг гүнзгийрүүлэн авч үзэх, үндэслэх, судлах ажиллагаа туйлын хангалтгүй хийгддэгийг хэн хүнгүй зөвшөөрөх байх. Монгол Улсад явагдаж буй эрх зүйн шинэтгэлийн үр дүнд эрх зүйн эх сурвалж бүхэлдээ шинэчлэгдэж, хэм хэмжээний бүтэц, агуулга шинэ чиглэлээр баяжиж байна. Эрх зүйн шинэчлэл төрийн бодлогын хэмжээнд тавигдан чиглэл, хөтөлбөр зэрэг баримт бичиг боловсрогдон хэрэгжиж байна. Түүний нэг жишээ, Монгол Улсын Их Хурлын 2000 оны 5 дугаар сарын 4-ний өдрийн 39 дүгээр тогтоолоор батлагдсан "Монгол Улсын шүүх эрх мэдлийн стратеги төлөвлөгөө" юм.

Шүүх эрх мэдэл шинжлэх ухааны, үндэслэл бүхий судалгаагаар тодорхой хэмжээгээр дутагдаж байгааг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй болов уу. Энэхүү судалгааг хийхэд шүүхийн эрх зүйн үзэл баримтлалыг анхаарч, амьдралд хэрэгжүүлэх боломжийг эрэлхийлэх нь чухал байна. Шүүхийн эрх зүйн үзэл баримтлалыг цаашид тал бүрээс нь авч үзэн зохистой шийдвэрлэж, хөгжүүлбэл эрх зүйн онол практикийн чухал ач холбогдолтой бөгөөд шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгууллагуудын үйл ажиллагааг боловсронгуй болгоход чухал үүрэгтэй гэж үзэж байна.

-ooOoo-

АЗИ, НОМХОН ДАЛАЙН ЗАРИМ ОРНЫ ХОРИХ БАЙГУУЛЛАГА: ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ЧИГ ХАНДЛАГА

*Эмэгтэйчүүдийн хорих ангийн дарга, Монгол
Улсын гавъяат хуульч, хурандаа Р.Оюунбадам*

Нэг. Ази, номхон далайн орнуудын засан сайжруулах байгууллагын туршлага

Ази, номхон далайн орнуудад ялтныг зөвхөн хорих биш засан сайжруулах талаас нь ханддаг ба тус газраа "Засан сайжруулах байгууллага" гэж нэрлэдэг. 1980 онд Хонг-конгод болсон Ази, номхон далайн орнуудын Хорих байгууллагуудын удирдах ажилтны анхдугаар хурлаас хойш 20 гаруй жилийн туршид Ази, номхон далайн орнуудын хорих байгууллагууд үйл ажиллагаагаа сайжруулах талаар олон практик алхмуудыг хийжээ. Тухайлбал, ялтанд ял шийтгэл эдлүүлэх үйл ажиллагааг гадаад болон дотоод эх сурвалжид түшиглэн явуулж эхэлсэн байна.

Гадаад эх сурвалжийн талаар. Гадаад эх сурвалжид хууль тогтоох байгууллага, төрийн бусад болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжтэй харилцан, хамтран ажиллах үйл ажиллагааг багтаана. Гадаад эх сурвалжид хамгийн гол нөлөө үзүүлэхүйц газар нь хувийн компаниуд байна. Ийнхүү гадаад эх сурвалжид тухайлбал, хувийн компанитай гэрээ хийж, уг гэрээний үндсэн дээр хорих ангийн олон асуудлыг хамтран шийддэг. Гадаад эх сурвалжийг өргөтгөснөөр хорих байгууллагын санхүүжилт, бусад үйл ажиллагаа нь өргөжин, чанаржиж байна. Иймээс хорих байгууллагууд а/Зардал хэмнэх; б/Ажлаар хангах зорилтын хүрээнд тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлдэг.

Үүний үндсэн дээр:

-Гадны компанитай гэрээ байгуулан ялтнуудын хоол хийлгэх. Шорон дотор өөрийн хоолоор хооллох нь амт чанар, нэр төрлийн хувьд хангалтгүй, харин компаниудаар хоол хийлгэснээр зардал багасч, хоолны чанар сайжирсан байна. Ийм өжил байрлал сайтай, жижиг хорихуудад илүү тохиромжтой.

-Шүүхээс хорих ялаар шийтгэгдсэн ялтнуудыг хорих ангид нь цагдаа хүргэдэггүй гэрээт харуулаар авчруулдаг. Энэ нь офицерын зардлаас хямд тусдаг байна.

-Шоронд ялтнуудын дунд үйлдвэрлэл явуулж, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг гэрээт компаниар борлуулах замаар ялтныг ажлаар хангаж, өөрийн төсөв мөнгөө нэмэгдүүлдэг.

-Сингапурын хориход ялтны хөдөлмөр, үйлдвэрлэлийг хувийн бизнестэй нэгтгэн явуулдаг. Энэ бүхнээс үзэхэд дэлхийн хорих байгууллагуудад нийтлэг турлагч буй бэрхшээл нь санхүүгийн хүндрэл юм. Монголын хорих байгууллагууд санхүүгийн байдлаа сайжруулахын тулд эдгээр орны хорих байгууллага гадаад эх сурвалжаа хэрхэн өргөтгөж байгаа туршлагыг хэрэгжүүлэх боломж байна. Тухайлбал, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай Монгол Улсын хуулийн "жирийн дэглэмтэй хорих ангийн ялтныг хорих байгууллага өөрийн болон өөрийнхөө хувь нийлүүлсэн, хамтарсан аж ахуйн нэгжид, эсхүл бусад аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан зохих хяналттайгаар

хөдөлмөрлүүлж болно" гэсэн заалтын дагуу Эмэгтэйчүүдийн хорих анги 1997 оноос "Буян" компанид 21-110 эмэгтэй ялтныг ажиллуулж байна.

Эрүүгийн ял шийтгэлийг зохицуулсан удаа дараагийн хууль тогтоомжид ялтыг гэрээгээр ажиллуулах тухай асуудал зохицуулагдсаар ирсэн хэдий ч "Буян" компанид гэрээгээр эмэгтэй ялтныг ажиллуулж байгаа байдал, тэнд ажиллаж буй ялтны хөдөлмөрийн онцлог, зохион байгуулалт нь шинэлэг үйл ажиллагаа юм. Тус компани ялтнуудад 45-60 хоногийн хугацаанд ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэх талаар мэргэжлийн сургалт явуулсны үндсэн дээр ажиллуулдаг. Тэднийг тодорхой хугацаанд ажилласны дараа мэргэжлийн зэргийг нь ахиулан, суллагдаж гарахад нь үндсэн ажилчнаар авч ажиллуулан олон хүнийг ажлын байртай болгож, амьдралд нь хөлөө олоход ихээхэн тус нэмэр болдог.

Ялтны боловсролыг дээшлүүлэх талаар. Канад, Сингапур зэрэг оронд ялтыг сургах ажлыг Засгийн газар нь дэмжин тусалж, боловсролын яам /тухайн бүс нутгийн боловсролын байгууллага/ нь эрхлэн сургалтыг явуулдаг, анхан шатны сургалт буюу ерөнхий боловсролын сургалт, мэргэжил эзэмшүүлэх сургалт буюу дээд боловсрол олгох, коллежийн сургалт, зан байдлыг нь өөрчлөх сургалт буюу хорих ял эдэлж байгаа янз бүрийн алдаж эндсэн хүмүүс, баривчлагдсан хүмүүс, хар тамхинд донтогчдод явуулах сургалт, Энэ ангиллын сургалтыг "Гуравдагч сургалт" гэж нэрлэдэг бөгөөд маш өвөрмөц арга барилаар явуулдаг. Хорих байгууллагад гадны дээд сургууль болон эрдэм шинжилгээ, сургалтын газар, хууль тогтоох байгууллагын ажилтнууд, ялтнуудад зориулсан сургалт-семинар зохион байгуулна. Энэ нь хорих байгууллагын ажилтан, ялтнуудын сургалтын менежментийг сайжруулахад чухал ач холбогдол өгдөг.

Энэ үндсэн дээр 2003 оны 10 дугаар сард Хууль зүйн үндэсний төв, Монголын өмгөөлөгчдийн холбоо, Эмэгтэйчүүдийн хорих анги хамтран Эмэгтэйчүүдийн хорих ангид "Зөвлөгөө, мэдээллийн өдөрлөг" зохион байгууллаа. Тус өдөрлөгийн зорилго нь Эмэгтэйчүүдийн хорих ангид ажиллаж байгаа шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчид болон нийт ялтны эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, тэдэнд хууль зүйн мэдээлэл өгөх, шаардлагатай асуудлаар хууль зүйн зөвлөгөө, тусалцаа үзүүлэхэд оршиж байв.

Ялтны эрүүл мэндийг сахин хамгаалах. Ази, номхон далайн зарим оронд тухайлбал, Канад улсад ялтны эрүүл мэндийн асуудлыг тухайн орны эрүүл мэндийн байгууллагын харьяанд багтааж, эмч, эмнэлгийн байр, эмнэлгийн тоног төхөөрөмжөөр хангадаг байна.

Дотоод эх сурвалжийн талаар. Хорих байгууллагын дотоод эх сурвалжид ялтанд ял эдлүүлэх нөхцөл байдал, ажилтны ёс зүй, боловсрол, харуул хамгаалалт, зохиож буй хүмүүжлийн ажил гэх зэрэг хорих байгууллагын ажилтан, ялантай холбогдсон дотоодын бүх төрлийн асуудал багтана. Хорих байгууллагууд дотоод эх сурвалжийн хүрээнд дараахь зорилтуудыг дэвшүүлэн, тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлдэг байна. Үүнд:

Ялтны эрх зүйн байдлыг дээрдүүлэх. Гадаадын хоригдол болон олон улсын хооронд хоригдол солилцох. Зарим улс орнууд одоог хүртэл ялтан солилцох асуудлыг эрс эсэргүүцдэг. Тэд шүүхээс гэм буруу нь тогтоогдсон хэрэгтнүүд хэрэг үйлдсэн газраа ялаа эдлэх ёстой гэсэн хатуу

байр суурьтай байна. Гэтэл зарим улс орны төлөөлөгчид хүмүүнлэгийн асуудалд тохирохгүй, ял эдэлж байгаа гадаадын иргэдийг амьдралд хөлөө олоход нь туслах зорилгоор боломжтой гэвэл нутаг руу нь буцаах хэрэгтэй гэж үздэг.

Харин Ази, номхон далайн орнууд энэхүү ялтан солилцох асуудалд анхаарлаа хандуулан дэмжиж байсан ба үүнийг зайлшгүй дэмжих гурван нотолгоо байна. Үүнд: Хүмүүнлэгийн талаас нь ялтныг хэл, соёл, хоол хүнс, эрүүл мэндийн үйлчилгээний хувьд бодолцож, өөрийнх нь эх оронд ял эдлүүлэх, ялтныг нутаг руу нь буцааснаар амьдралд хөлөө олох, хүмүүжиж засрахад нь ихээхэн үр дүн гарна. Наад зах нь тэдэнд гэр бүлийнхэнтэйгээ уулзах боломж бүрдэнэ. Гадаадын ялтантай харьцахад хорих байгууллагын ажилтнуудад багагүй бэрхшээл тулгардаг. Жишээлбэл, Швейцарийн хорихуудад нэг хорих ангид итали, франц, герман, уугуул иргэд, африкийн гэх мэтийн маш олон орны хүмүүс ял эдэлдэг учраас наад зах нь ажилтнуудад хэлний хүндрэл гарна. Энэ хүндрэл гадаад оронд өөрийн иргэдийн эрх ашгийг хамгаалж байгаа консулын ажилтнуудад нэгэн адил хамаардаг.

Ялтныг шилжүүлэхэд дараахь зүйлийг үндэслэл болгодог. Ялтан өөрөө хүсэж өргөдөл гаргасан байх; ялынхаа талаас илүү хувийг эдэлсэн байх; хоёр улсын хооронд ялтан солилцох хоёр талын гэрээ, хэлэлцээр зайлшгүй байх ёстой. Эцсийн дүндээ ялтан гадаад оронд оногдуулсан ялыг өөрийнхөө орондоо үргэлжлүүлж эдлэх нь зүйтэй. Энэ талаар хууль тогтоомждоо зохицуулалт хийх шаардлагатай. Монгол Улсын хувьд ОХУ-тай ялтан солилцох гэрээ байгуулсан байдаг. Хятад улстай ялтан солилцох гэрээ байгуулаагүй учраас хятад иргэд монголд ял эдэлдэг.

Ялтны ял эдлэх нөхцөл байдлыг сайжруулах асуудал. Ялтнуудыг ангиллаар ял эдлүүлэх асуудал юм. Ази, номхон далайн орнуудад ялтныг тодорхой шалгуураар ангилан ял эдлүүлдэг бөгөөд ялтны хувьд зан авир, араншин, ял шийтгэлийн хугацаа, ял шийтгэл эдэлж буй давтамж, хэргийн зүйл, анги буюу төрөл, байдал, биеийн болоод оюун санааны байдал, өвчний шинж /бие, сэтгэлийн эрүүл мэндийн байдлаар нь, нас, боловсролыг нь шалгуур болгон ангилдаг байна.

Ийнхүү ялтнуудыг ангилахын тулд хорих байгууллагын дэргэд дадлага туршлагатай шинжээчдээс бүрдсэн хороо ажилладаг бөгөөд тус хороо нь ялтнуудыг ангилах үүрэгтэй. Тухайлбал, тус хороогоор ялтны зан авир, араншинг тодорхойлсны дараа ангилалт хийдэг.

Ялтнуудыг ангиллаар ял эдлүүлэх гол зорилго нь эрүүл ялтныг өвчтэй ялтнаас тусгаарлах, ялангуяа халдварт өвчтэй ялтнуудыг нийтээс тусгаарлах, ялтнуудыг сэтгэл санааны дарамтанд орохоос хамгаалах, нэг төрлийн гэмт хэрэг үйлдсэн ялтныг өөр төрлийн гэмт хэрэг сурахаас урьдчилан сэргийлэх, анх удаагийн гэмт хэрэгтэй ялтнуудыг тусгай боловсруулсан менежментийн дагуу хамгаалалтад авч тэдэнтэй ажиллах хөтөлбөр боловсруулан ажиллах, ялтнуудын бие бялдар болон хоол идэх дур хүслийг нэмэгдүүлэх, боловсрол олгох, сургах ба хувийн эрүүл мэндийн байдалд нь тохирсон эмчилгээ хийх, эрүүл мэндийн чиглэлээр ангилал хийж байгаатай холбогдуулаад хорих байгууллага болгонд сэтгэл зүйн эмч, сэтгэл судлаач нарыг ажиллуулах, хоригдлын дунд сургалт хүмүүжлийн

ажлыг зохиох хөтөлбөр хэрэгжүүлэх, ялтны судалгааг нарийн гаргах боломж бүрдүүлэх. Тухайлбал, ялтны зан байдал хэрхэн өөрчлөгдөж байгааг судлагаагаар харуулдаг. Жишээ нь, анх ирснээс хойш сар сараар зан байдлын судлагааг гаргаж, дараа жил нь яаж өөрчлөгдсөн байгааг дүгнэж чаддаг байна.

Ангиллын ач холбогдол нь ялтныг нийгмийн амьдралд дасгах анхны алхам болж өгдөг. Ялтнуудыг ангилах үйл ажиллагааны гол хэсэг нь шүүхээс ирсэн баримт бичиг, тухайн хоригдлын амьдралын түүх, тэмдэглэл, мэдээллийн нарийвчилсан цуглуулгыг багтаасан байдаг.

Ялтны ял эдлэх хугацааг үр ашигтай байлгах. Австралийн засан хүмүүжүүлэх байгууллага нь ялтны ял эдэлж байгаа өдрийн үргэлжлэх хугацааг хэд, хэд хувааж үздэг. Үүнд:

- өглөө 8.30 цагаас үдийн хоол хүртэл сургалт хүмүүжлийн болон ажлын цаг;
- үдийн хоолноос оройны хоол хүртэл ажлын цаг;
- оройн хоолноос унтах хүртэл спортын болоод төрөл бүрийн тоглоом тоглох, мэдээ сонсох цаг байдаг байна. Олон жилээр ял эдлэх ялтныг сэтгэл санааны бэлтгэлтэй байлгахуйц мэдээллээр хангах, ял эдэлж байгаа үед нь үзэл бодлыг нь удирдан чиглүүлж өгөх хөтөлбөрийг хэрэгжүүлдэг.

Суллагдсан ялтныг нийгэмд буцаах. Суллагдсан ялтныг амьдралын хувьд "хөлд" оруулах тусгай хөтөлбөр хэрэгжүүлдэг. Энэ хөтөлбөрт "ялтны хувийн амьдралыг хэрхэн төвхнүүлэх, албан байгууллага, аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулдаг, тэр гэрээнд хоригдож байгаа хүний ажил мэргэжлийг заах, албан байгууллага, компанийн ажилтнуудын ялтнуудыг судлах, суллагдсан хүмүүсийн бичиг баримтын бүрдэлтийг хангах асуудал багтдаг.

Хорих байгууллагын ажилтнуудыг чадвартай байлгах. Эрт дээр үеэс хорих байгууллагад ажилтнуудыг сонгож авдаг уламжлал байжээ. Энэ нь биеийн тамирын мэргэжилтэй, том биетэй, хүч чадалтай, уншиж бичиж, тоолох чадвартай эрчүүд ажиллах нь тохиромжтой гэж үздэг. Өнөө үед дэлхий дахинд боловсрол, оюуны чадамжийг биеийн хүчнээс илүүд авч үзэх хандлагтай болсноор эмэгтэйчүүд эрэгтэйчүүдтэй нэгэн адил хорих байгууллагад ажиллах болсон юм. Жишээ нь, Хонг-конгод дадлагын офицеруудыг хорих байгууллагын ажилтнаар сонгож авдаг ба тэр талаар хууль тогтоомждоо зохицуулж өгсөн.

Хорих байгууллагын офицерууд болон харуул хамгаалалтын ажилтнууд хариуцлагатай байх гол үндэс нь тэднийг ажилд орохын өмнө боловсрол, мэргэжил болон ажилд тэнцэх эсэхийг нь турших шалгуур зохиож, уг шалгуураар шалгаж сонгодог байна. Хорих байгууллагын ажилтнуудыг шалгаруулан сонгосны дараа ажил, мэргэжлийг сайжруулах сургалт, дадлагад хамруулсны дараа ажиллуулдаг байна. Зарим орны хорих байгууллагад багш, сэтгэл зүйч, өмгөөлөгч, худалдааны зааварлагчийг авч ажиллуулах сонирхолтой байдаг. Энэ нь хорих байгууллагад шинэ санаануудыг авчирдаг давуу талтай гэнэ.

Австрали, Шинэ Зеланд, Канад, Сингапур зэрэг орнуудад мөн ийм мэргэжлийн хүмүүсийг авч ажиллуулдаг. Эдгээр орнуудын хорих

байгууллагад ажиллаж байгаа ажилтан нь өөрсдийн үндсэн мэргэжлээс гадна гуравдагч мэргэжлийг заавал эзэмшсэн байх ёстой. Яагаад гэвэл, ялтнууд байнга өөрчлөгдөж байдаг учраас ажилтнуудын мэдлэг нь байнга өөрчлөгдөж байх шаардлагатай байдаг.

Ажилтнуудыг сургах тухай. Ажилтнууд өөрийнхөө боловсролыг дээшлүүлэх талаар илүү их хичээдэг. Мөн тэднийг албан тушаал дэвшихийн өмнө сургалтад хамруулдаг. Сургалт нь:

- танхимын сургалт;
- мэргэжлийн сургалт;
- албан ёсны ба албан бус сургалт;
- зайны сургалт;
- анхан шатны сургалт гэх мэт.

Ажилтнуудыг хорих байгууллагын удирдах ажилд дэвшүүлэх, томилохийн тулд менежментийн сургалтад хамааруулдаг. Албан тушаал дэвшсэн тохиолдолд хорих байгууллагын дэргэдэх коллеж, академийн байнгын сургалтад хамруулдаг бөгөөд академийн багш нар нь хорих байгууллагын ажилтанд байнга зөвлөгөө удирдамж өгнө. Шалгууруудыг давж гарсан ажилтнууд нь ахлах офицер болж, цаашид удирдах ажилд хүчээ сорьдог байна.

Хорих байгууллагын ажилтнуудын цалин, хангамж, баталгааг сайжруулахад хорих байгууллагын офицеруудын цалингийн хэмжээтэй холбогдсон асуудлыг нарийвчлан авч үздэг. Хорих байгууллагын байнгын офицер болгохоос өмнө туршилтын хугацааг дамжина. Эдгээр сургалт болон шалгууруудаар шалгагдсан байнгын офицер гэдэг цол авсан ажилтнууд өөрийн мэргэжилдээ сэтгэл хангалуун байдаг бөгөөд цаашдаа хэр удаан ажиллах баталгааг тэдэнд гаргаж өгдөг.

Ажилтнуудын эрүүл мэндийг хамгаалахад ажилтнуудын сэтгэл зүйн болон эрүүл мэндийг анхаарч үздэг бөгөөд Засан сайжруулах байгууллагуудын дэргэд эрүүл мэндийн институт ажилладаг байна.

Хоёр. ОХУ-ын хорих байгууллагын туршлага

ОХУ-ын Липецк мужийн колониудад өндөр сэтгэгдэл төрүүлэхүйц үйл ажиллагаа явуулдаг. Елец хотын жирийн, чанга дэглэмтэй колони, мөн түүнчлэн гяндангийн байдалтай танилцахад Петр хааны үеэс шорон байсан барилгад гяндан нь байна. Эндхийн мянга шахам ялтны 200 гаруй нь гяндангийнх, бусад нь урьдчилан хоригдож байгаа хүмүүс. Үйлчилгээ аж ахуйд нь ажиллаж байгаа хөнгөн ялтай ялтнуудын 10-аад нь эмэгтэй байв. Тэнд тус тусдаа байртай, үзвэрийн, сургалтын, эмнэлгийн гэх мэт.

Елицийн гяндангийн нэг өрөөнд 6-7 ялтан байх бөгөөд тэд цай буцалгаж уух, тамхи татах чөлөөтэй. Бие засах, гар нүүр угаах газартай. Ахуйн хэрэглээний зүйлийн тавиур, бичгийн ширээ, сандал, номын тавиур, радио, телевизор гээд амьдралын нэн шаардлагатай зүйлсээр хангагджээ. Гяндангийнхан дотроо зураг зурах, тор сүлжих, жижиг цахилгаан хэрэгсэл засах зэрэг ажил хийнэ. Гурван сард нэг удаа 20 кг хүртэл хүнсний болон нэн тэргүүний хэрэгцээт зүйл илгээмжээр авахаас өөр эргэлт уулзалт бараг үгүй. Энд мөн л гурван нөхцөлд ял эдлүүлэх бөгөөд хамгийн сайн нөхцөл

нь жижиг цонхтой, дан ортой, 7 хоног бүр халуун усанд ордог гэх зэрэг давуу талтай байна.

Гяндангийн ялтныг усанд орох, өмгөөлөгчтэй уулзуулах зэрэг авч явах ямар нэгэн шаардлага гарвал нохой, буу бүхий харуул тал бүрт нь явна. Урьдчилан хоригдож буй сэжигтнүүдийг жирийн байранд нэлээд тохилог нөхцөлд байлгах юм. Тэднийг гэм буруутай гэдэг нь тогтоогдоогүй учраас телевиз, цай буцалгагч, бичгийн ширээ зэрэг тавилгатай өрөөнд хорино.

ОХУ-ын Хууль зүйн яамны Хорих ял эдлүүлэх ерөнхий газрын орлогч дарга, хошууч генерал В.К.Краев: "Ерөнхийлөгч В.Путин хорих байгууллагын ажилд багагүй анхаарал тавьдаг. Бидний хамгийн гол зорилт бол хорих ял эдлүүлэх байгууллагад байнга өсөн нэмэгдэж байгаа ялтны тоог цөөрүүлэх явдал юм. Ер нь олон ялтан ОХУ-ын Засгийн газрын зардалд ихээхэн хүндрэл учруулж байна" гэж онцлон тэмдэглэсэн билээ.

Хууль зүйн яамаар дамжуулан хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санал тавьсны дүнд Ерөнхийлөгч болон Дум хорих ял эдлэгсдийг цөөрүүлэх бодлого баримталсан байна. Хорих ял эдлүүлэх хугацааг ч хянаж үзжээ. Өнгөрсөн оны арваннэгдүгээр сарын 30-нд ОХУ-д "Өршөөл үзүүлэх тухай" хууль гарснаар хорих ял эдэлж байсан 25 мянган насанд хүрээгүй хүүхэд, эмэгтэйчүүдийг суллажээ.

Хуульд нэмэлт, өөрчлөлт орсны дүнд 100 мянган ялтан, 30 мянган сэжигтэн ялаас чөлөөлөгдсөн байна. Гэмт хэрэгтний тоо, гэмт хэрэгтний нийгэмд учруулсан хор аюулыг багасгахын тулд янз бүрийн арга тухайлбал, цахилгаан гав хэрэглэдэг болсон.

Тэд Европын Холбооны улсууд, Англи, Франц, Норвеги улсын хорих ял эдлүүлэх байгууллагатай холбоо тогтоож, шоронд хоригдогчдын эрхийн талаар нэлээд анхаарч байна гэж мэдээлсэн юм¹.

-ooOoo-

¹ ОХУ-ын Хорих ял эдлүүлэх ерөнхий газрын дарга, хуандаа генерал В.У.Ялунины урилгаар ШШБЕГ-ын дарга, хуандаа Ж.Чойжандангийн хийсэн айлчлалын тайлан. 2002 он.

АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛСАД ПРОКУРОР ЯМАР ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭДЭГ ВЭ?

*Нийслэлийн прокурорын туслах,
хэлтсийн дарга Ж.Эрдэнэбаатар*

АНУ-ын прокурорын байгууллага нь хуулийн биелэлтийг хангуулах, гүйцэтгэх засаглал болох. Засгийн газрын шат шатны байгууллагын ашиг сонирхлыг шүүх дээр төлөөлөхөөс гадна эрүүгийн хэргийн яллах чухал үүргийг хэрэгжүүлдэг. Төрийн нэрийн өмнөөс прокурорууд эрүүгийн хэргийг үүсгэж, мөрдөн байцааж, хуулийн хариуцлага хүлээлгэж, шүүх дээр яллаж байна. Төрийн нэрийн өмнөөс яллах албыг АНУ-ын Ерөнхий прокурор /US Attorney General буюу манайд ихэвчлэн "Хууль зүйн сайд" гэж нэрлэдэг/ толгойлдог. АНУ-ын Хууль зүйн яамыг /US Department of Justice/ АНУ-ын Ерөнхий прокурор толгойлдог боловч шүүх байгууллагаас ангид бөгөөд бусад орнуудад байдаг шүүх яамтай адил төсгүй ажээ.

Хууль зүйн яамыг толгойлж байгаа АНУ-ын Ерөнхий прокурорын ажлын аппарат нь бусад орнуудад байдаг Прокурорын байгууллага, Дотоод хэргийн яам, Сөрөг тагнуулын болон Эрүүгийн хэргийг мөрдөн шалгах, Шоронгуудыг удирдах газар гэсэн бие даасан байгууллагуудын эрх, үүргийг бүхэлд нь нэгтгэн хэрэгжүүлдгээр онцлог ялгаатай юм. АНУ-ын прокурорын байгууллагын үйл ажиллагааны хүрээ нь манай болон бусад орнуудын прокурорын байгууллагын үйл ажиллагаанаас хавьгүй өргөн цар хүрээтэй байдгаар ялгаатай байна.

АНУ-ын Холбооны улсуудын нэгдсэн тогтолцооны онцлогоос шалтгаалж прокурорын байгууллага нь нэгдсэн улсын, муж улсын, орон нутгийн гэж бие даасан тогтолцоотой байна. Прокурорын байгууллага нь тус тусын зохион байгуулалт, бүтэц, эрх үүргийн өөрийн гэсэн онцлогтой бөгөөд нутаг дэвсгэр, шийдвэрлэх асуудлын хүрээ хэмжээгээр ялгавартай байдгаар тодорхойлогдоно. Муж улс нь өөрийн Үндсэн хууль, бусад хуулийг үндэслэн прокурорын байгууллагыг бий болгох, эрх зүйн хэм хэмжээг тодорхойлж болно. Нэгдсэн улсын прокурорын байгууллага нь АНУ-ын Конгрессоос батлагдсан хуулийн дагуу үйл ажиллагаагаа явуулна.

АНУ-ын Ерөнхий прокурор түүнд захирагддаг прокурорын байгууллага муж улс дахь прокуроруудыг удирдах эрх хэмжээгүй байдаг. Холбооны улсын хэмжээний прокурорын байгууллага нь АНУ-ын Ерөнхий прокурор, АНУ-ын прокуроруудаас /US Attorneys/ бүрдсэн хатуу төвлөрсөн газар юм. АНУ-ын Ерөнхий прокурор нь АНУ-ын прокуроруудад хяналт тавьж, тэдгээрийг удирдана. АНУ-ын Үндсэн хуулийн хоёрдугаар зүйлд зааснаар "Хуулийг сахин биеүүлэхийг хангах" үүрэг хүлээсэн АНУ-ын Ерөнхийлөгч нь Ерөнхий прокурорыг улс төрийн удирдлагаар хангадаг байна. Ерөнхийлөгч Сенаттай зөвшилцөн зөвлөсний дагуу Ерөнхий прокурорыг томилно.

АНУ-ын Ерөнхий прокурорын албан тушаалыг 1789 оны Шүүхийн байгуулалтын тухай хуулиар бий болгожээ. Эхний үед өөрийнхөө үүргийг дангаар шахуу ямар нэг яам, тусгай газаргүй гүйцэтгэж байв. Ерөнхий прокурорын захиргаан дор Хууль зүйн яамыг 1870 онд бий болгожээ.

АНУ-ын Ерөнхий прокурорын үндсэн үүрэгт АНУ-ын Засгийн газрын ашиг сонирхлыг шүүхийн өмнө төлөөлөх, хууль зүйн асуудлаар Засгийн газарт зөвлөх, АНУ-ын прокурорууд, Хууль зүйн яамны албадуудаар

дамжуулан хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах асуудлууд ордог байна.

Ерөнхий прокуророос Засгийн газарт хууль зүйн зөвлөгөө өгөх үүрэг Ерөнхийлөгчийн болон төрийн яам, тусгай газруудын удирдлагын албан ёсны хүсэлтээр хийгддэг. Зөвлөгөө нь АНУ-ын Ерөнхий прокурорын санал гэсэн хэлбэрээр албан ёсны бичиг баримт болно. Энэ санал нь тодорхой үйл явдлуудад эрх зүйн хэм хэмжээг хэрэглэх талаар албан ёсны тайлбар хэлбэрээр бичигдэн гардаг байна.

АНУ-ын Дээд шүүхийн шүүгчид, Холбооны улсын шүүгчдийн албан тушаалд нэр дэвшигчдийн талаар Ерөнхийлөгчид зөвлөмж өгөх асуудал Ерөнхий прокурорын чухал үүргийн нэг болно. АНУ-ын ашиг сонирхлыг шүүхэд төлөөлөхдөө Ерөнхий прокурор Хууль зүйн яамны өндөр албан тушаалтны нэг болох АНУ-ын Ерөнхий солистрыг /US Solicitor General/ томилон илгээнэ. АНУ-ын ашиг сонирхлыг хөндсөн бүх төрлийн хэрэг, маргааныг Дээд шүүхэд Ерөнхий солистор төлөөлнө. Нэгдсэн улсын хуулийн биелэлтийг хангуулах Ерөнхий прокурорын үүргийг түүний нэгдүгээр орлогчийн /Deputy Attorney General/ удирдлагад байдаг Хууль зүйн яамны нэгжүүдэд /Газар, товчоо, алба, зөвлөл/ ногдоно. Ерөнхий прокурорын орлогч /Associate Attorney General/ иргэний эрх зүйн хэм хэмжээг хэрэгжүүлэх салбар нэгжүүдийг хариуцаж байна.

Хууль зүйн яамны удирдлага, зохион байгуулалт нь /divisions/ прокурортой адилхан хууль хэрэгжүүлэх байгууллагуудад хяналт тавьж, эрүүгийн хэрэг үүсгэх, мөрдөн байцаалтын байцаан шийтгэх ажиллагааг удирдах, эрүүгийн хэргийг шүүхээр хэлэлцүүлэхэд улсын яллагчийн үүргийг гүйцэтгэх, иргэний маргаанаар Засгийн газрыг төлөөлөх зэрэг үүргүүдийг хүлээдэг.

Хууль зүйн яам нь дараахь салбар нэгжүүдтэй:

-Эрүүгийн хэргийн талаар /Criminal division/;

-Иргэний хэргийн талаар /Civil division/;

-Монополийн эсрэг хууль тогтоомж зөрчсөн хэрэг маргаанаар /Antitrust division/;

-Татварын хууль тогтоомж зөрчсөн хэрэг маргаанаар /Tax division/;

-Байгалийн баялаг, байгаль орчныг хамгаалах асуудал эрхэлсэн /Environment and Natural Resources Division/;

-Иргэний эрхийг зөрчсөн тухай асуудал эрхэлсэн /Civil Rights Division/.

Эрүүгийн хэргийн асуудал эрхэлсэн газарт улс, хооронд эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх, өөрийн оронд гэмт хэрэг үйлдээд АНУ-д нуугдаж байгаа гэмт этгээдийг хүчээр харьяалан шилжүүлэн өгөх асуудал хариуцсан олон улстай харьцах хэлтэс бий. Мөн товчооны /Bureaus/ эрх хэмжээтэй нэгжүүдийг мөрдөн байцаалт явуулах эрхтэй, удирдан зохиох байгуулах эрхтэй гэж хувааж болно. Хар тамхитай тэмцэх газар /Drug Enforcement Administration/ хар тамхи, мансууруулах бодис хууль бусаар бэлтгэх, хадгалах, борлуулах, хэрэглэхтэй холбогдсон хэргийг мөрдөх, шуурхай эрэн сурвалжилах ажлыг хийдэг. АНУ-д хар тамхины худалдаа нь бараг бүхэлдээ зохион байгуулалттай гэмт хэргийн бүлэглэлүүд хяналтад байж гэмт арилжааны хамгийн их орлогын нэг болдог учир хар тамхитай тэмцэх газрын ажилтнууд Холбооны мөрдөх товчооны удирдлага дор бусад яамдын мөрдөн байцаах албадуудтай нягт хамтран ажилладаг.

Цагаачлалын алба /Immigration and Naturalization Service/ захиргааны байгууллагын хувьд АНУ-д цагаачдыг оруулах асуудлыг хянан шийдвэрлэдэг. Тус оронд ирж байгаа гадаадын иргэдийг бүртгэх, бичиг баримтыг шалгах, америкийн иргэн болохоор өргөдөл гаргасан иргэдийг шалгах үүрэгтэй. Мөн цагаачлалын хууль тогтоомж зөрчсөн асуудлыг мөрдөн байцаах, цагаачлалын хууль зөрчиж байгаа гадаадын иргэдийг эрэн сурвалжлах, албадан гаргадаг.

Холбооны мөрдөх товчоо /Federal Bureau of Investigation/ Хууль зүйн яамны мөрдөн байцаах, эрэн сурвалжлах ажлын үндсэн үүргийг хэрэгжүүлдэг. Мөрдөх товчооны удирдлагад захирал, олон тооны туслахууд ажиллаж салбар, нэгжүүдийг бүрдүүлэн удирддаг боловч хатуу төвлөрсөн удирдлагатай байгууллага болно. Мөрдөх товчоо нь АНУ-ын томоохон хотуудад 56 хэлтэс /тэдгээр нь өөрийн салбаруудтай/ гадаадын орнуудад 26 салбартай байна. Мөрдөх товчоо нь Холбооны улсын хуулийг зөрчсөн ихэнх хэрэгт мөрдөн байцаалт явуулдаг. Мөрдөн байцаах товчоо үндэсний аюулгүй байдлыг хамгаалах хууль зөрчсөн асуудлаар мөрдөн байцаах, гүйцэтгэх ажлыг явуулахдаа сөрөг тагнуулын байгууллагын үүргийг гүйцэтгэдэг.

Ерөнхийлөгчийн 1981 оны гүйцэтгэх тушаалаар Батлан хамгаалах яам, Тагнуулын төв газар, Засгийн газрын бусад байгууллагуудын сөрөг тагнуулын ажиллагааны зохицуулалтыг Мөрдөх товчоонд ногдуулсан байна. Ерөнхий прокурорын баталсан заавраар Мөрдөх товчоонд АНУ-ын дотоодын аюулгүй байдалд заналхийлсэн, алан хядах ажиллагаанд сэжиглэгдсэн иргэдийн үйл ажиллагааг тагнан мөрдөх эрх олгогдсон байна. Шоронгуудын товчоо /Bureau of Prisons/ нь Холбооны улсын хуулиар ял шийтгэгдсэн этгээдүүдийн ялыг эдлүүлэх засан хүмүүжүүлэх байгууллагуудыг захиргааны удирдлагаар хангадаг.

АНУ-ын Маршаллуудын алба /US Marshals Service/ Хууль зүйн яаманд товчооны зэрэглэлд орж, холбооны шүүхийн тойргуудад АНУ-ын маршаллуудын үйл ажиллагааг зохицуулж байдаг. АНУ-д маршаллууд, түүний туслахууд гүйцэтгэх засаглалын албан тушаалын ажилтнууд боловч шүүхэд шууд захирагддаг бөгөөд хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэрийн биелэлтийг хангуулах, холбооны шүүхээс гаргасан захирамж, шийдвэр, тушаалыг биелүүлэх гол үүрэгтэй. Холбооны улсын хэмжээнд АНУ-ын маршаллууд шүүхийн зөвшөөрлөөр баривчлах, нэгжлэг хийх, хураан авах, байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчдыг хамгаалах, баривчлагдсан, шийтгэгдсэн этгээдүүдийг цагдан хорих, хуяаглан хүргэдэг байна.

Интерполийн үндэсний төвийн товчоо /US National of General Bureau Interpol/ гэмт этгээдийг шуурхай эрэн сурвалжлах зорилгоор муж улсын болон орон нутгийн хууль хэрэгжүүлэгч 20 мянган байгууллагуудыг олон улсын цагдаагийн байгууллага интерполын гишүүн 136 оролцогч орнуудтай холбож байдаг. Товчооны бүрэлдэхүүнд Мөрдөх товчоо, Маршаллуудын алба, Хар тамхины тухай хуулиудын хэрэгжилтийг хангах захиргаа, Эрүүгийн хэрэгтэй тэмцэх газрын төлөөлөгчдөөс гадна, Сангийн яам, гаалийн алба, дотоод орлогын алба, галт зэвсэг, тамхи, спиртийн ундаанд хяналт тавих товчоо, албад, валютын албаны төлөөлөгчид ордог.

Шүүхийн ажиллагааг боловсронгуй болгох хөтөлбөрийн алба /Office of Justice Programs/ эрүүгийн гэмт хэрэгтэй тэмцдэг байгууллагуудын

болон шүүхийн үйл ажиллагааг боловсронгуй болгох, гэмт хэрэгтэй тэмцэхэд холбооны улс, муж улсуудын засаг захиргааны байгууллагуудын хамтын ажиллагааг зохицуулах, боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг хариуцан гүйцэтгэдэг.

Энэ албаны ивээл дор үндэсний шүүхийн хүрээлэн /гэмт хэргийн шалтгааныг судлаж, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулдаг судалгааны төв/, эрүүгийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэгч байгууллагуудад дэмжлэг үзүүлэх товчоо, муж улсуудад байгаа эрүүгийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэгч байгууллагуудад санхүүгийн дэмжлэг үзүүлдэг, шүүхийн статистикийн товчоо, мөн насанд хүрээгүй иргэдийн хэргийг шүүхээр шийдвэрлүүлэх тэдгээрийг гэмт хэргийг урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан алба багтдаг. Хууль зүйн яаманд зөвлөл /Boards/ эрхтэй дараахь салбар нэгжүүд байна:

Цагаачлалын хэргийг шийдвэрлэх алба /Executive Office for Immigration Review/ нь цагаачлал хариуцсан шүүгчдийн алба, тэргүүн шүүгчийн алба, цагаачлалын хэргийг давж заалдах шатаар хянах зөвлөлөөс бүрдэнэ. Эхнийх нь гадаадын иргэдийг албадан гаргах тухай хэргийг хэлэлцэнэ, хоёр дахь нь эдгээр шүүгчдийг ерөнхий удирдлагаар хангана, гурав дахь нь цагаачлалын албаны ажилтнууд, цагаачлалын хэргийг шийдвэрлэж байгаа шүүгчдийн шийдвэрийг давж заалдах шатаар хэлэлцэн шийдвэрлэдэг. Энэ зөвлөлийн шийдвэрт холбооны улсын шүүхэд ердийн журмаар гомдол гаргаж болно.

Хугацаанаас өмнө ял шийтгэлээс судлах АНУ-ын комисс /US Parole Commission/ холбооны улсын хууль зөрчсөн хэрэгт ял өдэлж байгаа этгээдийг хугацаанаас нь өмнө суллах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэдэг. Гадаад улс орнуудад гаргасан гомдол маргааныг зохицуулах АНУ-ын комисс /Foreign Claims Settlement Commission/ гадаад улс орны засгийн газраас хохирлыг арилгуулсхаар АНУ-ын иргэдийн гаргасан нэхэмжлэлд дэмжлэг үзүүлдэг.

Дээр дурдсанаас гадна Хууль зүйн яаманд дараахь салбар нэгжүүд бий:

- Хууль зүйн зөвлөгөө өгөх алба /Office of Legal Counsel/ АНУ-ын Ерөнхий прокурорын санал боловсруулдаг;
- Хууль тогтоомжийн асуудал хариуцсан алба /Office of legislative Affairs/ хуулийн төсөл боловсруулдаг;
- Хууль зүйн яамны бодлогыг боловсруулдаг алба /Office of Policy Development/;
- Өршөөлийн асуудал хариуцсан хуульч /Office of the Pardon Attorney/ шийтгэлийг багасгах, өршөөл үзүүлэх асуудлаар Ерөнхийлөгчид зөвлөмж боловсруулдаг;
- Овог хоорондын харилцааны асуудал хариуцсан алба /Community Relations Service/ үндэстэн, ястнууд, арьс өнгөний мөргөлдөөнийг эв зүйгээр зохицуулах хэлбэрийг боловсруулдаг;
- Хэрэг эрхлэх газар /Justice Management Division/ яамны салбар нэгжүүдийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах зөвлөмжийг боловсруулдаг;
- Мэргэжлийн хариуцлагын алба /Office of Professional Responsibility/ яамны ажилтнуудаас албан тушаалаа урвуулсан асуудлыг мөрдөн шалгадаг;

- Тагнуулын асуудал хариуцсан алба /Office Intelligence Policy and Review/ тагнуулын байгууллагуудын үйл ажиллагаанд эрх зүйн хяналт тавьж, үндэсний аюулгүй байдлын эрх ашгийн үүднээс чагнах тухай хүсэлтийг тусгай шүүхэд гаргадаг;
- Ерөнхий байцаагчийн алба /Office of the Inspector General/ хөрөнгийн зарцуулалтыг хянах зорилгоор санхүү, аудитын шалгалт хийдэг;
- Олон нийт, олон нийтийн мэдээллийн хэрэгсэлтэй харьцах алба /Office of Public Affairs/;
- Хувийн амьдралын халдашгүй байдал, мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн биелэлтийг хангуулах алба /Office of Information and Privacy/.

АНУ-ын прокурорууд нь АНУ-ын Ерөнхий прокурорын орон нутаг дахь төлөөлөгчид бөгөөд Холбооны улсын шүүхийн 94 тойрогт холбооны прокурорын газрыг толгойлдог. Ерөнхийлөгч, Сенатын зөвшөөрлөөр эдгээр прокуроруудыг томилдог. АНУ-ын прокурор нь нутаг дэвсгэрийн харьяаллын хүрээнд холбооны улсын хууль тогтоомжийн зөрчлийг эрүүгийн журмаар мөрдөн байцаах, иргэний хэрэг маргааныг шүүхээр хэлэлцэхэд аль нэг тал нь АНУ байвал Холбооны Засгийн газрыг төлөөлнө.

АНУ-ын Хууль зүйн яам нь хар тамхийг хууль бусаар худалдаалах, тараах, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх тусгай зорилтыг биелүүлэх зайлшгүй тохиолдолд мөрдөн байцаах, цагдаагийн байгууллагуудыг дайчлан цохилтын хүчийг /Strike Forces/ зохион байгуулж болдог байна. Үүнд Мөрдөх товчооны ажилтнууд, туршлагатай прокурорууд, мөрдөн байцаагчид, татвар, гаалийн байгууллагын ажилтнууд, нууц албад болон янз бүрийн төрлийн гэмт хэргийг мөрдөх дэдлага туршлагатай холбооны, муж улсын, орон нутгийн байгууллагуудын ажилтнуудыг нэгтгэдэг.

Муж улсууд дахь яллах алба холбооны улсын системээс ялгаатай нь төвлөрөлгүй. Ерөнхий прокурор орон нутаг дахь прокуроруудын үйл ажиллагааг хянаж удирддаггүй. Муж улсуудын түвшинд Америкийн прокурорын байгууллагын зохион байгуулалтын онцлог нь төвлөрөлгүй, доод шатны прокурор нь дээд шатны ерөнхий прокурорт захирагддаггүй, прокурорууд сонгогддогоор илэрдэг. Муж улсын ерөнхий прокурор /Attorney General/ нь сонгуулийн албан тушаалтан бөгөөд түүний эрх хэмжээ нь муж улсын хуулиар тогтоогддог тул янз бүр байна.

Ерөнхий прокурор эрх зүйн асуудлаар улсын хууль тогтоох хурлын гишүүд, албан тушаалтан, амбан захирагч нартай зөвлөлдөж, муж улсын хуулийг зөрчсөн асуудалд эрүүгийн хэрэг үүсгэж, шүүхэд муж улсыг төлөөлж, хууль хэрэглэх үйл ажиллагааны хүрээнд муж улсын гол этгээд болдог. Гэвч энэ байдал нь цөөхөн муж улсуудад байдаг. Тэгээд ч тэр цагдаад хяналт тавьдаггүй, орон нутгийн прокуроруудын үйл ажиллагааг зохицуулах байгууллагын үүргийг гүйцэтгэдэг.

Ихэнх муж улсуудын хууль тогтоомжоор иргэний эрх зүйн асуудлаар ерөнхий прокурорын эрх хэмжээг хязгаарлан гагцхүү амбан захирагчийн хуулийн зөвлөх, иргэний маргааныг шүүхээр хэлэлцэхэд муж улсын засаг захиргааг төлөөлөн оролцдог, эрүүгийн хууль тогтоомжийн хүрээнд хязгаарласан, нэлээн дуулиант хэргүүдийг шийдвэрлэхэд яллах үүргийг голчлон гүйцэтгүүлэхээр тогтоосон байдаг. Хууль хэрэгжүүлэгч гол албан

тушаалтны хувьд ерөнхий прокурор зарим муж улсуудад жинхэнэ үүргээ биелүүлж байна. Жишээлбэл, Калифорни муж улсад Үндсэн хуульд зааснаар ерөнхий прокурор орон нутаг дахь цагдаагийн байгууллагыг хянаж, үйл ажиллагааг зохицуулах, чиглүүлэх үүрэгтэй.

Калифорни муж улсын ерөнхий прокурор өөрийн эрх, үүргээ муж улсын засаг захиргааны дэргэдэх хууль зүйн газраар дамжуулан гүйцэтгэхдээ доод шатны бүх цагдаагийн газруудын хүчийг нэгтгэн зохион байгуулдгаараа муж улсын цагдаагийн дарга ч болдог. Аляск, Делавэр, Рэд-Айленд муж улсуудын ерөнхий прокурорт эрүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх, орон нутгийн прокуроруудыг хянах үүрэг, хариуцлага ногддог байна.

Муж улсуудад орон нутгийн прокуроруудыг дүүргийн (District Attorney) прокурор нэрлэдэг. Ихэнх муж улсуудад намуудаас нэр дэвшигчид дотроос иргэд прокуторыг шууд сонгодог.

Дүүргийн прокуторын эрх хэмжээ муж улсын хууль тогтоомж, орон нутгийн засаг захиргааны эрх зүйн актаар тогтоогддог. Дүүргийн прокуторын үүрэг зорилго холбооны болон муж улсын прокуторынхонтой бараг адилхан байна.

Тэр орон нутгийн засаг захиргааны байгууллагад эрх зүйн асуудлаар зөвлөмж, шүүхэд орон нутгийн засаг захиргааг төлөөлж мөрдөн байцаалтыг удирдан гүйцэтгүүлж байна. Аль ч шатны улсын яллагч-прокурор нь эрүүгийн хууль зүйн механизмын нэг хэсэг тул эрүүгийн байцаан шийтгэх бүх шатанд гол үүрэгтэй байна.

-ooOoo-

АНГЛИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ЭМХТГЭЛ БА ЭРХ ЗҮЙН ЭХ СУРВАЛЖИД ТООЦОГДОХ БҮТЭЭЛИЙН АЧ ХОЛБОГДОЛ

ХЗҮТ-ийн Олон улсын эрх зүйн секторын
эрдэм шинжилгээний ажилтан Б.Гүнбилэг

Англи-саксоны буюу нийтийн эрх зүйн бүлийн бусад бүлээс ялгагдах гол онцлог нь түүний эх сурвалж болох жишиг эрх зүй юм. Орчин үеийн эрх зүйн түүхэнд англо-саксоны эрх зүйн энэхүү эх сурвалжийг дангаар нь хэрэглэж буй туршлага бараг үгүй гэж хэлж болно. Энэхүү бүлийн хамгийн том төлөөлөл болох Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улс л гэхэд жишгээс гадна статут, зан заншил, номлол, хуулийн ном, зохиолуудыг эрх зүйн эх сурвалждаа тооцох болжээ.

Жишиг эрх зүйг эрх зүйн эх сурвалжид тооцдоггүй улс орны хуульчдын хувьд жишгийг бүрдүүлж буй тэрхүү шүүхийн шийдвэрүүдийг хэрхэн, яаж, хэн эмхтгэдэг нь бүрхэг байдаг. Иймээс шүүхийн шийдвэр эмхтгэх үйл ажиллагаа хэрхэн явагддаг ямар нэртэй эх сурвалжууд байдаг талаар болон ямар ном зохиолууд эх сурвалжид тооцогдож болох талаар товч өгүүлье.

Шүүхийн шийдвэр эмхтгэх ажиллагаа. Жишгийг амьдралд хэрэгжүүлэхийн тулд хуульчдад шүүхээр шийдвэрлэж байсан хэргүүдийн эмхтгэлийг эх сурвалж болгох шаардлагатай болдог. Мөн олон зуун жилийн түүхтэй шүүхийн практикаас хуульч өөрт хэрэгтэй жишгийг олж харахад туслах зорилготойгоор шүүхийн шийдвэрүүдийг эмхтгэн гаргадаг байгууллагууд байдаг байна. Шүүхийн шийдвэрийн дараахь эмхтгэлүүдийг Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын эрх зүйд эх сурвалжид тооцож байна¹.

Жилийн бүртгэл /Year Book/. Эртний шүүхийн шийдвэрүүдийн эмхтгэл буюу жилийн бүртгэл гэж нэрлэгдсэн хэргийн данс нь 1275-1535 оны хооронд Английн шүүхийн шийдвэрлэсэн хэргүүдийг бүртгэсэн байдаг. Энэ эмхтгэл нь эртний англи хэлээр бичигдсэн учраас хуулийн салбарт суралцаж буй оюутнуудад ойлгоход хүндрэлтэй асуудлууд гарч ирдэг. Нийтийн эрх зүйн гол зарчим, өмгөөллийн сонирхолтой жишээнүүдийг эндээс харж болдог байна. Жилийн бүртгэлийг орчин үеийн хэллэгт оруулан эмхтгэсэн *Селдоны хүрээлэнгийн цуврал*, *Роллсын цуврал* нэртэй цувралууд хэрэглэгдэж байна.

Хувийн эмхтгэл /Private reports/. Ингэж нэрлэх болсны учир гэвэл 1535-1865 оны хооронд шүүхийн шийдвэрүүдийг хувь хүмүүс эмхтгэж байсантай холбоотой юм. Хувь хүмүүс нийтэд худалдах зорилгоор шүүхийн эмхтгэлүүдийг хэвлэдэг байжээ. Зарим нэг нь тодорхой бус, чанарын шаардлага хангаж чаддаггүй байсан юм. Эдгээрийн дотроос өргөн хэрэглэгддэг эмхтгэлүүдийн тоонд Плауден, Коүк, Бароү нарынх ордог ба байнга хэрэглэгддэг жишгүүдийн жагсаалт гарган түүнийг харьцуулахыг зорьсон Английн эмхтгэл /English reports/ нэртэй эмхтгэл чухал байр эзэлдэг. Англи эмхтгэл 178 ботитой ба үүний 176 нь хэргийн тухай болон шүүхээс гарсан шийдвэрүүдийг, харин хоёр ботид эмхтгэгдсэн жишгүүдийн жагсаалтыг оруулсан.

¹ The English legal system. Gary Slapper and David Kelly, fifth edition. 2001., pp. 63-67.

Шинэ үеийн эмхтгэл /Modern reports/. Хувийн эмхтгэлийг хөтөлж буй хувь иргэдийн хөтөлсөн жишиг, шийдвэр эмхтгэх тодорхой загвар байгаагүйгээс шалтгаалан хэт урт, сунжирсан хэлбэртэйгээр хэвлэгдэх, зарим шийдвэрийн талаарх мэдээлэл ховордох, хэвлэлийн зардал өсөх хандлагууд гарч байсныг засаж, шийдвэрлэх зорилгоор 1865 онд Шүүхийн шийдвэр эмхтгэлийн Зөвлөлийг байгуулсан ба 1870 онд энэ байгууллага нэрээ өөрчилж Англи-Уэльсийн Шүүхийн шийдвэр эмхтгэлийн нэгдсэн Зөвлөл нэртэй болсон байна. Энэ Зөвлөлийн гол зорилго нь хямд өртгөөр ойлгомжтой, хурдан шуурхай, тодорхой байдлаар шүүхийн шийдвэрүүдийг эмхтгэх явдал ба Шүүх, эрх зүйн хүрээлэнгийн ивээл дор үйл ажиллагаагаа явуулдаг. 1865 оноос эхлэн өдийг хүртэл Шинэ үеийн шүүхийн шийдвэрийн эмхтгэл хэвлэгдэж байгаа юм.

Шүүхийн шийдвэрийн эмхтгэл /Law reports/. Англи-Уэльсийн Шүүхийн шийдвэр эмхтгэлийн нэгдсэн Зөвлөлөөс гаргадаг эмхтгэл юм. Энэ эмхтгэл нь хэвлэгдэхээсээ өмнө уг шийдвэрийг гаргасан шүүгчид хянуулан засварлуулж, хэргийг шийдвэрлэхэд үндэслэгдсэн шийтгэл үндэслэл, түүний товч утга санааг багтаасан байдгаараа давуу талтай. Шүүхийн шийдвэрийн эмхтгэлийн хүчин чадал, хэрэглэгдэх хүрээ нь бусад эмхтгэлээс өргөн цар хүрээтэй байдаг. 1891 оноос өнөөг хүртэл жил бүр дөрвөн хэсэгтэйгээр Шүүхийн шийдвэрийн эмхтгэл хэвлэгдэн гарч байна.

-Давж заалдах шатны шүүхийн шийдвэрлэсэн хэргүүд /AC-Appeal Cases/

-Шударга ёсны танхимын шийдвэрлэсэн хэргүүд /Ch-Chancery Division/

-Гэр бүлийн танхимын шийдвэрлэсэн хэргүүд /Fam-Family Division/

-Эзэн хаан /Хатан хаан/-ы шүүхийн шийдвэрлэсэн хэргүүд /KB/QB-Kings Bench/Queens Bench/

Долоо хоног тутмын эмхтгэл /Weekly Law Reports/. 1953 оноос хойш хэвлэгдсэн энэ мэдээлэл нь Шүүхийн шийдвэрийн эмхтгэлийг бодвол нийтэд түргэн хүрдэг. Шүүхийн шийдвэр эмхтгэлийн Зөвлөл шүүх үйл ажиллагааны явцад энэ ажиллагааны талаар эцсийн шийдвэр гарахаас өмнө гурван үе шаттай мэдээлэл гаргадаг ба сүүлийн хоёр мэдээлэл Шүүхийн шийдвэрийн эмхтгэлд тусгагддагаараа онцлог юм.

Бүх Английн шүүхийн шийдвэрийн эмхтгэл /All England Law Reports/. Энэ эмхтгэлийг Баттервортсын хэвлэлийн компани эрхлэн гаргадаг бөгөөд хэвлэхээсээ өмнө хуульчдаар хянуулдаг байна. Гэхдээ энэ эмхтгэлд өмгөөлөгчдийн гаргасан үндэслэл тусгагддаггүй. Долоо хоног бүр хэвлэгдэж, тухайн оны эцэст нь боть болон гардаг аж.

Хууль зүйн тогтмол хэвлэл ба сонин /Legal Periodicals and newspapers/. 1851 оноос эхлэн Солиситоруудын сэтгүүл буюу *Solicitors Journal*-д шүүхэд шийдвэрлэгдэж буй хэргийн талаар мэдээлэх болжээ. Зарим нэг хэргийн талаархи мэдээлэл зөвхөн энэ сэтгүүлд нийтлэгддэг ба хэрэв ийм тохиолдол гарвал тус сэтгүүлээс шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд иш татан хэрэглэж болдог. Ийм сэтгүүлийн тоонд мөн Шинэ хуулийн сэтгүүл буюу *New Law Journal* багтдаг.

Өдөр тутмын, өргөн хуудаатай Таймс, Гуарден, Индепендент зэрэг сонингуудад шүүх болон хууль зүйн үйлчилгээний тухай 1990 оны актын дагуу аливаа хэргийн талаар сонинд тайлбар өгөх эрх олгогдсон солиситор,

барристеруудын өгсөн мэдээлэл нийтлэгдвэл энэ нь хууль зүйн хүчин чадалтайд тооцогддог бөгөөд гагцхүү ихэнх тохиолдолд хийсвэр дүгнэлт хийгдсэнд тооцогддог байна.

Тусгайлсан эмхтгэл /Specialist reports/. Маш олон тооны ийм эмхтгэл байдаг ба тэдгээрээс онц ач холбогдолтой, өргөн хэрэглэгддэг аж үйлдвэр, орон нутгийн захиргаа, даатгал, татвар, эрүүгийн давж заалдах шатны хэргүүдийн эмхтгэл тооцогддог байна.

Европын Холбооны шүүхийн шийдвэрийн эмхтгэл /European Community reports/. Тусгайлсан эмхтгэлийн хүрээнд Европын холбоотой холбогдолтой дараахь хоёр эмхтгэл хэвлэгдэн гардаг. Үүнд: **Европын холбооны шүүхийн шийдвэрийн эмхтгэл** нь Европын холбооны шүүхээс гардаг албан ёсны баримт бичиг бөгөөд холбооны бүх улсуудын албан ёсны хэлнээ орчуулагддаг. **Нийтийн зах зээлийн холбогдолтой шүүхийн шийдвэрийн эмхтгэл** нь Европын эрх зүйн төвөөс хэвлэгддэг албан ёсны бус долоо хоног тутмын эмхтгэл юм. Страсбургэд орших **Европын хүний эрхийн шүүхийн шийдвэр** Европын хүний эрхийн тайланд тусгагддаг байна.

CD-ROM ба Интернэтийн мэдээллийн сан /CD-ROMs and Internet facilities/. Шинжлэх ухаан, технологийн хөгжилд интернэт мэдээллийн сан нэвтэрснийг даган шүүхийн шийдвэр эмхтгэх үйл ажиллагаанд хувьсгал гарчээ. Шүүхийн шийдвэрийн олон эмхтгэлүүдэд интернэтийн хаяг, CD-ROM-ны тухай заан тэндээс шүүхийн шийдвэр, хэргийн агуулгатай танилцаж болох талаар заасан байдаг. Эдгээрээс Justice, Lawtel, Lexis-Nexis, Westlaw UK зэргийг дурдаж болно.

Хүмүүст өөрийн компьютерээс Европын болоод дотоодын шүүхийн мэдээллийн сан руу нэвтрэн шүүхийн шийдвэр, хэргийн агуулгатай танилцах бололцоо олгосон эдгээр системүүдийн хамгийн анхдагч нь ихээхэн хэмжээний хуулийн мэдээлэл агуулсан Lexis систем юм.

Тус системд нэвтрэх эрхтэй хуульчид ямар ч мэдээллийг төвөг багатайгаар шаардлагатай хэргээ мэдээллийн сангаа шүүгчидтэй адил түвшинд олж авч эхэлсэн бөгөөд харин шүүх мэдээлэл авах түвшинд энэ явдлыг буруушаан шүүгч болон бусад хуульчдын хооронд ялгаа байх ёстой хэмээн мэдэгджээ. (*Stanley v International Harvester Co of Great Britain Ltd* (1983). Хэдийгээр зарим хуульчид өдөр тутмын сонин, интернэтээс авсан мэдээллийг албан ёсоор эрх зүйн эх сурвалж болгон хэвлэсэн боть, товхимолуудтай адил түвшинд авч үзэх боломжгүй гэж үзэж байхад зарим нь хүлээн зөвшөөрч дэмжиж байна.

Монгол Улсын хувьд шүүхийн шийдвэрийн эмхтгэлийг Дээд шүүхээс хэвлэн гаргах шаардлагатай бөгөөд энэ нь зөвхөн шүүгчид төдийгүй бусад эрх зүйч, иргэдэд шаардлагатай юм. Тэрхүү эмхтгэлээс иргэд өөрсдийн иргэний эрхийн хэрэгжилт, хууль, шүүхийн байгууллагуудын үйл ажиллагааны явц, арга барилыг олж үзэж болох бөгөөд цаашлаад эрх зүйд шамдан суралцаж байгаа оюутан, суралцагсдад шаардлагатай гарын авлага болж өгч чадна.

Мөн хэрэг хянан шийдвэрлэж байгаа шүүгчид бусад шүүгчдийнхээ туршлагаас суралцах, түүнд дүгнэлт хийх боломжтой болох юм.

Эрх зүйн эх сурвалжид тооцогдох бүтээл. Шүүх шийдвэрлэж буй тухайн хэрэгтээ хэрэглэгдэж болохуйц жишиг буюу хууль зүйн тайлбарыг олж чадахгүй бол эрдэмтдийн ном зохиолдоо дурдсан хууль зүйн тайлбаруудыг авч ашигладаг байна. Гэхдээ хууль зүйн дурын ном, зохиолыг эх сурвалжид тооцогдгүй бөгөөд үүнд тухайн бүтээл хэдэн онд хэвлэгдсэн, зохиогч нь хэр хүлээн зөвшөөрөгдсөн гэдгийг анхаарч үздэг.

Эдгээрээс 12 дугаар зууны Глэнвил, 13 дугаар зууны Брэктон, 17 дугаар зууны Көүк, 18 дугаар зууны Блэкстоуны бүтээлүүд ихэд нэр хүндтэйд тооцогддог ба эртний хууль зүйн ойлголтуудыг тодорхойлоход ихээхэн тус нэмэр болдог ажээ. Мөн орчин үед хуульчид дээрх номуудыг тайлбарлаж, шинэ үзэл баримтлал, онол, номлолыг дэвшүүлсэн бүтээлүүдийг олноор гаргаж байна¹. 1891 онд хэвлэгдсэн Хэри Кэмпбел Блэкийн "Хууль зүйн толь" Англи-Америкийн эрх зүйн тогтолцоон дахь хууль зүйн нэр томьёог тайлбарлах, нэг мөр ойлгоход ихээхэн хувь нэмэр оруулсан юм. Энэ бүтээл нь хууль зүйн нэр томьёог тодорхойлоод зогссонгүй англи хэлний хэл зүйн хөгжилд тодорхой хувь нэмэр оруулсанд тооцогддог. Учир нь "Оксфордын Англи хэлний толь" Блэкийн "Хууль зүйн толь" хэвлэгдсэний дараа зохиогджээ².

Жон Коул, Томас Блаунт, Гилес Якоб, Жон Боувьер, Ж.Ж.С.Вартон, Александр М. Буррилл, Арчибалд Браун зэрэг хуульчид өөрсдийн хууль зүйн толь болон холбогдох бүтээлийнхээ эхэнд "энэхүү бүтээлд миний хайхрамжгүй байдал, мэдлэг хомсоос шалтгаалан алдаа мадаг гарахыг үгүйсгэхгүй. Иймээс танаас уучлалт хүсье" хэмээн уншигчдаас өршөөл эрдэг байв. Харин Хэри Блэк өөрийн бүтээлд маш их ач холбогдол өгөн, бүтээлийнхээ чанарт сэтгэл хангалуун байдлаар "Энэхүү бүтээл нь Америк, Английн эрх зүйн нэр томьёог ойлгож, үйл ажиллагаандаа ашиглах хуульч нарт ихээхэн тус нэмэр болох бөгөөд бусад бүтээлээс олж үзэхгүй олон тодорхойлолтуудыг олж харах боломжтой" хэмээн итгэл дүүрэн мэдэгджээ.

Ингэж бусад хууль зүйн толиос өөрийнхөө толийг илүү гэдгийг итгэлтэйгээр мэдэгдсэн нь түүхийн хуудас эргэх тусам батлагдаж, үнэхээр чанартай, сайн бүтээл хэмээн дэлхийн хуульчид нэгэн дуугаар хүлээн зөвшөөрөхөд хүргэж байна. Блэкийн хууль зүйн толь одоогийн байдлаар долоо дах удаагаа хэвлэгдээд байгаа бөгөөд ижил хүйстний эрх, электрон шуудангийн хамгаалал, электрон бизнес зэрэг шинэ ойлголтуудыг түүнд хожим үеийн хуульчид нэмж оруулжээ.

Монгол Улсын хувьд нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн ном зохиол албан ёсны бус эх сурвалжид тооцогддог. Ийм ном зохиолд хуульч-эрдэмтдийн гаргасан хуулийн тайлбар, онолын ном зохиолуудыг багтааж болно. Эдгээр эх сурвалжийг хэрэглэх эсэх талаар албан ёсоор үүрэгчилсэн хэм хэмжээ байхгүй бөгөөд түүнийг хэрэглэх, эсэх нь гагцхүү шүүгчийн дотоод итгэлийн асуудал юм.

Английн эрх зүйн дээрхи онцлог нь түүний давуу тал болж өгч чаддаг бөгөөд шүүх эх сурвалж хэрэглэх тал дээр нэлээд чөлөөт сонголттой байдаг нь харагдаж байна. Тухайлбал, сонин, сэтгүүлд нийтлэгдсэн шүүхийн шийдвэрийн талаархи нэр хүндтэй хуульчийн хэвлүүлсэн материал шүүхэд

¹ The English legal system. Gary Slapper and David Kelly, fifth edition. 2001., pp. 85-86.

² Black's law dictionary, seventh edition 1999., ix-xii. Westgroup

шууд иш татагдаж, цавшлавд тэрхүү хэрэг хэрхэн шийдвэрлэгдэхийг тодорхойлж болох гэх мэт. Үүнтэй адилаар Монгол Улс шүүхийн шийдвэр болон нэр хүнд бүхий хуульчдын үзэл баримтлал, хууль зүйн тайлбаруудыг эмхтгэж гарын авлага, ном зохиол, боть болгон гаргаж нийтийн хүртээл болгох, хөндсөн асуудлыг хэлэлцэж, нийгмийн зохицуулагдаагүй үлдсэн зарим харилцааг тодорхойлохыг эрмэлзэх нь чухал билээ.

-ooOoo-

хууль зүйн үндэсний хүрээлэн
www.nli.gov.mn

ОЛОН УЛСЫН НИЙТИЙН ЭРХ ЗҮЙ, ОЛОН УЛСЫН ХУВИЙН ЭРХ ЗҮЙН ХАРИЛЦАН ХАМААРАЛ

Гадаад хэргийн яамны мэргэжилтэн А.Төмөр

Олон улсын нийтийн ба хувийн эрх зүйн харьцаа, хоорондын хамаарал нь онолын төдийгүй, гадаад харилцаа, гадаад бодлогын практик ач холбогдолтой чухал сэдэв юм.¹ Түүнчлэн шүүхээс олон улсын гэрээг хэрэглэхтэй уялдан үүсдэг нэн тулгамдсан асуудал билээ.

Дэлхий дээр олон улсын болон дотоодын эрх зүй гэсэн эрх зүйн хоёр систем үйлчилж байна. Дотоодынх нь тодорхой улсуудын эрх зүйн системд хуваагддаг. Олон улсын эрх зүй /ОУЭЗ/ нь дотроо өөрийн салбартай бие даасан эрх зүйн систем юм. Тухайлбал, олон улсын эдийн засгийн эрх зүй, олон улсын далайн эрх зүй, олон улсын агаарын эрх зүй, олон улсын сансрын эрх зүй гэх мэт. ОУЭЗ-н зохицуулах зүйл нь ОУЭЗ-н субъектийн хоорондын харилцаа болон Засгийн газар хоорондын олон улсын байгууллагын харилцаа, түүнтэй холбоотой бусад харилцаа байдаг.

Олон улсын хувийн эрх зүй болон олон улсын нийтийн эрх зүйн харьцаа, харилцан хамаарал нь онолын хувьд нэлээд маргаантай асуудлын нэг юм. Анх Голландад онолын хувьд судалж эхэлсэн байна.²

Гэхдээ уг хоёр эрх зүйн харьцааны асуудал анх Ромын эрх зүйгээс үүдэлтэй гэж үзэж болно. Олон улсын хувийн эрх зүй болон олон улсын нийтийн эрх зүйн харьцааны догматик үзэл аажмаар прагматик үзэл болж өөрчлөгдсөн байна. XIX зууны сүүл үеэр олон улсын хувийн эрх зүй нь олон улсын нийтийн эрх зүйд хамаарах нөмлөлөө алдаж улмаар дотоодынхонд хамааруулах үзэл дэлгэрэх болжээ. Гэхдээ XIX зууны сүүлч үеийн олон улсын хувийн эрх зүй дэх ОУЭЗ-н үзэл санааг үгүйсгэж болохгүй юм.

Германы "Төмөр канцлер" Отто фон Бисмарк олон улсын хувийн эрх зүйг хөгжиж буй процессийн хувьд дотоодын хууль тогтоомжид тусгахгүйгээр ОУЭЗ-д хамааруулах ёстой гэсэн байна. Тэрээр "Германы хууль тогтоомжид олон улсын хувийн эрх зүйн асуудлыг тодорхойлоон хэм хэмжээг тогтоовол улс төрийн үүднээс эргэлзээтэй алхам болно"³ гэж үзэж байв.

XX зууны дундуур олон улсын хувийн эрх зүйн хэм хэмжээг төрөлжүүлэн хуульчлах нь дотоодын хууль тогтоомжид өргөнөөр биеллээ олж эхэлсэн. Үүнд юуны өмнө ХБНГУ, Швейцарь, Австри, Унгар, Польшийг хамааруулж болох юм.

XX зууны сүүлч үед олон улсын хувийн эрх зүйг олон улсын нийтийн эрх зүй олон улсын нийтийн эрх зүйд хамаардаггүй гэсэн цөөн тооны үзэл байсан ба түүнтэй зэрэгцэн олон улсын хувийн эрх зүйн зарим хэм хэмжээ нь

¹ Hambro E. The relation between international law and conflict law. Rec. course. T 105, 1962., pp. 676.

² Wortley B. A. The interaction of public and private international law today. 1954 -1, pp. 245.

³ Wortley B. A. Op. Cit. p.p 246.

⁴ Тухайн үзлийг Бисмарк Гадаад харилцааны яамнаас Эзэнт улсын Хууль зүйн яаманд бичсэн захидалдаа дурдсан байна (1887.9.30)

ОУЭЗ-д, зарим нь дотоодын эрх зүйд хамаардаг гэсэн дуалист үзэлтнүүд гарч ирсэн байна.

Зарим эрдэмтэд олон улсын хувийн эрх зүй болон олон улсын нийтийн эрх зүйн харьцаа нь дотоодын болон ОУЭЗ-г харьцуулсантай төстэй гэж үздэг.

Энэ нь тийм биш юм. Хэдийгээр дотоодын эрх зүйн салбар болж тухайн улсаас гадагш гарч буй харилцааг зохицуулдаг ч нөлөөтэй нь тодорхой билээ. Дотоодын болон олон улсын эрх зүйн хоёр систем нь бие даасан салбар гэсэн утгаар нь хоорондоо ямар ч холбоогүй гэж үзэж бас болохгүй юм. Үүнтэй холбоотой олон улсын нийтийн эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээ болон зарчим нь олон улсын хувийн эрх зүйн хэм хэмжээг бий болоход дотоодын эрх зүйн нэгэн адил нөлөөлдөг. Олон улсын хувийн эрх зүйн хэм хэмжээний үүсэлтэй холбоотой, аливаа улс гүрэн оршин байгаа бусад эрх зүйн системийг хүлээн зөвшөөрөхгүй байж болохгүй тухай хамтын ажиллагааны зарчим бий. Ихэнхи эрдэмтэн судлаачид олон улсын гэрээг олон улсын хувийн эрх зүйн эх сурвалж яах аргагүй мөн гэж үздэг.¹

Э.Цительман олон улсын нийтийн эрх зүй нь зөрчилдөөний хэм хэмжээг тодорхой улсын позитив² эрх зүйд биеллээ олохыг тодорхойлдог гэж үздэг байв. Энэ онолын бас нэг төлөөлөгч бол Голландын хуульч, профессор Д.Житта (1854-1925) юм. Тэрбээр нийтээр хүлээн зөвшөөрсөн эрх зүйн зарчмын үндсэн дээр олон улсын хувийн эрх зүйн асуудлыг бодитойгоор шийдэж болно гэж үзэж байв.

Оросын эрдэмтэн Александр Пиленко (1873-1955) 1911 онд бичсэн бүтээлдээ олон талын зөрчилдөөний хэм хэмжээг хэрэглэхийг эсэргүүцэж байсан. Тэрээр шүүгчид гадаад улсын хүсэл зоригийн эсрэг гадаадын эрх зүй хэрэглэвэл бүрэн эрхт байдлаа алдаж байна гэж тэмдэглэж байв. Яг үүнтэй адил үзлийг Италийн эрдэмтэн Р.Кадри (1907-1976) баримталж байв.

Эсрэг байр суурийг баримтлагч, позитив үзэлтэн, германы хуульч Франц Кан (1801-1904) олон улсын хувийн эрх зүйг дотоодын эрх зүйтэй нягт холбон үздэг байсан. Яах аргагүй нэг улсын зөрчилдөөний хэм хэмжээ нөгөө улсынхтай таарахгүй гэдгийг дурдах хэрэгтэй. Олон улсын эрх зүйн энэ үзэл бодлыг дэмжиж Оросын эрдэмтэн А.И.Маковский, С.Н.Лебедев нар зөрчилдөөний хэм хэмжээ улс болгоны хувьд ялгаатай бөгөөд зарим улсад ерөөсөө байхгүй гэж үздэг нь сонирхолтой санаа юм. Энэ нь улс болгон өөр өөр эрх зүйтэй, өөрийн улс, ард түмэнд тохируулж хууль тогтоомж гаргадагтай холбоотой.

Олон улсын хувийн эрх зүй бий болгож байгаа харилцааг дан ганц улс зохицуулж чадахгүй. Уг харилцаа бий болсон газар нутаг, биеллээ олсон газар, үүнтэй холбоотой маргааныг бүхэлд нь аль нэг улс дангаараа бие дааж зохицуулж хянаж чадахгүй.³

¹ Рубанов, А.А. Теоритические основы международного взаимодействия национальных правовых систем. Москва 1984., С. 80.

² Schwarzenberger. G. Manual of International Law, 1967., pp. 3-4.

³ Позитив эрх зүй нь тухайн улсад үйлчилж буй эрх зүйн систем бөгөөд хууь хүнд хамаарах (сурах, амьд байх, тэтгэмж авах зэрэг) субъектив эрхээс ялгаатай ойлголт юм.

⁴ Храбсков. В.Г. Международное частное право в системе общего международного права. Правоведение, 1982., №6, С. 37.

Улс бүр өөрийн үзэл баримтлал, эрх зүйн үүднээс нийгмийн холбогдох харилцааг зохицуулдаг. Зарчмын хувьд ч өөрийн бүрэн эрхт байдлын үүднээс ингэж зохицуулах нь зүйн хэрэг. Нөгөө талаас олон улсын гэрээ байгуулах замаар тусгаар тогтносон улсуудын зөрчилдөөний хэм хэмжээний ялгаатай байдлаас зайлсхийх болно. Хэдийгээр ийм ялгааг хэсэг хугацаанд бүрэн арилгаж чадахгүй ч ийм алхам хийх бүрэн боломжтойг тэмдэглэх нь зүйтэй.

И.П.Блиценкогийн үзэж байгаагаар сүүлийн үед үндэсний хууль нь эрх зүйн эх сурвалжийн хувьд олон улсын хувийн эрх зүйд улам бүр баттай байр суурь эзлэх болж байна.¹

Тухайн салбарт олон улсын гэрээ, хэлэлцээрийн хандлага өсөж байгаа ч дотоодын хууль тогтоомж нь зохицуулалтын эрх зүйн эх сурвалж хэвээр байсаар байна. Энэ нөхцөл байдал олон орны номлолд хүлээн зөвшөөрөгдөж байгаа юм. Үндсэндээ улс болгон өөрийн гэсэн олон улсын хувийн эрх зүйтэй, тэр дундаа нэг хэсэг орон өөрийн гэсэн олон улсын хувийн эрх зүйт хуультай.² Ийм байдлаар улс бүр гадаадын элемент оролцсон өөрийн иргэний эрх зүйн харилцаанд олон улсын хувийн эрх зүйн хэм хэмжээг хэрэглэдэг. Үүнээс үндэслэж ОУЭЗ нь олон улсын харилцааг зохицуулдаг, олон улсын хувийн эрх зүй нь иргэний эрх зүйн шинжтэй харилцааг зохицуулан дотоодын эрх зүйд хамаарах болж байна гэж хэлж болмоор байна. Ийм байдлаар өнгөрсөн зуунаас эрдэмтэн, хуульчид олон улсын хувийн эрх зүйг ОУЭЗ-н практикт хүлээн зөвшөөрөхгүй нь нийтлэг биш байгаа юм. Улс бүр өөрийн хууль тогтоомждоо ямар зөрчилдөөний хэм хэмжээг агуулахаа тогтоож өгдөгт хэргийн учир байгаа юм.

Одоо арай сүүлийн үеийн судлаачдын үзэл бодлыг авч үзье. Бельгийн ОУЭЗ-н эрдэмтэн Ф.Риго олон улсын хувийн эрх зүйг болон олон улсын нийтийн эрх зүйг нийтэд нь ОУЭЗ-д хамааруулж үзэж байна. Түүний үзсэнээр францын үндэсний эрх зүй нь нийтийн болон хувийн гэсэн ангилалд хуваагдаж байгаа. Олон улсын хувийн эрх зүйг барууны эрх зүйн системийн хувьд олон улсын эдийн засгийн эрх зүйд хамаатуулдаг нь бас аргагүй юм.

ОУХЭЗ-д дотоодын эрх зүй үйлчлэх хүрээг нэгдүгээрт: хөрөнгө оруулалтыг дэмжих, хоёрдугаарт: эд хөрөнгө, үйлчилгээтэй холбоотой олон улсын гэрээ хэлцэл хийх гэж эрдэмтэд тодорхойлж байна. ОУЭЗ ба ОУХЭЗ-н хамаарлыг бий болсон улс хоорондын буюу үндэстэн дамнасан эрх зүйн үзэл баримтлалыг судлахгүйгээр ойлгох аргагүй юм. Үндэстэн дамнасан эрх зүй бол үндэсний зөрчилдөөний эрх зүйн хэм хэмжээний зэрэгцээ ОУНЭЗ-ээр тогтоосон үндэстний дээрхи хэм хэмжээтэй хамт хэрэглэгддэг эрх зүйн эх сурвалж юм.

ОУХЭЗ-н хэм хэмжээ нь ОУНЭЗ-н позитив бүтцэд хамаарах эсэх нь олон улсын шүүх болон олон улсын арбитрын дүн шинжилгээнээс маш ихээр шалтгаалдаг. Учир нь тэдгээрийн эрх зүйн байдал нь дотоодын эрх зүйн хэм хэмжээнээс урган гарч байгаа ба ОУХЭЗ-н хэм хэмжээнд ч багтаж байгаа юм. Олон улсын хэрэг маргаан шийдвэрлэдгийн хувьд ОУХЭЗ-н үүднээс "lex fori"-д юуг ойлгох вэ? Хэрвээ дотоодын эрх зүйг ойлгох юм бол эдгээр олон улсын

¹ Блиценко, И.П. Международное публичное и международное частное право. С. 47.

² Лунц, Л.А. Курс международного и частного права. Москва, 1970., С. 37.

байгууллага нь өөрийн гэсэн "lex fori"-гүй гэж ойлгоно, яагаад гэвэл ямар ч дотоодын эрх зүй тэдгээрт хамаарахгүй. Өөр нэг хувилбар нь ОУНЭЗ-г өөрийг нь "lex fori"-д, олон улсын шүүх болон түүнд хамааралтай бусад олон улсын байгууллагаар хүлээн зөвшөөрүүлэх явдал юм.

ОУНЭЗ болон ОУХЭЗ хоёр нь хоорондоо нягт уялдаа холбоотой юм. ОУНЭЗ гэдэг нь бие даасан эрх зүйн систем, харин ОУХЭЗ нь бүх улсын дотоодын эрх зүйн системийн нэгэн хэсэг юм. Энэ хоёр эрх зүйн системийн хэм хэмжээ нь адил нэгэн зорилгод үйлчилдэг. Тэр нь янз бүрийн салбарт олон улсын хамтын ажиллагааны эрх зүйн орчинг төлөвшүүлж хөгжүүлэх явдал юм. Өөрөөр хэлбэл аливаа нэг улсаас гадаад тал дахь нэг буюу түүнээс дээш улстай харилцах харилцааг зохицуулах үүрэгтэй. Уг хоёр эрх зүйн систем нь хоорондоо бүрэн тусгаарлагдсан хөндийрсөн шугам үгүй ба тэдгээрийн хэм хэмжээ, институт нь нягт холбоотой юм. ОУНЭЗ болон ОУХЭЗ-н уялдаа нь юуны өмнө олон улсын гэрээгээр тогтоосон журам нь анхлан томьёолон тодорхойлогдсон хэм хэмжээний хувьд олон улсын хувийн эрх зүйн эх сурвалж болж төлөвшсөний дараа дотоодын хууль тогтоомжид шилжүүлэн буулгасан хэм хэмжээний утгаар илэрдэг.

Олон улсын гэрээний оролцогч улс өөрийн дотоодын хууль тогтоомжид эдгээр хэм хэмжээг тусгах үүрэг хүлээдэг. Тухайн хэм хэмжээг иргэний эрх зүйн хэм хэмжээ гэж үзэхгүй байж болохгүй, яагаад гэвэл зорилго нь иргэний эрх зүйн шинжтэй харилцааг зохицуулдаг юм. Эцсийн дүндээ эдгээр хэм хэмжээ нь олон улсын гэрээний оролцогч улс болон бусад субъектийн харилцааг зохицуулдаг болно. ОУНЭЗ болон ОУХЭЗ-н уялдааг тодорхойлох ойлголтод юуны өмнө улсын бүрэн эрхт байдал, дотоод хэрэгт үл оролцох, эрх тэгш байдлын зарчмыг ойлгодог.

Зарим иргэний эрх зүй, түүний дотор өмчийн, гэр бүлийн эрх зүй, хувийн эрх зүйн салбар болох банкны зэрэг эрх зүйн зохиогчийн, хөдөлмөрийн харилцаанд оролцогчдын үйл ажиллагаа олон улсын эрх зүйн элементийг агуулж байдаг. Гэхдээ гадаад улс, хуулийн этгээд (гадаадын элемент гэх) оролцсон харилцааг олон улсын эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулдаг. Бүр тодруулбал эрх зүйн харилцааг өөрийн гэсэн онцлог эх сурвалж, субъект, хэрэг маргаан шийдвэрлэдэг арга, өвөрмөц санкци хэрэглэдэг ОУХЭЗ-н хэм хэмжээгээр зохицуулдаг.

Үүнээс үзвэл ОУХЭЗ-н хэм хэмжээний үндэс нь дотоодын (хууль тогтоомж) болон ОУЭЗ-н (олон улсын гэрээ) хэм хэмжээ байдаг нь тодорхой байна. Тэгэхээр энэ хоёр нь бие биетэйгээ холбоотой юм. Учир нь зөрчилдөөний хэм хэмжээ өөрөө бие дааж тодорхой харилцааг зохицуулдаггүй, харин дотоодын эрх зүйн хэм хэмжээний оролцоотойгоор зохицуулдаг байна.

Үүнтэй холбогдуулан Оросын эрдэмтэн Г.И.Тункин "ОУХЭЗ гэдэг нь зарим талаараа дотоодын эрх зүйтэй, зарим талаараа ОУНЭЗ-тэй холбоотой хэм хэмжээний цогц" гэж, харин Г.К.Дмитриева "ОУХЭЗ гэдэг нь өөр нэр томьёотой ч дотоодын эрх зүй юм." гэж тодорхойлсон байна. Хууль зүйн шинжлэх ухаанд ОУНЭЗ болон ОУХЭЗ-н уялдааны талаархи ойлголт нэгэн цэгт хүрж чадаагүй өнөөг хүртэл маргаантай байна.¹

¹ Под общей редакцией Бекяцева, Москва 1998, С. 29.

Ямар ч байсан ОУНЭЗ болон ОУХЭЗ, мөн ОУХЭЗ болон дотоодын эрх зүй нягт уялдаа холбоотой. Гэхдээ ОУХЭЗ нь ОУНЭЗ-н салбар байж болохгүй юм. Уг хоёр эрх зүйн субъект, объект нь зохицуулах зүйл үйлчлэх хүрээ нь өөр юм. ОУХЭЗ болон ОУНЭЗ-н чиг үүргийн харилцан хамаарал ба харилцан үйлчлэлийг үгүйсгэж болохгүй. Олон улсын хамтын ажиллагаа, үндэстэн дамнасан үйл ажиллагаа, глобалчлалгүйгээр олон улсын эрх зүй утга алдаж байгаа юм. ОУЭЗ-н хэм хэмжээ нь ОУХЭЗ-д нөлөөлдөг. ОУЭЗ-д ОУХЭЗ-н хэм хэмжээ, нийтээр хүлээн зөвшөөрсөн зөрчилдөөний хэм хэмжээ байхгүй, харин гадаадын эрх зүйг хэрэглэх тухай асуудал бий.

Энэ хоёрын хоорондын нягт уялдаа, ялангуяа олон улсын эдийн засгийн харилцааны салбарт тод илэрч байна. Худалдааны гэрээ, санхүү, татварын хэлэлцээр нь гадаад эдийн засаг, худалдааны талаар улс хоорондын харилцан хүлээх үүргийг тогтоодог. Эдгээрийн үндсэн дээр байгуулсан гадаад худалдааны хэлцлээр бараа тээвэрлэх, хүлээн авах, төлбөр хийх зэрэг ажиллагаанд иргэний эрх зүйн харилцаа үүсдэг. Улс хоорондын худалдааны гэрээг зөрчвөл олон улсын нийтийн эрх зүйн дагуу Засгийн газрын хэмжээнд яригдаж, цаашдаа дипломат шугамаар эсэргүүцэл илэрхийлж, хариу арга хэмжээ авах болоцоотой болдог. Тэгвэл хуулийн этгээдийн хооронд байгуулсан гэрээ, хэлцлийг зөрчих нь иргэний эрх зүйтэй холбоотой учраас түүнээс үүдэн гарах гомдлыг холбогдох улсын шүүхээр, эсвэл арбитраар шийдвэрлүүлдэг байна.

Дээр дурдсанаас дүгнэж үзвэл ОУНЭЗ ба ОУХЭЗ нь тус тусдаа зохицуулах зүйл, арга, харилцаатай онцлог систем боловч хоорондоо нягт уялдаатай, бие биенээсээ харилцан хамааралтай үзэгдэл мөн болох нь харагдаж байна.

-ooOoo-

**ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭГ ХУУЛЬ ЗҮЙН
ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ БОЛОН ӨМГӨӨЛЛИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЭРЭГЛЭХЭД АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ**

Хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор С.Жанцан

Өмгөөлөгч хуульд заасан журмын дагуу сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогчийн эрх, хууль ёсны эрх ашиг сонирхлыг хамгаалж, хууль зүйн туслалцаа үзүүлэхдээ өөрийн үйл ажиллагаанд Үндсэн хууль, бусад үндэсний хууль тогтоомж олон улсын хууль зүйн хэм хэмжээг нэг мөр зөв хэрэглэх чадвартай байх шаардлагатай. Энд олон улсын эрх зүйн хэм хэмжээ чухал ач холбогдолтой.

Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Монгол Улс олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг баримталж...", 2 дахь хэсэгт "...олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар биелүүлнэ", 3 дахь хэсэгт "Монгол улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ" гэж тус тус заасныг өмгөөлөгчид үйл ажиллагаандаа мөрдөн ажиллах учиртай.

Өмгөөлөгч юуны өмнө НҮБ-ын "Хүний эрхийн түгээмэл тунхаглал", "Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт" болон бусад хүний эрхийг хамгаалахтай холбоотой пакт, гэрээ, конвенцууд, "Хууль зүйн мэргэжлийн бие даасан байдлын талаархи олон улсын баарын холбооны стандарт", Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хууль зөрчигчтэй харилцах талаар 1990 оны 8 дугаар сарын 27-ноос 9 дүгээр сарын 7-ны өдрүүдэд хуралдсан НҮБ-ын 8 дугаар хурлаар батлагдсан "Хуульчдын гүйцэтгэх үүргийн үндсэн зарчим", "Өмгөөлөгчийн үүргийн талаархи НҮБ-ын үндсэн зарчим" зэрэг өмгөөллийн үйл ажиллагаанд шууд хамаарах олон улсын хууль зүйн хэм хэмжээг сайтар судалж үйл ажиллагаандаа мөрдөх шаардлага улам өндөржиж байна.

Нэгд. Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Хүн бүр хуулийн өмнө адил тэгш бөгөөд ямар ч ялгаваргүйгээр адилхан хамгаалуулах", 8 дугаар зүйлд "Үндсэн хууль, бусад хуулиар олгосон эрх нь зөрчигдөл хүн бүр эрх мэдэл бүхий Үндэсний шүүхээр эрхээ бүрэн сэргээн тогтоолгох", 10 дугаар зүйлд "Гэмт хэрэгт яллагдаж буй хүн бүр өөрт нь тулгасан хэргийг өмгөөлүүлэх буюу өөрөө өмгөөлөх бүрэн боломжтойгоор шүүх хурлаар ил хэлэлцэн таслаж, хуулийн дагуу гэм буруутай нь тогтоогдох хүртэл гэм буруугүй гэж тооцогдох эрхтэй"-г тунхаглажээ.

Хоёрт. "Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт"-ын 2 дугаар зүйлд пактаар хүлээн зөвшөөрөгдсөн эрх нь зөрчигдсөн хүмүүс, хохирогчийг хууль зүйн талаар хамгаалах үр нөлөөтэй арга хэмжээг авах, хууль зүйн хамгаалалтын /өмгөөлөл/ хэрэгслийг олгосон үед түүнийг эрх бүхий байгууллагаас хэрэглэх явдлыг хангах, 10 дугаар зүйлд "эрх чөлөөгөө хасуулсан хүн бүр өөртэй нь хүнлэг, бие хүний хувьд угаас заяасан

¹ Төрийн мэдээлэл. УБ., 1992., №1, 3 дахь тал

нэр төрийг нь хүндэтгэх ёсоор хандах эрх эдэлнэ", 14 дүгээр зүйлд "өөрийнхөө сонгон авсан өмгөөлөгчтэй уулзаж, өмгөөлүүлэхэд бэлтгэхэд хүрэлцэхүйц хугацаа, бодит бололцоотой байх, түүнчлэн хэргийг нь шүүхээр хэлэлцэх үед шүүхэд байлцаж, өөрийгөө өмгөөлөх буюу сонгож авсан өмгөөлөгчөөр өмгөөлүүлэх, хэрэв өмгөөлөгчгүй бол энэхүү эрхийн тухай түүнд мэдэгдсэн байх, шүүн таслах ажлын ашиг сонирхол хөндөгдөж байгаа аливаа тохиолдолд тохоон томилогдсон өмгөөлөгчтэй байх, өмгөөлөгч авсны хөлсийг төлөх хөрөнгө хүрэлцэхгүй үед түүнд үнэ төлбөргүй өмгөөлөгч гаргаж өгөх, гэмт хэрэгт шийтгүүлсэн хүн бүр хууль ёсоор дээд шатны шүүхэд давж заалдах зэрэг эрхтэй болохыг тус тус заасан нь Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хуульд тусгагдан хэрэгжиж байна.

Дээр дурдсан олон улсын хууль зүйн хэм хэмжээнд Монгол Улс нэгдэн орсон болон тэдгээрийг соёрхон баталсан үеэс хууль хүчин төгөлдөр болсон үеэс үндэсний хууль тогтоомжийн адил үйлчилдэг онцлогтой. Өөрөөр хэлбэл өмгөөлөгч тэдгээрийг заавал үйл ажиллагаандаа мөрдөнө гэсэн үг юм.

Гуравт, "Хуульчдын гүйцэтгэх үүргийн үндсэн зарчим" хэмээх бичиг баримтад хүн бүр өөрийн эрхийг хамгаалахын тулд эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны бүх шатанд өөрийгөө хамгаалуулахын тулд хуульчид /өмгөөлөгчид/ хандах эрхтэй. Засгийн газар нь баривчлагдсан буюу хоригдсон бүх хүмүүст эрүүгийн гэмт хэрэг үйлдсэнд ял сонгосон эсэхээс үл хамааран бүх тохиолдолд баривчлагдсан буюу хоригдсоноос хойш 48 цагаас хойшгүйгээр хуульчид нэн даруй хандах явдлыг хангана.

Баривчлагдсан, саатуулагдсан, шоронд хоригдсон бүх этгээд хуульчтай уулзах зохих боломж, хугацаа нөхцөл, түүнтэй саадгүй, бусдын оролцоогүй, бүрэн ганцаарчлан харьцах, зөвлөлдөх, тийм зөвлөгөөгөө хууль хэрэгжүүлэх, албан тушаалтны дэргэд, тэгэхдээ тэд нар сонгох боломжгүйгээр хийлгэх явдлыг хангах ёстой. Манай Эрүүгийн байцаан шийтгэх хуульд өмгөөлөгчтэйгээ ганцаарчлан, ямарваа хязгаарлалт, хөндлөнгийн хяналтгүйгээр уулзах нөхцөлийг хуульчилсан.

Дөрөвт, "Хууль зүйн мэргэжлийн бие даасан байдлын талаархи олон улсын Баарын холбооны стандарт"-д хуульч (өмгөөлөгч) бие даасан байх нь хүний эрхийг хамгаалан хөгжүүлэх чухал баталгаа бөгөөд хууль зүйн үр ашигтай зөвлөгөө, туслалцаа авахад зайлшгүй шаардлагатай гээд өмгөөлөгчид хууль бус хязгаарлалт, гадны шууд ба шууд бус оролцоогүйгээр мэргэжлийн үүргийг биелүүлэх баталгаа, түүнчлэн хүн бүр эрхээ эдэлж хамгаалуулахын тулд хүссэн өмгөөлөгчийнхээ туслалцааг шаардлагатай үедээ саадгүй авч чадах нөхцөл бүрдүүлэх зорилгоор Олон улсын Баарын холбооноос гаргасан журмыг тухайн улсын төр үндэснийхээ хууль тогтоомжид тусган хэрэгжүүлэхийг санал болгосон байдаг.

Энэ стандарт өмгөөлөгчийн мэргэжлийн онцлог, эрх, үүргийг тодорхойлж, өмгөөлөгч нь мэргэжлийнхээ талаар тогтсон дүрэм, журам, хэм хэмжээ, ёс зүйд нийцүүлж үүргээ гүйцэтгэхдээ үйлчлүүлэгчийнхээ хууль зүйн сонирхлын дагуу ямагт чөлөөтэй, нягт нямбай, айж эмээлгүйгээр, эрх баригчид буюу олон нийтийн зүгээс ямар ч шахалт хориггүйгээр ажиллах, өмгөөлөгч, үйлчлүүлэгч болон түүний хэргийг хууль зүйн хувьд төлөөлсөн,

¹ Шүүх эрх мэдлийн салбар дахь хүний эрх - НҮБ. УБ., 1996, 101-102 дахь тал

зөвлөгөө өгсөн, эрх зүйн туслалцаа үзүүлснийхээ төлөө шийтгүүлэх, иргэний, засаг захиргаа, эдийн засгийн болон бусад төрлийн заналхийлэл, сүрдүүлэлтэд өртөхгүй байх, мэргэжлийнхээ үүргийг нэр төртэй биелүүлэхэд шаардлагатай эрх ямба буюу боломжоор хангагдах ёстойг онцлон заажээ.¹

Тавд, "Өмгөөлөгчийн үүргийн талаархи НҮБ-ын үндсэн зарчим" хэмээх баримт бичигт улсуудын Засгийн газар нутаг дэвсгэр дээрээ оршин суугаа бүх хүнд ямар ч ялгаваргүйгээр өмгөөлөгчийн туслалцааг хуулийн хүрээнд шуурхай, үр дүнтэй авах боломжийг бүрдүүлэх, өмгөөлөгчдийн мэргэжлийн үүрэг, нийгмийн учир холбогдлыг иргэдэд сурталчлах, өмгөөлөгч шаардлагатай байгаа бүх тохиолдолд туршлага, мэдлэг чадвартай өмгөөлөгчөөр хангах, өмгөөлөгчийн хөлс төлөх чадваргүй бол төлбөргүйгээр үйлчлэхийг чухалчлан заасныг манай улс чанд мөрдөж ажиллах учиртай юм.

Гэтэл Хүний эрхийн үндэсний Комиссоос Улсын мөрдөн байцаах газар, нийслэлийн бүх дүүрэг болон Төмөр замын болон Замын цагдаагийн хэлтэс, 18 аймгийн Мөрдөн байцаах тасагт 2001 он болон 2002 оны эхний улиралд хэрэгсэхгүй болгосон 4236 хэрэгт холбогдсон дөрвөн хүн тутмын нэгийг нь 3-1047 хоногоор цагдан хорьж, хэрэгт холбогдогсдын өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах эрхийн хэрэгжилт туйлын хангалтгүй, үнэн хэрэгтээ зарим аймаг, газарт өмгөөлөгчийн оролцоогүйгээр хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан байна. УМБГ, Чингэлтэй, Баянзүрх дүүрэг, Дархан-Уул, Сэлэнгэ, Говь-Алтай аймагт хэрэгсэхгүй болгогдсон хэрэгт холбогдогчдын 46.1-97.5 хувийг нь өмгөөлөгчгүйгээр явуулсан байна.²

НҮБ-ын үндсэн зарчимд өмгөөлөгч хүн мэргэжлийн хувьд шүүх засаглалын чухал төлөөлөгч гэж бахархаж, нэр төрөө ямагт өндөрт өргөж явах учиртай бөгөөд өөрсдийнх нь зөвлөгөө, туслалцаа авч буй хүний өмнө:

а/ түүний хууль ёсны эрх, үүргийнх нь дагуу хуулийн хүрээнд зөвлөгөө өгөх;

б/ үйлчлүүлэгчдээ туслах, эрх, ашиг сонирхлыг хамгаалахад бүх үйл ажиллагаагаа чиглүүлэх;

в/ үйлчлүүлэгчийн эрх, ашиг сонирхолд ямагт үнэнч шударга, хүндэтгэлтэй хандах үүргийг хүлээнэ³ гэж заасан.

Зургаад, Монгол Улс 2000 онд нэгдэн орсон "Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг" конвенцын 2 дугаар зүйлд оролцогч улс бүр нутаг дээрээ эрүүдэн шүүх үйлдлээс урьдчилан сэргийлэх үр ашигтай хууль зүй, захиргаа, шүүхийн болон бусад арга хэмжээ авахыг, 4 дүгээр зүйлд оролцогч улс бүр эрүүдэн шүүх бүх үйлдлийг эрүүгийн хуульд гэмт хэрэг гэж үзэж, энэ нь онц аюултай гэмт хэрэгт хамаарах учиртайг заасан.

Урьдчилан сэргийлэх талаар одоо хүртэл дорвитой арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй, харин эрүүдэн шүүхийг Эрүүгийн шинэ хуульд "мэдүүлэг өгөхийг албадах" нэрээр хүнд гэмт хэрэгт хамааруулан хуульчилсан нь уг

¹ Хууль зүйн мэргэжлийн бие даасан байдлын талаархи Олон улсын Баарын холбооны стандарт

² Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний тухай илтгэл. УБ., 2003., 44 дэх тал

³ Хүний эрх: Олон улсын гэрээ, хэлэлцээрүүдийн эмхтгэл. УБ., 1988., 50 дахь тал

конвенцын "онц аюултай гэмт хэрэг" байх шаардлагатай зөрчилдөж байгаа юм.

Оролцогч улс бүр эрүүдэн шүүгдсэн этгээд хохирлоо нөхөн төлүүлэх, түүний дотор эрүүл мэндээ аль болох бүрэн сэргээхэд шаардлагатай шударга, тохирсон төлбөр авах, зөрчигдсөн эрхийг сэргээх эрхийг эрх зүйн тогтолцоогоор хангах үүрэг хүлээнэ. Эрүүгийн хэрэгт сэрдэгдэж эхэлсэн үеэс өмгөөлөгч оролцох болсон, энэ конвенцид манай улс нэгдэн орсон явдал өмгөөлөгч баривчлагдсан, цагдан хоригдсон үйлчлүүлэгчийнхээ эрх ашгийг хамгаалах, хоригдох нөхцөлийн талаар тодорхой хүсэлт, шаардлага тавих боломж бүрдсэн юм.

Өмгөөлөгчид эрүүдэн шүүх замаар авсан мэдүүлэх нотлох баримтын хүчин чадалгүй байдал, түүнчлэн хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас иргэнд учирсан хохирлыг арилгах эрх зүйн үндэс нэгэнт бүрдсэн зэргийг харгалзан үйлчлүүлэгчдээ туслах ажиллагааг идэвхитэй, санаачилгатай явуулах боломжтой.

Долоод, НҮБ-ын Ерөнхий ассамблейн 1988 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн 43/173 дугаар тогтоолоор батлагдсан. "**Аливаа хэлбэрээр саатуулагдсан болон хоригдсон хүмүүсийг хамгаалах зарчмын цогц**" хэмээх баримт бичигт "Аливаа хэлбэрээр саатуулагдсан болон хоригдсон хүний эрхийг тухайн улсад мөрдөгддөг хууль, конвенц, дүрэм, зан заншил нь энэ зарчимд тусгагдаагүй буюу бага хэмжээгээр тусгагдсан гэсэн үндэслэлээр ямарваа байдлаар хязгаарлах буюу дорд үзэх явдал байх ёсгүй.

Саатуулагдсан буюу хоригдсон нэг ч хүнийг эрүүдэн шүүх буюу хүнлэг бус, хууль бусаар буюу нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэж болохгүй. Үйлчлүүлэгч нь хууль бусаар албадан саатуулагдсан, хоригдсон, эрүүдэн шүүгдсэн нь тодорхой байвал холбогдох байгууллага, албан тушаалтанд мэдээлэх үүрэгтэй" болохыг заажээ.

Өмгөөлөгчид энэ зарчмын цогцод заасан "саатуулагдсан хүмүүс шийтгэгдээгүй хүмүүсийн байдалд тохирох дэглэмд ямагт тусдаа байх, баривчлагдсан шалтгааныг мэдэх, саатуулагдсан этгээд хуульд зааснаар өөрөө өөрийгөө хамгаалах бусад өмгөөлөгчийн туслалцаа авах, өмгөөлөгчтэйгээ холбоо барьж зөвлөлдөх, хөндлөнгийн хяналт, оролцоогүйгээр уулзах бололцоогоор хангагдах эрхтэйг анхааралдаа авсан байх учиртай.

Зарчмын 33 дугаарт зааснаар саатуулагдсан болон хоригдсон этгээд, түүний өмгөөлөгч нь тухайн этгээдтэй хэрхэн харьцаж байгаа, тухайлбал, эрүүдэн шүүх хэрцгийгээр хүнлэг бусаар, хүний нэр төрийг доромжлон харьцаж байгаа талаар саатуулах буюу хорих газрын удирдлага, тэдгээрийн дээд шатны байгууллагад гомдол хүсэлт гаргах эрхтэй байна.

Наймд, Монгол Улс 1990 онд соёрхон баталсан Хүүхдийн эрхийн конвенцын 19 дүгээр зүйл зааснаар оролцогч улсуудад нь эцэг эх, хууль ёсны асран хамгаалагч болон хүүхдийн төлөө анхаарал халамж тавих бусад хүмүүсийн зүгээс доромжлох бусад үүргээ хортойгоор ашиглах, анхаарч халамжлахгүй байх, хайхрамжгүй харьцах зэрэг бие бялдар, сэтгэл санааны талаар хүчирхийлэх бүх хэлбэрээс хүүхдийг хамгаалах талаар бүх талын арга

хэмжээ авах, нэг ч хүүхдийг тамлан зовоож, хэрцгий харгислах, хүний ёсноос гадуур харьцах, нэр төрийг гутааж харьцах буюу шийтгэхгүй байх, 18 насанд хүрээгүй хүүхдийг үйлдсэн гэмт хэрэгт цаазаар авах буюу ямар нэг хөнгөлөлтгүйгээр бүх насаар нь гянданд хорих ял оногдуулахгүй байх, эрх чөлөөг хасахгүй байх, хүүхдийг баривчлах, албадан саатуулах, гянданд хорих явдлыг хуулийн дагуу гүйцэтгэх бөгөөд гагцхүү эцсийн арга хэмжээ болгож аль болох богино хугацаагаар хорихыг /37 дугаар зүйл/ үүрэг болгосныг өмгөөлөгчид мэдэж байх учиртай.

Энэ конвенц болон НҮБ-ын Насанд хүрээгүй хүмүүсийн талаархи байцаан шийтгэх ажиллагаа явуулах наад захын жишиг дүрмийг /1985 онд Ерөнхий ассамблейн 40/33 дугаар тогтоолоор батлагдсан/ үндэслэн Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 42 дугаар бүлэгт эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулах тусгай журмыг хуульчлан тогтоохдооо гэмт хэрэг үйлдсэн хүүхдийн эрх, эрх ашгийг хамгаалах талаар өмгөөлөгчийн үүрэг, оролцоог өргөтгөсөн болно.

Дээр дурдсан НҮБ-ын наад захын жишиг дүрмийн 13-т зааснаар "Шүүхээс өмнө цагдан хоригдож байгаа насанд хүрээгүй хүмүүс хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрэм, түүнчлэн Иргэний болон Улс төрийн эрхийн тухай олон улсын пактад түүний дотор 9 дүгээр зүйлийн 2, 6; 10 дугаар зүйлийн 2 /в/ болон 3 дахь заалтад дурдсан бүх эрх, баталгаа, түүнчлэн өмгөөлүүлэх, эрх зүйн туслалцаа авах эрхээр хангагдана."

Есд, НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн зөвлөлийн 1984 оны 1984/50 дугаар тогтоолоор батлагдсан "Цаазаар авах ял шийтгүүлсэн хүмүүсийн эрхийн хамгаалалтыг баталгаажуулах арга хэмжээнүүд" хэмээх бичиг баримтанд цаазаар авах ял оноож болох гэмт хэрэгт сэжиглэгдсэн буюу яллагдсан хүн шүүх таслах ажиллагааны бүх шатанд эрх зүйн зохих туслалцаагаар хангагдсан байна. Цаазаар авах ял шийтгүүлсэн хүн бүр дээд шатны шүүхэд давж заалдах гомдол гаргах эрх эдлэх бөгөөд энэ эрхийг нь заавал хэрэгжүүлэх арга хэмжээ авах шаардлагатай болохыг онцлон заажээ.

Арает, Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 18 дугаар зүйлд зааснаар хохирогч өөрийгөө өмгөөлөх, өмгөөлүүлэх, хууль зүйн бусад туслалцаа авах эрхтэй учраас "Гэмт хэрэг болон албан тушаалын байдлаа урвуулан ашигласны улмаас хохирогсдын талаархи хууль цаазын үндсэн зарчмын тухай" тунхаглалыг /НҮБ-ын Ерөнхий ассамблейн 1985 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 40/34 дүгээр шийдвэрээр батлагдсан/ тусгайлан авч үзье.

Гэмт хэргийн хохирогч гэдэгт гишүүн улсуудын дагаж мөрдөж байгаа эрүүгийн хуулийг зөрчсөн үйлдэл, эс үйлдлийн улмаас бие махбодийн болон оюуны гэмтэл учирсан, сэтгэл санааны дарамтад орсон, эд хөрөнгийн хохирол учирсан, эсхүл үндсэн эрх нь ноцтойгоор зөрчигдсөн бие хүн болон хамт олныг ойлгоно. Хохирогчийн гэр бүлийн гишүүд, тэжээн тэтгүүлэгчид, тэжээн тэтгэгч, хүнд байдалд орсон хохирогчид туслахаар эрмэлзэж буй бусад хүмүүс хохирогч байж болно.

Хохирогчдод анхааралтай хандаж нэр төрийг нь хүндэтгэнэ. Тэд шүүх, хуулийн байгууллагад хандаж учирсан хохирлоо үндэсний хууль тогтоомжийн дагуу даруй нөхөн төлүүлэх эрхтэй. Өмгөөлөгчид хохирогчийн энэ эрхийг хангахад үйл ажиллагаа чиглүүлнэ.

Арван нэгд. Женевт хуралдсан НҮБ-ын 1957 оны нэгдүгээр их хурлаар батлагдаж, Эдийн засаг, нийгмийн зөвлөлийн 1957 оны 7 дугаар сарын 31-ний өдрийн 663 ө /XXIY, 1977 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 2076 тогтоолоор сайшаагдсан **"Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрэм"** хэмээх баримт бичгийн онцгой хэлбэрт хэрэглэгдэх журмуудын 95 дугаар зүйлд "Баривчлагдсан болон ял сонсголгүйгээр хоригдож байгаа этгээдүүд Иргэний ба улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 9 дүгээр зүйлтэй харшилдахгүйгээр "С" бүлгийн 1-ийн II хэсэгт зааснаар хангагддаг.

Тийм хэмжээнд өмгөөллөөр хангагдана. "А" бүлгийн II хэсэгт холбогдох заалтууд нь ашиг тустай байж болох тохиолдолд хоригдож байгаа онцгой бүлгийн эдгээр этгээдийн хувьд хэрэглэгдэж болох бөгөөд тэдний хувьд засан хүмүүжүүлэх, дахин хүмүүжүүлэх зорилготой арга хэмжээнүүд авагдахгүй байх учиртай.

Өмгөөллийн болон хууль зүйн туслалцаа үзүүлэх үйл ажиллагаатай холбогдох дээр дурдсан олон улсын эрх зүйн хэм хэмжээнүүдийг задлан шинжлэх аргаар бичигдсэн энэ өгүүлэл мэргэжил, зорилго нэгтэй хуульч нөхдөд минь тус хүргэнэ гэдэгт найдаж байна.

-ooOoo-

ЭРХ ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛБАРЫН КАНОН /дүрэм, журам/

*Цагдаагийн Академийн ахлах багш,
цагдаагийн дэд хурандаа Н.Гантулга*

Эрх зүйн хэм хэмжээг тайлбарлах асуудал хууль зүйн шинжлэх ухааны онол, практикийн гол асуудал, судалгааны чиглэл байсан ба цаашид ч улам нарийвчлагдан судлагдах нь дэмжиггүй юм.

Монгол Улсын Үндсэн хуулийн нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, **хуулийг дээдлэх нь** төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим болохыг; арван долдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д Монгол Улсын иргэн **Үндсэн хууль, бусад хуулийг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлэх** үндсэн үүрэгтэйг; тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4-т Улсын дээд шүүх **Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талгаар албан ёсны тайлбар гаргах** бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр тус тус хуульчилсан билээ.

Ардчилсан төрийн суурь зарчмын нэг нь төрийн амьдралын бүхий л хүрээнд хуулийн ноёрхлыг тогтоон хэвшүүлэх явдал ба төрийн болон төрийн бус байгууллага, албан тушаалтан, иргэн, хэн бүхэн **хууль** тогтоомжийг зөв ойлгож, мэдэх нь уг зарчим хэрэгжих нэг гол нөхцөл болдог.

Хууль тогтоомжийг уншихад тэдгээрийн агуулга, утга санааг зөв, бүрэн дүүрэн, нэг мөр, шууд ойлгох боломж хязгаарлагдмал бөгөөд үүнд эрх зүйн хэм хэмжээг илэрхийлсэн бичвэрийн хийсвэр, ерөнхий хэллэг, хууль зүйн болон бусад тусгай нэр томъёо, тэрчлэн эрх зүйг хэрэглэгчийн эрх зүйн мэдлэг боловсрол, соёлын түвшин зэрэг объектив, субъектив олон хүчин зүйлс нөлөөлдөг.

Ер нь эрх зүйн хэм хэмжээний үгэн илэрхийлэл нь түүнийг ойлгох, тайлбарлах янз бүрийн хувилбарыг үүсгэх боломжтой учир хууль хэрэглэгчийн зүгээс **хуулийн** /зүйл, заалтын/ агуулга, утга санааг гуйвуулах, өөрийн дураар тайлбарлан хэрэглэх явдлыг гаргуулахгүй байх үүднээс улс орнуудад тайлбарын каноны /*canon of construction, canons of interpretation*-тайлбарын дүрэм/ боловсруулан мөрддөг. Энэ нь зарим улс орны хувьд хуульчлагдсан заавал хэрэглэгдэх журам¹, мөн заримд нь зөвлөмжийн шинжтэйгээр ашиглагддаг. Тайлбарын каноныг хамгийн ерөнхий утгаар нь тодорхойлбол тэрээр эрх зүйн сэтгэлгээний дүрэм мөн. Тэд эрх зүйн хэм хэмжээний актыг ойлгох, задлан шинжлэх нэгдсэн шалгуурыг тогтоож, хууль

¹ Тухайлбал: Англид энэ нь - Interpretation Act 1889. /1987/, Канадад – Canadian Interpretation Act 1967., Австралид – Australian Acts Interpretation Act 1901. Түүнчлэн АНУ-ын зарим мужуудад ч хэм хэмжээний ийм акт үйлчилдэг байна.

Энэ талаар дэлгэрэнгүйгээр дараахь бүтээлээс үзэж болно:

- Л.И.Люблинский, Техника, толкование и казуистика уголовного закона. Пг. 1917.
- К.Ильберт, Техника английского законодательства. Санкт-Петербург, 1907.
- А.К.Романов, Правовая система Англии. М., 2002.
- Жан-Луи-Бержель, Общая теория права. М., 2000.
- Джиффорд Д.Дж, Правовая система Австралии. М., 1988.

тогтоомжийн актад хэрэглэгдсэн үгэн илэрхийллийн /бичвэрийн/ агуулгыг нээн харуулах аргачлал нь болон үйлчилдэг.¹

Жак Дэвисийн тэмдэглэсэнчлэн тайлбарын канон хэдийгээр эрх зүйг хэрэглэх практик хэрэгцээнд тулгуурлан бий болсон боловч "илүүтэйгээр хуулийн төсөл боловсруулагчдад үнэтэй материал" болон ашиглагддаг байна.²

Учир нь тайлбарын канон хуулийн төсөл боловсруулах үйл ажиллагааг тодорхой журам, логикт захируулж цэгцтэй болгож өгдөг. Иймээс хуулийн төсөл боловсруулагчид, төслийг хэлэлцэн батлах эрх бүхий субъектууд хэрвээ тайлбарын каноныг баримтлавал батлагдсан хуулийг хойшид хэрэглэх, тайлбарлах үйл ажиллагаанд үүсч болох хүндрэл бэрхшээл багасдаг. Харин холбогдох этгээд төслийг боловсруулах, хэлэлцэн батлахдаа тайлбарын каноныг баримтлаагүй үед эрх зүйг хэрэглэгчид тэдгээрийг үйл ажиллагаандаа мөрдлөг болговол хууль тогтоогчийн санаа бодол /хууль, түүний хэм хэмжээтэй холбон тавьсан зорилт/ хуулийн бичвэрт илэрхийлэгдсэн утга санаа хооронд зөрөлдөөн үүсч үүний улмаас эрх зүйг хэрэглэх үйл ажиллагаанд эрх зүйн алдаа гарах нөхцөл бүрддэг.

Эндээс үзвэл хуулийг бүтээхэд баримтлах канон хууль зүйн техникийн бусад дүрмийн адил практик хэрэгцээ, эрх зүйн алдааг нэгтгэн дүгнэсэн судалгааны үндсэн дээр бий болсон тайлбарын каноны шууд тусгал, илэрхийлэл мөн.

Одоо Англо-Саксоны эрх зүйн бүлийн орнуудад хамгийн өргөнөөр хэрэглэгддэг тайлбарын канонноос жишээ татан авч үзье.

Ejusdem generis /нэг төрөл, зэрэг гэсэн латин үг/ - тодорхой зүйлийг нэрлэн тоочиж байснаа "эх зэрэг", "бусад" хэмээн нэгтгэсэн хэлбэрээр ерөнхийлсөн үгийг дурдсан зүйлийн нэг төрөл эсвэл адил шинжтэй байхаар тайлбарлана. Жишээ нь, эрүүл ахуй, ариун цэврийн гэрчилгээгүй жимс жимсгэнэ, хүнсний ногоо болон бусад бүтээгдэхүүн тээвэрлэхийг хориглоно гэсэн заалтын "бусад бүтээгдэхүүн" гэсэн ойлголтод үр жимс, ногооны төрөл болон хүнсний бүтээгдэхүүн хамаарахаас бус үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, багаж зэвсэг орохгүй. Мөн нохой, муур, үхэр, хонь болон бусад амьтан гэдгийн "бусад амьтан" гэсэн ойлголт зөвхөн гэрийн тэжээвэр амьтдыг хамаарч байгааг харж болно.

Гэхдээ нэгэн төрөл /зэрэг/-ийн ойлголт байна хэмээн үзэхийн тулд тухайн бичвэрт хоёр, түүнээс илүү адил шинж, төрлийн зүйл нэрлэгдсэн байх учиртай.

Pari materia /тухайн зүйлийн гэсэн латин үг/ канон - нэг болон түүнтэй зохицуулах зүйлийн хувьд адил төсөөтэй харилцаанд хамаарах статутууд нэгдмэл зөвшилцсөн утгаар тайлбарлагдахыг илтгэнэ. Жишээ нь, гэр бүлийн тухай хууль тогтоомжид төрсөн болон үрчлэгдсэн аливаа хүүхдийг "хүүхэд"

¹ Shapo, Helen S. et. al., Writing and analysis in the Law. 3rd ed., Westbury, New York, The Foundation Press, Inc., 1995., pp. 66.

² Davies, Jack. Legislative Law and process in a nutshell. West Publishing Co., 2nd ed., 1986., pp. 306.

гэсэн нэг л ойлголтоор авч үзэх ёстой юм. Харин нэр томъёог тусгай утгатайгаар ашиглахаар хуульд дурдсан бол дээрх канон үүнд хамаарахгүй.

Expressio unius, exclusio alterius /нэрлэн заасан нь бусдыг үгүйсгэнэ/ гэсэн латин үг/ хуулийн бичвэрт хэрвээ түүнд хамаарах зүйлүүдийг тоочин заасан бол дурдагдаагүй бусад нь үүнд хамаарахгүй. Жишээ нь, хуульд ажил хаях эрх хамаарахгүй ажилтны мэргэжлийн жагсаалтыг дурдсан бол тэрээр дэлгэрэнгүй тайлбарт "өртөх" ёсгүй.

Тайлбарын каноныг ашиглах явдал тэднийг шууд механикаар хуулбарлахыг илтгэх бус харин логик үндэслэгээг нь авахыг шаарддаг. Тэгээд ч канон дотроо янз бүрийн хувилбар, найруулгатай байдаг. Тухайлбал, *Ejusdem generis* - каноны хувьд авсан жишээн дээрх "бусад бүтээгдэхүүн" хэмээх ойлголтотод таримал цэцэг орох эсэх нь бас л тодорхой бус байна. Иймээс үүнтэй төстэй асуудлыг тохиолдол бүрт зөв шийдвэрлэхийн тулд каноносоо гадна хууль тогтоогчийн эрх зүйн тухайн акт, түүний хэм хэмжээтэй холбоосон зорилго, эрмэлзлийг харгалзах шаардлага гардаг ба үүнийг хууль зүйн шинжлэх ухаанд тайлбарын "телеологийн арга" гэдэг. Авсан жишээний хувьд хууль тогтоогч хүнсний баталгаагүй бүтээгдэхүүнээс хүн ам хордох явдлыг таслан зогсоохыг зорьсон уу эсвэл хор хөнөөлтэй, өвчтэй ургамал, үр жимс тээвэрлэх явдлыг таслан зогсоох зорилго тавьсан уу гэдгийг тодруулах шаардлага гарна.

АНУ-ын Эрүүгийн хууль ёс зүйд үл нийцэх "ном, хошин шог зураглал, зурагт хуудас, захидал, тэмдэглэл, фото зураг болон бусад зүйлийг" тээвэрлэн хүргэхийг хориглодог. Тэгвэл садар самуун дүрслэл бүхий дуу бичлэгийн кассетыг шуудангаар илгээх явдалд *Ejusdem generis* каноныг шууд механикаар хэрэглэвэл энэхүү үйл ажиллагааг хууль ёсны хэмээн тооцох боломжтой мэт ч харагдаж болох юм. Учир нь эрүүгийн хуульд дурдагдсан зүйлүүдийн нийтлэг байдал нь сонголд бус хараанд өртөгдөх шинжийг илэрхийлж байна. Гэвч АНУ-ын Дээд шүүх энэ төрлийн эрхийг хэлэлцэх явцад хууль тогтоогчийн тавьсан зорилгыг эрхэмлэн үзэж *Ejusdem generis* каноныг хэрэглэсэн байна.

Expressio unius канон - мөн өөрийн тодорхой хувилбартай. Жишээ нь, хуулиар баталгаажуулсан иргэдийн эрхийн жагсаалт хуульд бэхжигдэн тусгагдаагүй тэдний бусад эрхийг үгүйсгэж байгаагаар тайлбарлагдах ёсгүй. Харин төрийн засаглалын байгууллага, албан тушаалтанд олгогдсон эрх мэдлийн жагсаалт дэлгэрэнгүй тайлбарт өртөхгүй. Өөрөөр хэлбэл тэд хууль тогтоомжид тусгайлан хуульчлаагүй бусад эрхийг эдлэх боломжгүй.

Энэ бүгдээс үзвэл шүүх каноныг механикаар шууд хэрэглэх бус гагцхүү аргачлал, логик үндэслэгээ болгон ашигладгийг харж болно. Нөгөө талаас каноныг хэрэглэхэд баримтлах гол дүрэм бол хууль тогтоогчийн зорилго, эрмэлзэл давуу хүчинтэй байдаг явдал юм.

Англо-саксон, ром-германы болон эрх зүйн бусад бүлд хамаарагддаг улс орнуудад ч эрх зүйн хэм хэмжээг тайлбарлахад баримтлах эрх зүйн сэтгэлгээний дүрэм байдаг. Олон эрдэмтэн, судлаачид бүтээлдээ энэ талаар дурджээ. Тухайлбал, ОХУ-ын хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор

¹ Т.Я.Насырова Телеологическое толкование советского закона: Теория и практика. Казань. 1988.

А.Ф.Черданцев эрх зүйн хэл зүйн тайлбарын агуулгад хамаарах дараахь дүрмийн талаар бүтээлдээ дурджээ:¹

1.Эрх зүйн актад хэрвээ тодорхой үг хэллэгийг хэрэглэх утгыг зааж өгсөн бол зөвхөн тэр л хүрээнд нь ойлгож хэрэглэх;

2.Нэр томъёо, үг хэллэгийн албан ёсны тайлбарын утгыг баримтлах;

3.Хуулийн үг илэрхийллийг хэрвээ өөр тусгай утгаар хэрэглэх хангалттай үндэслэл үгүй бол ердийн хэвшиж заншсан нийтлэг утгаар авч хэрэглэх /англо-саксоны болон олон улсын эрх зүйд энэ дүрмийг "Golden Rule" хэмээн нэрлэдэг/;

4.Хуулийн заалтын үг хэллэгийг түүнийг баталсан цаг үеийн утгаар авч хэрэглэх;

5.Хуулийн зүйл заалт, үг илэрхийллийг өөр хоорондоо зөрөлдөх байдлаар бус, харин харилцан холбогдох, нийцэх утгаар тайлбарлах;

6.Тодорхой үг хэллэг, хуулийн заалтын агуулгыг бүхэлд нь тогтоохдоо эрх зүйн тухайн актын шинж чанар, зохиогчийн бичлэгийн хэв маягийг харгалзан үзэх;

7.Эрх зүйн тодорхой институтын /салбарын/ нэр томъёоны агуулгыг хангалттай үндэслэл нотолгоогүйгээр эрх зүйн бусад институт /салбар/-д хамруулан хэрэглэхээс татгалзах;

8.Хангалттай үндэслэл, нотолгоогүйгээр өөр, өөр нэр томъёонд нэгэн адил утгыг өгөхгүй байх;

9.Хуулийн бичвэр дэх тодорхой үг, тэмдэглэл илүү байхаар тайлбарлагдах ёсгүй;

10.Гадаадын үг, нэр томъёот тэдгээрийн эх хэлэнд хэрэглэгддэг утгаар ойлгон, тайлбарлаж хэрэглэх.

Эцэст нь тэмдэглэн хэлэхэд нийгмийн хөгжил интеграцчлалын нөлөөгөөр эрх зүйн бүлүүдийн ойртон нягтрах үйл явц өрнөж буйн зэрэгцээ /тухайлбал нийгмийн аюулгүй байдал, хүний эрх зэрэг салбар дахь зохицуулалтын нэгдсэн хэв маягийг үгүйсгэлгүй/ эдгээр бүлүүдэд мөн эрх зүйн соёл, сэтгэлгээний хэв маяг нь өөрийн агуулга, онцлогийг хадгалан хөгжиж байгааг ч анхаарах ёстой.

Иймээс Монгол Улс ром-германы, англо-саксоны болон бусад эрх зүйн бүлийн зохицуулалтын давуу талыг дотоодын эрх зүйдээ авч хэрэглэхдээ эрх зүйн соёл, сэтгэлгээ, үзэл баримтлалын онцлогоо харгалзан Үндсэн хуулийн болон бусад хуулиудын зарчим, нийтлэг хэм хэмжээндээ тохируулж байвал зохилтой.

-ooOoo-

¹ А.Ф.Черданцев, Толкование советского права. М. 1979., С. 35-37.

ЭРҮҮГИЙН ХУУЛЬД ТУСГАГДСАН НИЙГМИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЯЛ, ТҮҮНИЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ АСУУДАЛ

*ХЗҮТ-ийн Криминологийн судалгааны секторын
эрдэм шинжилгээний ажилтан Б.Билэгсайхан*

Хүн төрөлхтөн өөрийн хөгжлийн явцад хамтран амьдрах ёс жаяг, хэм хэмжээг зөрчсөн гэм буруутай этгээдийг цээрлүүлж ирсэн шийтгэлийн төрөл янз бүр байсан ба тэдгээр нь хүний нийгмийн хөгжлийг даган өөрчлөгдсөөр өдийг хүрчээ. Гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийг цээрлүүлэх аргыг хүмүүс бодож олсоны хамгийн түгээмэл хэлбэр нь “хорих ял” байжээ. Энэ нь гэмт хэрэгтнийг нийгмээс тусгаарлаж, иргэдийг халдлагаас хамгаалах, гэмт хэрэгтнийг залхаан цээрлүүлэх, хүмүүжүүлэх, хохирогчийн хариугаа авах хүсэл сонирхлыг ямар нэг хэмжээнд хангах зориулалттай ялын төрөл бөгөөд түүхийн хөгжлийн явцад хаягдаж гээгдэлгүй дэлхийн аль ч улсын ял шийтгэлийн системд голлох үүрэг гүйцэтгэсэн хэвээр байна.

Гэвч уг ялыг эдлүүлэхэд төрөөс зарцуулах өртөг зардал их, мөн төрөөс ялтныг суллагдсаны дараа нийгэмшүүлэх арга хэмжээ зайлшгүй авах шаардлагатай байдаг зэрэг сул талуудтай билээ. Тухайлбал, манай улсад хорих ял эдлүүлэхэд гарч байгаа зардлын таван жилийн дундаж нь 2732627,5 төгрөг болж байгаа бөгөөд энэ нь Архангай, Увс, Төв, Булган, Баян-Өлгий зэрэг 12 аймгийн бүтэн жилийн төсөвтэй, 2001, 2002 оны зардал нь томоохон 16 аймгийн жилийн төсөвтэй тэнцэх хэмжээний зардал зарцуулдаг.¹ Нэг хоригдлыг хорих ял эдлүүлэхэд шууд бус зардал 1441, шууд зардал 793 бүгд 2234 төгрөгний зардлыг хоногт зарцуулж байна. Тэгвэл сард 67020 төгрөгний зардал гарна, Өнөөдрийн байдлаар төрийн албан хаагчийн сарын дундаж цалин 65000 төгрөг байгаа гэж бодвол төрийн албан хаагчид бүтэн сарын турш улсынхаа төлөө, амьдралынхаа төлөө зүтгэж олдог мөнгийг төр гэмт хэрэг үйлдсэн ялтнуудыг ял эдлүүлсний төлөө зарцуулж байна.

Хэрэв ялтанд хорих ялыг эдлүүлээд дараа нь нийгэмшүүлэх арга хэмжээ авахгүй бол тодорхой хугацаагаар нийгмээс тусгаарлагдсан хүн тухайн нийгэмд дасан зохицох чадвар нь суларсан байдлаас дахин гэмт хэрэг үйлдэх, улмаар нийгэмд “өширхөх” үзэл тогтох магадлал ихээхэн өндөр байдаг. Энэ байдал нь хорих ялыг хэрэглэхийн зэрэгцээ түүний оронд сонгон хэрэглэхэд илүү зохистой, үр нөлөөтэй, өртөг зардал, үр дагавар багатай ялуудын талаар эрэл хайгуул хийхэд гарцаагүй хүргэдэг. Энэхүү эрэл хайгуулын үр дүнд бий болж олон улс оронд хэрэглэгдэж орчин үед ихээхэн анхаарал татаж байгаа ялын төрөл бол “Нийгэмд үйлчлэх” /community service/ ял юм.

Энэ ялыг Баруун Европын ихэнх орнуудад төдийгүй төв болон Зүүн Европын орнуудад өргөн хэрэглэдэг бөгөөд олон орон эхлээд туршилтын хэлбэрээр хэрэгжүүлж байсан. Тухайлбал, Финляндад 1991 онд анх туршиж үзсэн бөгөөд улмаар 1994 оны 4 дүгээр сарын 1-нд албан ёсоор хуульчилж хэрэглэсэн бол Бельгид мөн туршилтын хугацаагаар хэрэглэж байгаад 1993 оноос ялын нэг төрөл болгон хуульчилжээ.² Швейцарт энэхүү ялыг зөвхөн

¹ Төрийн мэдээлэл. УБ., 2003., № 44, 2003 оны төсвийн тухай хуулиас дээрх аймгуудын төсвийн тооцоог авав.

² Community sanctions and measures in Europe and North America. 2002., pp. 68.

насанд хүрээгүй гэмт хэрэгтнүүдэд хэрэглэж байсан бол 1990 оноос эхлэн тодорхой нөхцөл байдлыг харгалзан насанд хүрсэн гэмт хэрэгтнүүдэд оногдуулах болсон.¹

Манай улс 2002 оны 9 дүгээр сараас хүчин төгөлдөр үйлчилж буй шинэ эрүүгийн хуульдаа энэ ялын төрлийг "Албадан ажил хийлгэх" хэмээн нэрлэж анх хуульчилсан юм. Эрүүгийн хуулийн 50.1-д энэ хуульд заасан хугацаагаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлсон газарт нийгэмд ашигтай ажлыг цалин хөлс олгохгүйгээр 100-500 цагийн хугацаагаар хийлгэхийг хэлэх ба хөнгөн хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэн этгээдэд үндсэн ялын чанартай хэрэглэнэ гэжээ. Энэ ялын давуу тал нь гэмт хэрэгтнийг хорих газраас өөр газар илүү олон нийтэд ойр дөт орчинд ялыг эдлүүлэх, тодорхой хяналтын дор нийгэмд ашигтай хөдөлмөр эрхлэх боломжоор хангах, "шоронжих" сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлэхэд оршино.

Нийгэмд үйлчлэх ял нь нийгэмд ашигтай ажил хийх, гүйцэтгэсэн ажлын төлөө цалин хөлс олгохгүй байх, тодорхой хяналтын дор уг ажлыг гүйцэтгэх, хуульд заасан цагаар ажил хийх, уг ялаа эдэлж дуусах тодорхой хугацаатай байх зэрэг шинжийг агуулдаг.

Монгол Улсын эрүүгийн хууль, шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд албадан ажил хийлгэх ял /нийгэмд үйлчлэх ял/-ыг хуульчилсан байдлыг судалж үзвэл зарим анхаармаар дараахь зүйлүүд ажиглагдаж байна.

1. Эрүүгийн хуульд нийгэмд ашигтай ажил гэж ямар төрлийн ажил байх вэ, уг ялыг нийгмийн аль салбарт "эдлүүлэх" гэдгийг заагаагүй. Нийгэмд ашигтай ажил гэж юуг ойлгох вэ гэдгийг 135 шүүгч нарын дунд явуулсан санал асуулгын дүнгээс харахад: - Төрийн байгууллагын хийж гүйцэтгэж буй бүх ажил гэж 15 шүүгч, Нийгмийн эмзэг бүлэгт чиглэсэн нийгмийн халамжийн үйл ажиллагаа гэж 9 шүүгч тус тус хариулсан бөгөөд бусад шүүгч нь энэ талаар ямар нэг санал дүгнэлт гаргаагүй байна. Харин нийгмийн аль салбарт албадан ажил хийлгэх ялыг эдлүүлэх нь зүйтэй вэ гэсэн асуултад төрийн байгууллага, албан газарт гэж 50 шүүгч төрийн өмчийн үйлдвэрийн газарт гэж 50 шүүгч, аж ахуйн нэгжид гэж 24 шүүгч, төрийн бус байгууллагад гэж 13 шүүгч хариулсан байна. Шүүгчдийн саналыг дүгнэж үзвэл ялыг төр, төрийн байгууллагад эдлүүлэх нь зүйтэй гэсэн үзэл зонхилж байгаа юм. Бусад орны туршлагаас харахад энэ ялын төрлийг хувийн секторт төрийн байгууллагад эдлүүлнэ гэж тодорхой зааж өгдөггүй бөгөөд ялны хийж буй ажлын үр ашгийг нь тухайн нийгэм, орон нутгийн иргэд нь шууд хүртэж байхуйц ажил гэсэн утгаар ойлгож хэрэгжүүлдэг ажээ. Тухайлбал, цэцэрлэг, гудамж талбай цэвэрлэх, хот тохижилт, настай хүмүүсийн асрамжийн газар, байгаль орчныг хамгаалах ажил гүйцэтгэх г.м

2. Эрүүгийн хуулийн 50.1-д нийгэмд ашигтай ажлыг цалин хөлс олгохгүйгээр эдлүүлэхээр заасан боловч Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 96.6-д албадан ажил хийж буй ялтны цалин хөлсийг гэмт хэргийн улмаас учруулсан хохирлыг нөхөн төлөхөд суутгана гэж заасан нь хоорондоо зөрчилдөж байна. Нийгэмд ажилгүйдэл, ядуурал их байгаа өнөө үед алтан байтугай энгийн хүнд ажил олдохгүй байхад цалин хөлстэй ажиллуулахаар заасан нь амьдралд нийцэхгүй зохицуулалт болсон гэж үзэж байна.

¹ Community sanctions and measures in Europe and North America. 2002., pp. 542

Зөрчилдөж байгаа энэ хоёр хуулийн алийг нь хэрэглэх вэ гэсэн асуултад санал асуулгад хамрагдсан 135 шүүгчийн 61 нь буюу 45 хувь нь Эрүүгийн хуулийг, 19 буюу 14 хувь нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг хэрэглэх нь зүйтэй гэж хариулсан бөгөөд харин дээрх хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах талаар нэг ч шүүгч санал ирүүлээгүй нь энэ асуудлыг шийдвэрлэх талаар тодорхой байр суурь төлөөшөөгүй байгаагаар холбоотой болов уу.

Ялын зорилго нь иргэн, нийгмийг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг цээрлүүлэх, хүмүүжүүлэх, гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэхэд оршино.

Албадан ажил хийлгэх ял /ААХЯ/-ын цээрлүүлэх шинж нь хүний цалин хөлс авах, ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох зэрэг үндсэн хуульд заасан эрхийг нь хязгаарлаж байгаагаар илэрдэг. Гэтэл ялтан эрүүгийн хууль зөрчсөн үйлдлийнхээ төлөө төрөөр хийх ажлаа олуулаад цалингаа аваад хохирлоо төлөөд явах болж байна. Үүнийг ял гэж үзэж болох уу үгүй юу? Хэлбэр талаас нь харвал ял мөн боловч ялын хүмүүжүүлэх, гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, цээрлүүлэх гэсэн гурван зорилго биелэгдэхгүйд хүрч байна.

Мөн 1986 оны Эрүүгийн хуульд байсан "засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ял" нь ялтны ажлын хөлснөөс 10-25 хувийг суутгаж авдаг ялын төрөл байсан бөгөөд тухайн ялтан тодорхой эрхэлсэн ажилтай тохиолдолд тэр ажлын байранд нь ялыг нь эдлүүлдэг байсан. Гэмт хэрэгт холбогдсон хүмүүсийн дийлэнх нь ажилгүй байдгаас уг ялыг оногдуулах нөхцөлгүй болсон ба оногдуулсан ч тухайн албан газар, байгууллага нь ял шийтгүүлсэн этгээдийг ажиллуулах сонирхолгүйгээс ажлаас халж мөн л уг ял биелэгдэхгүйд хүрч байсан бодит шалтгааны улмаас 2002 онд Эрүүгийн хуулиас хасагдсан. Гэтэл "Албадан ажил хийлгэх ял" гэсэн үр нөлөө бүхий ялын шинэ төрлийг Эрүүгийн хуульд шинээр оруулж ирсэн ч Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд хэрэгжих нөхцөлгүйгээс Эрүүгийн хуулиас хасагдсан "засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ял"-тай ойролцоо байдлаар хуульчилж өгснөөс уг шинэ ял маань мөн л хэрэгжих нөхцөлгүй болох магадлал өндөр байна. Иймд уг 96.6-д заасан цалин хөлстэй холбоотой хэсгийг эргэн харж өөрчлөлт оруулах нь зүйтэй.

3. Хууль тогтоомжийн тодорхой хэм хэмжээнүүдийн уялдаа холбооноос гадна ялын гүйцэтгэлд хэн хяналт тавих ёстой вэ, үүнийг хэрхэн үр ашигтай зохион байгуулах вэ, нийгмийн ямар агентлаг хорих ялын оронд хэрэглэх өөр төрлийн ялын асуудлыг хариуцах вэ, ялтнуудыг хэрхэн хянах вэ, шийдвэр гүйцэтгэгч, зуучлагч, хянан харгалзах албан тушаалтан, олон нийтийн төлөөлөгч, нийгмийн ажилтны хэн нь хяналт тавих вэ, тэднийг хэрхэн сургах вэ, гэсэн олон асуудал дээрхи ялыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор тавигдаж байна. Бусад орны жишгийг авч үзвэл:

- Латвид нийгмийн үйлчилгээ гүйцэтгэж буй ялтнуудыг хянах чиг үүргийг орон нутгийн засаг захиргаанд шилжүүлсэн байдаг;

- Австрид энэ ялын хэрэгжилтэд прокурорын байгууллагын хүсэлтээр тусгай агентлаг хяналт тавьдаг. Энэ агентлаг нь нийгэмд үйлчлэх ялыг эдлүүлж буй байгууллагад зөвлөгөө өгдөг;¹

- АНУ-д "probation department" гэдэг байгууллагаас хяналт тавьдаг. Уг байгууллага нь цагтнуудад ажил олж өгөх, мөн тэдний ял эдлэлтэд хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллага юм;²

- Зимбабвийн Засгийн газар нь Хууль зүйн яамныхаа дэргэд хорих ялыг багасган, хоригдлуудын нөхцөлийг сайжруулах үүрэгтэй Үндэсний хороог байгуулсан. Үндэсний хороо тухайн ялыг орон нутагт зөв хэрэгжүүлэх явдлыг зохион байгуулах чиг үүрэгтэй орон нутгийн хороодыг байгуулжээ. Орон нутгийн хороодыг анхан шатны шүүхийн шүүгч даргалж гишүүдэд нь төрийн бус байгууллагын төлөөлөгчид, нийтийн нэр хүнд бүхий иргэдийн төлөөлөгчид, цагдаа, шүүх, хорих байгууллага, орон нутгийн захиргаа, нийгмийн үйлчилгээний байгууллагын төлөөлөгчид орсон байна. Уг хорооны гишүүн болох нь сайн дурын үндсэн дээр явагддаг бөгөөд гишүүдийн хэн нь ч уг ажлыг хийсний төлөө цалин хөлс авдаггүй байна.³

Харин манай улсад уг ялыг эдлүүлэхэд тавих хяналтын талаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 96.8-д хяналт тавих журмыг Улсын ерөнхий прокурортой зөвшилцөн хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтоохоор зааснаас өөр хяналтын талаар зохицуулсан заалт байхгүй байна.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2002 оны 276 дугаар тушаалаар баталсан "Албадан ажил хийлгэх ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг гүйцэтгэхэд хяналт тавих журам"-д энэ төрлийн ялын эдлэлтэд шийдвэр гүйцэтгэгч хяналт тавихаар зааж, харин албадан ажил хийлгэх ял эдлүүлэх аж ахуйн нэгжид цаг бүртгэх, ажлын хөлсийг суутган шийдвэр гүйцэтгэлийн дансанд тушаах, ялтны засрал хүмүүжлийн талаар тодорхойлолт гаргаж өгөх зэрэг үүргийг хариуцуулсан. Ажлын байр ховор байгаа өнөө үед байгууллага, аж ахуйн нэгж өөртөө эдгээр үүргийг гэрээний үндсэн дээр хүлээж, ялтыг өөрийн байгууллагад ажиллуулах асуудал хязгаарлагдмал байна. Иймд бусад оронд үр дүнтэй хэрэглэгдэж байгаа хяналтын тогтолцоог судалж, өөрийн оронд туршиж, нэвтрүүлэх шаардлагатай байна.

4. Эрүүгийн хуулийн 50.3-т албадан ажил хийх ялаас зайлсхийсэн ялтны эдлээгүй үлдсэн ялын 24 цагийг нэг хоног баривчлах ялаар тооцож сольж болохоор заасан. Энэ заалтыг дүгнэж үзвэл ялтанд албадан ажил хийлгэх ялаас зайлсхийгээд баривчлах ялаар солиулах нь хамаагүй хөнгөн тусч болох юм. /Баривчлах ялын ердөө л 4-20 хоногтой тэнцэж байна/ Жишээ нь, Бусдын эд зүйл хулгайлах гэмт хэрэг үйлдсэн этгээд 100 цаг албадан ажил хийлгэх ялаар шийтгүүлжээ гэж бодье. Тэгвэл тэр ялтан ял эдлэхээс зайлсхийсэн тохиолдолд ердөө л 4 хоног баривчлах ял эдлэхэд л хангалттай болж байна.

Манай өнөөгийн нийгэмд 72 цаг саатуулах, 3 хоног баривчлагдах явдал ердийн үзэгдэл мэт сэтгэлгээ байдаг. Түүнтэй адил тэр ялтан 4 хоногийн баривчлах ялыг жинхэнэ утгаар нь ял эдэлсэн гэж ойлгон, үйлдэлдээ дүгнэлт

¹ Community sanctions and measures in Europe and North America. 2002., pp. 28.

² Community sanctions and measures in Europe and North America. 2002., pp. 560.

³ "Нийгмийн үйлчилгээ" сэдэвт Бүх Африкийн 1997 оны хурлын оролцогчдод тараасан гарын авлагаас

хийж засрах нь юу л бол. Ялтан дахин гэмт хэрэг үйлдэх эсэх асуудал нь тухайн хүний сэтгэлгээ хэр өөрчлөгдсөн, ял түүнийг оюун санааг хэрхэн өөрчилсөнтэй шууд холбоотой байдаг учир ялтны сэтгэлгээг өөрчлөхөд гол нь анхаарах хэрэгтэй. Бусад орны туршлагыг судалж үзвэл Латвид албадан ажил хийлгэх ялаас зайлсхийсэн тохиолдолд албадан ажил хийлгэх ялын 8 цагийг хорих ялын нэг өдөртэй, Финляндад хорих ялын нэг өдөр албадан ажил хийлгэх ялын нэг цагтай тэнцэнэ гэж хуульчилсан байдаг.¹

Эрүүгийн хуулийн энэ заалтыг бусад орны жишигт дүйцүүлэн ажлын 8 цагийг баривчлах ялын нэг өдөртэй дүйцүүлж солих шаардлага зүй ёсоор гарч ирж байна. Үүнд мөн урьдчилан хоригдсон хоногийн нэг өдрийг албадан ажил хийлгэх ялын 24 цагтай тэнцэхээр заасныг хамруулан авч үзэх хэрэгтэй.

5. Эрүүгийн хуулийн албадан ажил хийлгэх ялыг 100-500 цаг эдлүүлэхээр заасан боловч энэ заасан ялыг ямар хугацаанд эдэлж дуусах ёстойг хуульчилж өгөөгүй. Үүнээс гарах үр дагавар нь албадан ажил хийлгэх ялыг ажлын байр байхгүй болон өөр бусад шалтгааны улмаас эдлэлгүй нэг жилийн хугацаа өнгөрөхөд "Эрүүгийн хуулийн 76.1.1-д хорихоос өөр төрлийн ял шийтгэгдсэн боловч нэг жил өнгөрсөн бол ялтны ялыг эдлүүлж болохгүй" гэсэн заалтын дагуу ялаас чөлөөлөгдөнө. Иймд Эрүүгийн хуульд албадан ажил хийлгэх ял эдэлж дуусах хугацааг хуульчилж өгөх шаардлагатай бөгөөд энэ хугацаанд ялаа эдлээгүй тохиолдолд зайлсхийсэн гэж үзэн хүнд төрлийн ялаар сольж байх нь эрүүгийн хариуцлага гарцаагүй байх зарчимд бүрэн нийцэх биз ээ.

Энэхүү нийтлэлээрээ манай улсын ял шийтгэлийн тогтолцоонд шинээр орж ирсэн албадан ажил хийлгэх ялын талаар хийсэн судалгаандаа үндэслэн бусад орны жишиг хандлагатай харьцуулан өөрийн орны хууль тогтоомжид байгаа дутагдалтай талыг арилгаж боловсронгуй болгох тал дээр өөрийн саналыг нэмэрлэж байна. Хэдийгээр манай улсын эрүүгийн хууль тогтоомжид энэ ял төдийлөн оновчтой хуульчлагдаагүй боловч ялын системд орж ирсэн нь том дэвшил бөгөөд цаашид уг ялыг олон улсын жишигт ойртуулан боловсронгуй болгох, иргэд, олон нийтэд энэ ялын үр дүн, ач холбогдлын талаар сурталчлах ажлыг эрчимтэй зохион байгуулах шаардлагатай юм.

-ooOoo-

¹ Community sanctions and measures in Europe and North America. 2002., pp. 194-198.

ОРОСЫН ХОЛБООНЫ УЛС ДАХЬ АВИЛГАЛЫН ӨНӨӨГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

*ОХУ-ын ДЯЯ-ны Удирдлагын академийн
адъюнкт, цагдаагийн хошууч О.Зоригт*

Авилгал буюу коррупцийн асуудалтай тулгараагүй улс орон манай гариг дээр бараг үгүй гэдэгтэй хэн ч маргахгүй биз ээ. Улс орон бүр өөр өөрийн үндэсний онцлогийг харгалзан энэ сөрөг үзэгдэлтэй тэмцэл хийж байна. Дэлхийн хүн амын зургааны нэг нь оршин суудаг өмнөд хөрш улс гэхэд л төрийн хатуу чанга бодлогын хүчээр зөвхөн авилгал ч биш олон сөрөг үзэгдлийн хавтгайран тархах явдлыг тодорхой төвшинд хязгаарлан барьж байгаа билээ. Хятад улсад авилгал, хээл хахуулийн хэрэгт холбогдсон төрийн албан хаагчдад цаазаар авах хүртэл маш хатуу шийтгэл ноогдуулдгийг бид мэднэ.

Сүүлийн жилүүдэд ОХУ-д гэмт хэргийн асуудал улам хурцдаж байна. Зах зээлийн өөрчлөлт шинэчлэлтийн замд бодитой саад учруулж байгаа авилгалын уршгаар гэмт хэргийн ертөнц хүчирхэгжих хандлагатай байгаа нь эрүүгийн нөхцөл байдал бүхэлдээ "тааламжтай бус" болох гол хүчин зүйл болж байна. Цөөнгүй тохиолдолд албан тушаалтнуудын шийдвэр төр, нийгэм, ард иргэдийн эрх, ашиг сонирхолд биш, тодорхой бүлэглэл, хувь хүмүүсийн гэмт зорилгод үйлчлэх болов. Судалгааны төрөлжсөн байгууллагуудаас "авилгалд төрд алба хашиж буй хүмүүсийн 40-70 хувь нь өртсөн байна /авилгалд хамрагдсан байна/" хэмээн дүгнэж бичих болов.

Хээл хахууль нь албан тушаалтнуудын үндэслэлгүйгээр баяжих төрийн болон аж ахуйн байгууллагууд, иргэдийн хоорондох материаллаг асуудлыг шийдэх, хууль бус үйл ажиллагаа явуулдаг бүлэглэлүүдийн гэмт зорилгодоо хүрэх, тохиолдож буй "хууль ёсны" саадыг арилгах үндсэн арга хэрэглүүр болон хувирчээ. Албан тушаалын нийт гэмт хэргийн дунд хээл хахуулийн гэмт хэрэг нэлээд өндөр, тухайлбал 1/3 хувийг эзэлж байгаагийн дээр цаашид улам өсөх хандлага ажиглагдаж байна.

ОХУ-д шинэчилсэн Эрүүгийн хууль үйлчилж эхэлсэн 1996 оноос хойш бүртгэгдсэн хээл хахуулийн холбогдолтой гэмт хэрэг 27 хувиар өсөж, 1997 онд 5608 байсан бол 2000 онд 7047 болов. 1992 оноос хойш сүүлийн 10 жилийн хугацаанд хээл хахуулийн холбогдолтой, бүртгэгдсэн гэмт хэргийн өсөлт 114 хувьд хүрчээ.

Хээл хахуулийн нийт гэмт хэргийн 6-12 хувийг зохион байгуулалттай, бүлэглэж үйлдсэн хэрэг эзэлж байна. Авилгалаар холбогдсон зохион байгуулалттай гэмт хэргийн бүлэглэлүүдийн тоо өсөх хандлагатай байна.

Олон нийтийн, бүс нутгийн "Индем сан"-гийн 2001 онд явуулсан судалгааны дүнгээс үзвэл ахуйн төвшинд эрх мэдэлтнүүдэд өгөх хахуульд зориулж ОХУ-ын иргэд жилдээ хамгийн багаар бодоход 2 тэрбум 96 сая ам.доллар зарцуулж байгаа бол ажил хэрэгч бизнесменүүдийн эрх мэдэлтнүүдэд жилдээ төлж байгаа мөнгөний нийт дүн нь 33,5 тэрбум ам.доллар байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн бүтцэд авилгалын эзлэх хувь /жишээлбэл хээл хахууль хэлбэрээр 0,24 хувь/ өндөр биш байгаа ч энэ нь авилгалын үнэн цар хүрээ, төвшний нотолгоо биш юм. Албан тушаалын гэмт хэргийн далд байдлын төвшин өндөр байдгаас хамааран хээл хахуулийн гэмт хэргийн бодит тоон үзүүлэлт хавьгүй өндөр байна. Авилгалтай холбоотой гэмт хэргүүдийн 0,1-2 хувь нь илэрч, бүртгэгддэг гэж судлаачид үздэг. Тэгвэл энэ төрлийн гэмт хэргийн бодит тоо нь 50-1000 дахин өндөр байна гэж бодвол зөвхөн ганц хээл хахуулийн гэмт хэргийн тоо л 2001 онд бүртгэгдсэн 3 сая гаруй нийт гэмт хэргийн тооноос 2 дахин давж гарна гэсэн үг. /ОХУ-д 2001 онд албан ёсоор нийт 3 сая 27 мянга гаруй гэмт хэрэг бүртгэгдсэн./

Авилгалын гэмт хэргийн үзүүлэлтүүдийн өсөлтийг хууль сахиулах байгууллагын ажилтнуудын мэргэжлийн үр чадвар, идэвхи дээшилснээр энэ гэмт үйлдэлтэй хийж буй тэмцлийн үр дүн дээшилж байна гэж холбон ойлгож харахан болохгүй. Харин эсрэгээр мэргэжлийн үр чадварын төвшин доогуур байгааг, мөн авилгалчдын нэгдмэл байдал, бие биенээ далдуур дэмжих явдал улам бүр бэхжиж буйг, бүхэлдээ авилгалтай тэмцэх улс төрийн хүсэл, зориг үгүй байгааг авилгалын гэмт хэрэгт холбогдосдын 20-26 хувь нь хорих ялаар шийтгэгдэж байгаа явдал нотолно. Тухайлбал, хахууль авч эрүүгийн хариуцлагад татагдсан төр, засгийн төлөөлөгчид 1998 онд 6, 1999 онд 8, 2000 онд 4 байна.

Авилгал хээл хахуулийн гэмт хэрэгт эрүүгийн хариуцлага хүлээсэн хүмүүсийн тоог илэрч, бүртгэгдсэн нийт тохиолдлын тоонд харьцуулсан харьцаа буурч байна. Жишээлбэл: 1998 онд ОХУ-ын хэмжээнд 5804 хээл хахуулийн гэмт хэрэг бүртгэгдэж, тэдгээрт 2656 хүн холбогдсоны 2012 нь эрүүгийн хариуцлагад татагдаж, үүнээс 1522 нь хорих ялаар шийтгэгджээ. 1999 онд 6823 гэмт хэрэг бүртгэгдэж, 2782 хүн холбогдсоноос 1982 нь эрүүгийн хариуцлагад татагдаж, үүнээс 1755 нь хорих ял шийтгэгдсэн. 2000 онд энэ төрлийн гэмт хэрэгт 1895 авилгалч холбогдож, зөвхөн 1475 нь эрүүгийн хариуцлагад татагдсан байна.

Авилгалтай тэмцэх улс төрийн хүсэл, зориг үгүй байгааг олон нийтийн санал асуулгын дүн ч давхар баталж байна. Асуулгад оролцогсдын тал хувь нь улс орны удирдлага авилгалтай тэмцэж чадна, гэвч хүсэхгүй байна, эсвэл хүсэх ч үгүй, чадах ч үгүй байна гэсэн бол 32 хувь нь улс орны удирдлага авилгалтай тэмцэхийг хүсэж байгаа ч чадахгүй байна гэж үзжээ.

Авилгалын нийгэмд үзүүлэх хор аюулын төвшний өсөлт, хуулийг үгүйсгэх үзэл, авилгалын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үлбэр, сул байдал зэрэг нь бүгд эндээс эхлэлтэй гэж болно. Түүнчлэн хууль сахиулах байгууллагуудаас мэргэжлийн чадварлаг ажилтнууд олноор халагдаж байгаа явдал ч сөргөөр нөлөөлж байна.

ОХУ 1996 онд Европын зөвлөлд элсэхдээ хүний эрх, үндсэн эрх чөлөөг баталгаажуулах, цаазаар авах ялыг үгүй болгох үүрэг хүлээсний дагуу мөн оны 8 дугаар сараас хойш ОХУ-д цаазаар авах ялыг гүйцэтгэхгүй байгаа нь их хэмжээний авилгалтай холбогдолтой гэмт хэргийн өсөлтөд ч нөлөөлж буйг үгүйсгэхгүй ээ.

Гэмт хэрэг өсөж, төр, засгийн байгууллагууд үр дүнгүй ажиллаж, нийгэм өмчийн хувьд ангиудад хуваагдаж, хүн амын ихэнх хэсгийн амьжиргааны төвшин доройтож, оюун санаа, ёс суртахуун, бүтээлч чанар

унаж, төр, засагт үл итгэх байдал өсөж байгаагийн хамт авилгалын төвшин өндөрсөж, цар хүрээний хувьд өргөжиж байгаа нь ОХУ-ын үндэсний аюулгүй байдалд аюул учруулж, засаглалын хомсдолд хүргэж, төр, засгийг сулруулж болох юм.

Одоогоос арваад жилийн өмнө зарим криминологч социализм нь авторитаризм эсвэл фашизмаар солигдоно гэж урьдчилан хэлж байжээ. Тэгвэл өнөөдөр авилгалын улмаас төр, засаг өөрөө авторитар болох буюу гэмт авторитаризмаар солигдох болоод байна. Барууны зарим судлаач ЗХУ задран унасан шалтгаанд төрийн сул дорой байдал, авилгалыг оруулдаг.

Дэглэм өөрчлөгдөн, өмч хувьчлагдаж, ОХУ гадаад харилцаанд эрчимтэй оролцох болсон, төрийн өмч, нөөц хуримтлалыг завшсан хувийн өмчтөний эдийн засаг бий болсон зэрэгтэй холбогдон улам задтайрсан авилгалын улмаас энэхүү уналт улам хурдасч эхэлсэн байна. Хэрэв энэхүү хандлага, чиглэл, таамаглал үнэн бол засаг унах магадлал улам ихэсч байна гэсэн үг.

Авилгалтай хийж буй тэмцэлд мэдэгдэхүйц нааштай өөрчлөлт гарахгүй бол, замбараагүй байдлыг эцэс болгож, улс оронд дэглэм, журам тогтоох, иргэдийн хангалуун амьдралын төвшинг хангах чиглэлээр төрөөс авч хэрэгжүүлж буй арга хэмжээг сулруулж, төрийн удирдлагын зохион байгуулалт алдагдахад хүрч болох юм. Нийгэм нэг бол хатуу тоталитар дэглэм тогтоох замаар Оросын төрийг хадгалж үлдэх, эсвэл авилгалчид засгийн эрхийг булаан авч иргэдийн эрх ашгийг хөсөрдүүлэх, хүн амтай хэрцгий харьцах, зарим хэсгийг нь боолчлох, гэмт хэрэгтнүүд болоод авилгалчдаас бүрэн хараат болох боломжтойг нотлон харуулж байна.

Авилгалтай хийх тэмцэл зөвхөн эрх зүйн бус, мөн улс төрийн агуулгатай байх ёстой. Төр, нийгэм, иргэдийг албан тушаалтнуудын авилгалын дарамтаас бодитой хамгаалах авилгалын эсрэг эрх зүйн шинэтгэл хийх шаардлагатай байна.

Авилгал зөвхөн Орос оронд байгаа үзэгдэл биш гэдгийг тэмдэглэн хэлэх нь зүйтэй.

Өнөөдөр дэлхий дахинд авилгал улс дамжсан шинжтэй болоод байна. Энэ нь олон улсын улс төр, эдийн засаг, санхүү, мэдээллийн үйл ажиллагааны олон талт удирдлагын механизм бий болсонтой холбоотой.

Дотоод улс төр, эдийн засгийн үйл ажиллагаанд нөлөө үзүүлэх замаар зарим улсын засаг, захиргаа авилгал хөгжих нөхцөлийг бүрдэхэд дэм болж байна. Тухайлбал, Оросын олон нийт таалан хүлээж аваагүй /непопулярный/ шинэтгэлд ОУВС-ын зөвлөхүүдээс үзүүлсэн идэвхитэй дэмжлэг нь бусдыг худалдаж авах бүх төрөл, чиглэлийг өөртөө агуулж байлаа.

Үүнтэй холбогдуулаад Орост авилгал огцом өссөний зарим бурууг барууны орнууд үүрэх учиртай юм. Яагаад гэвэл тэдгээр орны өндөр албан тушаалтнууд энэ үзэгдлийг үл тоомсорлож, албан бусаар авилгалын экспортыг зөвшөөрч байсан нь мэдээж хэрэг барууны тусгай албадын оролцоогүй байх аргагүй юм.

Дэлхий дахинд болж буй нэгдэн нягтрах үйл ажиллагаа авилгалын цар хүрээг тэлэх урьдчилсан нөхцөл болж байна. Нэгдэх үйл ажиллагааны явцад

авилгал хилээс хил нэвтрэн, олон улсын үзэгдэл боллоо. Улс хоорондын корпорациудын хууль бус үйлдэл олон орны ашиг сонирхол, тайван байдлыг хөндөх боллоо.

Бараа, бүтээгдэхүүн болон түүхий эдийн зах зээлийг өргөжүүлэх шаардлага нь сонирхсон нутаг дэвсгэртээ өөрийн чанаргүй бараа, бүтээгдэхүүнээ борлуулах зорилгоор төрийн албан хаагчдыг лоббидох, худалдаж авах тогтолцоог бий болгон бэхжүүлж, нэмэгдүүлж байна.

Эдгээрийг харгалзан сүүлийн жилүүдэд дараахь олон улсын эрх зүйн баримт бичиг батлагдсан байна. Үүнд:

-“Гэмт үйл ажиллагаанаас олсон орлогыг илрүүлэх, хураах тухай” Страсбургийн конвенц /Европын зөвлөлийн конвенц №141, 1990.11.3/;

-“Олон улсын худалдааны гэрээ, хэлцэл хийх үед гадаад орны албан тушаалтнуудыг худалдан авахтай тэмцэх тухай” конвенц /1997.11.21/;

-“Авилгалд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын тухай” Страсбургийн конвенц /Европын зөвлөлийн конвенц №173, 1999.1.27/;

-“Авилгалтай тэмцэх тухай” үлгэрчилсэн дүрэм /ТТУХН-ийн орнуудын парламент хоорондын ассамблейн шийдвэр, 1999.4.3/;

-“Улс дамжсан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг Палермогийн конвенц, /НҮБ-ын конвенц, 2000.12.15/.

Орчин үеийн Орос орны гэмт хэргийн ертөнц төртэй илээр өрсөлдөж байна. Улс орны нөхцөл байдалд тавьж буй эрх зүйн хяналт суларч, гэмт бүлэглэлүүд хууль тогтоох болон гүйцэтгэх засаглалтай сүлбэлдэж, банк, том үйлдвэр, худалдааны байгууллагууд, бараа, бүтээгдэхүүний гол сүлжээнүүдийн удирдлагад нэвтрэн орж байгаа зэрэг нь үүнийг гэрчилнэ.

ОХУ дэлхийн эдийн засагт тэр тусмаа олон улсын зээл, санхүүгийн сүлжээнд өргөнөөр татагдан оролцох болсон. ТТУХН-ийн зарим оронтой харилцан хамтын ажиллагаа өргөжсөн зэрэг нь авилгалчдын нэгдэл, нягтрал, тэдний гэмт үйлдлийн нийгмийн хор уршгийг бодитойгоор нэмэгдүүлж байна.

Энэ нь авилгалтай тэмцэх чиглэлээр дэлхийн улс орнууд хоорондоо улам бүр нягт хамтран ажиллахыг шаардаж байна. Олон улсын эрх зүйн хэм хэмжээнд тохиромжтой механизмыг бий болгож, бэхжүүлэхгүйгээр энэ хамтын ажиллагаа үр дүнтэй болж чадахгүй юм.

ХУУЛЬЧДААС ӨНДӨР ТӨВШИНД СОНГОН ШАЛГАРУУЛНА

ХЗДХЯ-ны мэргэжилтэн, хууль зүйн магистр Т.Төгсжаргал

Улсын Их Хурлаас Хуульчдаас сонгон шалгаруулах тухай хуулийг 2003 оны 5 дугаар сарын 23-нд батлан гаргасан юм. Энэ хууль нь шүүгч, шүүхийн шийдвэр гүйцэтгэгчийн албан тушаал эрхлэх сонгон шалгаруулалтад оролцох, өмгөөллийн болон нотариатын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авах, прокурор, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчаар ажиллах хуульчдыг сонгон шалгаруулахтай холбогдолтой юм.

Монгол Улс гадаад, дотоодод хуульч мэргэжилтэн бэлтгэж эхэлснээс хойш одоогоор нийтдээ 8 мянга гаруй хуульчтай болсон бөгөөд улсын хэмжээнд сүүлийн жилүүдэд хууль зүйн сургалт эрхэлдэг их, дээд сургуулийг эрх зүйч мэргэжлээр 2 мянга гаруй хүн төгсөж байна. Цаашид ч эрх зүйч мэргэжилтэн жил бүр нэмэгдэх нь ойлгомжтой. Энэ нь хууль, эрх зүйн мэдлэг, боловсрол эзэмшигчид өсөж байгаа ч, нөгөө талаар мэргэжлийн боловсон хүчний бодит хэрэгцээ шаардлагын үүднээс үзвэл "ажилгүй хуульч"-дын эгнээ өргөжих сөрөг байдал бий боллоо. Иймд гадаадын бусад орны туршлагад тулгуурлан хуулийн чиглэлийн сургууль төгсөгч бүрт шууд хуульч мэргэжил олгох уу гэсэн асуулт тулгарч, түүнийг шийдвэрлэх арга замыг өөрчлөх хэрэгтэй болсон юм.

Иймд гадаадын хэд хэдэн орны туршлага судаллаа. Тухайлбал, Германд хоёр даваатай шалгалтын системтэй. Хоёрдахь нь жинхэнэ хуульч мэргэжил олгох шалгалт өгнө. Тэр нь ихээхэн хатуу шалгуурыг давдаг байна. АНУ-д "Бар"-ын систем гэж бий. Энэ нь хуулийн сургууль төгсөөд тодорхой хугацаанд ажилласны дараа "Бар"-ын гэх тусгай шалгалт өгөөд тэнцсэн нь мэргэжлийн хуульч болдог. Францад магистрантур гэсэн сургалтын системтэй, энэ нь хуулийн мэргэжил эзэмшүүлэхэд дагнаж мэргэшүүлдэг. Жишээлбэл, шүүгч болоход заавал шүүхийн магистрантур төгссөн байх шаардлагатай. Итали улсад тусгай шалгаруулалттай, хуулийн чиглэлийн албанд томилогдохын өмнө заавал тэр шалгаруулалтад орж тэнцсэн байх ёстой зэрэг олон хувилбар байна. Энэ бүхнийг нарийн судалж үзсэний үндсэн дээр манайх хуульчдаас сонгон шалгаруулалт хийх холимог хувилбарыг сонгосон юм.

Хуульд заасны дагуу сонгон шалгаруулах ажлыг эрхлэн гүйцэтгэх орон тооны бус Зөвлөл байгуулагдаж, уг Зөвлөлийг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Төрийн нарийн бичгийн дарга тэргүүлэх ба бүрэлдэхүүнд нь Төрийн албаны зөвлөлийн орон тооны гишүүн, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга, Монголын өмгөөлөгчдын холбооны Ерөнхийлөгч, Монголын Нотариатчдын танхимын Ерөнхийлөгч, прокурор, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, цагдаагийн байгууллагын хүний нөөцийн асуудал эрхэлсэн нэгжийн дарга нар орохоор хуульчлагдлаа. Зөвлөлийн тогтоолоор Зөвлөлийн ажиллах журам, Хуульчдын сонгон шалгаруулалтын тухай журам, Хуульчдаас сонгон шалгаруулахтай холбогдон үүссэн маргааныг шийдвэрлэх журам батлагдаж, сонгон шалгаруулалтыг хэрхэн зохион байгуулах талаар холбогдох заавар боловсруулан ажиллаж байна.

Сонгон шалгаруулах асуудлаар АНУ-ын Шүүх эрх мэдлийн шинэтгэлийн хөтөлбөрийн зохицуулагчидтай уулзж, туршлага солилцох, зөвлөгөө болон санхүүгийн дэмжлэг авах зэрэг чиглэлээр хамтарч ажиллахаар тохиролцож, шалгалтын төстийн хэсгийг дүгнэх машин АНУ-аас авчруулаад байна. Тус хөтөлбөрийн зохицуулагчид урьд нь Гүрж болон бусад хэд хэдэн улсад хуульдын сонгон шалгаруулалтыг зохион байгуулах ажилд оролцож, зөвлөгчөөр ажиллаж байсан туршлагатай мэргэжилтнүүд юм. Иймд сонгон шалгаруулалтын даалгаврын нууцлалыг хэрхэн хадгалах, ямар байдлаар явуулах зэрэг асуудлаар зөвлөгөө авч журам, заавартаа тусгалаа.

Хуульд сонгон шалгаруулалтад оролцох нэг оролцогчид нэгдөх зардлыг оролцогч өөрөө хариуцах ба зардлын хэмжээг Хууль зүй, дотоод хэргийн сайд, Санхүү, эдийн засгийн сайдын хамтарсан тушаалаар батална.

Сонгон шалгаруулалтыг зохион байгуулах шалгалтын хороог шүүх, прокурор, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон өмгөөллийн байгууллагад ажиллаж байгаа хуульч, эрх зүйн салбарын багш, эрдэмтдийн бүрэлдэхүүнтэйгээр байгуулна. Шалгалтын хорооны бүрэлдэхүүнийг хуульчдаас сонгон шалгаруулах зөвлөл шалгаруулалт явуулах бүрт томилох бөгөөд шалгагчдын нэрсийн жагсаалт нь сонгон шалгаруулалт явуулах өдөр, цаг хүртэл нууц байна. Хуульд заасны дагуу сонгон шалгаруулалтыг эрх зүйн хүрээнд тодорхой өгөгдлийг хууль хэрэглэж шийдвэрлэх бодлого тест болон ярилцлагын хэлбэрээр авна. Тэнцсэн хүнд гэрчилгээ олгоно.

Сонгон шалгаруулалтыг бүсчилсэн хэлбэрээр явуулна. Үүнд: Баруун бүс /Баян-Өлгий, Увс, Ховд, Завхан, Говь-Алтай/ Хөвд аймгийн төвд, Хангайн нэгдүгээр бүс /Хөвсгөл, Орхон, Булган, Дархан-Уул, Сэлэнгэ/ Орхон-Уул аймгийн төвд, Хангайн хоёрдугаар бүс /Архангай, Баянхонгор, Өвөрхангай/ Архангай аймгийн төвд, Төвийн бүс /Улаанбаатар хот, Төв, Говь-Сүмбэр аймаг/ Улаанбаатар хотод, Зүүн бүс /Хэнтий, Дорнод, Сүхбаатар/ Дорнод аймгийн төвд, Говийн бүс /Дундговь, Дорноговь, Өмнөговь/ Өмнөговь аймгийн төвд тус тус явагдана.

2003 оны сонгон шалгаруулалтад оролцох оролцогчдын багцаалсан тоог гаргах зорилгоор яам, агентлаг, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газарт албан тоот илгээж, одоо ажиллаж буй хуульч боловсон хүчний судалгааг гаргуулж байна. Ер нь сонгон шалгаруулалтад Монгол Улсад болон гадаад улсад эрх зүйн чиглэлээр суралцаж, бакалаврын болон түүнээс дээш зэргийн диплом эзэмшсэн, цагдаагийн байгууллагаас ял шийтгэлгүй нь тогтоогдсон хүн оролцох эрхтэй юм. Түүнчлэн Хуульчдаас сонгон шалгаруулалтын журамд дурдсан баримт бичгийг бүрдүүлсэн байх ёстой. Мөн Хуульчдаас сонгон шалгаруулах тухай хууль хүчин төгөлдөр болохоос өмнө буюу 2003 оны 6 дугаар сарын 27-оос өмнө ажиллаж байгаа шүүгч, прокурор, өмгөөлөгч, нотариатч, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нар энэ сонгон шалгаруулалтад оролцохгүй. Тэдгээрт Сахилгын болон мэргэжлийн хорооноос гаргасан ажил хэргийн ур чадвар, мэргэжлийн түвшингийн үнэлгээ, дүгнэлтийг нь үндэслэн шууд гэрчилгээ олгоно.

Хуульчдаас сонгон шалгаруулалттай холбогдуулан сургалт, семинар зохион байгуулах, гарын авлага материал бэлтгэх зэрэг өргөн хүрээтэй ажлыг дэс дараатайгаар ХЗДХЯ, Хууль зүйн үндэсний төвтэй хамтран зохион байгуулж байна.

НОТАРИАТ АЛИВАА БАРИМТЫН ҮНЭН ЗӨВИЙГ ГЭРЧИЛДЭГ

Монголын Нотариатчдын танхимын
Хэвлэл мэдээллийн албаны ажилтан П.Уянга

Хууль зүйн сайдын 1997 оны 147 дугаар тушаалаар баталсан "Нотариатын үйлчилгээний хөлс, зардлын жишиг"-ийг мөрдөж ажилласнаар 6 жил болсон. Энэ хугацаанд зах зээлийн харилцааг дагаж бусад үйлчилгээний үнэ, тариф хэд дахин өссөнтэй холбогдуулаад Нотариатын үйлчилгээний хөлс зардлын жишгийг өөрчлөх зайлшгүй шаардлага гарсан билээ. Өнгөрсөн 6 жилийн хугацаанд хэрэглэж ирсэн практикт үндэслэн үйлчилгээний хөлс нь хэт өндөр, хэт бага бус бодитой байх зарчмыг баримтлан нотариатын үйлчилгээний хөлс, зардлын жишгийг шинэчлэхээр төсөл боловсруулан ХЗДХЯ-нд хүргүүлсэн юм.

Хот, хөдөөгийн аль ч нотариатчийн өдөр тутмын үйлчилгээний ихэнх хувийг эзэлдэг, бичиг хэргийн ажилд чамгүй зардал гаргадаг хэрнээ үйлчилгээний хөлс нь харьцангуй хямд итгэмжлэл, бичиг баримтын хуулбар зэрэг зарим төрлийн үйлчилгээний хөлсийг тодорхой хэмжээгээр нэмэх нь зүйтэй гэж үзсэн. Баримт бичгийн хуулбарын үнэн зөвийг гэрчлэх үйлдэлд хариуцлагын асуудал хамгийн чухал байдаг. Баримт бичгийн хуулбарын үнэн зөвийг тогтоолгүй гэрчилснээс нотариатчийн нотариатын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсон тохиолдол цөөнгүй бий. Хуурамч төрсний гэрчилгээ, иргэний үнэмлэх зэрэг баримт бичиг гэрчлэгдэж нотариатын нэр хүнд унах, шүүхэд буруу нотолгоо гаргах явдал ихсэж байгаагаар холбогдуулан нотариатчдын ажилдаа анхааралтай ажиллах шаардлагын улмаас баримт бичгийн хуулбарын хөлсийг нэмэгдүүлсэн.

Нотариатчдын ажлын ачаалал, орлогыг ямар нэгэн байдлаар жигдрүүлэх, үйлчлүүлэгчийн зарим санал хүсэлтийг хэрэгжүүлэх үүднээс үл хөдлөх болон хөдлөх эд хөрөнгөтэй холбоотой тодорхой төрлийн баримт бичгийг гэрчлэх үйлчилгээний хөлсийг зохих хэмжээгээр бууруулах нь зүйтэй гэж үзсэн болно. Тухайлбал үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн гэрчилгээ гэрчлэхэд 5000 байсныг бууруулж 2500 төгрөг болгов. Өв залгамжлал, гэрээсэл, гэр бүлийн гишүүдийн дундаа хамтран өмчлөх эд хөрөнгөөс оногдох хувиа өмчлөх эрх, үл хөдлөх эд хөрөнгийг өмчлөх эрхийг шилжүүлэхтэй холбоотой гэрээ, хэлцэл, барьцааны гэрээ, лизингийн гэрээ зэрэг тодорхой үнийн дүн, төлбөрийн хэмжээ бүхий бүх төрлийн гэрээ, хэлцлийг гэрчлэх үйлчилгээний хөлсийг 5 шатлалд хуваан бууруулахдаа нэгдүгээрт үйлчилгээний хөлс өндөр гэсэн гомдлыг багасгах, хоёрдугаарт тухайн үйлчилгээний хөлс нь их учраас нотариатч, үйлчлүүлэгч хоёр тохиролцон бууруулж жишиг зөрчдөг дутагдлыг таслан зогсоох зорилт тавив.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2003 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 192 дугаар тушаалаар шинээр боловсруулсан "Нотариатын үйлчилгээний хөлс, зардлын жишиг" батлагдан 2003 оны 11 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдөгдөж байна.

Энэ шинэ жишигт зарим үйлчилгээний хөлсийг бага хэмжээгээр нэмсэн, зарим үйлчилгээний хөлсийг бууруулснаас өөр зарчмын томоохон өөрчлөлт оруулаагүй юм. Жишигтэй холбогдуулаад зарим тайлбарыг хийх нь зүйтэй юм. Итгэмжлэл, түрээсийн болон хөлслөх гэрээ нь жилд гэсэн ойлголт

байхгүй болсон. Тухайлбал: Итгэмжлэл 2000 төгрөг, итгэмжлэлийн ерөнхий хугацаа хуулиараа 3 жил байдаг бөгөөд энэ хугацаандаа багтааж итгэмжлэлийн үйлчилгээний хөлс 2000 төгрөг байна.

Үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээ, газар өмчлөх, ашиглах, эзэмших эрхийн гэрчилгээ, ашигт малтмалын хайгуул ба олборлолтын лиценз, аж ахуйн нэгжийн бүртгэлийн гэрчилгээ, тээврийн хэрэгслийн гэрчилгээ зэрэг үл хөдлөх болон хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийг нотлох бүх төрлийн бичиг баримтын хуулбарыг гэрчлэх үйлчилгээний хөлсийг 2500 төгрөг болголоо. Өөрөөр хэлбэл үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн гэрчилгээ 5000 төгрөгөөр, газар эзэмших эрхийн гэрчилгээг 100 төгрөгөөр гэрчилдэг байсан бол одоо шинэ жишгээр өмчлөх эрхийг нотлох бүх төрлийн бичиг баримтын хуулбар гэрчлэхэд дундажааад 2500 төгрөг болсон. Хадгаламжийн дэвтэр, бууны үнэмлэх зэрэг нь өмчлөх эрхийг нотолсон баримт бичиг гэдэгт орно. Дээрхи баримт бичгийг зөвшөөрөгдсөн хэмжээнээс илүү хувиар гэрчлүүлэхийг үйлчлүүлэгч хүсвэл хөлсийг хуудас тутмаас 200 төгрөг авах юм.

Зөвшөөрөгдсөн хэмжээ гэдэг нь гэрээний хувьд эрхийн улсын бүртгэлийн албанд бүртгүүлэх гэрээ 4 хувь, бусад гэрээг 3 хувь гэрчлэх ёстой. Бичиг баримтын хуулбарын хувьд 1 хувь байх юм. Гэхдээ тухайн гэрчилгээг үйлчлүүлэгч хүсвэл 3 хувиас илүүг гэрчлэхгүй. Өөрөөр хэлбэл 2500 төгрөгөөр нэг хувийг гэрчлээд үйлчлүүлэгч илүү гэрчлүүлэхийг хүсвэл илүү 2 хувь гэрчилж өгөх бөгөөд хуудас тутмаас 200 төгрөгийн хөлс нэмж авна. Дээрхи өмчлөх эрхтэйг нотлох бүх төрлийн баримт бичгийг гэрчлэхдээ баримт бичгийн хуулбарын дэвтэр дээр бүртгэж, хуулбарын тамга дарна. Баримт бичгийн хуулбар болон гэрчлэгдсэн баримт бичгийн хуулбар гэрчлэхэд хуудас тутмаас 400 төгрөг авахаар болж нэмэгдлээ.

Хуудас тутмаас гэдгийг нэг нүүрийг нэг хуудас гэж ойлгоно. Тухайлбал, нэг хуудас цаасан дээр иргэний үнэмлэхний урд ба ар талыг хувилж гэрчлэхэд 400 төгрөг, нэг хуудас цаасан дээр 3 ширхэг иргэний үнэмлэх хувилж гэрчлэхэд тус бүрт нь дугаар авч, баталгааны тэмдэг, тамга дарж тус бүрээс нь үйлчилгээний 1200 төгрөгийн хөлс авна. Цаашид нэг цаасан дээр олон тусдаа бичиг баримтыг хувилж, гэрчлүүлж байгаа тохиолдолд тус бүрт нь дугаар авч, тус бүрт нь баталгааны тэмдэг, тамга дарж тус бүрээс нь хөлсөө бодож авахыг анхааруулж байна. Олон баримт бичиг нэг дор гэрчлүүлэхэд тус бүрт нь дугаар аваагүйгээс тэдгээр бичиг баримтын зөвхөн нэг нь хуурамч байхад тэр бүртгэлийн дугаарт бүртгэгдсэн баримт бичгийг хүчингүй болгохдоо бусад баримт бичгийг давхар хүчингүй болгосон тохиолдол манай нотариатчдын үйл ажиллагааны практикт гарсан.

Дипломын хувьд ар, өвөргүй хавсралттайгаа нэг дугаар авч, тус бүрт нь тамга, баталгааны тэмдэг дарж, тус бүрээс нь хөлсөө авна. Их сургуулийн диплом ар, өвөргүй, хавсралттайгаа 3 нүүр болох бөгөөд 1200 төгрөгийн хөлс авч нэг дугаарт бүртгэнэ. Нотариатын тухай хуульд зааснаар нотариатаар гэрчлэгдсэн бүх баримт бичгийн хувь архивт үлдэх ёстой боловч нотариатчид баримт бичгийн хуулбарыг гэрчлэхдээ архивын материал авч үлддэггүй. Тийм учраас бүртгэлээ маш тодорхой, дэлгэрэнгүй, бүртгэлээс харахад бүх зүйл ойлгомжтой байхаар /нэр, хаяг, улсын бүртгэлийн дугаар, олгосон он, сар, өдөр/ дараа нь өөрсдийгөө хамгаалахад баримт болж чадахаар бүртгэж байх нь зүйтэй байна. Тэр ч байтугай тухайн гэрчилгээ нь усанд норсон баяв,

өнцөг нь урагдсан байв гэх мэтчилэн онцгой, илэрхий байдлыг нь бүртгэлд тэмдэглэхэд илүүдэхгүй.

Нотариатын үйлдэл эрхлэн хийх зааврын 6 дугаар зүйлд заасны дагуу нотариатч баримт бичгийн хуулбарыг эх хувьтай тулган шалгаж, түүний үнэн зөв гэдгийг гэрчлэх ёстой. Хуурамчаар тамга, тэмдэг дарж, гарын үсэг зурсан албан бичиг, бусад баримтуудыг үнэн зөв гэдгийг нь тогтоолгүй гэрчилж болохгүй.

Өв залгамжлал, гэрээслэл, гэр бүлийн гишүүдийн дундаа хамтран өмчлөх эд хөрөнгөөс оногдох хувиа өмчлөх эрх, үл хөдлөх эд хөрөнгийг өмчлөх эрхийг шилжүүлэхтэй холбоотой гэрээ, хэлцэл, барьцааны гэрээ, лизингийн гэрээ зэрэг тодорхой үнийн дүн, төлбөрийн хэмжээ бүхий бүх төрлийн гэрээ, хэлцэл гэрчлэхдээ нэг сая хүртэл төгрөгийн үнийн дүнгээс 0.5 хувиар, нэг саяас давсан тохиолдолд жишгийн 1.6.2-д заасан шатлалаар авна. Өмнө нь барьцааны гэрээг тусад нь 0.1 хувиар тооцож гэрчилдэг байсан бол шинэ жишгээр ингэж ялгахгүй юм.

Арилжааны гэрээг гэрчлэхдээ аль нэг үл хөдлөх эд хөрөнгө байгаа тойргийн нотариатч гэрчлэх бөгөөд үйлчилгээний хөлсийг 2 үл хөдлөх эд хөрөнгийн үнийг нэмж хоёрт хуваагаад жишгийн 6-д заасан шатлалаар авна.

Гэр бүлийн гишүүдийн орон сууцны өмчлөлөөс хамтран өмчлөгч хасагдах, нэмэгдэх хэлцлийг үнэ тодорхойгүй хэлцэлд оруулаад үйлчилгээний хөлс 3000 төгрөгөөр тооцож авна. Нэг дор гэрчлүүлбэл 3000 төгрөг, тус тусдаа ирж гэрчлүүлбэл тус бүр нь 3000 төгрөгөөр тооцож үйлчилгээний хөлс авна.

"Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээ"-нд үнэ бичдэггүй болсон тул бэлэглэлийн гэрээний маягыг бөглөхдөө тэдэн төгрөгийн үнэтэй эд хөрөнгийг хариу төлбөргүй бэлэглэж байна гэдэг заалт дээр үнийг бичүүлэх нь зүйтэй байна. Ингэхдээ иргэдээс эд хөрөнгөө анх бүртгүүлэхдээ бөглөдөг мэдүүлгэн дээрхи үнийг тавина гэж ойлгуулах хэрэгтэй юм.

Зарим банк, банк бус санхүүгийн байгууллага нь зээлийн болон барьцааны гэрээтэй хавсарган зээлдэгч зээлээ төлж чадахгүй бол түүний өмнөөс түүний учруулсан хохирлыг арилгуулахын тулд гуравдагч этгээдээр батлан даалт гаргуулсан батлан даалтын гэрээ /тухайн зээлийг төлж чадахгүй бол би хариуцна гэсэн утгатай/-г хийх болсон. Энэ нь хэдийгээр тухайн зээлтэй хамаатай боловч батлан даалтын гэрээг тусад нь дугаар өгч тусад нь гэрчилнэ. Ингэхдээ хуулийн дагуу батлан даагчийг байлцуулж, гарын үсэг зуруулж, гэрээний үр дагаврыг тайлбарлан өгсний үндсэн дээр журмын дагуу гэрчлэх бөгөөд үнэ тодорхойгүй гэдгээр 3000 төгрөгийн үйлчилгээний хөлс авна.

Гадаад оронд байдаг хамтран өмчлөгчдийн зөвшөөрлийг нотариатын үүрэг гүйцэтгэгч болох тухайн оронд оршин суугаа Дипломат төлөөлөгчийн болон консулын газар буюу тухайн орны нотариатаар гэрчлүүлсэн тамга, тэмдэг нь эх хувиараа дарагдсан баримт бичгийг хүчин төгөлдөр гэж үзнэ. Харин тамга, тэмдэг нь эх хувиараа дарагдаагүй факсаар ирүүлсэн баримт бичгийг шаардлага хангасан хүчин төгөлдөр гэж үзэхгүй. Эх хувиар нь

ирүүлсэн зөвшөөрөл, итгэмжлэлийг нотариатч авч үлдэх бөгөөд эрхийн улсын бүртгэлийн албанд хуулбар хувь дээр тамгаа даран хүргүүлнэ.

Гэрээ, хэлцэл, хуулийн этгээд үүсгэн байгуулах баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулсан, хугацааг нь сунгасан, цуцалсныг гэрчлэхэд 3000 төгрөгийн хөлс авна. Гэрээний сунгалтыг гэрчлэхдээ үндсэн гэрээнд хугацааг дахин сунгах эсэх талаар юу гэж тохиролцсоныг харах нь зүйтэй. Үндсэн гэрээндээ хугацааг сунгахгүй гэж тохиролцсон гэрээг нотариатч анзааралгүй сунгасны улмаас тухайн гэрээ хүчингүй болсон тохиолдол гарлаа.

Хуулийн этгээд үүсгэн байгуулах тухай гэрээ, дүрэм, гэрээний орчуулга, дүрмийн орчуулга тус бүрээс 5000 төгрөгийн үйлчилгээний хөлс авна.

-ооОоо-

МЭДҮҮЛЭГ АВАХ АРГА¹*(Мөрдөн байцаагчид өгөх сэтгэл зүйн зөвлөмж)*

Мөрдөн байцаагчийн зорилго бол гэмт хэргийг илрүүлэх. Гэхдээ амьдрал дээр хэргийг шүүхэд шилжүүлж болох хэмжээний мэдээлэл цуглуулахад амар хялбар байх нь тийм ч цөөнгүй. Тухайлбал, гэмт хэрэг үйлдсэн тухай хилсээр хүлээн зөвшөөрөх, ямар нэг зүйл дээр буруутгасан худал мэдээлэл олох. Юу нь сонирхолтой вэ гэвэл худал юм шиг мөртлөө үнэн мэдээллийг авч хэрэглэх нэг буюу хэд хэдэн арга байдаг. Сэтгэл зүйн хэд хэдэн суурь үйлдлүүд болох айдас, гэм, давуу тал, хардалт, өс хонзон, атаархал, шударга зан гээд л бүгдийг энэ аргуудад ашигладаг. Сэтгэл зүйн хямралд оруулах тодорхой арга, тухайлбал, сэтгэлийг нь зовоох, хоосон худал үгээр хуурах, айлган сүрдүүлэх, итгэлийг олох, биеийн болон сэтгэл зүйн хувьд туйлдуулах зэрэг бүх арга энд багтана.

Мэдээж мөрдөн байцаагчид янз бүрийн л хүмүүс байна. Гэвч нийгмийн өвөрмөц шалгаралд өртөмтгий байдлаасаа болоод гол чанараараа тусгай системд өөрсдийгөө төсөөлдөг, бусад хүмүүсийг өөрсдийн сонирхлоороо эрхэндээ оруулан нөлөөлж, өөртөө татаж чаддагаараа мэргэжлийн хувьд бүлэг болдог /багш, эмч, сурвалжлагч, мөрдөн байцаагч, шүүгч, өмгөөлөгч/ хүмүүс байдаг. Хэрэв хувь тавилан таныг мөрдөн байцаагчтай орооцолдуулчихвал ... яана, үүнд бэлэн байх хэрэгтэй гэдэг нийтлэг зөвлөгөө эндээс шууд л гарч ирнэ. Сэжигтэн хэрэв чин сэтгэлээсээ хэргээ хүлээхгүй бол мөрдөн байцаагч түүнд нөлөө үзүүлж аргандаа оруулах хэрэгтэй болно. Ер нь түүний ажлын өвөрмөц онцлог тийм байдаг. Тэдний ажлын зарим арга барилыг авч үзье. Энд мөрдөн байцаагчийн мэргэжлийн үйл ажиллагааны бүх нарийн ширийнийг өгүүлэхгүй, зөвхөн хамгийн гол болох хэргийн сэтгэл зүйн тал дээр анхаардаа төвлөрүүлнэ гэдгээ тэмдэглэн хэлье.

Сэтгэл зүйн тайван бус байдал. Мөрдөн байцаалт сэжигтний түрүүчийн удаа хууль зөрчсөн хожиг асуудалтай танилцахаас эхлээд аажмаар түүний тухай мөн бүх нууж хааж байгааг нь мэдэж байгаа сэтгэгдэл төрүүлэх замаар жинхэнэ үнэн мөнд дөхөж очно. Мөрдөн байцаагчид мөн үүний зэрэгцээ зайлшгүй хэрэгцээтэй мэдээллийг бие биедээ өгч байдаг сэжигтний хуурамч гэрчүүдтэй ажилладаг. Жишээлбэл, хуурамч гэрчийн өөрийнхөө намтрыг бичээд сууж байгаа өрөөний дэргэдүүр сэжигтнийг өнгөрөөж явуулна. Тэгээд "Хараач, тэр чиний тухай бичиж байна" гэж үймүүлэн, хуурамч гэрчид "Би бүх үнэнийг ярьсан" гэж хэлээрэй гэнэ. Тэр сандарч мэгдсэнээсээ болоод яг чухам ямар үнэнийг яриад байгааг үнэндээ бол мэдэхгүй.

Худал үгээр хуурах. Мөрдөн байцаагчийн худал үгээр хэрхэн хуурахыг дараахь үгсээс харж болно. "Би таны бодож байгаагаас илүү ихийг мэдэж байна. Таны мэдэгдэж байгаа чинь хоосон ёс төдий зүйл. Бид одоо юу хийх тухайгаа, зарим нэгэн ёс журмыг сахин биелүүлэх тухай протокол зохиох л бидэнд хэрэгтэй байна" гээд протоколыг бөглөх явцад "жижиг сажиг аяхихгүй" зүйлсийг нарийвчлан тодруулна.

¹ Игорь О.В. Сэтгэл зүйд нөлөөлөх боломж. УБ., 2003. 115-125 дахь тал

Мөрдөгчид үнэхээр тодорхой байгаа зүйлийн тухайд сэжигтний мэдэхгүй зүйл байгаа нь анхаарал сарниулах, бухимдуулах хэрэгсэл болж байгааг тэмдэглэх хэрэгтэй. Хүн толгойдоо маш олон жижиг сажиг зүйлсийг тогтоон барьж байж чадахгүй. Тэр хэдийчинээ их ярина ямар ч зүйлсийг хэдий чинээ их мэдээлнэ, төдий чинээгээр жижиг зүйлсдээ орооцолдож түрүүчийн удаа ярьж байсан зүйлээ мартах аюултай. Туршлагатай мөрдөн байцаагч өөрт нь сэжигтний ярьсан зүйлийг мартсан дүр үзүүлэн, асуултуудаа давтан тавих, дахин лавлах, ач холбогдолгүй жижиг зүйлсийг нарийвчлан тодруулах аргыг хэрэглэнэ. Шууд бус тойруу замаар асуултуудаа давтан тавьж, амархан мартагдах жижиг сажиг зүйлийг л тодруулна.

Сэжигтний анх ярьсан зүйлийг хурдхан мартуулахад л мөрдөгчийн зорилго оршино. Тийм маягаар түүний худал хэлсэн нь илчлэгдэнэ. Харин сэжигтнийг ярьсан зүйлийг нь хурдан мартуулахын тулд яах вэ? Хоёр хувилбар бий. Эхнийх нь улир болсон асуултуудыг давтан тавихдаа хоорондох хугацааг зайтай болгох хэрэгтэй. Энгийнээр хэлэхэд хэсэг хугацааны дараа дахин асуух. Удаах нь сэжигтний анхаарлыг огцом сарниулах, эсэргүүцэх хүслийг нь эвдэх. Энэ давалгаан дунд түүний алдааг илрүүлээд зогсохгүй, хэргийг нь хүлээлгэх үнэ цэнэтэй мэдээллийг олж авч болно. Жишээ нь:

-Хардлага төрүүлж болно. "Чамайг энд сууж байхад чиний гэрт эхнэртэй чинь хамт ... байгаа";

-Шударга байдлтай холбох. "Чамайг энд сууж байхад харин тэр чөлөөтэй явж байдаг, энэ шударга хэрэг мөн гэж үү?";

-Засаршгүй, аргалж баршгүй байдалтай холбох. "Чиний хуурамч гэрч чамайг аль хэдийн бидэнд тушаасан" (түүний мөрдөн байцаалтын хуурамч протокол, түүнээс авсан гэх амаар өгсөн мэдүүлэг харуулж байгаа) эсвэл "Цэцэрхэх гэсний хэрэггүй, торны цаана сууж байгаа тэр олон хүмүүс бас л өөрсдийгөө ухаантайд тооцож байсан" Энэ оролдлого сэжигтний өөрийн боломжиндоо итгэх итгэлийг эвдэн хаяж, бүх юм ямар ч хэрэггүй, тийм ухаантнууд ч "хага үсэрч" байхад ... чи ч дээ, шалдаа бууж л таарна гэж байгаа хэрэг;

-Дур гутах. "Ямар хог шаарнуудтай холбогдсоноо хар даа! Энэ таны хүрээний хүмүүс мөн гэж үү? Тэд чинь төрүүлсэн эхээ ч алж мэдэх улс";

-Өс хонзон. "Чамайг худалдаж байгаа, тэр шаарыг чи юунд нь өрөвдсөн юм бэ?";

-Гэм буруу. "Яаж чи өөрийнхөө найзда тэгж хандаж чадаж байна аа!";

-Айдас. Зүгээр л шоронгийн нөхцөлөөр айлгаж болно. "Хууль завхруулагчидтай хамт сүрьеэгийн халдвартай камерт суулгана" гэх зэргээр хүний сэтгэл зүйгээр тоглож болно.

Айлган сүрдүүлэх. Айлган сүрдүүлэх арга барагдашгүй мэт ундарч байдаг. Гэвч янз бүрийн соёлыг төлөөлсөн янз бүрийн хүмүүсийн мэдрэхүй адилгүй гэдгийг санах хэрэгтэй. Жишээлбэл, лалын шашинтанг үхлээр айлгахад илүү хэцүү, лалын шашинтай олон оронд өөрийн ч бусдын ч амь насыг бага үнэлдэг байхад, хардалт илүү хүчтэй нөлөө үзүүлдэг. Хүн тус бүрийн үнэ цэнэтэй зүйл дотор жишээ нь шившигтэй явдалтай харьцуулахад үхэл шал дэмий зүйл юм.

"Арван есын хороо" хэмээх кинонд хэргийнхээ гогцоог гаргачихаад баривчилсан хүнээ айлган сүрдүүлэхээр оролдож байгаа нэгэн мөрдөн байцаагчийн тухай гайхалтай өгүүлсэн байдаг. Нэртэй эрдэмтний мөн бүсгүйчүүлд их дуртайг нь мэдсэн мөрдөгч "Хэрэв та энэ баримт дээр гарын

үсэг зурахгүй бол бид таныг хөнгөлж тайган болгоно". Үүнээс сайн юм юу байх вэ гэж баярласан хоригдол "Та надад их тус боллоо. Ингээд би шинжлэх ухааны ажлаа ул суурьтай эрхэлж чадахаар болов" хэмээн хариулна.

Биеийн болон сэтгэл зүйн хувьд туйлдуулан ядраах. Сэтгэл хөдлөлийн хариу үйлдэл үзүүлэх нь ямагт хүнийг амархан ядрааж, гэнэтийн гай зовлон учруулдаг. Тэгэхлээр эндээс хүнийг туйлдуулан ядраах аргуудыг бид зөвхөн сургамжлах зорилготойгоор хувааж байгаа боловч амьдрал дээр ч мөн эдгээр нь хэд хэдэн хүрээнд хамаарч байдаг. Биеийн болон сэтгэл зүйн хувьд ядраах нь олон цагаар байцаалт явуулж унтуулахгүй байх (6 цагаас илүүгүй байхыг зөвлөдөг), нэг асууснаа дахин дахин асууж лавлах г.м.

Хүмүүсийн олонхи нь байдал тодорхойгүй, учир шалтгаан нь мэдэгдэхгүй бүрхэг байдлыг тэвчиж чаддаггүй учраас тийм байдлыг бий болгох нь (санал асуулгаа дахин дахин эхлэн сунжруулах, болж буй үйл явдлыг оньсого, таавар мэт болгох, битүү ёгт яриа, мэдээллийн вакум) сэтгэл зүйн хувьд ядраан туйлдуулах аргын төрөл зүйлийн нэг юм. Өмгөөлөгчтэй зөвлөхөө шийдэж чадаагүй байхад нь халуун мөрөөр нь мөрдөн мөшгөж байцаалт явуулах (өмгөөлөгчтэй уулзахыг нь түр хойшлуулан сунжруулах нь сонгодог жишээ).

Гэнэтийн дайралт. Тайван уулзаж байх үед гэнэт огт өөр өнгөөр гол чухал асуултаа тавих. Энэ нь уулзалт бараг дуусч байхад сэжигтэн бүр тайвшран сульдсан үед болно. Жеглов, Шаранов хэмээгдэх "сайн", "муу" хоёр мөрдөн байцаагч хэрхэн чадварлаг ажилласныг саная. Эдгээр дүрүүдийг сэлгэн дослуулж болно (солбицсон байцаалт). Мөрдөн байцаагчийг солих нь доор дурдсан ач холбогдолтой.

-Хоёр хүн байх нь ялангуяа тэр хэмжээгээр өөр өөр байж, нэг нь мэдэхгүй байх, нөгөөдөх нь өөрөөр ярих хуурмаг байдлыг бий болгоно. Энэ тохиолдолд анхаараал суларч, хүн алдаа гаргаснаар мэдүүлэг зөрөөтэй өөр байгааг харуулдаг.

-Хэрэв сэжигтэн ийм аргын тухай мэдэж байсан ч "сайн мөрдөгч" рүү илүү тэмүүлнэ. ("сайн" гэдэг үгийг хашилтад хийсэн нь түүний "арга" болохыг онцлон тэмдэглэсэн хэрэг. Үнэндээ тэр үнэхээр сайн, сайхан сэтгэлтэй хүн байж болно.) (Жүжигчин Сергей Юрскийн тоглосон "Уулзах газрыг өөрчилж болохгүй" киноны баатар энэ тухай ярьдаг.)

-Хүн бие махбодийн хувьд, (нэг нь хоёрын эсрэг) сэтгэл зүйн хувьд "тэнцвэргүй байдалд" орно. (Муу мөрдөгчөөс сайн руу) Хэрэв сэжигтэн хамтран ажиллахыг хүсч байгаа бол түүнд ихэвчлэн урамшуулах, өрөвдөх, амлах зэрэг аятайхан сэтгэгдэл төрүүлэх, ойр дотно байх, харилцааны эв нийцтэй байдлыг бий болгох зэрэг "эерэг" аргуудыг хэрэглэнэ: Жишээ нь: мөрдөн байцаагч ярихдаа "Би чиний асуудлыг ойлгож байна, чамд ямар хэцүү байгааг ч мэдэж байна, тэгээд би чамд туслах гэсэн юм. Би хугацааг багасгах талаар бодно оо. Чи бол ингэх эрхтэй хүн", "Бид чинь нэг нутгийн улс. Чи чинь хэн нэгэн кавказ эр биш орос хүн биз дээ?" Хэрэв сэжигтэн хамтран ажиллах бодолгүй шууд ба шууд бусаар шахалт үзүүлэх аргыг хэрэглэнэ. Үүнд өмнө тоочсон аргууд дээр нэмж доор дурдсаныг өгүүлнэ.

Өдөөн хатгах. Түүний зорилго нь сэтгэл хөдлөлийн хүчтэй хариу үйлдэл үзүүлэхэд хүргэж үр дагавар, гарз хохирлыг нь хянах явдал юм. Бидний санаж байгаа хоосон, худал үгээр хуурах нь өдөөн хатгалтын нэг зүйл гэж хэлж болно. Жишээ нь сэжигтэнд нэмэлт мэдээлэл өгөх бөгөөд энэ нь гол

чухал гэрч баримт нь хаана байгаа нь тодорхой гэсэн үг. Тэр түүнийг устгахын тулд хайхаар явж, өөрийгөө илчилнэ. (нууц зэвсэг, хар тамхи-бүх кинонуудын сонгодог өгүүлэмж) Угтаа бол бидний тоочоод байсан сэжигтний сэтгэл зүйн янз бүрийн үйлдлүүдэд өдөөн хатгалтын хувилбарууд байна. Түүн дээр хүний мэдрэхүйн тоо томшгүй олон нарийн өнгө ялгааг нэмж болно.

Мөрдөн байцаагчийн асуулт. Асуулт ийм байж болно.

-Хэрэгцээтэй, шууд бус тойруулж хэлсэн асуултыг багтаасан, саармаг байж болно.

-Хариулт нь мөрдөн байцаагчид хэрэгтэй голдрилоор чиглэн явах бүлэг асуулт.

-Хэргийн хувьд ярихад, зүгээр л шууд товч байдлаар сэлгэн хариулах боломжгүй "тэгсэн үү, үгүй юу?" гэх хэв шинжийн хуваагдмал асуулт байж болно. Жишээ нь, "Шууд хариул, хуурсан уу, үгүй юу?"

-Хоёр хариултын хооронд сонгох боломж олгох асуултууд гэхдээ зөрөг нааштай асуулт нь асуугчийн горьдож байгаатай тохирч байна.

-Сонгох хариулт үлдээгээгүй асуулт. (хариултуудаас нэг нь ч боломжгүй) "Үгүй бол чи алсан, (гэхдээ, тэр үүнийг хийгээгүй гэдгийг бид мэдэж байгаа) үгүй бол чи хулгайлсан". Өөрөөр хэлбэл, сэжигтэн ер нь буруугүй байсан ч ядахдаа "арай аюул багатай" хариултыг нь сонгуулна гэсэн үг.

-Шууд ятгах асуулт. Энэ нь "Чи алсан!" гэж тулган хүлээлгэж хэлж болно. Сэжигтэн хэзээ ч дийлэхгүйгээ мэдэж шантарсан үедээ зөвхөн "тийм" гэж хариулах л үлдэж протоколд гарын үсэг зурахаас аргагүй болгох.

-Ерөнхий хариулт нь тавигдсан асуултуудыг нарийвчлан тодруулахад ашиглагдах нийлмэл, нарийн түвэгтэй асуулт. Тэдгээрийг илүү энгийн асуулт болгон хувааж болно.

-Заримдаа юу? хаана? хэзээ? яаж? яагаад? гэх мэт цуврал асуулт тавих нь ашигтай байдаг. Эдгээр цуврал асуулт, тус бүрд нь удаан бодож хариулах боломж өгдөггүй учраас худал хэлсэн тохиолдолд сэжигтэн заавал "хатгагдан" баригдана.

-Янз бүрийн найруулгаар (өөр, өөр байдлаар) асуултыг давтан тавих. Огт өөр зүйлийн тухай асууж, хуурмаг сэтгэгдэл төрүүлэх нь сэжигтэнг тайвшруулна. Үлэмж нийтлэг чанартай хувилбарууд бөгөөд мэдээж 100 хувь яг тохирохгүй ч тоймлосон чиг хандлагыг гаргаж байгаа юм.

Буруугүй хүний хариулт: эрс ширүүн, шууд дор нь хариулна, нийгмийн хэм хэмжээ, үнэ цэнэтэй зүйлд хандана, хүмүүсийн үнэлэлтэд сэтгэл түгшинэ.

Буруутан хүний хариулт: удаан хариулна, "бүх хэзрөө дэлгэхдээ" шууд дор нь хариулахгүй, нийтлэг хариулт өгнө. Тэд нарыг зөвхөн шийтгэл залхаалт л санааг нь зовоох бөгөөд хүмүүсийн үнэлэлтийг хайхардаггүй.

ОЮУНЫ ӨМЧИЙН ЭРХИЙН НЭР ТОМЪЕОНЫ ДАГАЛГА

"Евромаркпат-Монгол" ХХК-ийн захирал Ю.Энхтөвшин

Барааны тэмдэг	товарный знак	trademark
Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг иргэн, хуулийн этгээд өөрийн бараа, үйлчилгээг бусдын бараа, үйлчилгээнээс ялгах зорилгоор хэрэглэх ялгагдах чадвартай илэрхийлэл.		
Хамтын тэмдэг	коллективный знак	collective mark
Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчид нэгдсэн хяналтын дор ашиглах барааны тэмдэг.		
Гэрчлэх тэмдэг	сертификационный знак	certification mark
Тухайн бараа, үйлчилгээний чанар, үйлдвэрлэх арга, бусад онцлог шинж чанарыг тэмдэг эзэмшигч гэрчлэн бусад этгээдэд ашиглуулах барааны тэмдэг.		
Газар зүйн заалт	географическое указание	geographical indication
Тухайн барааны чанар, нэр хүнд, онцлог бусад шинж чанар нь түүний газар зүйн гарал үүсэлтэй салшгүй холбоотойг илэрхийлсэн, тус барааг үйлдвэрлэсэн улс, бүс, газар нутгийн газар зүйн нэр.		
Бүртгэгдсэн тэмдэг, газар зүйн заалт	зарегистрированный знак и географическое указание	registered mark and geographical indication
Оюуны өмчийн байгууллага хуульд заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгэж, гэрчилгээ олгосон барааны тэмдэг, газар зүйн заалт.		
Гэрчилгээ	свидетельство	certificate
Улсын бүртгэлд бүртгэгдсэн барааны тэмдэг эзэмшигч, газар зүйн заалт хэрэглэгчийн онцгой эрхийг зөвшөөрч, төрөөс олгож байгаа баримт бичиг.		
Барааны тэмдэг эзэмшигч	обладатель товарного знака	owner of trademark
Бүртгэгдсэн тэмдгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхийг хуульд заасан журмын дагуу олж авсан этгээд.		
Газар зүйн заалт хэрэглэгч	потребитель географического указания	consumer of geographical indication
Газар зүйн заалтыг өөрийн бараанд ашиглах эрхийг хуульд заасан журмын дагуу олж авсан этгээд.		

Мэдүүлэг	заявка	application
Барааны тэмдэг, газар зүйн заалтыг бүртгүүлэхийг хүссэн иргэн, хуулийн этгээдээс оюуны өмчийн байгууллагад гаргаж байгаа өргөдөл, хуульд заасан бусад баримт бичиг.		
Шүүлт	экспертиза	examination
Тухайн барааны тэмдэг, газар зүйн заалт энэ хуульд заасан шаардлага хангасан эсэх, тэдгээртэй ижил төстэй тэмдэг, газар зүйн заалт өмнө нь бүртгэгдсэн эсэх талаар оюуны өмчийн байгууллагын эрх бүхий шинжээчийн хийх магадлагаа.		
Нийтэд түгээмэл болсон тэмдэг	общеизвестный знак	well known mark
Монгол Улсын нутаг дэвсгэр дээр тухайн салбарт нийтэд танил болсон тэмдэг.		
Лиценз	лицензия	license
Барааны тэмдэг эзэмшигч бүртгэгдсэн тэмдгээ бусдад ашиглуулахаар өгсөн зөвшөөрөл.		
Анхдагч огноо	регистрационная дата	filing date
Барааны тэмдгийн мэдүүлгийг оюуны өмчийн байгууллагад анх өгсөн он, сар, өдөр.		
Давамгайлах огноо	приоритетная дата	priority date
Барааны тэмдгийг Парисын конвенцийн гишүүн болон Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн аль нэг оронд бүртгүүлэхээр өгсөн, эсхүл уг конвенцийн 4 дүгээр зүйлд заасны дагуу давуу эрх авахыг хүссэн он, сар, өдөр.		
Олон улсын ангилал	международная классификация	international classification
1957 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн Ницийн хэлэлцээрээр баталсан "Барааны тэмдэг бүртгэхэд ашиглах бараа, үйлчилгээний олон улсын ангилал".		
Барааны тэмдгийн олон улсын бүртгэл	международный регистр товарного знака	international register of trademark
Дэлхийн оюуны өмчийн байгууллагын Мадридын хэлэлцээр, Мадридын Протоколын дагуу Олон улсын товчооны гүйцэтгэдэг бүртгэл.		
Парисын конвенц	Парижская конвенция	Paris convention
1883 оны 3 дугаар сарын 20-ны өдөр байгуулсан, нэмэлт, өөрчлөлт оруулж хянан засварласан Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын конвенц.		

Мадридын хэлэлцээр	Мадридское соглашение	Madrid Treaty (agreement)
1891 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр байгуулсан, нэмэлт, өөрчлөлт оруулж хянан засварласан Барааны тэмдгийн олон улсын бүртгэлийн тухай Мадридын хэлэлцээр.		
Мадридын Протокол	Мадридский Протокол	Madrid Record
1989 оны 6 дугаар сарын 27-ны өдөр байгуулсан Барааны тэмдгийн олон улсын бүртгэлийн тухай Мадридын хэлэлцээрийн Протокол.		
Мадридын хэлэлцээр болон Мадридын Протоколын журам	Правила к Мадридскому соглашению и Протоколу	Procedure of the Madrid Treaty and Record
Уг Хэлэлцээр болон Протоколын 2002 оны 4 дүгээр сарын 1-ний өдөр хүчин төгөлдөр Нийтлэг журам.		
Шинэ бүтээл	изобретение	Invention
Байгалийн хуульд тулгуурлан анх сэдэж, үндэслэлийг нь нээн илрүүлсэн үйлдвэрлэх арга ажиллагаа болон бүтээгдэхүүнд хамаарах цоо шинэ шийдэл.		
Бүтээгдэхүүний загвар	промышленный образец	industrial design
Үйлдвэрлэлийн аргаар хийх боломжтой бүтээгдэхүүний хэлбэр, хийцэд хамаарах өвөрмөц, цоо шинэ шийдэл.		
Ашигтай загвар	полезная модель	utility model
Аливаа үйлдвэрлэлийн арга, хэрэгсэл, бүтээгдэхүүн, тэдгээрийн үндсэн хэсэг, зохион байгуулалтад хамаарах, шинэ, үйлдвэрлэлд ашиглагдах боломжтой ашигтай шийдэл.		
Патент	патент	patent
Тухайн шийдэл нь шинэ бүтээл, эсхүл бүтээгдэхүүний загвар болохыг тодорхойлж зохиогч нь тодорхой хугацаанд түүнийг өмчлөх онцгой эрхтэй болохыг хүлээн зөвшөөрч төрийн эрх бүхий байгууллагаас олгож байгаа баримт бичиг.		
Ашигтай загварын гэрчилгээ	свидетельство полезной модели	certificate of utility model
Ашигтай загварыг улсын бүртгэлд бүртгэн авч, зохиогч нь тодорхой хугацаанд түүнийг өмчлөх онцгой эрхтэй болохыг хүлээн зөвшөөрч төрийн эрх бүхий байгууллагаас олгож байгаа баримт бичиг.		
Лиценз	лицензия	license
Патент олгосон шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварыг бусдад ашиглуулах зөвшөөрөл.		

Анхдагч огноо	регистрационная дата	filing date
Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварын мэдүүлгийг Оюуны өмчийн газарт, ашигтай загварын мэдүүлгийг тухайн байгууллагад анх өгч бүртгүүлсэн он, сар, өдөр.		
Давамгайлах огноо	приоритетная дата	priority date
Мэдүүлгийнхээ анхдагч огнооноос өмнө Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын конвенцийн гишүүн аль нэг оронд уг шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварыг мэдүүлж бүртгүүлсэн мэдүүлгийн он, сар, өдөр.		
Патент эзэмшигч	обладатель патента	owner of patent
Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварын патент болон ашигтай загварын гэрчилгээ, түүнтэй холбоотой онцгой эрхийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу олж авсан зохиогч буюу түүнээс эрх шилжүүлэн авсан этгээд.		
Монгол Улсын олон улсын гэрээ	международный договор Монголии	international agreement of Mongolia
Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын конвенц /1883/ болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлт, Бүтээгдэхүүний загварын олон улсын хадгалалтын тухай Гаагийн хэлэлцээр /1960/, Патентийн хамтын ажиллагааны гэрээ /1970/, Дэлхийн худалдааны байгууллагын Оюуны өмчийн эрхийн худалдаанд хамаарах хэлэлцээр/1994/.		
Патентийн хамтын ажиллагааны гэрээнд нийцсэн Монгол Улсыг нэр зааж гаргасан олон улсын мэдүүлэг	международная заявка, предъявленная с указанием Монголии в соответствии с Договором Патентной коопераций	an international application naming Mongolia to be compliant with PCT
Конвенцийн давамгайлах огноо бүхий Патентийн хамтын ажиллагааны гэрээний дагуу гаргасан шинэ бүтээл, ашигтай загвар, мэдүүлэг.		

-00000-

Сонин, сэтгүүлийн нэгдсэн зөвлөл

Хаяг: Улаанбаатар – 46, Үндэсний архивын газрын байр,
206 тоот өрөө

Утас, факс: 322094, 315789, 315734

“Хууль дээдлэх ёс” сэтгүүлийн индекс: - 14279

Хууль тогтоомж, шүүх эрх мэдлийн
эрдэм шинжилгээ, сургалт,
мэдээлэл, сурталчилгааны үндэсний төв